

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025.11.28

Дорноговь аймаг

№	Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилт	Үнэлгээ /хувиар/
				5	6				
НЭГ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
1	“Алтанширээт, Гэрэлт говь” үйлдвэрлэл технологийн паркийг дагалдах бусад үйлдвэр байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх	Үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын явц	Хувь	2024	50	60	68	<p>"Монголиан транс ложистик" ХХК-ийн Алтанширээт үйлдвэр технологийн паркийн Нойтон соронзон аргаар хүдэр угаах үйлдвэрийн ажил эхэлж 120.0 мянган тонн хүдрээс 21.6 мянган тонн баяжмал боловсруулж экспортод гаргахад бэлэн болсон. Нүүрсний үйлдвэрийн туршилт тохируулгын ажил хийгдэхээр хүлээгдэж байна. Нийт төслийн явц 60 хувьтай үргэлжилж байна.</p> <p>Хөвсгөл сумын нутагт баригдаж буй "Си Өү Эй Эл" ХХК-ийн "Гэрэлт говь" УТП-ийн үйлдвэрийн угаах үйлдвэрийн барилгын ажил 100, коксын үйлдвэрийн барилгын ажил 30, төмөр замын далан, гүүрэн байгууламжийн ажил бүрэн дуусаж нийт төслийн ажил 76.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.</p> <p>Хөвсгөл сумын нутагт баригдаж буй "Гэрэлт говь" УТП-ийн 22,6 км төмөр замын бүтээн байгуулалтыг улсын комисс хүлээн авсан.</p> <p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04/07 дугаар тогтоолоор Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутаг дэвсгэрт буюу Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам дагуу 7 байршилд нийт 1579.5 га газрыг дээрх үйлдвэр технологийн паркуудыг дагалдах үйлдвэрүүдийг байгуулахад зориулж орон нутгийн тусгай хэрэгцээнд авч хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт явуулах суурь нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд орон нутгийн зүгээс дэмжлэг шаардлагатай үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй.</p>	100
2	Газрын тос боловсруулах үйлдвэрийг	Үзүүлсэн дэмжлэг	Тоо	2024	2	3	3	Аймгийн Засаг даргын 2025 оны А/33, А/270 дугаартай захирамжаар байгуулсан улсын комиссын бүрэлдэхүүн Сайншанд сумын 6 дугаар багийн нутаг	100

	ашиглалтад оруулах Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлэх							<p>дэвсгэрт байршилтай МГТБҮ ТӨХХК-ийн 549 айлын хотхоны 1-р ээлжийн 95 айлын орон сууц /1-р байр/-ыг УҚД-07/2025 дугаартай дүгнэлтээр, Оффис үйлчилгээний барилгыг УҚД-14/2025 дугаартай дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулсан.</p> <p>Мөн “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, Төслийн менежментийн зөвлөх "Engineers India Limited", Ерөнхий гүйцэтгэгч "Megha Engineering and Infrastructures Ltd" компанийн ажилтнууд үйлдвэрийн талбайд 800 мод тарих ажилд холбогдох төрийн байгууллагуудын арга зүйн зөвлөмжийн дагуу хамтран ажилласан.</p> <p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт, барилгын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд "Эм И Ай Эл Интернэшнл" ХХК, "Норинко Интернейшнл" ХХК-ийн гадаад иргэдэд оршин суугаа иргэдийн тодорхойлолтыг гаргаж, үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлсэн. Байгаль, орчны менежментийн төлөвлөгөөг баталгаажуулсан. Онцгой байдлын ерөнхий газрын удирдамжийн дагуу гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, заавар, зөвлөмжийг өгч ажилласан.</p> <p>Газрын тосны үйлдвэрийн явцтай танилцахаар орон нутагт ажилласан Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд болон салбарын холбогдох албан тушаалтанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж мэдээ, мэдээллээр хангасан.</p>	
3	Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах хүнд үйлдвэрүүдийг байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх	Үзүүлсэн дэмжлэг	Тоо	2024	0	5	5	<p>Айраг сумын нутаг дэвсгэрт MV-005692 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Си Эм Кингс” ХХК нь “Хонгор овоо” уурхайд жонш боловсруулах үйлдвэр барих ажлыг “Лаквэст” ХХК-тай хамтран хэрэгжүүлэх төслийн хүрээнд хаягдал ус зайлуулах цэгийг Айраг сумын Засаг даргын 2025.06.16-ны өдрийн А/95 дугаар захирамжаар тогтоож, бодлогын дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт “Далан ухаа” нэртэй MV-022826 дугаартай 1422.95 га талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ундармал хүдэр” ХХК нь төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар буталж ангилах үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг холбогдох</p>	100

							<p>хууль тогтоомжийн дагуу авч, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хөвсгөл сумын нутагт баригдаж буй "Гэрэлт говь" УТП-ийн төмөр замын бүтээн байгуулалтыг улсын комисс хүлээн авсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/33 болон А/270 дугаар захирамжаар "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс"-ыг тус тус томилж, Сайншанд сумын 6-р багт байршилтай Газрын тосны үйлдвэрийн ажилчдын хотхоны 1-р ээлжийн 95 айлын орон сууцыг 2025 оны УҚД-07/2025 дугаартай комиссын дүгнэлтээр, оффис үйлчилгээний барилгыг 2025 оны УҚД-14/2025 дугаартай комиссын дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Мандах сумын нутагт "Түмэн айл энерги" ХХК-ийн 100 МВт-ын цахилгаан станцын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг тус сумын 1-р багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох газарт уламжилсан.</p>		
4	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр барилгын материалын үйлдвэр байгуулах аж ахуй нэгжтэй хамтарч ажиллах	Үзүүлсэн дэмжлэг	Тоо	2024	0	5	4	<p>Сайншанд сумын барилгын материалын үйлдвэрлэл, чанарын хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд аймгийн ГХБХБГ-ын барилгын материалын сорил, шинжилгээний лаборатори хамтран ажиллаж байна.</p> <p>Сайншанд сумын 2 дугаар багт "Өрнө Дорно Урлан Зам" ХХК цагт 40м³ бетон үйлдвэрлэх хүчин чадалтай зуурмагийн үйлдвэр шинээр байгуулж, 182 дээж (бетон сорьц-180, элс-1, дайрга-1)-ийг лабораторид шинжилгээнд хамруулсан. Мөн "Дэлгэр Баясах Зам" ХХК-ий үйлдвэрлэж буй явган замын хавтан, авто замын хашлага зэрэг бетон бүтээгдэхүүний чанарт лабораторийн хяналт хийж, баталгаажуулсан.</p> <p>Сайншанд сумын 4 дүгээр багт "Арвижин Цацрах" ХХК автоклавын бус хийт бетон гулдмайн үйлдвэр байгуулж, үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээ авсан бөгөөд бүтээгдэхүүний чанарыг лабораторид шинжилж хамтран ажиллаж байна.</p> <p>Өргөн сумын нутагт "Монцемент" ХХК үйлдвэрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн төрөл нэмэгдүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүч</p>	80

								болон шохойн чулууны үйлдвэр байгуулах санал ирүүлснийг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахыг Геодези, зураг зүйн ерөнхий газарт уламжилсан. Аймгийн барилгын материалын лаборатори MNS ISO/IEC 17025:2018 стандартад нийцсэн үйл ажиллагаагаар барилгын материалын үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдлыг хянаж, аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж өгч, үйлдвэрлэлийг дэмжин хамтран ажиллаж байна.	
5	Бүс нутгийн онцлогт нийцсэн эдийн засгийн төрөлжилт, үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөгжлийн корпорац байгуулах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, эдийн засгийн төрөлжилт, хөрөнгө оруулалтын менежмент, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийг дэмжих замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулж, бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Их Говийн Хөгжлийн Гарц" ОНӨААТҮГ-ыг 2021 онд байгуулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 04/03 дугаар тогтоолоор дүрмийг шинэчлэн баталсан. Энэхүү орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь 7 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн баримт бичигт дата анализ хийж ажиллаж байна. Мөн Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/589 дүгээр захирамжаар Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт 849 м2 газрыг шийдвэрлэж "Дорноговьд үйлдвэрлэв" цогцолборыг Дорноговь аймгийн "Худалдаа аж үйлдвэрийн танхим"-тай хамтран 2024 онд бүрэн барьж, 2025 онд нээлтээ хийсэн.	100
6	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх	Экспортолсон бүтээгдэхүүн сая.тн	Тоо	2024	7	10	10	2025 онд Ханги хилийн боомтоор 4.6 сая тонн, Замын-Үүд боомтоор 509.35 сая тонн, нийт 513.9 сая тонн бүтээгдэхүүн экспортолсон нь өмнөх оны мөн үеэс Ханги боомтоор 35%, Замын-Үүд боомтоор 32%-иар буурсан. Бууралт нь Хятадын худалдан авалт болон нүүрсний үнийн бууралттай шууд холбоотой байна. Уул уурхайн олборлолт, тээврийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Даланжаргалан суманд "Алаг Толгой" нүүрсний бүлэг ордыг түшиглэн	100

									үйл ажиллагаа явуулж буй 5 аж ахуй нэгжтэй хамтран хайрган хучилттай авто зам тавих ажлыг эхлүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу эхлүүлэхэд орон нутгаас хамтран ажиллах гэрээ байгуулж дэмжлэг үзүүлсэн.	
7	“Цэвэр дулаан хангамжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эрчим хүчний шилжилтийг дэмжих” төслийн хүрээнд Сайншанд хотод 8-10МВт-ын нарны дулааны эх үүсвэрийг байгуулах судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	1	Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын санаачлагаар Сайншанд хотод Нарны дулааны станц барих төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг ЭН ЭКС АЙ ТИ ВАЙ корпоративн компани гүйцэтгэхээр зөвлөх үйлчилгээний гэрээг төсөл санаачлагч, гүйцэтгэгч нар байгуулсан. Орон нутгийн зүгээс төсөл хэрэгжүүлэх боломжтой газрын асуудлыг Чандмань-Илч ОНӨХХК-ийн саналыг үндэслэн Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлж тус сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, дэмжлэг үзүүлж ажиллалаа.	100
8	Чойр-Сайншанд чиглэлийн 220кВт-ын хүчин чадалтай дэд станц, агаарын шугам барих ажлыг үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	1	“Чойр-Сайншандын 220 кВ-ын ЦДАШ төсөл”-ийн хүрээнд 220,4 км ЦДАШ барих ажлыг Европын сэргээн босголтын банкны 62,8 сая ам.долларын зээл, 12,0 сая еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 256 дугаар тогтоолоор шийдвэрлэж төслийн ТЭЗҮ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ 2021 онд хийсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласны дагуу үнийн санал ирүүлсэн 4 аж ахуйн нэгжийн тендерийн баримт бичигт үнэлгээ хийх ажил Эрчим хүчний яаманд зохион байгуулагдаж байна. Төсөл санхүүжилт, техникийн бэлтгэл, газрын зохицуулалтын шатуудаа амжилттай хангаж, барилга угсралтын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эцсийн шатанд хүрээд байна. Орон нутгийн зүгээс 2021 онд Чойр-Сайншанд чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зориулалт бүхий 7.8 га газрыг шийдвэрлэж гэрчилгээг олгож, 2024 онд төсөл хэрэгжүүлэх нэгж, болон орон нутгийн мэргэжлийн	100

								байгууллагуудын төлөөлөл ЦДАШ барих трассын дагуу газар дээр нь ажиллаж шаардлагатай арга хэмжээг авч хамтран ажилласан.	
9	Сайншанд-Цагаан суварга чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам барих төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	Сайншанд–Цагаан суварга чиглэлд 220 кВ-ын ЦДАШ байгуулах төслийн ТЭЗҮ болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээг 2021 онд хийж дуусгасан. Аймгийн зүгээс шугамын трассын дагуух газрын давхцалыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллийн сантай тулган баталгаажуулж, төслийн нэгжтэй уялдаа холбоотой ажилласан.	100
10	Улаанбадрах суманд Дулааны уурын зуух болон тоног төхөөрөмж худалдан авах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн төсвийн 583.8 сая төгрөгөөр Улаанбадрах суманд 2 зуух худалдан авах ажлын тендерийг 2024 онд зохион байгуулж 09 дүгээр сард 2 зуух болон дагалдах тоног төхөөрөмжийг хүлээн авч, 318.4 сая төгрөгийг санхүүжүүлсэн бөгөөд үлдэгдэл 265.4 сая төгрөгийг тайлант хугацаанд гүйцэтгэгчид олгосон.	100
11	Сайншанд сумын дулааны станцыг 1500 кВт-ын хүчин чадал бүхий цахилгааны нөөц үүсгүүртэй болгох	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Сайншанд сумын дулааны станцын цахилгаан нөөц бололцоог нэмэгдүүлэхээр орон нутгийн төсвийн 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1500 кВт-ын хүчин чадалтай нөөц үүсгүүр нийлүүлэх тендер зарлагдаж, "Ихэрбаян говь" ХХК шалгарч уг үүсгүүрийг амжилттай хүлээлгэн өгсөн.	100
12	"Говь" нарны цахилгаан станцын дэргэд 30/120МВт цэнэг хуримтлуур байгуулах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	25	Сайншанд сумын 8-р багт 189 га газарт "Говь" нарны цахилгаан станцын дэргэд 30/120 МВт хүчин чадалтай цэнэг хуримтлуурын станц байгуулахаар төлөвлөсөн. Газрын байршил нь Сайншанд сумын 2025 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05/01 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. Одоогоор газрын дуудлага худалдааг зохион байгуулах шатанд явж байна. Дуудлага худалдаа зохион байгуулах Аймгийн Засаг даргын 2025 оны А/672 дугаар захирамжаар дуудлага худалдаа зарлагдаж 12 сарын 12-ны өдөр цахим тендер шалгаруулалт явагдана.	25
13	Чандмань-Илч ОНӨХХК-ийг нэн шаардлагатай	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	66	Чандмань-Илч ОНӨХХК-ийг шаардлагатай тээврийн хэрэгслээр хангах зорилгоор бохир соруулах машин, нүүрс тээврийн автомашин, дугуйт эксковатор худалдан авах гэрээг нийт 740.3 сая	66

	тээврийн хэрэгслээр хангах							төгрөгөөр "ЭМББ РОУД ТРАНС", "Намдэмүнсервис", "Монтех дистрибьюшн" ХХК-тай байгуулсан. Нүүрс тээврийн автомашин техникийн шаардлага хангаагүй тул хүлээн авахаас татгалзсан бол бохир соруулах машин, дугуйт эксковаторыг ажлын хэсэг хүлээн авч ашиглалтад оруулсан. Төслийн гүйцэтгэл одоогоор 66 хувьтай байна.	
14	Мандах, Хөвсгөл сумын төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах ажил:	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	68	Орон нутгийн төсвийн 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандах сумын төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний угсралтын ажлыг "Оджон холдинг" ХХК гүйцэтгэж байна. Цэвэр, бохир усны төв магистрал шугамын угсралтын ажлууд хийгдэж дууссан. Үүнд: Цэвэр усны эх үүсвэрийн шугам 3200 м, түгээх шугам 780 м, нийт 3980 м шугамын угсралтын ажил хийгдэж дууссан. Ариутгах татуургын гол шугам БУХ-24-НС хүртэл 600м, даралттай шугам НС-ЦБ хүртэл 167 м, салбар шугам БУХ78-34 хүртэл 300м, БУХ86-БУХ99 хүртэл 426м, нийт 1493 м хийгдэж дууссан. Нийт ажлын гүйцэтгэл 35%-тай. Хөвсгөл суманд халаалтын зуух, нэгдсэн шугам сүлжээ барих ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Б-Софт ХХК гүйцэтгэж 2022 онд ашиглалтад оруулсан. Одоогоор хэвийн ажиллаж байна. Гадна цахилгаан хангамжийн ажил 100 хувь гүйцэтгэгдсэн бөгөөд 2025 онд материалын үнийн зөрүү 445.6 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон.	67.5
15	Алтанширээ сумын гадна цахилгаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн төсвийн 413.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтанширээ сумын гадна цахилгаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг "Уртын-Уул" ХХК гүйцэтгэж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр дуусгасан. Ажлыг улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 26-нд хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан.	100
16	Сайншанд, Замын-Үүд, Зүүнбаян зангилааны өргөтгөл, шинэчлэлтийг хийхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	Сайншанд-Зүүнбаян зангилааны өргөтгөл, шинэчлэлтийг дэмжих зорилгоор Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/112 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, газар дээр судалгаа хийсэн. Судалгаагаар Зүүнбаян өртөөний зүүн талаас Сайншанд сумын 5 дугаар багийн төвийн урдаас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр	100

								замтай авто замыг холбох санал боловсруулж, яаманд уламжлан шийдвэрлүүлсэн. Өргөтгөл, шинэчлэлийн зургийг "Улаанбаатар төмөр зам" ХХН хэвийн гүйцэтгэж байна.	
17	Налайх хот-Замын-Үүд хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	Говьсүмбэр аймгийн Чойр хотоос Дорноговь аймгийн Замын-Үүд боомт хүртэлх авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх ажлыг ТЭЗҮ, БОНУ, зураг төсөв боловсруулах үүргийг "Монголын тусгай зориулалтын авто зам" ХХК гүйцэтгэж байна. Орон нутгийн зүгээс төслийг үргэлжлүүлэх санал Засгийн газарт хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 233 дугаар тогтоолоор хэрэгжүүлэх шийдвэр гарсан. Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид шаардлагатай мэдээллийг 2025 оны 07 сарын 24-ний 02/1178 дугаар албан бичгээр хүргүүлж хамтран ажилласан.	100
18	Сайншанд суманд ачаа тээврийн логистикийн төвийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	Сайншанд сумын 4-р багт Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах стандартын агуулахын цогцолбор бүхий ачаа тээврийн логистикийн төвийг "Өү Эн И Март" ХХК-ийн ONEXPERESS төслийн хүрээнд "Женерал консалтинг констракшн" ХХК барьж байна. Барилга угсралтын ажил одоогоор 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн зүгээс тухайн аж ахуйн нэгжид ажил эхлүүлэх зөвшөөрөл олгож, үйл ажиллагааг дэмжин ажилласан.	100
19	Зүүнбаян-Баруун-Урт хот чиглэлийн төмөр замыг барихад дэмжлэг үзүүлж ажиллах	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	"Монгол төмөр замын хөгжлийн стратеги – Зүүн Азийн төмөр замын нийгэмлэгийг үүсгэн байгуулахтай уялдуулах нь" төслийн хүрээнд Зүүнбаян–Баруун-Урт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ боловсруулсан. ТЭЗҮ боловсруулах явцад газрын трассын давхцалын мэдээллийг хянаж, төслийн багтай хамтран ажилласан. Гэвч хөрөнгө оруулалтын хүндрэлээс шалтгаалж төслийн явц удаашралтай байна.	100
20	"Ханги" хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	Боомтын сэргэлтийн үндэсний хорооны захиалгаар Ханги боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах тендерийг зарлаж, 2025 оны 05 дугаар сарын 19-нд "Циркулпроект" ХХК шалгарч, 645.0 сая төгрөгийн гэрээг Эдийн засаг хөгжлийн яамтай байгуулсан. Орон нутгийн зүгээс Ханги боомтын суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг "Ланд Овнер" ХХК-аар боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан	100

								холбогдох байгууллагуудад хүргүүлж, уялдуулан хэрэгжүүлэх санал ирүүлсэн. Мөн ерөнхий төлөвлөлтийн ажлыг дэмжихээр шаардлагатай мэргэжлийн байгууллагуудтай холбож хамтран ажиллаж байна.	
21	Замын-Үүд, Ханги хилийн боомтуудад чингэлэгт тээвэр, ачилт буулгалт, шилжүүлэн ачих терминалуудыг байгуулахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	Замын-Үүд болон Ханги боомтод чингэлэгт тээвэр, ачилт буулгалт, шилжүүлэн ачих терминал байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, салбарын яаманд уламжилсан. Үүний дагуу Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны 120 дугаар тогтоолоор Замын-Үүд сумын 3-р багт 50,024 м² газрыг терминалын талбайн зориулалтаар баталж, газрын цахим биржээр 2025 оны 06 дугаар сарын 05-нд дуудлага худалдааг зохион байгуулсан. Анхны үнэ 300,1 сая төгрөгөөс эхэлж, 840,1 сая төгрөгийн үнийн саналаар ялагч тодорсон.	100
22	Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	0	1	1	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нийслэлийн зураг төслийн хүрээлэн “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг 2011 онд боловсруулсан. 20 жилийн хугацаатай төслийн хоёрдугаар үе шат буюу 2019–2029 онд хэрэгжих 900 га талбайг бүрэн дэд бүтцээр хангах ажлын зураг төсөв бүгд хийгдсэн. Энэ хүрээнд Замын-Үүд сумын ЗДТГ, Чөлөөт бүсийн захирагчийн алба, “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ хамтран өмнөх онуудад баригдсан шугам сүлжээг турших, гэмтлийг илрүүлэх ажлыг эхлүүлж 30 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
23	Зарим сумдын алслагдсан багт үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	1	2	3	Орон нутгийн хөгжлийн сангийн 958.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өргөн, Мандах, Улаанбадрах сумдад үүрэн холбооны сүлжээний өргөтгөлийн ажил хийгдсэн. Үүнд: Өргөн суманд хөдөөгийн 3 багийн үүрэн телефоны сүлжээ нэмэгдүүлэх ажлыг 367.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Скайтел ХХК, Мандах суманд Хөдөөгийн багуудад үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх ажлыг 410.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Юнител ХХК, Улаанбадрах сумын төвийн сүлжээний антен өргөтгөх ажлыг 181.0 сая	100

								төгрөгийн хөрөнгө оруулалтаар Намуун хишиг далай ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	
24	Хөдөө аж ахуйн анхан болон дундын хоршоог байгуулах	Шинээр байгуулагдсан хоршоо (өссөн дүнгээр)	Тоо	2023	70	190	240	<p>“Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд тайлант онд 44 хоршоо, нийт 240 хоршоо шинээр байгуулагдаж, 14 сумын 517 малчин нийт 20.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйл ажиллагаа эхлүүлсэн. Үүний үр дүнд 14 сумын 142 хоршоо зээлийн хөрөнгөөр, 2 сумын 2 хоршоо хувийн хөрөнгөөр түүхий эд бэлтгэх, боловсруулах, мал сүргийн ашиг шимийг нэмэгдүүлэх, бойжуулах, худаг гаргах, хашаа саравч барих зэрэг чиглэлээр ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 5 сумын 9 хоршоонд 851.1 сая төгрөгийн зээл олгож, 5 сумын 8 хоршоонд 29.09 га газар эзэмшүүлэх эрх олгосон. Мөн 5 сумын 6 хоршооны 19.5 га газар эзэмших хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа байна. Хоршоодын чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод 3 хоногийн вакум сургалт зохион байгуулж 14 сумын 40 малчин оролцсон бөгөөд 4 сумын малчдын зөвлөгөөнөөр 800 гаруй хоршооны гишүүн, малчдад мэдлэг олгосон.</p> <p>Мөн “Говийн бүсийн анхдугаар хуралдаан”-ы үеэр болсон үзэсгэлэн худалдаанд 10 хоршоо бүтээгдэхүүнээр, 3 хоршоо үйл ажиллагаагаа сурталчлан оролцсон. Аймгийн хэмжээнд нийт 310 хоршоо үйл ажиллагаа явуулж байна.</p>	100
25	Зарим сумдад хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн парк байгуулах суурь судалгааны ажлыг гүйцэтгэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2023	0	70	10	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол, мөн 2025 оны 120 дугаар тогтоол, Аймгийн аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөөний хүрээнд бэлтгэгдсэн суурь судалгаанд үндэслэн зарим сумдад хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах газар зохион байгуулалтын дагуу Замын-Үүд суманд 2 га, Дэлгэрэх суманд 1.5 га, Мандах суманд 5 га, Өргөн суманд 6 га, Хатанбулаг суманд 2 га, Сайншанд суманд 5 га, нийт 21.5 га газрыг мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэхээр баталсан.</p>	14.2

								<p>Сайншанд сумын Зээгийн хөтөлд Зэвсэгт хүчний 336-р ангийн харьяа 400 м² өвлийн хүлэмж, 5000 м² зуны хүлэмж, 12 ил талбайд Агропарк байгуулагдсан. Дэлгэрэх сумын 1.5 га талбайд мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалт 2 удаа зохион байгуулсан боловч оролцох хүсэлт ирээгүй байна. Иймд дахин төсөл сонгон шалгаруулалт зарлах бэлтгэлийг хангаж байна. Монгол улсын анхны кластер фермийн үйл ажиллагаа эрхлэгч "Нүүдэлчин агро ферм" ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж эрчимжсэн мал аж ахуйг цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх, хөдөө аж ахуйн нөөцүүдийн үнэ цэний хэлхээг бий болгох чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг авч ажиллаж байна.</p>	
26	Сумдын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэлийн хувь	Хувь	2023	0	80	80	<p>Аймгийн Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх, Даланжаргалан, Сайхандулаан, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ зэрэг найман сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын хүрээнд ажлын зургийн даалгаврыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай зөвшилцөн баталж, зарласан тендерээр "Циркулпроект" ХХК шалгарч 2025 оны 5 дугаар сарын 29-нд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэгч байгууллага өмнөх ерөнхий төлөвлөгөөнд үнэлэлт дүгнэлт өгч, суурь судалгаа болон инженер-геологийн ажлыг бүрэн дуусган нэгдүгээр шатны тайланг ирүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны А/542 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд төлөвлөлтийн үндсэн шийдлүүдийг сум бүрийн ажлын хэсэгт танилцуулж санал, дүгнэлт авах уулзалтуудыг зохион байгуулсан. Төслийн хэрэгжилт төлөвлөгөөний дагуу үргэлжилж байгаа бөгөөд гүйцэтгэл 80 хувьтай байна.</p>	100
27	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	50	100	90	<p>Орон нутгийн төсвийн 339.2 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжиж буй аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын гүйцэтгэгчээр Лапланд Эко ХХК шалгарч, 2024 оны 06-р сарын 07-нд ОНТХО-НТШ-11/2024 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага дунд шатны төлөвлөгөөний</p>	80

								төслийг боловсруулж, 2025 оны 04-р сарын 17 болон 05-р сарын 21-нд аймгийн ЗДТГ болон холбогдох байгууллагуудад танилцуулж, санал авч тусган боловсруулалт хийсэн. Төлөвлөгөөний тодотголын тайланг аймгийн холбогдох нэгжүүд хянаж, цахим системд байршуулсан хувилбар дээр дүгнэлт гарган гүйцэтгэгчид хүргүүлснээр шаардлагатай засварууд хийгдэж, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн.Төслийн гүйцэтгэл 90 хувьтай байна.	
28	Хот суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 14 сумын хэмжээнд хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	90	Орон нутгийн төсвийн 345.8 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Аймгийн 14 сум, хот, тосгон болон бусад суурины нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийх” ажлын гүйцэтгэгчээр Инженер Геодизи ХХК шалгарч, нийт 66,253.2 га талбайд газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг хийж гүйцэж байна. Одоогоор суурин боловсруулалт болон хээрийн судалгааны ажил бүрэн хийгдэж дуусгаж, материал боловсруулалтын ажил хийгдэж байна. Тухайлбал Дорноговь аймгийн 14 сумын хот тосгон бусад суурин газарт мониторингийн 143 цэг, бохирдлын 160 цэг, тариалангийн газрын мониторингийн 17 цэг, хөрсний 22 цэгүүд дээр зүсэлт хийж, 160 цэг дээр ургамлын 1 бичиглэлийг хийсэн. Шинжилгээний хариуг үндэслэн сум тус бүрээр мониторингийн цэгийн дүгнэлтүүд гарсан тайланг нэгтгэх ажлыг хийж байна. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай.	90
29	Сайншанд сумын суурьшлын хэсгийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	0	ОНТ-ийн 276,0 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тендер шалгаруулалт цуцлагдсан. Тус ажлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07/01 дүгээр тогтоолоор баталсан “Дорноговь аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	0

30	Устсан геодезийн цэг тэмдэгтийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулах	Сэргээсэн цэгийн тоогоор	Тоо	2024	30	45	44	<p>Аймгийн хэмжээнд 2020 онд геодезийн цэг тэмдэгтийг орон нутгийн үндсэн хөрөнгөнд бүртгэхтэй холбогдуулан цэг тэмдэгтийн тооллогыг хийж гүйцэтгэсэн ба тооллогоор аймгийн хэмжээнд нийт 261 ширхэг геодезийн цэг тэмдэгт устсан үр дүн гарсан.</p> <p>Дээрх устсан цэг тэмдэгтийг сэргээн босгоход шаардагдах төсвийг орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг жил бүр тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал 2021-2024 онд Айраг- 3, Дэлгэрэх-15, Замын-Үүд-11, Сайхандулаан-15, Сайншанд-2, Хатанбулаг-5 нийт 51 цэг тэмдэгтийг нийт 74.5 сая төгрөгөөр сэргээн засварласан бол 2025 онд Айраг-4, Дэлгэрэх-10 нийт 14 цэг тэмдэгтийн 22.98 сая төгрөгөөр шинээр сэргээн засварласан. Аймгийн хэмжээнд 2025 оны устсан 15 цэгийг сэргээхээр төлөвлөж, тухайн жил нийт 14 геодезийн цэг тэмдэгтийг сэргээж, ажлын биелэлт 93.3 хувьд хүрсэн.</p>	93.3
31	Газрын бүртгэлийн нэгдсэн системд эзэмшил, ашиглалт, өмчлөлд олгогдсон газруудыг бүрэн хамруулж, нөхөн бүрдүүлэлт хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	50	100	90	<p>Аймгийн хэмжээнд 2003–2023 онд эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан захирамж, шийдвэрүүдэд хяналт шалгалт хийж, газрын бүртгэлийн нэгдсэн системд бүртгэгдээгүй нэгж талбаруудыг тодорхойлон нөхөн бүрдүүлэлт хийж байна. 2025 оны 10-р сарын байдлаар мэдээллийн санд бүртгэлгүй байсан 29 нэгж талбарыг шинээр бүртгэж, газрын эрхийн мэдээллийг бүрэн болгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.</p>	80
32	Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын суурьшлын бүс, Дэлгэрэх, Улаанбадрах сумдад Төрийн албан хаагчийн орон сууц барих ажлыг үргэлжлүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Орон нутгийн төсвийн 2,247.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын суурьшлын бүс, Дэлгэрэх болон Улаанбадрах сумдад төрийн албан хаагчдын зориулалттай нийт 20 айлын орон сууц барих ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. Ханги боомтод 8 айлын орон сууцыг “БЭМЭС” ХХК 1,171.1 сая төгрөгөөр барьж, 2025.07.09-ний УҚД-15/2025 дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Дэлгэрэх суманд төрийн албан хаагчдын 6 айлын орон сууцыг “Дэлгэр цамхаг өргөө” ХХК 608.6 сая төгрөгөөр гүйцэтгэж, 2025.09.03-ны УҚД-22/2025 дүгнэлтээр ашиглалтад хүлээлгэн өгсөн. Улаанбадрах суманд 6 айлын орон</p>	100

								сууцыг “Зэс-Орд” ХХК 467.0 сая төгрөгийн санхүүжилтээр барьж, 2025.08.07-ны УҚД-21/2025 дүгнэлтээр ашиглалтад оруулсан бөгөөд бүх барилгууд төлөвлөгөөний дагуу ашиглалтад орсон.	
33	Түрээсийн орон сууц төслийг хэрэгжүүлэх	Түрээсийн орон сууцанд хамрагдсан өрх	Тоо	2024	30	161	174	Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Мандах наран-6 хорооллын 288 айлын орон сууцнаас Орон нутгийн хөгжлийн сангийн 15.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 144 ширхэг орон сууцыг худалдан авч, 105 айлд түрээсээр олгож, 39 айлыг төрийн албан хаагчдад “түрээсийн орон сууц”-ны ангиллаар олгох төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Мөн Сайншанд сумын 7 дугаар багийн Мандах наран-7 хорооллын 288 айлын орон сууцнаас Орон нутгийн хөгжлийн сангийн 21.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 144 ширхэг орон сууцыг худалдан авахаар гэрээ байгуулан төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	100
34	"Мандах наран орон сууцны хороолол" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Төсөлд хамрагдсан өрх	Тоо	2024	288	576	576	Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Мандах наран-6 хорооллын 288 айлын орон сууцыг “Гантулга трейд” ХХК барьж, 2025 оны УҚД-28/2025 дугаартай дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Төслийн хүрээнд Сайншанд сумын 7 дугаар багийн Мандах наран-7 хорооллын 288 айлын орон сууцыг мөн “Гантулга трейд” ХХК гүйцэтгэж, барилгын үндсэн хийц бүтээцийн ажил дуусаж, дотор ханын шавардлага болон гадна метал фасадын ажил үргэлжилж байна. Ажлын гүйцэтгэл 70%-тай байна.	100
35	УБТЗ-ын ХНН-тэй “Говийн төмөр замчин орон сууцны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлэх	Гүйцэтгэлийн хувь	Хувь	2024	0	30	70	“Говийн төмөр замчин” 180 айлын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд архитектур төлөвлөлтийн даалгавар олгож, Ньюкон ХХК-ийн боловсруулсан NC-06/2025 шифртэй ажлын зургийг хянан баталж хүргүүлсэн бөгөөд барилгын хөгжлийн төвийн 2025 оны 1955/2025 дугаартай нэгдсэн магадлал хийгдсэн. Төслийн гүйцэтгэл одоогоор 70%-тай байна.	100
36	Сайншанд сумын 8 дугаар багийн Холбооны 4,5,6 дугаар гудамжаар бохир усны шугам татах ажлыг үргэлжлүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн хөгжлийн сангийн 526,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 8 дугаар багийн 4, 5, 6 дугаар гудамжаар бохир усны шугам татах ажлыг “Эгнэгт өрнөх” ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100

37	Сайншанд сумын 6 дугаар багийн Шинэ зууны гудамжны Офицерын 80-н айлын 3-н замын уулзвараас Газрын тосны үйлдвэрийн орон сууц хүртэлх 2.0 км хатуу хучилттай авто замд засвар шинэчлэлт хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	80	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 6 дугаар багийн Шинэ зууны гудамжны Офицерын 80 айлын 3-н замын уулзвараас Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын орон сууц хүртэлх 2.0 км авто замын засвар шинэчлэлтийн ажлыг “Дэлгэр баясах зам” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл одоогоор 80%-тай үргэлжилж байна.	80
38	Сайншанд сумын 4 дүгээр баг 34,154 дүгээр байрны зүүн талаар төв замаас Төмөр замын нүхэн гарц хүртэл 0.42 км хатуу хучилттай авто зам барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	0	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2025 оны аймгийн төсөвт тодотгол орж, эх үүсвэргүй болсон.	0
39	Сайншанд сумын 6-р багийн 3.6 км авто замыг үргэлжлүүлэн Дэнжийн пост руу холбож авто зам барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	99	100	100	Орон нутгийн төсвийн 3.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 6-р багийн 3.6 км авто замыг Дэнжийн пост руу холбох ажлыг “Дэлгэр баясах зам” ХХК гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 100%-тайгаар дуусгаж, байнгын ашиглалтад хүлээн авсан.	100
40	Хүүхдийн парк руу авто зам тавьж зогсоол байгуулах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн төсвийн 567.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүүхдийн парк руу 450м авто зам тавьж зогсоол байгуулах ажлыг “Дэлгэр баясах зам” ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтад хүлээн авсан.	100
41	Сайншанд сумын 3-н замын уулзвараас Зүүнбаян багийн авто замыг холбох 1км хатуу	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 3-н замын уулзвараас Зүүнбаян багийн авто замыг холбох 1 км хатуу хучилттай авто замыг “Борхойн зам” ХХК гүйцэтгэж, ажлыг дуусган байнгын ашиглалтад хүлээн авсан.	100

	хучилттай авто зам барих								
42	Сайншанд сумын 7 дугаар баг "Тэс петролиум" ШТС-ын 3-н замын уулзварын тойргийн өргөтгөл хийж авто зам барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	99	100	100	Орон нутгийн төсвийн 175.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7 дугаар баг "Тэс петролиум" ШТС-ын 3-н замын уулзварын тойргийн өргөтгөл хийж авто зам барих ажлын тендерт "Дэлгэр баясах зам" ХХК шалгаран гүйцэтгэж 2024 оны 06 сард ашиглалтад оруулсан. Тус ажлын санхүүжилтийг 2024-2025 онд санхүүжүүлэхээр аймгийн 2024 оны төсөвт баталсан тул гэрээний дагуу 2024 онд 119.4 сая төгрөгийг, 2025 онд 56.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.	100
43	Сайншанд сумын 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш үргэлжлэх авто замаас "Мандах наран-5 хороолол" хүртэлх 0.16 км авто зам барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	99	100	100	Орон нутгийн төсвийн 313.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш үргэлжлэх авто замаас "Мандах наран-5 хороолол" хүртэлх 0.16 км авто замын барилга угсралтын ажлыг "Дэлгэр баясах зам" ХХК гүйцэтгэж 2024 оны 06 сард ашиглалтад оруулсан. Тус ажлын санхүүжилтийг 2024-2025 онд санхүүжүүлэхээр аймгийн 2024 оны төсөвт баталсан тул гэрээний дагуу 2024 онд 230.0 сая төгрөгийг, 2025 онд 83.4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.	100
44	Замын-Үүд чиглэлд төмөр замын гармаас Шунхлай ШТС хүртэл 2.8км гэрэлтүүлэг шинээр хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	99	100	100	Замын-Үүд чиглэлд төмөр замын гармаас Шунхлай ШТС хүртэл 2.8 км гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил орон нутгийн 671.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бөгөөд тендерт "Сонголт нар" ХХК шалгарч гүйцэтгэгчээр ажилласан. Улсын комисс 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдөр ажлыг ашиглалтад хүлээн авсан. Төсвийн санхүүжилт 2024-2025 онд шатлалтайгаар хийгдэхээр батлагдсан ба гэрээний дагуу 2024 онд 287.3 сая, 2025 онд 384.3 сая төгрөгийг олгохоор тусгагдсан. Ажлын үр дүнд төмөр замын гарам болон холбогдох замын аюулгүй байдал сайжирч, шөнийн хөдөлгөөнийг гэрэлтүүлгээр хангасан.	100
45	Сайншанд сумын 1, 6, 7 дугаар баг "Тэс петролиум" ХХК-ийн ШТС-ын тойргоос	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	99	100	100	Сайншанд сумын 1, 6, 7 дугаар багт "Тэс петролиум" ХХК-ийн ШТС-ын тойргоос офицерын төв зам хүртэлх 3.6 км авто замын гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил орон нутгийн 595.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бөгөөд гүйцэтгэгчээр	100

	офицерын төв зам хүртэлх 3.6 км авто замын гэрэлтүүлэг хийх							"Насака" ХХК ажилласан. Ажлыг 2024 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан. Санхүүжилт нь 2024-2025 онд шатлалтайгаар хийгдэж, гэрээний дагуу 2024 онд 400.0 сая, 2025 онд 195.1 сая төгрөгийг олгосон.	
46	Алтанговийн 3 дугаар гудамж "12 Худалдаа" үйлчилгээний төвөөс Дүүдэй баатар-6 гудамж хүртэл авто зам дагуу явган хүний зам барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Алтанговийн 3 дугаар гудамж дахь "12 Худалдаа" үйлчилгээний төвөөс Дүүдэй баатар-6 гудамж хүртэлх авто зам дагуу явган хүний зам шинээр барих ажил орон нутгийн 175.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, гүйцэтгэгчээр "Айсуй хөгжил" ХХК ажилласан. Ажлыг 2025 оны АЗ-03/2025 дугаартай дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.	100
47	Сайншанд сумын 5-р 58 айлын гадна авто зогсоол, үерийн далан байгуулах ажил	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн хөгжлийн сангийн 299,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 5-р 58 айлын гадна авто зогсоол, үерийн далан байгуулах ажлыг "Дэлгэр баясах зам" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж, ажлыг бүрэн гүйцэтгэн ашиглалтад хүлээн авсан.	100
48	Сайншанд сумын 2-р сургуулийн арын авто замыг П хэлбэрийн автозамтай холбох ажил	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Сайншанд сумын 2-р сургуулийн арын авто замыг П хэлбэрийн автозамтай холбох ажил аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 812.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, гүйцэтгэгчээр "Дэлгэр баясах зам" ХХК ажилласан. Ажлын гүйцэтгэл 100%-тай.	100
49	Улаанбадрах, Эрдэнэ сумдад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж байгаа төвлөрсөн уурын зуух, инженерийн шугам сүлжээг орон нутгийн өмчид шилжүүлэн авах, шинэчлэх, засварлах ажил	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	50	50	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах, Эрдэнэ сумдад баригдсан Халаалтын зуух, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг орон нутагт шилжүүлэн авах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны өдрийн А/216 дугаар захирамжаар байгуулсан. Тус ажлын хэсэг 2025 оны 05-р сарын 19-ний өдөр Улаанбадрах суманд ажиллаж зуух, инженерийн шугам сүлжээний үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үзлэгийг зохион байгуулсан. Улаанбадрах суманд "Сүлд үнэлгээ" ХХК-тай хөрөнгө үнэлэх гэрээ байгуулж, бодит үнэлгээг тогтоолгохоор ажиллагаа хийгдэж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан мэргэжлийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг Улаанбадрах,	100

								<p>Эрдэнэ сумдад 08 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд ажиллаж, сумдын төвлөрсөн уурын зуух, инженерийн шугам сүлжээний бодит нөхцөл байдалд үзлэг шалгалт хийж, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон албан газар, аж ахуйн нэгж, ард иргэдийн төлөөлөлтэй уулзалт хийж, тайланг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулсан.</p> <p>Уг ажлын үр дүнд Улаанбадрах сумын төвлөрсөн халаалтын зуух, нэгдсэн шугам сүлжээг Чандмань-Илч ХХК-д хариуцуулж, халаалтын зуухны шинэ эх үүсвэр барих хөрөнгийг шийдвэрлэсэн.</p> <p>Мөн Эрдэнэ сумын Онцгой комисст төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Сумдын халаалтын зуух, тоноглол, шугам сүлжээг шинэчлэх ажлыг 9, 10-р сард гүйцэтгэж дуусган, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан.</p>	
50	Сайншанд сумын дахин төлөвлөлтийн бүсэд инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинээр барих ажил	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Сайншанд сумын дахин төлөвлөлтийн бүсэд инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинээр барих ажил аймгийн ОНТ-ийн 1.091 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, нийт 10 байршилд 1726 м хос дулааны шугамыг өргөтгөн шинэчилж, дулаан дамжуулах төвүүдийг тоноглон, шаардлагатай хаалт, арматурыг солих ажлыг “Чандмань Илч” ОНӨХХК 100% гүйцэтгэлтэй хийж дуусгасан. Үр дүнд нь дахин төлөвлөлтийн бүсийн халаалт, инженерийн сүлжээний найдвартай ажиллагаа сайжирч, хэрэглэгчдийг дулаанаар тогтвортой хангах нөхцөл бүрдсэн.</p>	100
51	Залуус хорооллын орон сууцны гадна фасад /31,32, 36 дугаар байрууд/ засварын ажил	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Орон нутгийн хөгжлийн сангийн 705.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Залуус хорооллын орон сууцны гадна фасад /31, 32, 36 дугаар байрууд/ засварын ажлыг Дэлгэр баян хүлэг ХХК гүйцэтгэж байна. Барилгуудын 2-5 давхрын гадна заслын ажил бүрэн дууссан. 1 дүгээр давхарт файбер хавтан өнгөлгөө хийх ажил үргэлжилж байна. Ажлын гүйцэтгэл 100%-тай.</p>	100
52	Сайншанд, Замын-Үүд сумдад “Garden city” төслийг	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Сайншанд, Замын-Үүд сумдад “Garden City” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл, эхлэл ажлууд хийгдэж байна. Замын-Үүд суманд 3 га газарт хэрэгжүүлэх төслийн зураг төслийг “ИЗНЭГ” ХХК боловсруулж</p>	100

	хэрэгжүүлэх төлөвлөлтийг гаргаж, зарим ажлыг эхлүүлэх							байгаа бөгөөд Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-аас Сүлд багт 2 га, Соёмбо багт 1 га газарт болон авто замын хамгаалалтын 2 км бүсэд нийт 10 нэр төрлийн 10,172 мод тарьж ногоон байгууламжийг 5 га-аар нэмэгдүүлсэн. Шинэ суурьшлын бүсэд “Urban House” ХХК 8 гудамж, 256 айлын эрчим хүчний хэмнэлттэй HYBRID хувийн орон сууцны архитектур төлөвлөлтийг боловсруулж байна. Сайншанд сум “Garden City” төлөвлөгөөнд нийтийн эзэмшлийн 6 байршил, 35 км зам дагуу 350 мянган хайлаас, мөн 3 байршилд цэцэрлэгт хүрээлэн байгуулж 6,300 мод тарих төлөвлөлт гарган ИТХ-аар батлуулсан. Түүнчлэн “Хотын стандарт” өдөрлөг зохион байгуулж, модны суулгац, эко ариун цэврийн байгууламж, цахилгаан халаагуур, Пассив хаус зэрэг шийдлүүдийг танилцуулсан. “Ногоон барилга”-ын стандартыг нэвтрүүлэх зорилгоор 24 орон сууцны хорооллын суурь судалгаа гаргаж, 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахаар бэлдсэн.	
53	Сайншанд,Замын-Үүд суманд хувийн хэвшилтэй хамтран шинэ суурьшлын бүсэд “ECO”, “HYBRID”, “HOUSE TOWN” амины орон сууцны хороолол байгуулах судалгааны ажлыг хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Сайншанд, Замын-Үүд сумдад хувийн хэвшилтэй хамтран “ECO”, “HYBRID”, “HOUSE TOWN” амины орон сууцны хороолол байгуулах судалгаа, төлөвлөлтийн ажил үргэлжилж байна. Замын-Үүд сумын 3-р багт иргэний газарт эрчим хүчний хэмнэлттэй “ECO” загварын 4 давхар, 12 айлын орон сууцны барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг олгож, зураг төсөв боловсруулах шатанд ажиллаж байна. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Urban House” ХХК 256 айлын HYBRID амины орон сууцны архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан Замын-Үүд сумын хүргүүллээ. Мөн Сайншанд сумын 6-р багийн иргэний эрчим хүчний хэмнэлттэй 3 блок, 12 айлын орон сууцны архитектур төлөвлөлтийн даалгавар болон загвар, ажлын зургийг баталж, барилгын ажил эхэлсэн бөгөөд гүйцэтгэл 75%-тай байна.	100
54	Замын-Үүд сумыг “SMART CITY” болгох ажлыг	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Замын-Үүд сумыг “SMART CITY” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээг цахимжуулах, боомтын үйл ажиллагаанд ухаалаг	100

	эхлүүлж төрийн үйлчилгээг цахимжуулах							систем нэвтрүүлэх ажлууд хийгдэж байна. Зорчигч тээврийн терминалд импортын 24, экспортын 30 буюу нийт 54, харин ачааны терминалд экспортын 11, импортын 28 буюу нийт 39 байршилд ухаалаг гарцын төхөөрөмж суурилуулж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж байна. Явган зорчигчдын орох, гарах хэсэгт тус бүр 4 цахим гарц ажиллуулснаар тайлант хугацаанд 211,393 иргэн үйлчлүүлж, тэднээс 42,278 нь цахим паспортаар зорчсон нь өнгөрсөн оны мөн үеэс 25 хувиар өссөн дүнтэй байна. Мөн өрхийн хэрэглээний усны менежментийг сайжруулах зорилгоор нийтийн орон сууцны 500 хэрэглэгчийн шугам хоолойд ухаалаг усны тоолуур суурилуулах төслийг Юнител групптэй хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 45%-тай явж байна.	
55	Замын-Үүд хилийн боомт дээр үйл ажиллагаа явуулж буй Авто тээврийн Үндэсний төв, Хилийн шалган нэвтрүүлэх цэг, Гааль, хорио цээрийн бүртгэл, дардасжуулах ажиллагааг цахимжуулах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	80	100	100	<p>Замын-Үүд хилийн боомтын үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд Авто тээврийн үндэсний төв, Хилийн шалган нэвтрүүлэх цэг, Гааль болон хорио цээрийн бүртгэл, дардасжуулах процессыг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж байна.</p> <p>Замын-Үүд сумын ЗДТГ нь HiPay болон Тоффика компаниудтай хамтран 2025 оны 4 дүгээр сарын 5-наас бичил бизнес эрхлэгчдийн татварын төлөлтийг бүрэн цахимжуулснаар орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 127.4%-иар өсөж, 837,0 сая төгрөг төвлөрүүлсэн.</p> <p>Зорчигч тээврийн терминалын импортын 24, экспортын 30 буюу нийт 54, ачааны терминалын экспортын 11, импортын 28 буюу нийт 39 байршилд ухаалаг гарцын систем суурилуулан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж байна. Мөн зорчигчдын орох, гарах хэсэгт тус бүр 4 цахим гарцын төхөөрөмж суурилуулснаар цахим паспортаар саадгүй нэвтрэх нөхцөл бүрдсэн.</p>	100
56	Улс хооронд тээвэрлэлт хийж буй хүнд даацын авто тээврийн хэрэгслийг цахимаар бүртгэх машины зогсоол,	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	80	100	100	<p>Улс хооронд тээвэрлэлт хийж буй хүнд даацын автомашины нэвтрэлтийг сайжруулах хүрээнд боомтын дарааллын системийг цахимжуулж, камержуулалтын шийдлүүдийг нэвтрүүлжээ. Суудлын автомашины нэвтрэлтийг хурдасгах зорилгоор Хилийн хаалтын 3-н хаалтан дээр автомашины улсын</p>	100

	дарааллын системд камер, мэдрэгч төхөөрөмжүүдийг ашиглан хилийн боомтын нэвтрэлтийг сайжруулах							дугаар унших төхөөрөмжийг 78.0 сая төгрөгөөр суурилуулсан. Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгчид Авто тээврийн үндэсний төвийн D, C ангиллын бичгийг transdep.bizpro.mn системээр цахимаар авах боломжтой болсон. Мөн гаалийн gaali.mn системээр хүнд даацын автомашины бүртгэлийг камер, мэдрэгч төхөөрөмжөөр автомат уншуулах хэлбэрт шилжүүлснээр орох чиглэлд 88,720, гарах чиглэлд 82,650 автомашин бүртгэгдэж, боомтын нэвтрэх хүчин чадал нэмэгдсэн.	
57	Шилжин суурьшигчдын тоог нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх	Шилжин ирсэн хүний тоо	Тоо	2024	788	800	813	Монгол Улсын Засгийн газрын "Шинэ сэргэлт бодлого"-ын баримт бичгийн "Хөдөөгийн сэргэлт" зорилтын хүрээнд төрийн албан хаагчийг орон сууцжуулах хөтөлбөрөөр эрүүл мэндийн салбарын албан хаагчид болон хөдөө орон нутагт ажиллахаар ирсэн нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттайгаар орон сууцжуулах ажлыг хэрэгжүүлж байна. Шилжин суурьшигчдын тоог нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсээс "Бүрэн бүртгэл" аяныг санаачлан хэрэгжүүлж аймгийн хэмжээнд шилжин суурьшигчдын тоог нэмэгдүүлэхээр удирдамж, ажлын нарийвчилсан төлөвлөгөө, аргачилсан загвар зэргийг боловсруулан ажилласан. Аймгийн хэмжээнд 2025 оны 11 сарын байдлаар нийслэл болон бусад аймаг орон нутгаас 813 иргэн шилжин ирсэн. Шилжин ирсэн иргэн 2024 оны мөн үетэй харьцуулахад 85 иргэн буюу 10.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
58	Гадаадад болон бусад орон нутагт ажиллаж амьдарч байгаа залуучуудыг аймагтаа хэрэгцээт салбарт манлайлан ажиллахад чиглэсэн цогц арга	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хувь	2024	0	50	40	Гарааны бизнесийг хөгжүүлэх зорилгоор аймгийн "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төв" гарааны бизнесээ хөгжүүлэх, олон нийтэд түгээх маркетингийн сургалтыг хувиараа бизнес эрхлэгч 17 залууг хамруулан зохион байгуулсан. Мөн ажилгүй, ажил хайгч, сонирхогч иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 15-34 насны 72 иргэнийг хамруулан хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийх, сул чөлөөтэй ажлын байрны захиалга танилцуулга, холбон зуучлах богино	80

	хэмжээг хэрэгжүүлэх							хугацааны сургалтын бүртгэлийн мэдээллээр хангаж, 32 иргэнд ганцаарчилсан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад бизнес санааг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээлэл хүргэх зорилгоор 2024 онд санхүүгийн дэмжлэг авсан “Little paws” жижиг амьтны эмнэлгийн үйл ажиллагааны богино бичлэг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан залуу үйлдвэрлэгч “Содон бургер” цехийн үүсгэн байгуулагчтай ярилцлага хийж тус тус цахим хуудсаар дамжуулж, 2800 үзэгчдийн хандалт авсан. Залуучуудыг орон нутагтаа ажиллах нөхцөл байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 40%-тай байна.	
59	Орон нутаг шилжин суурьших иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Олгосон зээл, мөнгөн дүн	Тоо	2024	49	52	59	Орон сууцжуулах бодлогыг дэмжиж ажиллах хүрээнд аймгийн хэмжээнд Залуу гэр бүл болон Улаанбаатар хотоос шилжин суурьшихаар ирсэн иргэдэд ипотекийн 3 хувийн хүүтэй зээлийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ний байдлаар өссөн дүнгээр 59 иргэнд 6.7 тэрбум төгрөг, 6 хувийн хүүтэй зээлийг 36 иргэнд 6.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон.	100
			сая.төг	2024	4.2 тэрбум	5	6.7		
Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн дундаж үнэлгээ:									90.7
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
60	Гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүйн боловсрол, үүрэг хариуцлага, ёс зүй, үнэ цэнийг эрхэмлэн дээдлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэд	Тоо	2024	3/ 5000	5//8000	18/ 8062	Гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн боловсрол олгох, эерэг харилцаа хандлагыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран 52 охидод “Өсвөр насны охидын сэтгэл зүйн онцлог” сэдэвт сургалт, 10 охид ээжүүдэд “Ээжийгээ ойлгоё, охидоо сонсьё” сэдэвтэй ээж охидод зориулсан бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, сургалт, Хараацай цэцэрлэгийн 230 эцэг эхчүүдэд “Эерэг хүмүүжлийн арга”, “Хайрын хэл” сургалт, “Хөөрхөн зүрх” ТББ-тай хамтран 120 эмэгтэйд “Өөрийгөө хайрлахуй” сэдэвт сэтгэл зүйн сургалт, Сайншанд	100

								<p>сумын ИТХ-аас 50 тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан “Хамтдаа гоё” арга хэмжээг тус тус зохион байгуулж, 462 эцэг эхчүүдийг хамруулан мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөө үзүүллээ.</p> <p>Мөн гэр бүлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх ажлын хүрээнд “Боловсрол гэр бүлээс эхэлдэг” гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөрийг аймгийн 8 баг, 14 сумын хэмжээнд хэрэгжүүлж 1100 иргэн, “Бүх хайраа гэр бүлдээ” уриа дор эцэг эх, асран хамгаалагчид болон хүүхдүүдийг хамруулсан нөлөөллийн 6 арга хэмжээг 14 суманд зохион байгуулж давхардсан тоогоор 6500 иргэнийг хамруулжээ.</p> <p>Тайлант хугацаанд хүүхэд, гэр бүлд чиглэсэн нийт 18 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 8062 иргэдийг хамруулан гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа хандлагыг төлөвшүүлж, сэтгэл зүйн боловсрол олгож, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн.</p>	
61	“Говийн Дорнын Айл” Монгол гэрийн онолд суурилсан хувь хүний хөгжлийн төслийг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	0	100	80	<p>Иргэдийн хувь хүний хандлагад эергээр нөлөөлж, аймгийн хүүхдийн хөгжлийн бодлогыг өрх бүлгийн зүгээс дэмжих зорилгоор “Говийн Дорнын Айл” Монгол гэрийн онолд суурилсан хувь хүний хөгжлийн хөтөлбөрийг 5 зорилт 12 арга хэмжээний хүрээнд боловсруулан хэрэгжилт 80%-тай байна.</p> <p>Боловсролын сайдын 2025 оны А/77 дугаар тушаалаар “Малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих” арга хэмжээг баталсны дагуу өөрийн орон нутгийн онцлогт тохируулан Мандах, Сайхандулаан сумдад Залуу гэр бүлийн чуулган “Өөрчлөлтийг өөрөөсөө” сэдэвт сургалтыг 52 иргэнд, малчдын чуулганд “Харах өнцгөө өөрчилж хамтдаа хөгжье” сургалтыг 68 малчдад хүргэж ажиллалаа.</p> <p>Мөн аймгийн хэмжээнд зуд, өвөлжилт хүндрэлтэй айлуудад гарын авлага болон хувь хүний хөгжлийг дэмжих ном, зурагт хуудас зэргийг тараан мэдээллээр хангаж нийт 5 чиглэлээр 532 малчин иргэнд хүрч ажиллалаа.</p> <p>Даланжаргалан сумын малчин иргэдэд санхүүгийн боловсролын чадамж олгох сургалтыг 42</p>	80

								иргэнд, 14 сумын 210 өрхийн 412 иргэнд цахим лавлагаа авах сургалт мэдээллийг хүргэсэн. Насан туршийн суралцахуйн төвийн гэр бүлийн сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө ярилцлага хийх, зохистой хооллолт, гэр бүл төлөвлөлтийн сургалт зохион байгуулах сургалтын танхимыг НҮБ-н 8,2 сая төгрөгийн санхүүжилтээр тохижуулж гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр олон талт сургалтыг тухтай зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүллээ.	
62	Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг идэвхжүүлэх	Эцэг, эхийн зөвлөлийн тоо	Тоо	2024	144	150	152	Аймгийн хэмжээнд эцэг эхийн зөвлөлтэй 152 байгууллагаас Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг боловсруулж батлуулсан 60 байгууллага байгаа бөгөөд 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувьтай байна. Шинээр 8 эцэг эхийн зөвлөл нэмэгдэж, 5 байгууллага шинээр хүүхдийн өрөө засаж тохижуулснаар өссөн дүнгээр нийт 152 эцэг эхийн зөвлөл, 85 байгууллага хүүхдийн өрөөтэй болж ажилтан албан хаагчдын хүүхдүүдэд амрах, тоглох, гэрийн даалгавраа хийх, хөгжих ая тухтай орчныг бүрдүүлсэн. Төрийн болон хувийн хэвшлийн 136 байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор байгууллагынхаа ажилтан албан хаагчдын хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон "Хөгжилтэй буухиа", "Бяцхан дуучин", "Авьяаслаг бүжигчин", "Уран уншигч", "Дугуй", "Гүйлт", "Шатар", "Даам", "Сагсан бөмбөгийн 3*3", "Open mic" зэрэг 12 төрлийн үйл ажиллагааг насны ангиллаар зохион байгуулж давхардсан тоогоор 17,000 гаруй хүүхдийг хамруулж хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүллээ. Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 10 удаагийн сургалт, арга хэмжээнд 469 иргэнийг хамруулан гэр бүл дэх хүүхэд хамгаалалд асран хамгаалагчийн хуулиар хүлээсэн үүрэг оролцоо болон хүүхдийн эрх, хамгааллын хууль эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлсэн.	100
63	Мэргэжлийн сэтгэл зүйчдийг бэлтгэж,	Сэтгэл зүйчийн тоо	Хувь	2024	5	7	17	Гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, үйлчилгээний чанар хүртээмжийг	100

	<p>гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх</p>						<p>нэмэгдүүлэх зорилгоор сэтгэл зүйн үйлчилгээ авах шаардлагатай 5 иргэн, 8 хүүхдийг мэргэжлийн сэтгэл зүйч рүү холбон зуучилж, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй, ар гэрийн анхаарал халамж сул 10-16 насны 30 хөвгүүдийг хамруулан англи хэл, сайн дурын ажил болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх "Боловсролоор үлгэрлэе" 100 хоногийн нөлөөллийн сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар 2025 оны 09 дүгээр сараас мэргэжлийн 2 сэтгэл зүйчийг томилон ажиллуулж, 30 хүүхэд 7 эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлсэн бөгөөд үйлчилгээний үр дүнд сэтгэл санааны тогтвортой байдлаа хадгалах, стресс дарамтыг даван туулах, бусадтай харилцах чадвараа сайжруулах чадварт суралцлаа.</p> <p>Эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд дээрх сэтгэл зүйн болон сургалт, нөлөөллийн үйлчилгээ үзүүлснээр гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй нөхцөл байдлыг бууруулж, тэдний нийгэмд өөрийгөө илэрхийлэх боломжийг нэмэгдүүллээ.</p> <p>Мөн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Зүүнбаянгийн сургуулийн сэтгэл зүйчид мэргэшүүлэх 45 хоногийн сургалтад, Сайншанд сумын 2 дугаар сургуулийн сэтгэл зүйч "Гэрэлт эргэлт" хөтөлбөрийн сургалтад, нийт 3 сэтгэл зүйч сургалтад хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн бөгөөд аймгийн ерөнхий боловсролын 13 сургууль, хүүхдийн 2 цэцэрлэг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангагдсан нь өмнөх оноос боловсролын байгууллагын сэтгэл зүйчид 8-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 3 хүүхдийг хяналтад авч, хууль эрх зүй, сэтгэл зүй, хүмүүжил, хандлага зан үйл сургалтыг тогтмол зохион байгуулан, эцэг эх асран хамгаалагчидтай нууцын болон хариуцлагын гэрээг байгуулан хяналт тавин ажиллалаа.</p> <p>Тайлант хугацаанд ерөнхий боловсролын сургуулиудын 13, хүүхдийн цэцэрлэгийн 2, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2 сэтгэл зүйч, нийт 17 сэтгэл зүйч сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 1887</p>	
--	--	--	--	--	--	--	---	--

								суралцагчид, ганцаарчилсан зөвлөгөөг 996 багш, суралцагчид, сэтгэл зүйн сургалтыг 12726 хүнд хүргэж, нийт давхардсан тоогоор 15609 хүнд үйлчилгээ үзүүлсэн.	
64	Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх	Хүүхэд харах үйлчилгээний төвийн тоо	Тоо	2024	0	2	1	<p>Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах төр болон хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих ажлын хүрээнд Хатанбулаг сум дахь Хилийн цэргийн 0168 дугаар ангийн 3 заставд ажиллаж амьдарч байгаа албан хаагчдын гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийг эрсдэлт хүчин зүйлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, сурч хөгжих, эрхийг хангах хэрэгцээ шаардлагын дагуу Хатанбулаг сумын Засаг даргын 2024 оны А/149 дүгээр захирамжаар хүүхэд харах үйлчилгээний зөвшөөрлийг 0168 дугаар ангид олгож, 4 сургагч багшийг бэлтгэж, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас үйл ажиллагаанд 34,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хүүхэд харах тогтмол үйлчилгээнд энэ оны 5 дугаар сар хүртэл 17 хүүхдийг хамруулан сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг дэмжин, 4 иргэнийг ажлын байраар хангаж, 6 асран хамгаалагч ажил хөдөлмөр эрхэлж байна.</p> <p>Мөн Эрдэнэ сумын Хилийн 0129 дүгээр ангийн 2 заставд 10 хүүхдэд хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан ч бэлтгэгдсэн сургагч багш байхгүйн улмаас үйл ажиллагааг эхлүүлээгүй байна.</p>	50
65	Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын гэр бүлийн төлөөх санал санаачилга, сайн дурын идэвхтнийг дэмжих	Зохион байгуулсан арга хэмжээ	Тоо	2024	0	1	5	<p>Гэр бүлийн гишүүдийн ёс зүй, үүрэг хариуцлага үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ахмадын хороотой хамтран 25-аас дээш жил амьдарсан 11 ахмад гэр бүлийг алдаршуулах алтан хуримын ёслолын "Ханьсахын жаргал" арга хэмжээ, ахмадын "Нумт" шагайн клубтэй хамтран 35 гэр бүлийн шагайн харвааны "Аргайн хосууд" арга хэмжээг тус тус зохион байгуулж, 2,6 сая төгрөгийг шийдвэрлэсэн.</p> <p>Мөн Юнител групптэй хамтарсан "Unitel hub" сургалт, уран нугаралт, шатар, англи хэл, мэтгэлцээний дугуйлан болон дууны дугуйлан зэрэг хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжин "Хүүхдийн хөгжлийн төв"-д өрөө, танхимаар ханган ажилласан. Ерөнхий боловсролын 2, 5 дугаар сургуулийн "Говийн</p>	100

								<p>уянга", "Болор-Эгшиглэн" хамтлагийн хамтарсан "Уран бүжиг-Яруу хөгжим" тоглолт, Жюү жцүгийн "Дорноговь опен" нээлттэй тэмцээн, Magic Dance бүжгийн клубийн "Бүжиг-хайр, азжаргал" тоглолтыг тус тус Хүүхдийн ордонд үнэ төлбөргүй зохион байгуулж, иргэд олон нийтийн хүртээл болголоо.</p> <p>Өсвөр насны хөвгүүдэд зориулсан "Боловсролоор үлгэрлэе" нөлөөллийн арга хэмжээг "Өгөх урлаг" ТББ-тай хамтран 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ар гэрийн анхаарал халамж сул, гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 14-18 насны зорилтот бүлгийн хөвгүүдэд Англи хэл, Сэтгэл зүйн үйлчилгээ, Сайн дурын ажил гэсэн чиглэлээр 7 хоногт 6 өдрийн 12 цагийн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 30 хүүхдийг хамруулж, тайлан болох төсөл дээр ажилласан 4 багшийн тэмдэглэл судалгаан дээр үндэслэн 200 ном хэвлүүлсэн.</p> <p>Мөн "Угийн бичиг удмын хэлхээ" сургалтыг Сайншанд сумын 120 ахмадыг хамруулан зохион байгуулж, 3,8 сая төгрөгийг шийдвэрлэсэн бөгөөд сургалтын үр дүнд угийн бичгийн уламжлалыг хадгалах, хойч үедээ өвлүүлэх соёлыг төлөвшүүллээ.</p> <p>Тайлант хугацаанд иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын гэр бүлийн төлөөх 5 арга хэмжээг зохион байгуулж, дэмжлэг үзүүллээ.</p>	
66	Орон нутгийн хүүхэд хөгжил, хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын үүрэг хариуцлага, чадамжийг нэмэгдүүлэн, салбар дундын уялдаа холбоо, үр нөлөөг сайжруулах	Сургалт, сургалтад хамрагдсан хүн	тоо	2024	2/ 199	4/ 300	10/469	<p>Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг аймгийн бодлогын баримт бичигтэй уялдуулан баталсан.</p> <p>Орон нутгийн хүүхэд хөгжил, хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын үүрэг хариуцлага, чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөг 5 зорилт, 17 арга хэмжээтэй төлөвлөсөн бөгөөд хүүхдийн төлөө зөвлөлийн хурлыг 1, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хурлыг 3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн салбар зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 88.2 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	100

							<p>Хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Цагаан шугам, ногоон гэрэл", "Өсвөрийн сэргийлэгч-2025", Хүүхдийн зуслангийн тохижилт мод тарих арга хэмжээ, "Мини робот" өсвөрийн зохион бүтээгчдийн тэмцээн, "Хамтдаа гоё" зэрэг 20 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 16100 гаруй хүүхэд багачууд, эцэг эх, асран хамгаалагчдыг хамрууллаа.</p> <p>Мөн хүүхдийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Хүүхэд эрхэм хэрэглэгч", Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр, Хүүхдийн төлөө утас-108 өдөр, Олон улсын гэр бүлийн өдрийн хүрээнд 25 удаагийн арга хэмжээг 14 суманд зохион байгуулж 2100 асран хамгаалагч, 3450 хүүхэд, өсвөр үеийг хамрууллаа.</p> <p>Хүүхдийн хөгжил, хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор 10 удаагийн сургалтыг зохион байгуулж, 469 иргэнийг хамруулсан.</p> <p>Мөн салбар дундын уялдаа холбоо, үр нөлөөг сайжруулах ажлын хүрээнд "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Асран хамгаалагчийн үүрэг оролцоо", "Хамтын шийдэл-Үр дүнд суурилсан хариу үйлчилгээ" сэдэвт чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулж нийт 27 хамтарсан багийн 165 гишүүнийг хамруулан аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын 2025 оны А/79 дүгээр тушаалаар 10,8 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Уг сургалтаар хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үеийн журам, арга зүй, байгууллагуудын уялдаа холбооны талаар мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлж, бодит нөхцөлд хэрэгжүүлэх аргачлал эзэмшсэн.</p>		
67	"Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн "Child future" хүүхдийн хөгжил, хамгааллын	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2024	88	90	91.7	<p>"Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн "Child future" хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/558 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулан "Эерэг хандлага-Зөв дадал" хүүхдийн эрхийг хамгаалах нөлөөллийн аяны төлөвлөгөөг 5 зорилт 59 арга хэмжээний дагуу</p>	100

	хөтөлбөр хэрэгжүүлэх							<p>баталсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 91.7 хувьтай байна.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалах нөлөөллийн аяны хүрээнд Ерөнхий боловсролын 1,2,3,5,6 сургуулийн дэргэд сэргийлэгч хүү, зөвлөгч охины дүрээр гэрэлтэгч самбарыг байршуулж, 1-4 ангийн 3500 сурагчийн цүнхэнд гэрэл ойлгогчтой наалтыг наасан бөгөөд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 63 төрийн байгууллага олон нийтийн эргүүлийг хуваарийн дагуу гүйцэтгэж хэвшлээ.</p> <p>Мөн Сайншанд суманд такси үйлчилгээ эрхэлж байгаа 3 компанийн 120 жолоочид замын хөдөлгөөний дүрмийн сургалтыг зохион байгуулж, такси үйлчилгээний стандартыг мөрдөж хэвшүүлэхийг үүрэг болголоо.</p> <p>Хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Бүтээлч ирээдүйг хамтдаа бүтээнэ" уран илтгэл, "Хайраар дүүрэн захиа" шүлгийн тэмцээн, "Өсвөрийн парламент", "Цагаан шугам, ногоон гэрэл", "Өсвөрийн сэргийлэгч-2025", "Мини робот" өсвөрийн зохион бүтээгчдийн тэмцээн, Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын арга хэмжээ, "Эх оронч үзэл-Үндэсний бахархал" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, "Хамтдаа гоё" зэрэг 20 арга хэмжээнд давхардсан тоогоор 16100 гаруй хүүхдийн тэгш оролцоог ханган оролцууллаа.</p> <p>Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх зорилгоор "Утаат болон электрон тамхины хор уршиг", "Цахим орчны хэрэглээ", "Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, аюулгүй байдал" сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 22 сургуулийн ахлах, дунд ангийн 4500 сурагч, 1800 эцэг эх, асран хамгаалагч, Политехник коллежийн 550 оюутан, 56 багш ажилчид, 14 сумын 27 хамтарсан багийн 165 гишүүдэд, "Өөрчлөлийг өөрөөсөө" сургалтад 975 иргэнийг тус тус хамруулан зохион байгуулсан.</p>	
68	Хүүхдийн оролцооны байгууллага, "Хүүхдийн элч"-ийн	Оролцооны байгууллагын тоо	Тоо	2024	4	8	6	<p>Аймгийн хэмжээнд хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр Хүүхдийн зөвлөл, Өсвөрийн парламент, Лидер сурагч академи, Охидын зөвлөл, Эко клуб, Өсвөрийн сэтгэл зүйчид клуб зэрэг нийт 6</p>	50

	<p>үйл ажиллагааг идэвхжүүлэх</p>						<p>хүүхдийн оролцооны байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Хүүхдийн оролцооны байгууллагуудын санаачилгаар “Бүтээлч ирээдүйг хамтдаа бүтээнэ” уран илтгэлийн тэмцээн, “Хайраар дүүрэн захиа” шүлгийн уралдаан, “Өсвөрийн парламент” зэрэг хүүхдийн оролцоог дэмжих арга хэмжээнүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор 1500 гаруй хүүхэд багачуудыг хамруулсан бөгөөд уралдаан, тэмцээн, арга хэмжээний зардалд нийт 3,2 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Сайншанд сумын 6, Замын-Үүд сумын 3, бусад сумдын 12, нийт 21 ерөнхий боловсролын сургуулиудад 2024-2025 оны хичээлийн жилд "Сурагчдын зөвлөл", "Залуу байгальч", "Өсвөрийн сэргийлэгч", "Өсвөрийн эмч", "Улаан загалмай" зэрэг сургуулийн дэргэдэх хүүхдийн оролцооны 83 байгууллагууд хүүхдийн идэвх оролцоог ханган ажилласан. Эдгээр Хүүхдийн оролцооны байгууллагуудыг удирдлага арга зүйгээр ханган ажилладаг сургуулийн нийгмийн ажилтан, насан туршийн боловсролын багш буюу нийт 22 хүнийг "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга"-ын сургалтад хамруулсан.</p> <p>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/244 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийн элчийг сонгон ажиллуулах журам”, мөн тус газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/73 дугаар тушаалыг хэрэгжүүлж, хүүхдийн элч нарыг арга зүйгээр хангах, чадваржуулах сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 20–21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалтад 10 хүүхдийн элчийг хамруулж, мэргэшсэн сургагч багш нар хүүхдийн элчийн эрх, үүрэг, хүүхдийн эрх хамгааллын талаар сургалт, мэдээлэл өгч, Хүүхдийн элчийн үнэмлэх, батламжийг олголоо.</p> <p>Сонгогдсон хүүхдийн элч сум орон нутгийнхаа онцлогт тулгуурлан хүүхэд хамгааллын төлөвлөгөөг боловсруулж, хүүхдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, хамгааллын үйлчилгээний чанарыг</p>	
--	-----------------------------------	--	--	--	--	--	--	--

								<p>сайжруулах зорилгоор “Хүүхдээ сонсох өдөр”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” зэрэг сургалт, арга хэмжээг зохион байгуулж, нийт 2500 хүүхэд багачуудыг хамруулсан.</p> <p>Эрдэнэ сумын хүүхдийн элч сумын Ерөнхий боловсролын сургуулийн цахилгааныг, Замын-Үүд сумын хүүхдийн элч тусгай хэрэгцээт 10 хүүхдэд тэргэнцэр, мөн 5 өрхөд гэрийн дэмжлэг үзүүлж, Улаанбадрах сумын Хүүхдийн элч эцэг эх асран хамгаалагчдад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, сум бүрийн Хүүхдийн элч нар 5 сард "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээг зохион байгууллаа.</p>	
69	Мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг бэлтгэж, сум бүрийг хүүхэд, хамгааллын ажилтантай болгох	Хүүхэд хамгааллын ажилтны тоо	Тоо	2024	0	14	21	<p>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар батлагдсан “Сум, баг, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтын” дагуу аймгийн хэмжээнд 18 нийгмийн ажилтныг томилон, Дундговь аймагт зохион байгуулсан бүсийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу аймгийн хэмжээнд нийт 24 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллахаар төлөвлөгдсөнөөс 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 21 нийгмийн ажилтан үндсэн орон тоонд ажиллаж байна.</p> <p>Нийгмийн ажилтнуудын тогтмол үйл ажиллагааны үр дүнд гэрийн эргэлтийг долоо хоног бүр зохион байгуулж, эрсдэлт нөхцөлд байгаа 60 хүүхдийг илрүүлэн, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хоол хүнсний дэмжлэг олгох, боловсролын үйлчилгээнд хамруулах зэрэг хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд нийт 340,0 мянган төгрөгийн хүнс, ахуйн хэрэглээний дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүүхдэд үл хайхрах, хүчирхийлэл үйлдсэн 1 иргэний эх байх эрхийг шүүхийн шийдвэрээр хасаж, мөн 4 эцэг эх, асран хамгаалагчийг Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 100,0 мянган төгрөгөөр торгож, холбогдох арга хэмжээг авсан.</p>	100

								<p>Мөн аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт гэр бүлийн сургагч багшаар бэлтгэх сургалтыг зохион байгуулж, нийт 22 нийгмийн ажилтныг хамруулан сертификат олгосон. Уг сургалтын үр дүнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр аймгийн 14 суманд нийт 39 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 17000 орчим эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалагчийг хамруулсан хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлж, хүүхэд хүмүүжлийн эерэг хандлагыг төлөвшүүлсэн.</p>	
70	Өсвөр үеийн охид, хөвгүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	0	90	95	<p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/504 дугаартай “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан “Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний журам”-ын дагуу “Өсвөр үеийн охид, хөвгүүдэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн боловсрол олгох төлөвлөгөөг 3 зорилт 8 үйл ажиллагааны хүрээнд 95%-тай хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагууд өсвөр үеийнхэнд зориулсан ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэхэд анхааран ажиллаж байна. Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, боловсрол олгох 2 кабинетаар 4135 хүүхэд үйлчлүүлж, 631 хүүхдэд өвчлөл илрүүлж, 89.5%-ийг эмчилж, эрүүлжүүлэлт өмнөх оноос 36.6%-иар нэмэгдсэн. Үүнээс бэлгийн замын дамжих халдвар илэрсэн 2 хүүхдийг сайн дурын кабинеттай хамтран 100% эрүүлжүүлсэн.</p> <p>Хүчирхийлэлд өртсөн 0-18 насны 17 хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оноос 4-өөр буурсан ба бие махбодын хүчирхийлэл 16, бэлгийн хүчирхийлэл 1 бүртгэгдэж, тэдэнд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүлээгдэл чирэгдэлгүй үзүүлсэн.</p> <p>“Үе тэнгийн сургагч багш чадавхжуулах” сургалтад ЕБ-ын 5-н сургуулийн 35 хүүхдийг хамруулж, аймгийн хэмжээнд 192 үе тэнгийн сургагч багш бэлтгэн, сургуулийн орчинд 19 удаагийн</p>	100

								<p>өртөөчилсөн сургалт зохион байгуулж, 517 хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгосон.</p> <p>“Өсвөр үеийн эрүүл мэндийн 7 хоног”, “24/3 Шүдээ зөв угаа-2025” аяны хүрээнд өсвөр үеийнхний дунд амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, 3248 хүүхдийг хамруулсан.</p> <p>Орон нутгийн DTV телевизтэй хамтран “Охид хөвгүүдийн цаг” нэвтрүүлгийг 8 удаа, “Хүүхэд-Эрүүл мэнд” нэвтрүүлгийг 3 удаа бэлтгэн хүргэснээр 13351 хандалт авсан. Эдгээр ажлуудын үр дүнд өсвөр насны охидын жирэмслэлт 39%-иар, үр хөндөлт 62.5%-иар тус тус буурсан.</p>	
71	<p>Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах</p>	<p>Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн эзлэх хувь</p>	Тоо	2024	3,1	2,9	2,5	<p>Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хууль эрх зүйн мэдлэг зорилгоор аймгийн ГХУСАСЗ болон Цагдаагийн газартай хамтран 5 удаагийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, хүүхдийн өмнө үүрэг хүлээгч 215 албан тушаалтан, ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн 620 суралцагчдыг хамрууллаа.</p> <p>Мөн DSB телевизийн “Хуулийн цаг”, “Ярилцлагын цаг” нэвтрүүлгээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, “Насанд хүрээгүй хүүхдийн хараа хяналт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд 3 удаагийн ярилцлагыг олон нийтэд хүргэж 11600 иргэний эрх зүйн боловсролыг нэмэгдүүллээ. Хүүхдийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд эрхэм хэрэглэгч”, Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр, Хүүхдийн төлөө утас-108 өдөр, Олон улсын гэр бүлийн өдрийн хүрээнд 25 удаагийн арга хэмжээг 14 суманд зохион байгуулж 2100 асран хамгаалагч, 3450 хүүхэд, өсвөр үеийг хамруулсан.</p> <p>Аймгийн Цагдаагийн газартай хамтран Сайншанд сумын 8 багийн 60 байр талбайд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, нийт 30 гаруй зөрчлийг илрүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд эрсдэлт нөхцөлд байгаа 796 хүүхдээс түр хамгаалах, нөхөн сэргээх, асрамж халамжийн төвд зуучлах замаар өндөр эрсдэлтэй</p>	100

							<p>хүүхдийг 27-өөр, бага эрсдэлтэй хүүхдийг 124-өөр бууруулж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо 645 болсон нь нийт хүүхдийн 2,5 хувийг эзэлж байна.</p> <p>Эрсдэлт бүлэгт хүргэх шуурхай тусламжийн 10,0 сая төгрөгийн 500 ширхэг багц бэлтгэн 13 сумын 25 багт хүргэсэн. Тайлант хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг түр хамгаалах байраар насанд хүрээгүй 6 хүүхдийг хамгаалалтад авч, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүллээ.</p> <p>Мөн хоригдож байгаа өсвөр насны 2 хүүхэд, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авхуулсан өсвөр насны 42 хүүхдэд хиймэл оюуны хэрэглээ, тусгай хөтөлбөрийн дагуу 2 хүүхдэд 51 цагийн 34 удаагийн хичээл зааж, мэдлэгийг дээшлүүллээ.</p>	
72	<p>Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог тохирсон уралдаан тэмцээн, олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулж, тэгш оролцоог хангах</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	Тоо	2024	10	15	<p>47</p> <p>Хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээнд хүүхдийн тэгш оролцоог хангах зорилгоор Юнител групптэй хамтарсан "Юнител хаб" танхимын үйл ажиллагаа тогтмолжуулж, 500 гаруй хүүхдүүдэд инженерчлэл, код бичилтийн сургалт зохион байгуулж, сертификат олголоо.</p> <p>Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон уран уншлагын уралдаан, шатрын 2 удаагийн тэмцээн, илтгэлийн тэмцээн, урлагийн тоглолт, "Өсвөрийн сэргийлэгч-2025", цэрэг спортын "Дөл", "Дорноговь робот-2025" өсвөрийн зохион бүтээгчдийн тэмцээн, "Эх оронч үзэл-Үндэсний бахархал" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан зэрэг 20 гаруй арга хэмжээг зохион байгуулан 15000 гаруй хүүхдийн тэгш оролцоог ханган ажиллалаа.</p> <p>Өсвөр насны хөвгүүдэд зориулсан "Боловсролоор үлгэрлэе" нөлөөллийн арга хэмжээг "Өгөх урлаг" ТББ-тай хамтран 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ар гэрийн анхаарал халамж сул, гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 14-18 насны зорилтот бүлгийн хөвгүүдэд англи хэл, сэтгэл зүйн үйлчилгээ, сайн дурын ажил гэсэн чиглэлээр 7 хоногт 6 өдрийн 12 цагийн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 30 хүүхдийг хамруулж, тайлан болох төсөл дээр</p>	100

								<p>ажилласан 4 багшийн тэмдэглэл судалгаан дээр үндэслэн 200 ном хэвлүүлсэн.</p> <p>Дэлхийн “Сансрын 7 хоног” арга хэмжээнд нийт 1200 гаруй хүүхэд хамрагдан, өртөөгөөр амжилттай аялж батламж гардуулсан. "Ирээдүй" хүүхдийн Сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор аймгийн Ерөнхий боловсролын 6-н сургуулийн 21 багийн 640 өсвөрийн тамирчид оролцсон. Лигийн тэмцээнээс шалгарсан шилдэг тоглогчдоос бүрдсэн аймгийн шигшээ баг энэ онд Австри улсын “United World Games 2025” олон улсын хүүхдийн спортын наадам, БНХАУ-д зохион байгуулагдсан олон улсын тэмцээнд Монгол улсаа төлөөлөн амжилттай оролцож, улсын аварга шалгаруулах “U-15” насны Сагсан бөмбөгийн тэмцээнд хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ. Аймгийн аварга шалгаруулах 22 удаагийн тэмцээн, уралдаан, суманд 31 удаагийн тэмцээнийг спортын холбоодын дэмжлэгтэй хамтран зохион байгуулан 2278 хүүхдийн оролцоог ханган спортоор дамжуулан өөрийгөө хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх боломжийг олголоо.</p> <p>Тайлант хугацаанд 47 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 19688 хүүхдийг хамруулж хүүхдийн тэгш оролцоог хангаж ажиллалаа.</p>	
73	Замын-Үүд суманд “Хүүхэд хөгжлийн төв”-ийн барилга барих ажлыг үргэлжлүүлнэ.	Гүйцэтгэлийн хувь	хувь	2024	20	80	40	<p>Замын-Үүд сумын Хилчин багийн нутаг дэвсгэрт 1 давхартаа "Хүүхэд хөгжлийн төв" -тэй, 48 айлын 5 давхар орон сууцны барилга угсралтын ажлыг "Гантулга трейд" ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 40%-тай байна.</p>	33.3
74	Бүх шатны байгууллагад жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх	төлөвлөгөө баталсан байгууллагын тоо	Тоо, хувь	2024	-	10	29	<p>"Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлэхээр аймгийн Жендэрийн салбар хороо 2025 онд 3 зорилт, 18 заалт бүхий төлөвлөгөөг баталж 84.4 хувьтай хэрэгжсэн. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 15 төрийн байгууллага, 14 сумын жендэрийн дэд салбар хороо буюу нийт 29 байгууллага 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллалаа.</p>	100

								<p>Эрүүл мэндийн салбарт 2025 оныг Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласны хүрээнд "Эрэгтэйчүүдийн кабинет"-ын үйл ажиллагааг идэвхжүүлж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлэн УНТЭ Урологи-Андрологийн тасаг, Гурван гал эмнэлгийн эмч нарын багийг урьж 291 эрэгтэйд үзлэг хийж, 7 иргэнд мэс засал хийсэн.</p> <p>Оюутан суралцагчдын дунд нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, 135 оюутан хамрагдсаны 89 нь эрэгтэй байна. Нийт 64 өвчлөл илрүүлж, 86% эрүүлжүүллээ. "Бүх төрлийн тамхины хор хөнөөл", "Охид хөвгүүдийн эрүүл ахуй", "БЗДХ түүнээс урьдчилан сэргийлэх", "Дэлгэцийн донтолт" сэдвийн хүрээнд 4 удаагийн сургалт зохион байгуулж 259 оюутан хамрагдлаа.</p> <p>Орон нутгийн түвшинд "Жендэрийн бодлогоор уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах" сэдвээр говь, төвийн болон зүүн бүсийн 10 аймгийн 100 гаруй оролцогчтой сургалтыг зохион байгуулснаар орон нутгийн төрийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, малчид, тариаланчдын жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт хоорондын холбоо хамаарал, жендэрт суурилсан хүчирхийлэл, жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх, тулгарч буй саад бэрхшээл, сайн туршлага, шинэлэг санаачилгын талаар мэдлэг, мэдээллийг солилцсон.</p>	
75	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлан, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг дэмжих	Сургалт, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	Тоо	2024	8/ 1500	10/ 1800	14/ 1950	<p>Жендэрийн хэвшмэл байдлыг халах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр "Эмэгтэйчүүдийн оролцоо ба манлайлал", "Жендэр эрх тэгш байдал ба түүний үндсэн ойлголт", "Өсвөр насны хүүхэд рүү чиглэсэн үе тэнгийн дээрэлхэлт, электрон тамхины хэрэглээг бууруулах", "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Архины хор уршиг ба хэрэглээ" зэрэг 14 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 1,950 гаруй иргэд, албан хаагчид хамрагдсан нь иргэдийн жендэр, жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах</p>	100

								талаар мэдлэг ойлголтыг авсан. Өмнөх онтой харьцуулахад сургалтад хамрагдсан иргэдийн тоо 30 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
76	Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын үйл ажиллагааг хүний эрхийн шаардлагад нийцүүлэн үйлчилгээ үзүүлэх	Асруулагч ахмадуудад үзүүлсэн үйлчилгээ	Тоо	2024	5	11	11	<p>Говийн бүсийн төрөлжсөн асрамжийн газар нь нийт 30 ортойгоос энэ онд 1 ахмад настнаас асруулах хүсэлт ирсэн.</p> <p>Тайлант онд Говийн бүсийн төрөлжсөн асрамжийн газарт асруулж байсан 3 ахмад нас барснаар 16 ахмад настан асруулж байна.</p> <p>Ахмад настнуудын хэрэгцээ, нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор улиралд нэг удаа үнэлгээ хийж, оролцооны бүлэгт хамрагдсан 10 ахмад, оролцооны бус, бие даах чадваргүй 6 ахмад тус бүрийн хөгжлийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.Төлөвлөгөөний дагуу ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сэтгэл зүйн байдлыг дэмжих, чадавхыг хадгалах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, давхардсан тоогоор 75 хөгжлийн ажилд асруулагч нарыг тогтмол хамрууллаа.</p> <p>Ахмадуудын хөгжлийн ажлын оролцоог дэмжих, хөгжлийн ажлаар урласан гар урлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дотоод сургалтаар үзэсгэлэн гаргаж албан хаагчдад танилцуулсан.</p> <p>Салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх үүднээс АШУҮИС, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төвүүдтэй хамтран 6 удаагийн үзлэг, шинжилгээнд давхардсан тоогоор 96 асруулагч хамрагдсан. Эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд асруулагчдад дархлаа сэргээх эм, бэлдмэл олгох, эмчилгээ, сувилгааны үйлчилгээ болон эмчилгээний хоолоор тогтмол үйлчлэх ажлыг хэвшүүллээ.</p> <p>Мөн Музей сургалт судалгааны төв, Хөгжимт драмын театр, Болор эгшиглэн хамтлаг, Эвийн эгшиг дууны дугуйлан, 3-р цэцэрлэг зэрэг байгууллагуудтай хамтран 5 удаагийн соёл, урлагийн арга хэмжээг зохион байгууллаа.</p>	100

								<p>Амьдрах орчны тав тухыг сайжруулах хүрээнд нийт 19,7 сая төгрөгийн өртөг бүхий ус цэвэршүүлэгч, кондейшн, хивс зэрэг тоног төхөөрөмжийг худалдан авч, 5 өрөөнд 30 хивс, 2 өрөөнд кондейшн байрлуулсан.</p> <p>Хөгжлийн ажлын төлөвлөгөө болон асруулагч ахмадад үзүүлж буй 11 төрлийн үйлчилгээний үр дүнд ахмад настнуудын оролцоо сайжирч, оролцооны бүлгийн ахмадуудын тоо өмнөх оноос 2-оор нэмэгдэж, нийт 10 болж өссөн.</p>	
77	"Төвшин сайхан" ахмадын сувиллын үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд менежментийн шинэ тогтолцоонд шилжүүлж, үйлчилгээг олон улсын чанар, стандартад нийцүүлэх	Хамрагдсан хүний тоо	Тоо	2024	1062	1100	1543	<p>Аймгийн "Төвшин сайхан" ахмадын сувиллын үйл ажиллагааг "Нандин энх тэмүүлэл" ХХК ашиглалтын гэрээний дагуу 2024.12.14-ний өдрөөс үргэлжлүүлэн иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Ахмадын ая тухтай амрах, сувилуулах нөхцөлийг хангах зорилгоор аймгийн "Төвшин сайхан" ахмадын амралт, сувиллын 2025 оны тогтмол зардалд 226,5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын А/77 дугаар захирамжаар шийдвэрлэсэн.</p> <p>Тайлант онд уламжлалт эмгүй эмчилгээ, нөхөн сэргээх физик эмчилгээнүүдээр биеийн алжаалыг тайлах, парафин болон элсэн жин зэрэг 24 төрлийн үйлчилгээг бүрэн тоноглогдсон кабинетаар дамжуулан 1543 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.</p>	100
78	Ахмад настныг шинэ ур чадварт сургах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг, туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлэх	Нэмэлт орлого олсон ахмадын тоо	Тоо	2024	916	920	1210	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)"-ны "Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа"-ны Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 16 байгууллагын 5 чиглэлээр ирүүлсэн төсөлд 10 байгууллагын 305 албан хаагчид хамрагдаж, 7 ахмадад 10,8 сая төгрөгийн урамшуулал олгосон.</p> <p>Мөн "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 57 ахмадын төслийг хүлээн авч, 32 ахмадад 250.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон бөгөөд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмадын үйл ажиллагааны чиглэлийг авч үзвэл хоол үйлдвэрлэл 8, оёдол 6, төмөр эдлэл 3, газар тариалан 6, сувилал</p>	100

								<p>бариа 4, цэвэрлэгээ үйлчилгээ 1, гар урлал 1, цагаан идээ 2, арьс нэхий боловсруулах 1 үйлдвэрлэл эрхлэгч байна.</p> <p>Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэл төлж хөдөлмөр эрхэлж байгаа 757 ахмад, нэмэлт орлого олж байгаа 453 нийт 1210 ахмад байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 32.1 хувиар нэмэгдсэн байна.</p>	
79	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллага, бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлж, саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, саадгүй үйлчилгээг нэвтрүүлсэн байгууллагын тоо</p>	Тоо	2024	75	80	80	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2025 оны А/164 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан бөгөөд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт 25 арга хэмжээтэйгээр боловсруулан баталсан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллагад мөрдүүлэх зорилгоор үзлэг шалгалт зохион байгуулж, Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй 25 ба түүнээс дээш ажиллагсадтай 55 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан. Үзлэгт хамрагдсан 55 аж ахуйн нэгж, байгууллагуудад нийт 5049 ажилтан ажиллаж байгаагаас 163 хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1,7 сая төгрөгийн дундаж цалин хөлстэй ажиллаж байна.</p> <p>Ажлын байрандаа налуу замтай 23 аж ахуйн нэгж, тусгайлан ариун цэврийн өрөө шийдвэрлэсэн 9 аж ахуйн нэгж, стандартын шаардлага хангасан хаалгатай 24 аж ахуйн нэгж, зориулалтын машины зогсоолтой 14 аж ахуйн нэгж байна. Мөн налуу шат, ариун цэврийн өрөөний хүртээмж, стандартын хаалгатай сумдын 57 төрийн байгууллага байна.</p> <p>Улсын үзлэгээр илэрсэн алдаа дутагдал, хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй асуудлыг газар дээр нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтанд танилцуулан зөвлөгөөг өгч, улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй орон тоондоо нөхөн төлбөр төлөөгүй зөрчил илэрсэн нийт 2 аж ахуйн нэгж, байгууллагад тус бүр 1,5 сая, нийт 3,0 сая</p>	100

								<p>төгрөгийн торгууль, нийт 8 аж ахуйн нэгжид 101,9 сая төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус ногдуулснаас 5 аж ахуйн нэгж 86,8 сая төгрөгийг барагдуулсан.</p> <p>Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэгш хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар олон нийт, орон сууцны барилгын 37 архитектур төлөвлөлтийн даалгаварт тусган ажлын болон загвар зургийг хянан баталсан. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй 80 байгууллага байгаа бөгөөд өмнөх оноос 6,2 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p>	
80	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг хийж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах</p>	Хамрагдсан иргэд	Тоо	2024	960	1000	1343	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах зорилгоор “Халамжаас хөдөлмөрт 222” арга хэмжээний хүрээнд байнгын асаргаатай хүүхдийн асран хамгаалагч болон хөгжлийн бэрхшээлтэй 192 иргэнд, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 157 хүүхдийн эцэг эхэд, “Монгол Солонгосын хамтарсан шим тэжээл судлалын төв”-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдийн эх эцэг, асран хамгаалагчдад, “Хамтдаа гоё” арга хэмжээнд 40 эцэг эх, 14 сумын 766 төрийн албан хаагчдад 20 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Мөн хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хэвтрийн 12 хүүхдэд Австралийн ротари клуб, Хангай сайн дурын нийгэмлэг тэргэнцэр, аймгийн ХГБХХГ-тай хамтран байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй 131 хүүхдэд эрүүл мэнд, дархлаажуулалтын багцыг олгосон.</p> <p>“Эрхэм нандин сувд” ТББ-аас санаачлан зохион байгуулсан нарийн мэргэжлийн эмч нарын удаагийн нэгдсэн үзлэг оношилгоонд 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан 4,5 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Тусгай хэрэгцээт иргэдэд соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор “Соёлын үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлаар зохион байгуулах нь” гарын авлага, номыг соёлын салбарын 18 байгууллагад мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	100

							<p>Хөгжлийн бэрхшээлтэй нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн тэгш, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд худалдан авах ажиллагааны хүрээнд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5 дахь заалтыг үндэслэн 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй эрхлэгчдэд дотоодын давуу эрх тооцохоор тендер шалгаруулалтуудын баримт бичгийн ТШЗ 31.1 дэх хэсэгт тусгаж тайлант хугацаанд давхардсан тоогоор 109 удаагийн тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.</p> <p>Тайлант оны хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэх 26 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 1343 иргэнийг хамруулсан.</p>		
81	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэх	Ажилд зуучлагдсан залуучууд	Тоо	2024	482	490	484	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны гарааны бизнес эрхлэгч залуучуудыг дэмжих санхүүгийн дэмжлэгийн хүрээнд "Говийн бүс"-ийн гарааны бизнес эрхлэгч залуучуудыг шалгаруулах арга хэмжээг 09 дүгээр сарын 04-ний өдөр Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр гэсэн говийн бүсийн аймгуудын 8 залуучуудын дунд зохион байгууллаа. "Говийн бүс"-ийн гарааны бизнес эрхлэгч залуучуудыг шалгаруулах арга хэмжээнд Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр гэсэн багууд шалгарч 50 хувийн эргэн төлөх нөхцөлтэй 36 сарын хугацаатай зээлийг олголоо.</p> <p>Аймгийн хэмжээний гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох Start-up арга хэмжээний анхан шатны сургалтыг 9 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд тус бүр 2 гишүүнтэй 3 багийг хамруулан зохион байгууллаа. Дээрх 3 баг хөтөлбөрийн дагуу 5 долоо хоногийн хурдасгуур арга хэмжээнд хамрагдсан бөгөөд үүнээс сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 багт тус бүр 15.0 сая төгрөгийг 50 хувийн эргэн төлөлттэйгөөр олголоо. Аймгийн хэмжээнд 1777 ажлын байрны захиалга авснаас 15-34 насны нийт 484 иргэнийг ажлын байранд зуучилсны 59 нь түр ажлын байр, 425 нь</p>	25

								байнгын ажлын байр байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, залуучуудад зориулсан гарааны бизнесийн талаар богино хэмжээний бичлэг 4, подкаст 2-ыг бэлтгэн цахим хуудсаар дамжуулан хүргэсэн бөгөөд 8600 хандалттай байна."	
82	"10000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд залуучуудыг байртай болгох бодлогыг хэрэгжүүлж, амьдрах таатай нөхцөлийг сайжруулах	Хамрагдсан залуучуудын тоо	Тоо	2024	10	20	27	<p>Замын-Үүд сумын Соёмбо багийн нутаг дэвсгэрт "Мандах наран-6" орон сууцны хороолол барих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 144 айлын орон сууц нь "Түрээсийн орон сууц"-ны ангиллаар төлөвлөгдөж, орон нутгийн хөгжлийн сангийн 16 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх" ажлын тендерт "Гантулга трейд" ХХК шалгарч, 9 давхар 4 блок 288 айлын орон сууцны барилгыг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр ашиглалтад оруулж Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12/02, 12/03 дугаар тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам"-ын дагуу түрээсийн орон сууцанд хамрагдах 792 иргэний хүсэлтийг хүлээн авч, шалгаруулалтыг удирдан зохион байгуулах аймгийн Засаг даргын А/610 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Замын-Үүд суманд ажиллаж, 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос 27 иргэн нь залуучуудын насны иргэд байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас баталсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого", Дорноговь аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил" 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдөр "Сингл апартамент" залуусын түрээсийн орон сууцны шавыг тавилаа.</p> <p>Уг орон сууцанд орон нутагт ажиллахаар ирсэн ганц бие залуучууд болон гэр бүлд 5 жил хүртэл хугацаатайгаар түрээслэн амьдарч болох бөгөөд энэ хугацаанд байрны урьдчилгаа мөнгөн хуримтлалыг</p>	100

								үүсгэн ипотекийн зээлд хамрагдах замаар орон сууцны асуудлаа шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.	
83	Өсвөр үе, залуучуудад эх оронч, байгаль орчноо хайрлах, хамгаалах, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх хандлагыг төлөвшүүлэх	Арга хэмжээний тоо, хамрагдсан залуучуудын тоо	Тоо	2024	33/ 8542	35/ 8600	45/ 13165	<p>Залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, сайн дурын үйл ажиллагааг дэмжих, олон нийтийн оролцоог өргөжүүлэх зорилгоор “Сайн дурын сар” аян, “Гайхамшигт бямба гараг”, Үндэсний бичиг соёл, номын баяр-2025”, “Миний мод-Бидний төгөл”, соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлагч нарыг таниулах, тэдний хэл яриаг хөгжүүлэх зорилгоор “Бяцхан ерөөлч” уралдаан зэрэг нийт 21 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, 2800 гаруй залуучуудыг хамруулан ажиллалаа.</p> <p>Монгол Улсын Засгийн Газраас 2025 оныг “Залуучуудын хөгжлийг дэмжих жил”, Дорноговь аймаг “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Залуучуудын соёлын фестиваль”-ийг аймгийн Засаг даргын санаачилгаар “Тэнгэрийн хутагт” аялал жуулчлалын фестивальтай хамтатган зохион байгуулах шийдвэрийг аймгийн Засаг даргын А/375 дугаар захирамжаар 2025 оны 09 дүгээр сарын 19-21-ны өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Тус фестивалиар “Өв соёлын өргөө” буюу 14 сумын нүүдэлчин ахуйн онцлог шингээсэн гэр үзэсгэлэн, Монгол наадгай, “Говийн мэргэн” нум, сум, шагайн харваа, Дорноговийн брэнд бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдаа, элсэн урлалын үзүүлбэр, Морь тэмээ унах эдлэх өв соёлын үйлчилгээ, өвлөн уламжлагчдын тоглолт, нарны мөргөл, биелгээ иог, сүсэгтэн олны эргэл мөргөл, үлэмжийн чанар яруу найргийн наадам, тэнгэрийн хутагт бүжгэн жүжиг зэрэг 20 гаруй арга хэмжээ үзвэр үйлчилгээг зохион байгуулж 25000 гаруй иргэдэд үйлчилгээг үзүүлснээс 15-34 насны залуучууд 40 түүнээс дээш хувь буюу 10000 гаруй залуучууд хамрагдлаа. Мөн Өсвөр үе, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эх оронч залуу” “торгон хил”, “Иргэний андгай” зэрэг 4 арга хэмжээг зохион байгуулж 365 өсвөр үе залуучуудыг хамруулан ажилласан.</p>	100

								Залуучуудын хөгжил оролцоог хангах, олон нийтийн оролцоог өргөжүүлэх чиглэлээр нийт 45 арга хэмжээг зохион байгуулж өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12 буюу 73.3 хувиар, хамрагдсан залуучуудын тоо 13165 буюу 64,8 хувиар өссөн байна.	
84	Өсвөр үе, залуучуудад соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагаагаар дамжуулан хувь хүний хөгжил, гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх	Арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	Тоо	2024	13/2300	15/2400	98/ 8023	<p>Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хуралдуулж эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, соёл урлаг боловсрол, залуучуудын хөгжил, оролцоо аюулгүй байдал гэсэн үндсэн 5 чиглэлийн 22 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг 90 хувьтай ханган ажиллалаа.</p> <p>Төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх, сумдын залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр СУАЖЗГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 72 дугаар албан бичгээр 14 сум, агентлагуудад зөвлөгөө чиглэл хүргүүллээ.</p> <p>Хувь хүний хөгжил, гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Төв номын сангийн дэргэдэх Америкийн соёл, мэдээллийн төв өсвөр үе, залуучуудад зориулсан 42 хөтөлбөрийг хэрэгжүүлж, салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд сэтгэлзүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх “Стресс менежмент”, “Харилцаа хандлага”, хууль эрх зүй, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр 14 сумын хэмжээнд 34 төрлийн сургалтын арга хэмжээ, "Агаа Эгээ менторшипийн хөтөлбөр", "Оюу-ай" хайрын шүлгийн яруу найргийн наадам, "Tech trend event", "Эртэч өглөө" уулзалт, "Хайрт аавынхаа гэгээн дурсгалд цэцэрлэгт хүрээлэн" "Хичээлийн шинэ жилийн анхны чөлөөт уулзалт-2025" зэрэг 22 төрлийн арга хэмжээ зохион байгууллаа.</p> <p>Тайлант онд нийт 98 төрлийн сургалт, арга хэмжээг хэрэгжүүлж, 8023 өсвөр үе залуучуудыг хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хамрагдсан залуучуудын тоо 40,1 хувиар өсөж өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлж сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдах, хувь хүний хөгжил оролцоог хангасан.</p>	100

85	Эрүүл амьдралын зан үйлийг сурталчлах, залуучууд бие бялдраа чийрэгжүүлэх, спортын үйл ажиллагааг дэмжих, залуучуудын өвчлөл түүний шалтгааныг бууруулах	Арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	Тоо	2024	0	5/300	55/ 6015	<p>Аймгийн Залуучуудын салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн газартай хамтран үе тэнгийн сургагч багш нарын оролцоог идэвхжүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх, өсвөр үеийнхэнд үнэн зөв эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Үе тэнгийн сургагч багшийг чадавхжуулах” сургалтад Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн 20 суралцагчийг хамруулсан. Сургагч багш нараар дамжуулан сургуулийн орчинд 9 удаагийн өртөөчилсөн сургалтаар 1285 хүүхдэд мэдээлэл хүргэсэн.</p> <p>Орон нутгийн DTV телевизтэй хамтран өсвөр үеийн эрүүл мэндийн боловсрол олгох мэдээллийг хүргэн, “Хөвгүүдийн эрүүл мэндийн чухал асуудлууд” сэдвийн хүрээнд “Охид, хөвгүүдийн цаг” нэвтрүүлгийг 3 удаа бэлтгэн хүргэж, 4715 хандалт авсан. Мөн өсвөр үеийнхэнд зориулсан “Хүүхэд-Эрүүл мэнд” нэвтрүүлгийг 1 удаа бэлтгэн хүргэж, 1985 хүнд хүрсэн хандалт авсан.</p> <p>ЕБС-ийн "Мэдээллийн цаг-444" үйл ажиллагаанд тулгуурлан сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүд, эцэг эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох 6 сургалт, арга хэмжээг зохион байгуулж, 1025 хүнийг хамруулсан.</p> <p>Мандах, Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвөөс залуучуудын эрүүл мэндийн үзлэг болон сэтгэлзүйн эрүүл мэндийн сургалтад 140 залууг хамруулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд залуучууд бие бялдраа хөгжүүлэх, залуучуудын дундах өвчлөлийн шалтгааныг бууруулах, чийрэгжүүлэх чиглэлийн сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, марафон, дугуйн уралдаан, явган аялал зэрэг нийтийн биеийн тамир, спортын 42 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, 3545 залуусын оролцууллаа.</p> <p>“Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 15–64 насны 6879 эрэгтэйчүүдээс идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэсэн судалгаа авсан бөгөөд 3899 буюу 56,6% нь 18-34 насны залуучууд хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 66% нь багийн спортоор хичээллэх,</p>	100
----	--	--	-----	------	---	-------	----------	--	-----

								идэвхтэй дасгал, хөдөлгөөний ач холбогдлын талаар мэдээлэлтэй байсан ба үүний 31% нь 18-34 насны залуучууд байсан. Энэ онд өсвөр үе, залуучуудын эрүүл зан төлөв, бие бялдрын хөгжил, мэдлэг, идэвхийг нэмэгдүүлэх 55 арга хэмжээ зохион байгуулж нийт 6015 залуучуудыг хамруулж ажиллалаа.	
86	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болох хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцэх ажиллах хүчнийг сургаж бэлтгэн ажлын байраар хангах цогц бодлогыг хэрэгжүүлэх	Шинээр бий болсон ажлын байрны тоо	Тоо	2024	1450	1500	1477	"Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)"-ны Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагааны танхимын мэргэжлийн сургалт, ур чадварын цахим сургалтын бүртгэлийг 14 сумдад зохион байгуулж 201 иргэнийг хамруулсан. Сургалтаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ихтэй байгаа цахилгаанчин, гагнуурчин, тогооч мэргэжлээр аймгийн Политехникийн коллежтэй хамтран 50 иргэнийг хамруулан зохион байгуулж байна. Сургалтын зардалд 19,2 сая төгрөгийг зарцуулах бөгөөд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт судалгааны хүрээлэнгээс санхүүжүүлнэ. Тайлант оны жилийн эцсийн байдлаар 1477 шинэ ажлын байр бий болсон бөгөөд 1250 буюу 84,6 хувь байнгын, 34 буюу 2,3 хувь нь улирлын, 193 буюу 13,1 хувь нь түр шинэ ажлын байр байна. Өмнөх онтой харьцуулбал 10-аар буюу 0.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.	54
87	Аймагт хэрэгжүүлж байгаа томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын захиалгат ажил үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх бодлогыг үргэлжлүүлэн	Томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтаар бий болсон ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо	Тоо	2024	281	285	346	Орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг "Дэнжийн хүү", "Айсуй хөгжил", "Мунара констракшн", "Дэлгэр баян хүлэг", "Эргэл хийц", "Сутайн жинст", "Суман зурхай", "Хур билиг", "Гантулга трейд", "Говийн шандаст хүлэг", "БЭМЭС", Асралт баян хайрхан" ХХК-тай Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлээр "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан ажиллаж байна. Тайлант онд томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын 128 захиалгат ажлын байранд 346	100

	ажлын байр нэмэгдүүлэх							иргэнийг ажилд зуучилснаас 76 иргэнийг дээрх гэрээний дагуу зуучилсан байна. Томоохон бүтээн байгуулалтад зуучлагдсан ажиллагсдын тоог өмнөх онтой харьцуулахад 18-аар өссөн үзүүлэлттэй байна.	
88	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	Төсөл хөтөлбөрт хамрагдаж ажлын байртай болсон иргэд	Тоо	2024	331	340	335	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)”-г 7 үйлчилгээний 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд үүнээс орон нутагт хэрэгжих боломжтой 24 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. Тайлант оны 11 дүгээр сарын байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа арга хэмжээнд 733 иргэнийг хамруулж, 1,315.3 сая төгрөгийг зарцуулсан. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 188 иргэн, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаанд 395, түр ажлын байраар хангах арга хэмжээнд 150 иргэн хамрагдаж 168 иргэнийг байнгын, 167 иргэнийг түр ажлын байртай буюу нийт 335 ажлын байр бий болгосон.	44.4
89	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох	Ажилд зуучлагдсан иргэдийн тоо	Тоо	2024	1020	1300	1121	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хувийн түншлэлээр дамжуулан хэрэгжүүлэх Жоб центр төвийг Дарь-Овооны эзэд хувийн биржтэй хамтран хэрэгжүүлэхээр өрөө тасалгааг стандартын шаардлагын дагуу бүрэн тохижуулсан. Мөн аймгийн ажил олгогч эздийн “ХАН БАЯН” холбооны тэргүүн болон ажил олгогчдын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж "Хамтран ажиллах боломжууд, 2 талын оролцоо “ сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан. Санамж бичиг байгуулсны үр дүнд ажил олгогчдод 2 удаагийн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж ажил олгогч эздийн холбооны 5 тэргүүлэгч, 84 ажил олгогч хамруулж холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгууллаа. Тайлант онд нийт 1121 иргэн ажилд зуучлагдсан бөгөөд үүнээс байнгын ажлын байранд 908 иргэн, улирлын болон түр ажлын байранд 134 иргэн тус тус зуучлагдсан. Өмнөх онтой харьцуулахад 22 оор нэмэгдсэн байна.	36

90	Хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог сайжруулах	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	Тоо	2024	17	20	24	<p>Хөдөлмөр нийгмийн 3 талт оролцоонд тулгуурлан аймгийн Засаг даргын 2025 оны А/49 дүгээр захирамжаар ХАБЭА-н зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, 2 зорилт 18 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан.</p> <p>Тайлант онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог сайжруулах зорилгоор 10 сумын ХАБЭА-н салбар зөвлөлийн 21 гишүүнийг хамруулан арга зүйн зөвлөгөө өгч мэдлэг чадварыг дээшлүүллээ.</p> <p>Мөн ХАБЭА-н хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалтыг 14 суманд зохион байгуулж, 182 ААНБ-ын 598 албан хаагчдыг хамруулсан. ХАБЭА-н сарын аяныг зохион байгуулж 16 ААНБ-ын хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэргэжлийн багаж хэрэгслийг үзэсгэлэн хэлбэрээр 378 иргэдэд танилцуулж, сайн туршлагыг түгээлээ.</p> <p>Жилийн эцсийн байдлаар 4 салбарын 32 ААНБ-т үзлэг шалгалтыг зохион байгуулж, 8 удаагийн уулзалт, арга хэмжээнд 356 иргэд, ажилтан албан хаагчийг хамруулан ХАБЭА-н тухай хуулийг сурталчлан таниуллаа.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог аймгийн Засаг даргын 2024 оны А/908 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 6 зорилт 65 арга хэмжээ бүхий хэлэлцээрийг баталсан.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтын дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 16 байгууллагын хамтын гэрээг бүртгүүлэх хүсэлт ирсэн бөгөөд хуулийн үндэслэл шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, зөрчилгүй байсан тул гэрээг баталгаажуулж, мэдээллийн сан үүсгэсэн бөгөөд боловсрол, соёлын 8, эрүүл мэндийн 4, нутгийн өөрөө удирдах 1, төрийн үйлчилгээ 1, орон нутгийн өмчит 2 байгууллага байна.</p>	100
----	---	---------------------------------------	-----	------	----	----	----	---	-----

								<p>Аймгийн хэмжээнд хамтын гэрээ байгуулсан 56 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хамтын гэрээтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй байна.</p> <p>Тайлант хугацаанд 24 үйл ажиллагаа зохион байгуулж, 210 аж ахуй нэгж байгууллага, 1353 иргэнийг хамруулан 9,8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.</p>	
91	"Бүтээмжийн хувьсгал"-ыг өрнүүлж, "Чадварлаг ажилтан-Тогтвортой ажлын байр" хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх	хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Тоо	2024	0	5	5	<p>Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.4 дэх заалтын хүрээнд "Бүтээмжийн хувьсгал"-ыг өрнүүлж, "Чадварлаг ажилтан-Тогтвортой ажлын байр" хөтөлбөрийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас батлаагүй байна.</p> <p>"Бүтээмжийн хувьсгал"-ыг өрнүүлж, "Чадварлаг ажилтан-Тогтвортой ажлын байр" хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх зорилгоор ажил олгогчийг дэмжих арга хэмжээний хүрээнд 5 аж ахуй нэгж байгууллагатай ажил олгогчийн урамшуулал олгох гэрээ байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүллээ.</p> <p>Гэрээний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажил хайгчаар бүртгэлтэй байсан иргэнийг байнгын ажлын байраар хангаж, 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар тогтвортой ажлын байраар хангасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг ажилтны тоогоор олгохоор ажиллаж байна.</p>	100
92	Зайнаас, цахимаар, цагаар ажиллах ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлэх	Цагийн ажилд зуучлагдсан иргэдийн тоо	Тоо	2024	103	110	121	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 66, 67, 68 дугаар зүйлийг сурталчлан таниулах зорилгоор ажилтан нь ажлын бүтэн бус цагаар ажиллах, гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах талаар зурагт хуудас бэлтгэн цахим хуудаст байршуулан олон нийтэд сурталчилж, 1280 хандалттай байна.</p> <p>Тайлант хугацаанд "Тэнгэрийн хутагт" аялал жуулчлалын фестивалд 80 оюутныг түр ажлын байраар хангаж, 41 иргэнийг хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгжүүдэд цагийн ажилд зуучилсан нь өмнөх онтой харьцуулахад 18 иргэнээр нэмэгдсэн.</p>	100
93	Иргэдийг нийгмийн даатгалд	Даатгуулагчдын тоо	Тоо	2024	22774	26401	25236	<p>Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор тайлант оны хагас жилийн байдлаар 13</p>	67.8

	хамруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх							<p>сум, 1 багт Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээг зохион байгуулж, 2129 иргэнд, аймгийн Боловсролын газар, АШУҮИС-н салбар сургуультай хамтран "Даатгалтай ирээдүй" 12 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, 745 сурагч, оюутнуудад, НДЕГ-тай хамтран "Даатгуулагчдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 4,7 сая төгрөгийг зарцуулан орон нутгийн төлөөлөл болсон 368 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, нийт 3242 иргэнд нийгмийн даатгалын ач тусын талаар мэдээлэл хүргэлээ.</p> <p>Үүний үр дүнд даатгуулагчийн тоо 25236 болж нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэгдсэн бөгөөд хэрэгжилтийн хувь 90,9 байна.</p>	
94	Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан цахимаар авах боломжийг бүрдүүлэх	Цахим үйлчилгээний тоо	Тоо	2024	24	26	29	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газар хамтран нийгмийн даатгалын үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг улсын хэмжээнд эхлүүлсэн. Нийгмийн даатгалын байгууллага нийт 34 төрлийн үйлчилгээ үзүүлж байгаагаас тайлант оны хугацаанд 5 үйлчилгээг цахимаар авах нөхцөл бүрдэж нийт 29 үйлчилгээг цахимжуулсан. Цахим үйлчилгээг хүртээмжтэй байлгахад дээрх 29 үйлчилгээг 3 сувгаар дамжуулан авах боломж бүрдсэн. Үүнд: 1. E-Mongolia цахим системээс 18 үйлчилгээг авах боломжтой бөгөөд үүнээс 4 үйлчилгээг Англи хэлээр авах боломжтой болсон. 2.Нийгмийн даатгалын аппликейшнаар 5 үйлчилгээ, мөн нийгмийн даатгалын тухай хуулийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. 2024 оноос хэрэгжиж байгаа нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогын хэмжээг иргэн бүр шууд харах боломжийг бүрдүүлсэн. 3.Даатгуулагчдад зориулсан цахим хуудас /www.portal.ndaatgal.mn/ ажил олгогч, даатгуулагч нарт шинэчлэн хүргэсэн цахим үйлчилгээний сайтаар дамжуулан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хүсэлт илгээх, даатгуулагчид үйлчилгээнийхээ процессын явц, шат дарааллыг өөрөө хянах боломжтой болсон.</p> <p>Нийгмийн даатгалын шинэ систем нэвтрүүлж үйлчилгээг цахимжуулснаар 2025 оны 10 дугаар сарын байдлаар 8737 даатгуулагчийн 11467</p>	100

								хүсэлтийг цахимаар хүлээн авч 99,05 хувийг шийдвэрлэсэн бөгөөд 0,95 хувь шийдвэрлэх шатанд байна.	
95	Эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах улсын бодлогыг сурталчлах	Нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	Тоо	2024	2/ 1300	25/ 5762	86/ 8536	<p>Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдан, 2024 оны 01 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээр иргэн бүр тэтгэврийн мөнгөн хуримтлалтай болж, мөнгөжүүлж эхэлсэн.</p> <p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хуулийн зохицуулалт 2030 оноос хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 14 суманд 86 удаагийн сургалтаар 484 ажил олгогчийн төлөөлөл, 8536 даатгуулагч, иргэнийг хамруулж зөвлөгөө мэдээллийг хүргэсэн бөгөөд 563 хүүхэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр хэлбэрээр, 120 даатгуулагч нас барсан гэр бүлийн гишүүний өндөр насны тэтгэврийн 20 хувийг тусгай зохицуулалтын дагуу авах хэлбэрээр өвийн харилцаа хэрэгжиж байна.</p> <p>Мөн аймгийн хэмжээнд 25236 даатгуулагч тэтгэврийн мөнгөжүүлсэн хуримтлалтай байна.</p>	100
96	Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлэх	Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	Тоо	2024	26643	26000	19347	<p>Монгол улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам” батлагдсан.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээ нь 2020 оны 08 дугаар сараас эхлэн үе шаттайгаар цахим системд шилжиж, 64 нэр төрлийн үйлчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авч нийт үйлчилгээний 88,8 хувийг цахимжуулсан. Мөн И-Монголиа системд 12 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг цахимаар авах нөхцөл боломж бүрдлээ.</p> <p>Тайлант хугацаанд нийгмийн халамжийн үйлчилгээнд 5618 иргэн хамрагдахаар хүсэлт гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 27386 хүүхдэд 26,563.8 сая төгрөг, бусад тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид давхардсан тоогоор 19347 иргэнд 14,384.5 сая төгрөг, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 550 иргэнд 44,2 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хүүхдийн тоо 3,0% буюу 812-оор нэмэгдэж тэтгэвэр, тэтгэмж, тусламж</p>	100

								хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо 20,9% буюу 5133-өөр, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ-12,4% буюу 78 иргэнээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.	
97	“Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хүүхдийн тоо	Тоо	2024	26570	0-18 насны бүх хүүхэд	27386	<p>Монгол улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 236 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-аар 0-18 хүртэлх насны хүүхдэд сар тэтгэмж олгож байна.</p> <p>Тайлант хугацаанд шинээр төрсөн 925 хүүхдийн асран хамгаалагчийн тэтгэмжид хамрагдах хүсэлтийг хүлээн авч цахим системд бүртгэн 0-18 хүртэлх насны бүх хүүхдэд буюу 27386 хүүхдэд 26,563.8 сая төгрөг олголоо.</p> <p>Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхдэд зарцуулаагүй, хүүхдийн асран хамгаалагчийн маргаантай холбоотой аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлтээр 30 өрхийн 56 хүүхдийн хүүхдийн мөнгөний үйлчилгээг зогсоосноос тайлант хугацаанд 41 хүүхдийн мөнгөний үйлчилгээг сэргээж, зогсоосон хугацаанаас нөхөн олгосон бөгөөд 8 өрхийн 15 хүүхэд асран хамгаалагчийн асуудал шийдэгдээгүй байгаа учир үйлчилгээг түдгэлзүүлсэн хэвээр байна.</p> <p>“Хүүхдийн мөнгө” хөтөлбөрт хамрагдаж буй хүүхдийн тоо өмнөх оны жилийн эцсээс 812-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p>	100
98	“Халамжаас-Хөдөлмөрт” зорилтот арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Халамжаас хөдөлмөрт шилжсэн иргэдийн тоо	Тоо	2024	31	40	151	<p>Тайлант онд шинээр өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан 401.2-с доош оноотой 14 сумын 1095 зорилтот өрхийг хөгжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2 зорилт, 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Сонгогдсон 1095 өрхөд 0-18 хүртэлх насны хүүхэд 2377, 18-с дээш насны 2061 иргэн байгаагаас ажил хөдөлмөр эрхэлдэг 1455, ажилгүй 606 иргэн байна. Ажилгүй 606 иргэнээс ахмад настан 121, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 154, оюутан 159, хөдөлмөр эрхлэх чадвартай боловч хөдөлмөр эрхлэхгүй байгаа 172 иргэн байна. Ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа 172 иргэнийг хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор</p>	100

								<p>446 иргэнийг хамруулсан. Үүнд: 171 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд, халамжаас хөдөлмөрт 222 арга хэмжээнд 107 иргэнийг хамруулж, 8 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн зээлийн өмнөх сургалтад, 9 иргэнийг мэргэжил олгох сургалтад хамрууллаа.</p> <p>Тайлант онд нийт 151 иргэнийг халамжаас хөдөлмөрт шилжүүлснээс 10 өрхийн 20 иргэнийг малжуулах арга хэмжээнд, байнгын ажлын байранд 60 иргэн, түр ажлын байранд 71 иргэнийг тус тус хамрууллаа.</p> <p>Мөн аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй гэрээлэн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах 4 төрлийн сургалтыг 50 иргэнд үе шаттай зохион байгуулж, цаашид өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой 20 өрхөд 36,0 сая төгрөгийн тусламж үзүүлэх юм.</p>	
99	Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газарт цахилгаан шат худалдан авах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	10	<p>Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар нь 2024 оны 10 дугаар сарын 06-ны өдөр шинэ барилгын нээлтээ хийж 18 асруулагч ахмадаа хүлээн авсан.</p> <p>Асрамжид буй тэргэнцэртэй ахмадуудыг барилгын дотоод болон гадаад орчинд саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цахилгаан шат суурилуулах шаардлагатай байгаа тул уг цахилгаан шатны төсвийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж өгөхийг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 200 дугаартай албан бичгээр аймгийн Засаг даргад, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраар дамжуулан ЖАЙКА төсөлд хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна. Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас цахилгаан шатны зургийн даалгаврыг хийлгэсэн.</p>	10
100	Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан	Нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	Тоо	2024	81/11000	82/15000	117/27392	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	100

	сэргийлэх, эрүүл, идэвхтэй зан үйлийг төлөвшүүлэх, иргэдийг дасгал хөдөлгөөн хийхэд уриалах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх							<p>ажлын хүрээнд эрүүл идэвхтэй зан үйлийг төлөвшүүлэх 117 тэмцээн, арга хэмжээг (аймгийн төвд 50, сумдад 67) зохион байгуулж, давхардсан тоогоор 51015 иргэнийг хамруулсан. Үүнд: Говийн бүсийн "Иргэдийн спортын их наадамд" 4 аймгийн 800 гаруй тамирчин оролцож 40,0 сая төгрөг зарцуулсан. "Сайншанд марафон-2025", уулын дугуйн тэмцээн, хүүхдүүдийн марафон тэмцээнд нийтдээ 1848 тамирчин, флаш моб, хийн дасгал, ажлын байрны түмэн дасгал, явган алхалт, шугаман болон нийтийн бүжиг зэрэгт 5202 иргэн хамрагдсан.</p> <p>Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, эрүүл бие бялдрыг хөгжүүлэхэд зориулж 2025 онд Сайншанд суманд 2 дугаар багт нийтийн биеийн тамирын талбайг шинээр байгуулж, Алтанширээ сумын спорт заалны барилгын ажил 95%-тай явагдаж байна.</p> <p>Тайлант онд 117 арга хэмжээнд оролцсон иргэдийн тоо 27392 буюу өмнө оноос 33,6%-иар, идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамрагддаг иргэдийн тоо 18,1%-иар өсөж, биеийн тамираар тасралтгүй хичээллэдэг болсон.</p>	
101	Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлэх	Системд бүртгэгдсэн иргэдийн тоо	Тоо	2024	3683	4654	<p>Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус 52 байгууллагын 18-64 нас, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 3-17 насны 4654 иргэдийг хамруулсан. Үүнээс А үнэлгээтэй 1109 хүн буюу 24%, В үнэлгээтэй 971 хүн буюу 21%, С үнэлгээтэй 965 хүн буюу 21%, D үнэлгээтэй 640 хүн буюу 14%, F үнэлгээтэй 969 хүн буюу 20%-ийг тус тус эзэлж байна. C,D,F үнэлгээтэй иргэдэд гарын авлага тарааж, өглөө ажилдаа алхаж ирэх болон ажлын байрны дасгалуудыг тогтмол хийх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгсөн.</p>	100	
102	Спортыг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Спортын төрлийн тоо	Тоо	2024	12	13	<p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоо, клубүүдтэй гэрээ байгуулж, спортын 13 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 20000 өсвөр болон насанд хүрэгчид хамрагдсан.</p> <p>Биеийн тамир спортын газар 43 аж ахуй нэгж, байгууллагатай заалаар үйлчлэх гэрээ байгуулан</p>	100	

								<p>давхардсан тоогоор 7495 иргэн, шугаман бүжгээр давхардсан тоогоор 2530 иргэн, спортын үйл ажиллагаанд 27392 иргэнийг хамруулсан. Мөн 29 тэмцээн уралдааныг зохион байгуулж 7107 тамирчин оролцлоо.</p> <p>Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдагчдын тоо өмнө оноос 5,9%-иар өссөн. Орон нутагт шинэ тутам хөгжиж байгаа модон барилдаан, жүдо бөхийн төрлөөр нийтдээ 80 хүүхэд хичээллэж байна. Шинээр Кудо тулааны спортын төрөлд 50 хүүхэд хичээллэж байгаагаас 15 хүүхдийн бүрэлдэхүүнтэй өсвөрийн шигшээ багийг бүрдүүлж улсын аварга шалгаруулах 5 тэмцээнд 35 медаль, олон улсын 1 тэмцээнд 16 медаль хүртэн амжилтыг үзүүлсэн.</p> <p>Орон нутгаас спортын төрлүүдийг жигд хөгжүүлэн, бүх төрлийг дэмжин биеийн тамир, спортын арга хэмжээнд 226,3 сая, уралдаан, тэмцээнд оролцох баг, тамирчдын тэмцээний болон замын зардалд 90,9 сая, тив дэлхий, олон улс, улсын хэмжээний тэмцээнд орон нутгийнхаа нэрийг гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах арга хэмжээнд 131,4 сая төгрөг, спортын дасгалжуулагч, арга зүйчдийг мэргэшүүлэх, чадваржуулах сургалтад хамруулахад 5,7 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Үүний үр дүнд спортоор хичээллэдэг тамирчдын тоо 25,7%-иар өссөн.</p> <p>Үүний үр дүнд спортоор хичээллэдэг тамирчдын тоо 25,7%-иар, идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамрагддаг иргэдийн тоо 33,6%-иар өсөж, нийт хүн амын 18,1% биеийн тамираар тасралтгүй хичээллэдэг болсон.</p>	
103	Шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг улс, тив, Дэлхий, олимпын түвшинд хүргэх	Шигшээ багийн тоо	Тоо	2024	11	12	12	<p>Аймаг орон нутгаа төлөөлөн оролцох шигшээ багийг бий болгох, залгамж халааг бэлтгэх зорилгоор орон нутагтаа улсын болон аймгийн аварга шалгаруулах 17 арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд спортын 13 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, бокс, чөлөөт бөх, жүдо, хөл бөмбөг, гандбол зэрэг) шигшээ баг хичээллэдэг.</p>	100
		Медалийн тоо	Тоо	2024	298	310	355		

								<p>Шигшээ багт нийтдээ 575 тамирчид хамрагдаж байна.</p> <p>Нийтийн биеийн тамир, спортын 117 тэмцээн, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 51015 иргэнийг хамруулсан.</p> <p>Үүнээс спортын тэмцээн уралдаанд оролцсон тамирчдын тоо 12874, өмнө оноос тамирчдын тоо 34,7%-иар өссөн байна.</p> <p>Орон нутгаас шигшээ багийн үйл ажиллагааг дэмжин Монголын хүүхдийн спортын VIII наадамд 122 тамирчин, Австри улсын Клагенфурт хотод зохион байгуулагдах олон улсын “United World Games”, өсвөрийн U15 насны улсын аварга шалгаруулах тэмцээн, 19 дэх удаагийн Улсын аварга шалгаруулах Пауэрлифтингийн тэмцээн, Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадам, Говийн бүсийн “Иргэдийн спортын их наадам” зэрэг олон улс, улсын зэрэглэлтэй тэмцээн, арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, нийт 355 медаль хүртсэн.</p> <p>Тайланд онд спортоор хичээллэгчдийн тоо 3 дахин, медалийн чанар 25,8 хувиар өслөө.</p>	
104	Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулах	Сургалт, арга хэмжээний тоо	Тоо	2024	3	5	5	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос өсвөрийн шигшээ багийн тамирчдын бие бялдрын хөгжлийг хэмжих, сэтгэл зүй, хоол шим тэжээлийн байдлыг шалгах, шинжлэх ухаан, анагаах ухааны мэдлэг, арга зүйн зөвлөмж өгөх сургалтыг зохион байгуулж, 50 багш, дасгалжуулагч хамрагдсан. БНХАУ-ын Өвөр Монголын Туняло хотод зохион байгуулсан 14 хоногийн бэлтгэл, туршлага солилцох үйл ажиллагаанд Чөлөөт бөхийн 2 дасгалжуулагч, өсвөр үеийн 11 тамирчин оролцлоо.</p> <p>Олон Улсын Олимпын Хорооны “Эв санааны нэгдлийн хөтөлбөр”-ийн хүрээнд биеийн тамирын багш, арга зүйч нараар дамжуулан спорт, олимпын үзэл санааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, спорт, олимпын хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг хүргэх, хувь хүний хөгжлийг дэмжих, “Олимпын үнэт зүйлсийн боловсролын хөтөлбөр”-т сургах зорилго бүхий сургалтыг 50 спортын дасгалжуулагчдыг хамруулан зохион байгууллаа.</p>	100

								<p>Оросын холбооны улс руу Тийболын спортын сургагч багшаар бэлтгэх, сурталчлах, туршлага судлах зорилгоор аймгийн ЕБС-ийн 2 багшийн замын зардалд 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, сургалтад хамруулсан. Мөн аймгийн 6-н сургуулийн биеийн тамирын багш нарыг Улаанбаатар хот руу Тийболын спортын танхимын сургалтад хамруулж, 750,0 мянган төгрөгийн замын зардлыг шийдвэрлэсэн.</p> <p>Тайлант онд 5 сургалт, мэргэшүүлэх үйл ажиллагаанд 112 багш, дасгалжуулагч, арга зүйч нарыг оролцуулж, 11,0 сая төгрөгийн замын зардлын дэмжлэг үзүүллээ.</p>	
105	Спортын авьяасыг нээн илрүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлж, хөгжих боломжийг олгох	Арга хэмжээний тоо	Тоо	2024	3	4	29	<p>Тайлант онд спортын авьяасыг нээн илрүүлэх, тамирчид, дасгалжуулагчдад дэмжлэг үзүүлэх, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор спортын холбоодтой хамтран Олон улсын тэмцээн 3, Улсын аварга 4, аймгийн аварга шалгаруулах 22, нийт 29 тэмцээн уралдааныг аймаг орон нутагтаа зохион байгуулсан. Монголын бүх ард түмний XVI наадам, Хүүхдийн спортын VIII их наадам, Говийн бүсийн шатарчдын улсын аварга, Говийн бүсийн "Иргэдийн спортын их наадам", "Ирээдүй" хүүхдийн лиг, сонирхогчдын "Champions" сагсан бөмбөгийн лиг, 19 дэх удаагийн Улсын аварга шалгаруулах Пауэрлифтингийн тэмцээн, "Дорноговь опен" жюү жицүгийн Олон Улсын нээлттэй тэмцээн зэрэг 29 арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулж, нийтдээ 313.3 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлж, спортоор хичээллэгчдийн тоо 12874 буюу өмнө оноос 35,3%-иар өссөн үзүүлэлттэй байна.</p>	100
106	Алтанширээ суманд спорт заал барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	95	<p>Алтанширээ суманд спорт заал шинээр барих ажил орон нутгийн 1.946 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, гүйцэтгэгчээр "ЭИБОЛ" ХХК ажиллаж байна. Барилгын каркас, дээврийн хучилт бүрэн хийгдэж, дотор заслын ажил үргэлжилж байгаа бөгөөд нийт гүйцэтгэл 95%-тай байна.</p>	95
107	Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн баруун талд	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	90	100	100	<p>Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн баруун талд Нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажлыг "Сутайн жинст" ХХК Орон нутгийн төсвийн 712,1 сая төгрөгийн</p>	100

	Нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах							хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.	
108	Сайншанд сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт тоглоомын талбай байгуулах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн хөгжлийн сангийн 196.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 4 дүгээр багт 2 байршилд тоглоомын талбай байгуулах ажлыг "Эгнэгт өрнөх" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	100
109	"Мэдээллийн цаг-444" үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хамрагдсан асран хамгаалагчдын тоо	Тоо	2024	5000	8000	8600	Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагч олон нийтэд сурталчлах зорилгоор 2025 онд "Мэдээллийн цаг-444" үйл ажиллагааг төрийн болон төрийн бус 127 байгууллагатай хамтран зохион байгуулж 243 үйл ажиллагаанд давхардаагүй тоогоор 1597 багш, ажилтан, 5197 суралцагч, 8600 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан сургалтын байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшил, зөв дадал хэвшил бий болгох нөлөөллийн ажлуудыг зохион байгуулснаар багш, эцэг эх, суралцагчийн хамтын ажиллагаа сайжирлаа.	100
110	Суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх "Төслийн цаг" үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Үр дүнтэй хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Тоо	2024	4	5	9	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг хөгжлийг дэмжих, асуудлыг шийдвэрлэх, бие даан суралцах, бусадтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах, бүтээлч, инженерчлэл сэтгэлгээний чадварыг хөгжүүлэх зорилгоор "Төслийн цаг" үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үйл ажиллагаанд 21 сургуулийн 6-12 дугаар ангийн 7688 суралцагч 38 төсөлд хамрагдан, 6 сургууль төслийн цагийн үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлсэн. Үүнд: Замын-Үүд сумын 2 дугаар сургуулийн "Холивол хог ангилбал баялаг", "Шагайн наадгай", Айраг сумын сургуулийн "Уншиж ойлгох чадварыг хөгжүүлэх нь", "Дизайн технологи бидний амьдралд", "Цаг баримтлах 7:50 шугам", Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн "Гүн суулгац" говийн 11 төрлийн ховор ургамал тарих, Замын-Үүд сумын 3 дугаар сургуулийн "Гэрэлт цохны жим", Хатанбулаг сумын сургуулийн "Өөхөн тосоор саван хийх", Хөвсгөл сумын сургуулийн "Зөв хүмүүжил зөв иргэн" зэрэг 9 төслийг үр дүнтэй хэрэгжүүлж, нийт 2126	100

								суралцагчийг хамруулснаар суралцагчид багаар ажиллах чадвар, өв уламжлалаа танин мэдэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, эрүүл ахуй, амьдралын зөв дадал хэвшилд суралцсан.	
111	Дижитал технологи дээр суурилсан тэгш хүртээмжтэй сургалтын системийг хөгжүүлэх	Сургалтын системийг нэвтрүүлсэн сургуулийн тоо	Тоо	2024	21	22	22	<p>Боловсролын сайдын 2025 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан "Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам"-ын дагуу 2025-2026 оны хичээлийн жилд "Их нүүдэл", "Edumar" гэсэн 2 төрлийн цахим системийг ерөнхий боловсролын 22 сургуульд нэвтрүүлж, "Edumar" системийг 20 сургуулийн 14127 суралцагч, "Их нүүдэл" системийг 2 сургуулийн 2250 суралцагч, нийт 16377 суралцагчийг хамруулан үндсэн мэдээллийн бүртгэл хийсэн.</p> <p>2024-2025 оны хичээлийн жилд цахим системээр дамжуулан нийт 14143 суралцагчийн анги дэвшилт, 9 дүгээр ангийн 1296 суралцагч, 12 дугаар ангийн 765 суралцагчийн дэвшилтийг зохион байгуулсан.</p> <p>Мөн Medle.mn цахим сургуульд ерөнхий боловсролын сургуулийн 6 багш багшилж, 212 суралцагч амжилттай суралцсан.</p> <p>Ерөнхий боловсролын 22 сургууль 2025 онд цахим системийг нэвтрүүлэн ашиглалаа.</p>	100
112	Монгол өв соёл, ухаанд суурилсан орон нутгийн онцлогтой төслийг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлж нийтэд тайлагнасан сургууль, цэцэрлэгийн тоо	Тоо	2024	2	5	7	<p>Орон нутгийн онцлогтой хөтөлбөрийн зорилго нь монгол ахуй, өв соёл, зан заншлаа танин мэдэх, түгээн дэлгэрүүлэх, байгаль орчин, эх орон, эх дэлхийгээ хайрлан хамгаалахад суралцан, чөлөөтэй сэтгэх, мэдрэмжээ хуваалцах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд оршино.</p> <p>2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 21 сургууль, 33 цэцэрлэг орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан. Уг үйл ажиллагаанд сум орон нутгийн удирдлага 23, багш 544, суралцагч 11205, эцэг эх 5697, сургуулийн өмнөх боловсролын хүүхэд 425, төр болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчид 1843 давхардаагүй тоогоор нийт 19718 хүн хамрагдлаа.</p> <p>Ерөнхий боловсролын 5 сургууль, 2 цэцэрлэг нийт 7 сургалтын байгууллага үйл ажиллагааны үр дүнгээ олон нийтэд тайлагнасан нь өмнөх оны хичээлийн жилээс 5 байгууллагаар нэмэгдсэн. Үүнд:</p>	100

								Сайншанд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль "Монгол гэр", Сайншанд сумын 2 дугаар сургууль " Хутагтын үр сад", Мандах сумын сургууль "Мандахын улаан тэмээ", Хөвсгөл сумын сургууль, цэцэрлэг " Үхэр судлал", Дэлгэрэх сумын сургууль, цэцэрлэг "Шинэ зууны малчин", "Нүүдэллэх ёсон ба тэмээний соёл" гэсэн орон нутгийн онцлогтой хөтөлбөрийн хэрэгжилтийг сум орон нутгийн иргэдэд тайлагнаж танилцууллаа.	
113	Унших чадвар, математик сэтгэлгээг хөгжүүлэх агуулга боловсруулан хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо	Тоо	2024	0	3000	3095	Аймгийн ерөнхий боловсролын 22 сургуулийн 6 дугаар ангийн 1573 суралцагчийн математик сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэг чадвараа хэрэглээ болгох чадварыг хөгжүүлэх зорилгоор MS1A хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэхээр хөтөлбөр боловсруулсан. Хөтөлбөрийн хувьд "Натурал тоо", "Аравтын бутархай", "Бүхэл тоон олонлогт үйлдэл хийх " агуулгыг эзэмшүүлэхийн тулд 2025-2026 оны хичээлийн жилд төлөвлөгөөний дагуу сургагч багш MS1 хөтөлбөрийг хэрэгжүүлэх, MS1 олимпиад, түүнд бэлтгэх тухай, багш нарын мэргэжил арга зүйг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж , төвийн сургуулийн 18 багш танхимаар, 26 багшийг цахимаар хамрууллаа.	100
		Сургалтад хамрагдсан багшийн тоо	Тоо	2024	0	70	106	<p>Ерөнхий боловсролын 6 дугаар ангийн суралцагчдаас тусгай стандартын дагуу оношлох шалгалт авахад 1518 сурагч хамрагдаж 39,3%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. Монгол хэл, уран зохиолын хичээлээр 6 дугаар ангийн суралцагчдын уншиж, ойлгох чадварыг хөгжүүлэхэд багш нарын арга зүйд дэмжлэг үзүүлэх замаар эхийг уншиж ойлгох, хам сэдвийн хүрээнд тусган хүлээн авах, ойлгосноо бичгээр болон амаар илэрхийлэх чадварыг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөрийг эхлүүлээ.</p> <p>2025-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 6 дугаар ангийн суралцагчдаас гарааны үнэлгээ авахад 53,1%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн.</p> <p>Хөтөлбөрийн сорилд математик судлагдахуунаар 1577, монгол хэлний судлагдахуунаар 1518, нийт 3095 суралцагч хамрагдаж, "Багшийн хөгжил-Сургалтын арга зүй" сургалтад математик, монгол хэлний судлагдахууны</p>	

								106 багш хамрагдаж, унших чадвар, математик сэтгэлгээг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.	
114	Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн олон улсын Кембрижийн агуулгыг нэвтрүүлж эхлэх	Хэрэгжилтийн хувь	Хувь	2024	30	50	50	<p>Олон улсын сурлагын амжилтын үнэлгээ (PISA)-г ахиулах, Монгол өв ухаан хөтөлбөртэй уялдуулан дэлхийн боловсролыг орон нутагтаа эзэмших боломжийг олгох зорилгоор Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуульд хөтөлбөр хэрэгжих бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Уг ажлын хүрээнд тус сургуулийн 5 удирдах ажилтан, 2 багш Улаанбаатар хотын олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын 5 сургуулийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежментийн сургалтад хамрагдаж, сургуулийнхаа 40 багшид сургалт зохион байгуулснаар олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх мэдээлэлтэй боллоо.</p> <p>Багш нарын англи хэлний түвшин болон цахим орчинд ажиллах чадварыг дээшлүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Багш нарын англи хэлний мэдлэгийн түвшнийг тогтоож 3 түвшний сургалтыг англи хэлний багш нар зохион байгуулж, 38 багшийг хамрууллаа.</p> <p>"Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийг цахим системд нэвтрүүлэх" сургалтыг Сайншанд сумын ерөнхий боловсролын 3 , 6 дугаар сургуулийн байгалийн ухааны 15 багшийг хамруулан зохион байгуулсан. Үндсэн сургалтад танхимаар хамрагдсан 140 гаруй багшид Mozaik программыг танилцуулж, түгээн дэлгэрүүлэлт хийлээ.</p> <p>Олон улсын хөтөлбөрийн англи хэл, математик, байгалийн ухааны хичээлүүдийн агуулгыг судалж үндэсний хөтөлбөртэй харьцуулж, хэлэлцүүлсэн. Олон улсын eduten,pearson, mozaik, chatgpt, google gemini, coreldraw программуудыг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж, хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд гүйцэтгэл 50%-тай байна.</p>	100
115	Төр, хувийн хэвшлийн	Сургалтын төвийн тоо	Тоо	2024	0	1	1	Бүгд найрамдах Хятад ард улсаас Замын-Үүд суманд суугаа ерөнхий консулын дэмжлэгээр хятад	100

	түншлэлээр олон улсын хэлний сургалтын төв байгуулах	Сургалтад хамрагдсан суралцагчдын тоо	Тоо	2024	0	25	30	<p>хэлийг сурах боломжоор хангасан "Дижитал төв"-ийг 47,5 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд байгуулсан. Дижитал төвийг түшиглэн Сайншанд суманд хятад хэл сурах сонирхолтой суралцагчдад сурах боломжийг олгох зорилгоор Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дэргэдэх Хятад хэлний сургалтын төвийн үйл ажиллагааг тухайн сургуульд эхлүүлж, бага ангийн 30 суралцагчид 7 хоногт 2 удаа хятад хэлний анхан шатны сургалт, үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>Мөн Сайншанд сумын 1, 2, 3, 5, 6 дугаар сургуулийн хятад хэл сурах хүсэлтэй 150 суралцагчид хэл, соёлын өдөрлөг арга хэмжээ зохион байгуулсан.</p> <p>Дорноговь аймаг ОХУ-ын Эрхүү муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд "Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэл", "Улаанбаатар дахь Орос ордон-Оросын Шинжлэх ухаан, соёлын төв-РЦНК"-аас Иххэт сумын ерөнхий боловсролын сургуульд "Орос хэлний төв"-ийг байгууллаа.</p> <p>Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дэргэд "Хятад хэлний сургалтын төв" 2018 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа ба 2024-2025 оны хичээлийн жилд 300 суралцагч хамрагдаж байна.</p> <p>Ерөнхий боловсролын сургуульд 2025 онд шинээр 1 сургалтын төв байгуулж, хятад хэлний анхан шатны сургалтад 30 суралцагчийг хамруулж байна.</p>	
116	Төрөлжсөн ахлах сургууль байгуулах ажлыг судлах	Хэрэгжилтийн хувь	Хувь	2024	0	30	30	<p>Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/188 дугаар тушаалын дагуу Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийг аймгийн хөгжлийн бодлогод тулгуурлан "Байгалийн ухааны" чиглэлээр төрөлжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>2025-2026 оны хичээлийн жилд байгалийн ухааны хичээлээр байгаль дахь судалгаат хичээлийг аймгийн хэмжээний 9 дүгээр ангийн 1352 суралцагчийн дунд зохион байгуулахад Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 169 сурагч хамрагдаж судалгаат хичээл, хэлэлцүүлэг хийх арга барилд суралцсан. Төрөлжсөн ахлах сургуулийн</p>	100

								<p>хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр аймгийн 136 багшийг магистрын хөтөлбөрт хамруулахаар төлөвлөгөө гарган ажиллалаа.</p> <p>Аймгийн төвийн сургуулиудад энэ хичээлийн жилд 10-12 дугаар ангийн нийт 1614 суралцагч сурч байгаа бөгөөд барилгын багтаамж, хүүхдийн тооноос шалтгаалан 2026-2027 онд төрөлжсөн ахлах сургууль руу бүрэн шилжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бэлтгэл ажил 30%-тай байна.</p>	
117	Сургуулийн өмнөх боловсролын ирээдүйн инженерүүд буюу "2И" төслийг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Тоо	2024	3	33	35	<p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/82 дугаар захирамжаар бага насны суралцагчдын инженер, бүтээлч сэтгэлгээ, танин мэдэхүйг хөгжүүлэх, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг дээшлүүлэх зорилгоор "2И буюу Ирээдүйн инженерүүд" төсөл, хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 4800 суралцагч, төмөр замын 2 цэцэрлэгийн 500 суралцагч, нийт 35 цэцэрлэгийн 5300 суралцагчийг хамруулан хэрэгжүүлсэн нь өмнөх оноос 29 цэцэрлэгээр нэмэгдлээ.</p> <p>Уг хэрэглэгдэхүүнийг сургалтад ашиглах багш нарын арга зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сар бүрийн 2 дахь долоо хоног мягмар гариг бүр цахим болон танхимын нийт 10 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, говийн бүсийн аймгуудын сургалт, орон нутгийн түвшний сургалтад нийт 416 гаруй удирдах ажилтан, багш нарыг хамруулан шинэ сургалтын хөтөлбөрийн мэдлэг ойлголтоо нэгтгэн STEAM хэрэглэгдэхүүнийг сургалтын чиглэл бүрийн нийт 74 суралцахуйн үр дүнд уялдуулан өдөр тутмын сургалт үйл ажиллагааны явцад хэрэгжүүлж хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшихүй, биеийн том жижиг булчингийн хөгжлийг дэмжин хүүхдийн судлан шинжлэх, харилцааны ур чадвар, бие даан суралцах, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, сэтгэн бодох,технологитой харьцах, бүтээлч чадвар зэрэг чадварын суурь хөгжлийг дэмжлээ.</p> <p>Төсөл, хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн нийт 330,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар STEAM сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан ба нийт давхардсан тоогоор 544 сургалт, үйл ажиллагаанд 10670 суралцагч хамруулсан.</p>	100

								Нэмэлтээр 3966 ширхэг сургалтын материал олшруулж сургалт, үйл ажиллагаанд ашигласан.	
118	Ерөнхий боловсролын сургуулийн “Англи хэлтэй Дорноговь” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хамрагдсан хүүхдийн тоо	Хувь	2024	0	3500	8305	<p>Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчдад зориулсан англи хэлний хөтөлбөрийн 2025 оны үйл ажиллагааны 5 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд “Xreading цахим номын сан”-гийн Монгол дахь төлөөлөгч “Лингорс” боловсролын байгууллагын 291,8 сая төгрөгийн санхүүжилтээр “Англи хэлээр уншигч анги” болгох суурь нөхцөлийг бүрдүүлэх, англи хэлний үгсийн санг нэмэгдүүлэх, унших, сонсох, бичих, ярих чадварыг сайжруулах, IELTS-ийн шалгалт өгөх бэлтгэлийг хангах зорилгоор “Бүтээлч уншигчид” төслийг аймгийн хэмжээнд амжилттай хэрэгжүүллээ.</p> <p>Уг төсөлд ерөнхий боловсролын 21 сургуулийн англи хэлний 74, анги удирдсан 281 багш, 6-12 дугаар ангийн 8305 суралцагчийг хамруулсан. “Бүтээлч уншигчид” төслийн аймгийн шилдэг сургууль, багш, суралцагч, ангиудыг шалгаруулсан. Дэээрэт, Энх тайвны корпусын 6 мэргэжилтэн болон англи хэлний мэргэжлийн хөгжлийн бүлэг хамтран 4 чиглэлээр 54 арга хэмжээ зохион байгуулж 10000 гаруй суралцагчийг хамруулж хөгжүүлсэн. Солонгос улсад зохион байгуулагдсан 32 дахь удаагийн “КОТЕСОЛ” олон улсын хурал, хэл соёлын арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 26 багш амжилттай оролцож батламж авсан.</p> <p>Дэээрэт байгууллагатай хамтран англи хэлний багш нарын заах арга зүйг сайжруулах зорилгоор Америкийн нэгдсэн улсаас их сургуулийн хэл шинжлэлийн 5 профессорыг урьж 80 багшид “Англи хэлний заах аргын сургалт”-ыг аймагтаа анх удаа амжилттай зохион байгуулсан.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний хөтөлбөрийн 2025 оны төлөвлөсөн ажил 100%-тай хэрэгжлээ.</p> <p>Мөн “Бүтээлч уншигчид” хөтөлбөрт ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 8305 суралцагч, англи хэлний 74, анги удирдсан 281 багш хамрагдсаны үр дүнд 13 суралцагч IELTS-ийн оноо</p>	100

								авсны 4 суралцагч нь элсэлтийн шалгалтын 800 оноог дүйцүүлсэн. 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтаар суралцагчдын англи хэлний бичгийн шалгалт 52,5 %-тай үнэлэгдсэн нь өмнөх оны үнэлгээнээс 11,3%-иар ахисан.	
119	“Сүү” хөтөлбөрийг боловсролын сургалтын байгууллагад хэрэгжүүлэх	Сүү хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Тоо	2024	23	33	33	Бага насны хүүхдүүдийн сүүний хоногийн хэрэгцээг хангах замаар эрүүл мэнд, өсөлт хөгжилд дэмжлэг үзүүлж, амьдралын зөв зохистой дадал хэвшилд сургах зорилгоор аймгийн хэмжээний төрийн өмчийн 33 хүүхдийн цэцэрлэгийн нийт 4797 суралцагчийг хамруулан “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүллээ. “Сүү” хөтөлбөрийн үр дүнг хэмжих зорилгоор төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 3485 суралцагчийн биеийн өндөр, жинг хянаж, шүдний урьдчилан сэргийлэх үзлэг болон эрдсийн шинжилгээнд хамруулан судалгаа гарган ажилласан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/79 дүгээр захирамжаар орон нутгийн төсвийн 272,7 сая төгрөгөөр санхүүжүүлж төрийн өмчийн цэцэрлэгийн суралцагчийг 100% хамруулсан. Мөн орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжин хамтран ажиллаж, төвийн 13 цэцэрлэгийн 2151 суралцагч, төмөр замын цэцэрлэгийн 193 суралцагчид 7 хоногт хүүхэд бүрд 1 удаа 50 мл-ээр ингэний сүүг "Хашаатын говийн заг" ХХК-иас нийлүүлдэг. Бусад өдрүүдэд “Өгөөж эрдэнэ дэлгэрэх” ХХК, “Цагаан сүүний буян” ХХК, “Борхойн сүү” ХХК-иуд хэрэгцээт сүүг нийлүүлж ажилласан. Үр дүнд суралцагчдын дархлаа сайжирч, кальцийн хэрэглээ нэмэгдэж, шүдний өвчлөл 4-3%, өндрийн үзүүлэлтэд хүрэхгүй байгаа хүүхдийн тоо 0.5% болж буурсан.	100
120	“Үдийн хоол” хөтөлбөрийг ЕБС-ийн дунд ангид хэрэгжүүлж, хоолны шим тэжээлийг нэмэгдүүлэх	Үдийн хоолыг дунд ангид хэрэгжүүлсэн сургуулийн тоо	Тоо	2024	2	21	22	Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн үзүүлэлт, судалгааг үндэслэн суралцагчдын уураг, амин дэмийн хэрэглээг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй, чанартай хоол хүнсээр хангах, суралцах анхаарал төвлөрлийг сайжруулах, сурлагын чанарт ахиц гаргах зорилгоор “Үдийн хоол” хөтөлбөрийг аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 22 сургуулийн 6-9 дүгээр	100

								<p>ангийн нийт 5977 суралцагчийг хамруулан хэрэгжүүлээ.</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/81 дүгээр захирамжаар "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвийн 926,6 сая төгрөгийг шийдвэрлэсэн ба "Үдийн хоол"-ыг ерөнхий боловсролын 22 сургууль өөрийн цайны газарт бэлтгэн ажиллаж байна.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны 04 дүгээр сар болон 09 дүгээр сард авч, ерөнхий боловсролын 22 сургуулийн нийт 4563 суралцагч, 4520 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан.</p> <p>Үр дүнд сурах идэвх, анхаарал төвлөрөл 15%, хүнсний ногооны хэрэглээ 14%, эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдын сэтгэл ханамж 15%-иар тус тус нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.</p> <p>Төвийн болон баруун бүсийн 26 цэцэрлэг, 14 сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний явц болон хоолны чанарт хяналт шалгалт 1 удаа буюу нийт 40 байгууллагад зохион байгуулсан.</p>	
121	"Сайн багшийг таны дэргэд" арга хэмжээг хэрэгжүүлэх	Сургалтад хамрагдсан багшийн тоо	Тоо	2024	1017	1200	2510	<p>Сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжих чадавхжуулах зорилгоор дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: Аймгийн Засаг даргын 2025 оны А/80 дугаар захирамжаар 40,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж цэцэрлэг, сургуулийн 1100 багш, ажилтанд "Багшийн хөгжил-сургалтын арга зүй" танхимын сургалт, зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй 21 бага боловсролын багшийг ерөнхий боловсролын сургуульд "Ментор багш"-аар сэлгэн ажиллуулах, багшийн хөгжил хариуцсан 21 сургалтын менежерийг чадавхжуулах сургалт, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд 5, 10, 15, 20 дахь жилдээ ажиллаж байгаа 126 багш, 2, 7, 12 жилдээ ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн 19 удирдах ажилтан хамрагдаж эргэцүүлэлд суурилсан багшлахуй, суралцахуйн мэдлэг чадвараа дээшлүүлээ.</p> <p>Мөн "Боловсролын бодлого, анхаарах асуудал" сэдвээр багш нарын бага хурлыг зохион байгуулж 998 багш, удирдах ажилтанд, Пийрсон хөтөлбөрийн</p>	100

							<p>хэрэгжилтийг сайжруулах хүрээнд 51 багш, Дээрэт олон улсын байгууллагаас англи хэлний багш нарыг чадавхжуулах сургалтад 80 багш, сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх "Дэмжлэгийн баг"-ийг бэлтгэх үндэсний сургалтад эрхлэгч, арга зүйч, Боловсролын газрын арга зүйч 12 хүн, бүсийн сургагч багш бэлтгэх сургалтад 82 багш, удирдах ажилтныг тус тус хамруулсан.</p> <p>Багш нарын мэргэжлийн ур чадвар, заах арга зүйг тогтмол дээшлүүлэн ажилласны үр дүнд Боловсролын сайдын 2025 оны А/489 дүгээр тушаалаар 2 багш "Зөвлөх багш" мэргэшлийн зэрэг, Боловсролын газрын даргын 2025 оны Б/41 дүгээр тушаалаар Тэргүүлэх зэрэгтэй багш, удирдах ажилтан 48-аар нэмэгдсэн. Боловсролын газраас удирдан чиглүүлдэг судлагдахуунд суурилсан 13 мэргэжлийн бүлгээр 9 удаа давхардсан тоогоор 6543 багшид арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Мөн багш нарын онол, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төрөлжсөн сургалт зохион байгуулж 54 багшаас сургалтын хэрэгцээ тодорхойлох саналыг авч нэгтгэхэд 3816 санал гарсныг нэгтгэн 954 багшид онолын болон багшлахуй суралцахуйн хөгжлийг дэмжсэн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Нийт давхардсан тоогоор 1004 багш туршлагаа түгээж, 9 удаагийн сургалтад 2510 багш, удирдах ажилтныг хамрууллаа.</p>		
122	Багш нарын сурган хүмүүжүүлэх илтгэл, сайн хичээл ур чадварын уралдаан зохион байгуулах	Хоёр дугаар шатны шалгаруулалтад оролцсон багш	Тоо	2024	39	45	98	<p>2024-2025 оны хичээлийн жилийн Улсын оны шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний хуралд аймгаас шалгарсан Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн багш Д.Алтанхуяг ахлагчтай 3 багшийн баг "Математик, мэдээллийн технологийн судлагдахуун дахь дунд ангийн хөтөлбөрийн агуулгын давхцалд интеграци хийн хөтөлбөрийг шинэчлэх нь", Замын-Үүд сумын 7 дугаар цэцэрлэгийн багш Б.Оюунтөгөлдөр багшийн "Хүүхдийн хөгжилд шагайн тоглоомын үзүүлэх нөлөөлөл" илтгэлийг 2025 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод амжилттай хэлэлцүүлсэн.</p>	100

								<p>2025-2026 оны хичээлийн жилд “Боловсролын шинэчлэлд эцэг эхийн үүрэг,оролцоо” сэдэвт аймгийн багш нарын сурган хүмүүжүүлэх уншлагын уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, боловсролын сургалтын 42 байгууллагын 43 багшийн илтгэлийг хэлэлцүүлж, арга туршлагыг түгээн дэлгэрүүлсэн. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нэг нэг шилдэг илтгэлийг улсын уралдаанд оролцуулахаар шалгаруулсан.</p> <p>Боловсролын сургалтын байгууллагын багш нарын дунд “Хүүхэд төвт идэвхтэй сургалтын арга зүй” сэдэвт сайн хичээл ур чадварын уралдааны 2 дугаар шатанд 55 багш оролцсоноос заах арга зүй, ур чадвараараа манлайлсан шилдэг 12 багшийг шалгаруулсан.</p> <p>Багш нарын сурган хүмүүжүүлэх илтгэлд, сайн хичээл ур чадварын уралдаанд нийт 98 багш оролцож, шилдэг арга зүйг түгээн дэлгэрүүлсэн.</p>	
123	Бүс, анги нийт, нэрэмжит олимпиад зохион байгуулах	Амжилт гаргасан багш, суралцагчдын тоо	Тоо	2024	93	253	239	<p>2024-2025 оны хичээлийн жилд зүүн бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан олимпиадад математик, мэдээлэл зүйн хичээлийн судлагдахуунаар оролцож, алтан медаль 1, мөнгөн медаль 6, хүрэл медаль 2, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтын байгууллагын улсын олимпиадад газар зүй, монгол хэл, нийгмийн хичээлийн судлагдахуунаар оролцож, алтан медаль 4, тусгай байр 1, улсын төрөлжсөн олимпиадад биологи, техник технологи, газар зүйн хичээлийн судлагдахуунаар оролцож, мөнгөн медаль 3, хүрэл медаль 1 хүртсэн амжилт үзүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд уламжлал болгон жил бүр зохион байгуулдаг "Анги хамт олны олимпиад"-ыг 12 судлагдахуун хичээлээр 2-3 шаттай зохион байгуулж, давхардсан тоогоор 21 сургуулийн 1-11 дүгээр ангийн 53300 суралцагчийг хамруулж, мэдлэг чадвараа сорин амжилттай оролцсоноос давхардсан тоогоор 63 анги, бүлгийн 1800 суралцагч шагналт байранд шалгарсан.</p> <p>Мөн Боловсролын ерөнхий газраас жил бүр зохион байгуулдаг 12 судлагдахууны улсын</p>	91.2

								<p>олимпиадын хоёрын даваанд амжилт гаргасан 45 багш, 105 суралцагчийг 5,0 сая төгрөгийн мөнгөн шагналаар урамшуулсан.</p> <p>Нийт ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 239 багш, суралцагчид улс, бүс, аймгийн олимпиадын шагналт байранд шалгарсан нь өмнөх оноос 146-иар өссөн ч зорилтот түвшинд хүрээгүй.</p> <p>Өмнөх хичээлийн жилд улс, бүсийн олимпиадад 3 багш, 9 суралцагч шагналт байр эзэлж байсан бол 2024-2025 оны хичээлийн жилд 5 багш, 17 суралцагч шагналт байр эзэлж, медалийн тоо, чанараа 10-аар ахиулсан амжилт үзүүлсэн.</p>	
124	"Багш авьяас" наадам зохион байгуулах	Оролцсон багш, ажилтны тоо	Тоо	2024	0	709	800	<p>Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд боловсролын салбарын албан хаагчдын хамтын ажиллагааг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, авьяаслаг "Шилдэг хамт олон"-ыг шалгаруулах зорилгоор "Багшийн авьяас-2025" урлагийн наадмыг 2 ангилал, 5 төрлөөр 2025 оны 10 дугаар сарын 02, 03-ны өдөр зохион байгууллаа. "Багшийн авьяас-2025" арга хэмжээнд аймгийн ИТХ-ын даргын 2025 оны 215 дугаар захирамжаар 3,0 сая төгрөг, "Юнител", "Edumar" ХХК-ий дэмжлэгээр нийт 18,9 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>"Багш авьяас-2025" урлагийн наадамд боловсролын сургалтын 56 байгууллагын 824 багш, ажилтан оролцсоноос Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Сайншанд сумын төвийн цэцэрлэгүүдийн 1 дүгээр баг, Сайхандулаан сумын ерөнхий боловсролын сургууль, Даланжаргалан сумын ерөнхий боловсролын сургууль шагналт байрт шалгарсан.</p>	100
125	"Алтан зул" наадам зохион байгуулах	Сургууль, цэцэрлэг, заах аргын нэгдлийн тоо	Тоо	2024	50	50	83	<p>Дорноговь аймгийн Нутгийн зөвлөлтэй хамтран боловсролын салбарт амжилт гарган ажиллаж буй, сайн туршлага, оновчтой санаачилгын эзэд "Шилдэг баг, хамт олон"-ыг тодруулан алдаршуулах, туршлагыг түгээн дэлгэрүүлж, бие биеэсээ суралцан хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор говийн бүсийн "Алтан зул-2025" наадмыг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа.</p>	100

								<p>“Алтан зул-2025” наадамд 48 байгууллагын 83 баг, хамт олны материал ирснээс 9 номинацид Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн 250 гаруй багш нэр дэвшин оролцож шилдгүүдийг шалгаруулсан. “Хүүхэд хамгааллын шилдэг баг”-аар Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, “Аж ахуйн шилдэг баг”-аар Дундговь аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын сургууль, “Шилдэг дотуур байр” шагналаар Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, “Шилдэг эцэг, эхийн зөвлөл, сургуулийн зөвлөл”-өөр Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ерөнхий боловсролын сургууль, “Сургуулийн өмнөх боловсролын шилдэг байгууллага”-аар Говьсүмбэр аймгийн хүүхдийн 5 дугаар цэцэрлэг, “Мэргэжлийн шилдэг бүлэг” шагналаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын ерөнхий боловсролын сургууль, “Суурь боловсролын шилдэг сургууль”-иар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургууль, “Бүрэн дунд боловсролын шилдэг сургууль”-иар Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль тус тус шалгарч, “Алтанзул” наадмын “Шилдгийн шилдэг номинаци” шагналаар Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын “Цэгцбилиг” сургууль шалгарсан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2023 онд "Алтан зул" наадмыг 7 төрлөөр 50 баг, хамт олныг оролцуулан зохион байгуулж байсан бол 2025 онд говийн бүсийн хэмжээнд өргөжүүлэн аймгийн Засаг даргын 2025 оны А/641, А/642, А/643 дугаар захирамжаар 95,6 сая, Нутгийн зөвлөлийн санхүүжилт 120,0 сая, нийт 215,6 сая төгрөгийг зарцуулж 9 төрлөөр Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн 83 баг, хамт олныг оролцууллаа.</p>	
126	Сэтгэл зүйчийн мэргэшүүлэх сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	Тоо	2024	0	3	3	<p>Аймгийн ерөнхий боловсролын 13 сургууль, хүүхдийн 2 цэцэрлэг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангагдсан нь өмнөх оноос 8-аар нэмэгдлээ.</p> <p>Энэ онд 10 сэтгэл зүйч сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 1887 суралцагчид, ганцаарчилсан</p>	100

								<p>зөвлөгөөг 996 багш, суралцагчид, сэтгэл зүйн сургалтыг 12726 хүнд хүргэж, нийт давхардсан тоогоор 15295 хүнд үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Зүүнбаянгийн сургуулийн сэтгэл зүйчид мэргэшүүлэх 45 хоногийн сургалтад, Сайншанд сумын 2 дугаар сургуулийн сэтгэл зүйч "Гэрэлт эргэлт" хөтөлбөрийн сургалтад, нийт 3 сэтгэл зүйч сургалтад хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүллээ.</p>	
127	"Мини робот" уралдаан зохион байгуулах	Хамрагдсан суралцагч	Тоо	2024	60	75	144	<p>Аймгийн ИТХ-ын даргын 2025 оны 88 дугаар захирамжаар 2,0 сая төгрөг, Хүүхэд хамгаалал, гэр бүл хөгжлийн газрын даргын 2025 оны А/21 дугаар тушаалаар 1,5 сая төгрөг болон бусад байгууллагуудын дэмжлэгээр нийт 6,9 сая төгрөг зарцуулж суралцагчдын багаар ажиллах, зохион бүтээсэн төхөөрөмжөөрөө даалгавар гүйцэтгэх, хичээлээр сурсан мэдлэг, чадвараа практикт туршин хэрэглэх, программчлалын ач холбогдлыг ойлгуулж инженер сэтгэлгээ, зохион бүтээх чадварыг хөгжүүлэх зорилгоор "Дорноговь робот-2025" өсвөрийн зохион бүтээгчдийн тэмцээнийг "Миниробот", "Ардуино робот" гэсэн үндсэн 2 төрөл, 5 насны ангиллаар амжилттай зохион байгууллаа.</p> <p>Тэмцээнд аймгийн ерөнхий боловсролын 9 сургуулийн 6-12 дугаар ангийн 56 багийн 144 суралцагч оролцсон. Тус тэмцээнээр дамжуулан суралцагчдын инженерийн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, бүтээлч багаар ажиллах чадвар дээшилж, программчлал болон электроникийн хэрэглээний ойлголт, сонирхол нэмэгдэж, манлайлах, хариуцлага хүлээх, харилцан суралцах чадвар төлөвшлөө.</p> <p>Мөн аймгийн хэмжээнд робот, инженерийн боловсролыг хөгжүүлэх нөхцөл бүрдэж, багш, суралцагчийн оролцоо, бүтээлч санаачилга, хандлага жилээс жилд нэмэгдэж 2024 онд 5 сургуулийн 60 суралцагч оролцож байсан бол 2025 онд 4 сургууль, 84 суралцагчаар өссөн байна.</p>	100
128	Д.Равжаагийн "Цагийн жамыг	Хамрагдсан хүний тоо	Тоо	2024	0	15	13	<p>Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын 1,7 сая төгрөгийн дэмжлэгээр Их</p>	86.6

	тодруулагч цаасан шувууны сургаал" зохиогдсоны 200 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах							соён гэгээрүүлэгч Д.Равжаагийн “Цагийн жамыг тодруулагч цаасан шувууны сургаал” зохиогдсоны 200 жилийн ойг тохиолдуулан боловсролын салбарын албан хаагч, багш нарын дунд "Цагийн жамыг тодруулагч цаасан шувууны сургаал ба орчин үе, өв уламжлал, шинэчлэл" эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 15-нд Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд нийт 13 оролцогч илтгэлээ хэлэлцүүлсэн ба Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Төвөд судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор Д.Мөнх-Отгон, Говийн Ноён Хутагтын музейн эрдэм шинжилгээний ажилтан, хэл шинжлэлийн докторант Э.Эрдэнэдалай нар хүрэлцэн ирж, Равжаа хутагтын зохиол бүтээл, эрдэм судлалын ажлаа тус тус танилцуулан хэлэлцүүлж, нийт 36 багш, суралцагчдыг хамрууллаа.	
129	Дотуур байрны суралцагчдыг хөгжүүлэх "Брэнд" төслийг хэрэгжүүлэх	Хамрагдсан суралцагчдын тоо	Тоо	2024	0	400	684	Дотуур байрны суралцагчдыг хөгжүүлэх "Брэнд" төсөл нь суралцагчид зорилготой болох, өөрсдийн сонирхсон зүйлсийг багаар хийж сурах, эрүүл аюулгүй, цэвэр орчныг өөрсдөө бүрдүүлж, амьдрах ухаанд сургах, бизнес сэтгэлгээг хөгжүүлэх зорилготойгоор ерөнхий боловсролын сургуулийн 16 дотуур байр хэрэгжүүлж 684 суралцагч, 216 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан. Дотуур байрны багш, суралцагчид саналаа нэгтгэн брэндээ сонгон хэрэгжүүлснээр суралцагчид өөртөө итгэлтэй, хариуцлагатай, зорилготой хувь хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлж, багаар ажиллах, мэргэжлийн чиг баримжааны бодит дадлага туршлагатай болсон. Улаанбадрах сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Хувцас эвхэлт", Сайхандулаан сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Шимт ааруул" Даланжаргалан сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Эртэч хүүхдүүд", Хөвсгөл сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Хөмөл" брэндүүд хэрэгжүүлсэн нь бусад дотуур байрны суралцагчдад сайн туршлага болж түгээн дэлгэрүүлсэн.	100

								Ерөнхий боловсролын сургуулийн 16 дотуур байр "Брэнд" төслийг хэрэгжүүлж, 684 суралцагч, 216 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан нь нь өмнөх оноос 284 хүнээр буюу 58,4%-иар өссөн.	
130	"Зорилгын хүч" үйл ажиллагааг зохион байгуулах	Хамрагдсан суралцагчдын тоо	Тоо	2024	700	750	761	<p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/284 дүгээр захирамжаар 14,7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж элсэлтийн шалгалтад бэлтгэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, суралцагчдыг идэвхжүүлэх, шалгалтад амжилттай үнэлгээ авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор "Зорилгын хүч-6" арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.</p> <p>Энэхүү үйл ажиллагаанд урьдчилсан сорилын шалгалтыг 10 судлагдахуунаар 3 удаа авч, шалгалтад давхардсан тоогоор 5092 сурагч хамрагдаж, сорил-3 нь сорил 1-ээс 8,2 %-иар ахисан. Суралцагчдыг түвшнээр нь 4 хувааж зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй 41 багш, 761 суралцагчдад сургалт зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.</p> <p>Сургуулиуд нийт 11 удаа "Нээлттэй өдөрлөг" зохион байгуулж, сурагчдыг идэвхжүүлсэн бүтээлч ажил зохион байгуулж, сургуулийнхаа цахим хуудсанд тогтмол байршуулан бусдаас суралцсан.</p> <p>Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор 7271 сурагч, 385 эцэг эх, асран хамгаалагч, 103 багш, 5 байгууллага оролцсон. "Зорилгын хүч" үйл ажиллагаа зохион байгуулснаар Элсэлтийн шалгалтын хэмжээст оноо өмнөх оныхоос 1,3-аар нэмэгдсэн.</p>	100
131	Орон нутагт "Гүүр" төслийг хэрэгжүүлж, хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцагчдад гадаад, дотоодын сургалтын тэтгэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Тэтгэлэгт хамрагдсан хүний тоо	Тоо	2024	0	8	69	<p>ОХУ-ын Засгийн газрын 100%-ийн тэтгэлэгт Сайншанд сумын ерөнхий боловсролын 1, 2, 3 дугаар сургуулийн 4 төгсөгч "Оросын улс түмний найрамдлын их сургууль", "Москвагийн Эрчим хүчний дээд сургууль", "Екатерина II-ийн нэрэмжит Санкт-Петербургийн уул уурхайн их сургууль", "Н.И.Пироговын нэрэмжит Оросын Үндэсний Судалгааны Анагаах Ухааны их сургууль"-д тус тус суралцахаар болсон.</p> <p>Мэргэжил сонголт, мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн 5993 суралцагч "Зорилгын хуудас" хөтөлж, хичээл сонголтоо хийлээ. Энэхүү зорилгын хуудсанд үндэслэн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн</p>	100

							<p>эмнэлэг, Төмөр зам, "Мак" ХХК, Салхин сэнс, Цагдаагийн газар, Шүүх, Прокурорын газар, банк санхүү гэсэн 9 мэргэжлийн байгууллагатай хамтран "Дадлагажигч сурагч" үйл ажиллагааг зохион байгуулсан. Дээрх үйл ажиллагаанд 5600 суралцагч хамрагдаж өөрсдийн сонирхсон мэргэжилтэй танилцах нэг өдрийн дадлага хийж ирээдүйн мэргэжилдээ өөрийгөө бэлтгэхэд дэмжлэг үзүүллээ.</p> <p>Гадаадын их дээд сургуульд суралцах хүсэлтэй суралцагчдад Тайвань, БНХАУ, Япон, Ирланд, Филиппин, ОХУ, АНУ, Солонгос улсын мэдээллийг өгөх 7 арга хэмжээнд 488 суралцагчийг хамрууллаа.</p> <p>Дорноговь аймгаас их дээд сургуульд сурч байгаа төлбөрийн сурлага сайтай 4 төгсөгчийг "Дэлгэр говийн хүн" сан төрийн бус байгууллагын сургалтын төлбөрийн 100%-ийн тэтгэлэгт хамрууллаа.</p> <p>Орон нутагт "Гүүр" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж гадаадын тэтгэлэгт 27 хүүхэд хамрагдсанаас гадна энэ онд ерөнхийлөгчийн тэтгэлэгт 6, дотоодын тэтгэлэгт Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Замын-Үүд, Иххэт, Мандах, Сайншанд, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ сумд 101 оюутанд орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн дэмжлэгээр 205,5 сая төгрөгийн төлбөрийн дэмжлэгийг үзүүлсэн. Нийт хөтөлбөрийн хүрээнд 132 оюутан 241,5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүллээ.</p>		
132	Багш нарын нийгмийн баталгааг сайжруулах, үр дүнд суурилсан урамшууллыг нэвтрүүлэх ажлыг судлах	Элсэлтийн шалгалтын үр дүнгээр урамшуулал авсан багшийн тоо	Тоо	2024	5	8	19	<p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/478 дугаар захирамжаар элсэлтийн шалгалт болон олон улсын шалгалт дүйцүүлэн 800 оноо авсан 8 сурагч болон бэлтгэсэн 5 багшийг 12,1 сая төгрөгийн өргөмжлөл, мөнгөн шагналаар, Замын-Үүд сумын Засаг даргын 2021 оны А/77 захирамжийн дагуу элсэлтийн шалгалт болон олон улсын шалгалтыг дүйцүүлэн 680-аас дээш оноо авсан 17 сурагч, 14 багшийг 12,9 сая төгрөгөөр, нийт 25 суралцагч, 19 багшийг 25,0 сая төгрөгийн өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан.</p> <p>Өмнөх онтой харьцуулахад элсэлтийн шалгалтад амжилт үзүүлж урамшуулалд хамрагдсан суралцагч 21-ээр буюу 84% нэмэгдэж, багш 15-аар буюу 78.9% нэмэгдсэн. Ерөнхий боловсролын</p>	100
		Бичгийн шалгалтын үнэлгээний ахицаар урамшуулал авсан багшийн тоо	Тоо	2024	0	10	174		

								сургуулийн 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 174 багш буюу 27.3% нь 1-4 дүгээр индекст үнэлэгдэж урамшуулал авсан багшийн тоо нь өмнөх оноос 4%-иар нэмэгдсэн.	
133	“Суралцагч иргэн-суралцагч аймаг” төслийг хэрэгжүүлэх	Хамрагдсан хүний тоо	Тоо	2024	24581	24681	37291	<p>Аймгийн Насан туршийн суралцахуйн төв нь ЮНЕСКО-гийн "Суралцагч хот" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн онцлогт тохируулан "Суралцагч аймаг-суралцагч иргэн" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 2025 оны эхний хагас жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 90%-тай байна. Төлөвлөгөөний дагуу "Суралцагч" өдөрлөг зохион байгуулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар "Суралцагч байгууллага"-аар шалгарлаа.</p> <p>Мөн хүүхэд хүмүүжлийн эерэг аргын 8 модуль сургалтыг Насан туршийн суралцахуйн 13 нэгжээр /Улаанбадрах суманд багшгүй/ дамжуулан зохион байгуулж, сумдын олон хүүхэдтэй 118 эцэг эхийг хамруулан, хэлэлцүүлэг хийхэд хүүхэд, эцэг эхийн дундах үл ойлголцол, сонирхлын зөрчил, харилцааны бэрхшээлүүд эергээр шийдэгдсэн үр дүн гарсан. “Суралцагч иргэн-суралцагч аймаг” төслийн хүрээнд 2025 оныг “Суралцагч иргэн-Суралцагч аймгийн хамтдаа бүтээцгээе” урианд дор насан туршдаа суралцахуйн соёлыг иргэддээ түгээх зорилготой насан туршийн суралцахуйн тэргүүлэх 7 чиглэл 28 зүйл заалтын дагуу 69 байгууллагатай хамтран 302 удаагийн сургалт нөлөөллийн ажлаар дамжуулан давхардсан тоогоор 37291 иргэнд танхимын болон цахим хэлбэрээр хүрч ажилласан. Үүнд: 14 сум, 5 цэргийн ангид Насан туршийн суралцахуйн өдөрлөг, арга хэмжээ, зөв дадал эрүүл амьдралын үндэс, хиймэл оюун ухааныг ажил амьдралдаа ашиглах нь, үндэсний бичгийн цахим бичвэр, гар урлал, мэргэжил сонголт, хүндлэл дүүрэн гэр бүл, хуримтлалтай ирээдүй, малчдын боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдвүүдээр сургалт, уулзалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.</p> <p>Энэ нь өмнөх онтой харьцуулахад сургалтын тоо, давтамж 19,3%, иргэдэд хүрч ажилласан хүртээмж 6,9% өссөн.</p>	100

								Аймгийн Засаг даргын 2025 оны А/151 дүгээр захирамж болон НҮБ-ын Хүүхдийн сангаас аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулахад зориулж нийт 28,7 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	
134	Иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломж, нээлттэй боловсролын тогтолцоог бүрдүүлж, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх	Хамрагдсан хүний тоо, хамтарсан байгууллагын тоо	Тоо	2024	24581/64	26000/80	37291/172	<p>Иргэд насан туршдаа тасралтгүй суралцах, амьдралын зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор 2025 онд цахим ур чадвар олгох сургалт, гар урлалын мэдлэг олгох чиглэлээр 29 удаагийн сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулан 514 иргэнд хүрч ажилласан.</p> <p>Үүнээс иргэдэд цахим ур чадварын мэдлэг олгох мэдээллийн технологийн анхан шат, хиймэл оюуны хэрэглээ, түүнийг ажил мэргэжилдээ хослуулан хэрэглэх, хэвлэлийн эх бэлтгэлийн программ хангамж зэрэг сургалтуудаар 262 иргэнд мэдлэг олгосон.</p> <p>Мөн гар урлалын лаа, саван, ванны бөмбөлөг, гипсэн урлал зэрэг сургалтуудаар 252 иргэнд хүрсэн нь өөрсдийн бүтээлээр бизнес эрхлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.</p> <p>Аймгийн хэмжээний нийт төрийн байгууллагын 156 архив, бичиг хэргийн ажилтны 108 буюу 70%-ийг үндэсний бичгийн цахим бичвэрийн сургалтад хамруулж, албан хэрэг хөтлөлтийн чадварыг дээшлүүлсэн. Нийт 7 хөтөлбөрийг хэрэгжүүлж 302 удаагийн сургалт нөлөөллийн ажлаар дамжуулан давхардсан тоогоор 37291 иргэнд танхимын болон цахим хэлбэрээр хүрч ажилласан байна.</p> <p>Үндэсний бичгээ сурталчлах, иргэдийн сурах идэвхийг өрнүүлэх зорилгоор үндэсний бичгийн мэдлэг чадварыг сорих “ТУНГААМАЛ” тэмцээнийг улиралд 2 удаа ЕБС-ийн сурагчид болон төрийн албан хаагчдын дунд зохион байгуулдаг уламжлалын дагуу 03 дугаар сарын 22-нд Замын-Үүд сумын ИТХ, СЗДТГ-тай хамтран зохион байгуулж, 5 багийн тус бүр 30, нийт 60 иргэн оролцож, улирлын аваргаа шалгарууллаа.</p> <p>Мөн аймгийн хэмжээний Төрийн албан хаагчид болон ЕБС-ийн 12-р ангийн сурагчдын дунд үндэсний бичгээ сурах, ЭЭШ-д бэлтгэхэд нь туслах зорилгоор</p>	100

								<p>улирал бүр 2 удаа зохион байгуулж, нийт 8 удаагийн тэмцээнд 25 албан хаагч, 25 сурагч оролцон, мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө. Мөн эх хэлний мэдлэг, зөв бичих дүрмийн чадварыг сайжруулах зорилгоор “Үсэглэлийн хаад” тэмцээнийг Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж, нийт 93 албан хаагч оролцлоо.</p> <p>Энэ онд салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, төр, хувийн хэвшил, олон улсын нийт 172 байгууллагатай хамтран ажилласан нь туршлага солилцох, сургалт, үйл ажиллагааг шинэлэг сонирхолтой байдлаар зохион байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах зэрэг ач холбогдолтой байсан. 2025 онд шинээр олон улсын FXB, SAVE THE CHILDREN, UNICEF, HWPL зэрэг байгууллагатай хамтран ажилласан нь 2024 онтой харьцуулахад гар урлалын сургалт 12%, цахим ур чадварын сургалт 8%-иар өссөн.</p>	
135	"Бага насны хүүхдийн цогц хөгжил" хөтөлбөрийн хүрээнд "Эрүүл ходоод-эрүүл бие" танхимыг тохижуулах	Тохижуулсан танхимын тоо	Хувь	2024	0	1	1	<p>Аймгийн насан туршийн сургалтын 14 сумын багш нар ЮНЕСКО болон Боловсролын яамнаас хамтран хэрэгжүүлж буй "Бага насны хүүхдийн цогц хөгжил" хөтөлбөрийн сургагч багшаар бэлтгэгдлээ.</p> <p>ЮНЕСКО-оос орон нутагт хийсэн мониторингийн тайлант уулзалтаар хэрэгжүүлсэн ажлыг үнэлж 8,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснийг зохистой хооллолт, гэр бүлийн сургалтын танхим болох "Эрүүл ходоод-эрүүл бие" танхимыг бүрэн тохижуулж дуусгасан. Хоол тэжээл, хүнсний зохистой хэрэглээ, хосын сэтгэл зүйн зөвлөгөө, ганцаарчилсан ярилцлага, бэлгийн боловсролын сургалтуудыг энэхүү танхимаар дамжуулан бүх насныханд олгох боломж бүрдэж олон төрлийн сургалт уулзалтыг зохион байгуулж нийт 1800 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>"Бага насны хүүхдийн цогц хөгжил" хөтөлбөрийн хүрээнд Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан нялх балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2 настай хүүхдийн хөгжлийн гарааны үнэлгээ хийх арга зүйн сургалтад 300 гаруй багшийг хамруулж, мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн. Мөн хүүхдийн шүдний эрүүл мэндийг дэмжих зорилгоор аймгийн хэмжээнд 7 хоногийн нэг</p>	100

								<p>өдрийг "Чихрийн өдөр" аян хэрэгжүүлж шүдний өвчлөлийг багасгахад эерэг нөлөө үзүүллээ.</p> <p>Сумд болон цэргийн ангийн 3278 иргэнд хүрч ажилласнаас 412 малчин, 720 цэргийн албан хаагч, 2142 зорилтот иргэдэд гэр бүл бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих чиглэлээр зохистой хооллолт, бид жирэмсэн, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд сургалтуудыг хүргэсэн.</p>	
136	Сайншанд сумын 7, 8, 9 дүгээр цэцэрлэг, Айраг, Даланжаргалан сумын цэцэрлэг, Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн их засварын ажлыг хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	90	<p>2025 онд Сургууль, цэцэрлэгийн орчныг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн нийт 3.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7, 8, 9 дүгээр цэцэрлэг, Айраг, Даланжаргалан сумын цэцэрлэгийн засварын ажлыг гүйцэтгэн, улсын комисст хүлээлгэн өгсөн.</p> <p>Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар ажлыг Япон улсын Засгийн газрын Өвсний үндэс төсөл болон орон нутгийн төсвийн 901.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар БЭМЭС ХХК гүйцэтгэхээр тендерт шалгарч гэрээ байгуулсан.</p>	90
137	Аймгийн зарим цэцэрлэг, сургуулийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмжөөр хангасан байгууллага	Тоо	2024	0	55	55	<p>Аймгийн сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийн тендер шалгаруулалтыг 2 багц болгон 2025 оны 06 дугаар сард багц-2, 08 дугаар сард багц 1-ийг нээхэд тус бүрд "Чиглэл" ХХК шалгарч гэрээ байгуулсны дагуу багц 2-ын 16 нэр төрлийн 157 ширхэг 280,0 сая, багц 1-ийн 6 нэр төрлийн 59 ширхэг 293,7 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлэн сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд бүрэн ашиглаж байна.</p> <p>Мөн Дээрээт олон улсын энэрлийн байгууллагын хандиваар ерөнхий боловсролын 10 сургууль, 20 цэцэрлэгт 101,0 сая төгрөгийн 11 нэр төрлийн 42 ширхэг гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.</p> <p>Тайлант онд орон нутгийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар нийт боловсролын салбарын 55 байгууллагын гал тогоонд нэн шаардлагатай 33 нэр төрлийн 258 ширхэг 674,4 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.</p>	100
138	Хөвсгөл сумын сургууль,Замын-	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	67.5	<p>Хөвсгөл сумын ЕБС-ийн өргөтгөл барих, хуучин сургуулийн гадна фасад засварын ажлыг орон</p>	67.5

	үүд сумын 1 дүгээр сургуулийн барилга шинээр барих							нутгийн төсвийн 2817.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хөх оноо” ХХК гүйцэтгэж байна. Хуучин сургуулийн гадна металл фасадын ажил хийгдсэн. 150 хүүхдийн шинэ сургуулийн барилгын үндсэн хийц бүтээцийн угсралтын ажил дуусаж, дотор сантехник, гадна металл фасадын угсралтын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 75%-тай. Орон нутгийн хөгжлийн сангийн 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийг буулгаж шинээр 960 хүүхдийн сургууль барих ажлыг “Голомт констракшн” ХХК гүйцэтгэж байна. Барилгын каркасны хийц, гадна ханын дүүргэлт, дотор хамар ханын өргийн ажил хийгдсэн. Дотор засал, шал, сантехник, цахилгаан, холбоо дохиоллын ажлууд хийгдэж байна. Ажлын явц 60%-тай үргэлжилж байна.	
139	Ерөнхий боловсролын сургуулиудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмжөөр хангасан сургууль	тоо	2024	0	21	22	Орон нутгийн төсвийн 750,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд тавилга, тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалт 4 багцаар явагдсан ба 1 дүгээр багц буюу тавилга эд хогшил нийлүүлэхэд "Асанга билгэх" ХХК, 2 дугаар багцад кабинетын хэрэгсэл нийлүүлэхэд "Голден Хоул" ХХК, 3 дугаар багц техник, тоног төхөөрөмж нийлүүлэхэд "Хоче трейд" ХХК, 4 дүгээр багц дуу хөгжмийн кабинетын хэрэгсэл нийлүүлэхэд "Намуун хишиг далай" ХХК шалгарч, нийт 216 нэр төрлийн 1837 ширхэг 652,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангаж, хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн Боловсролын яамнаас 17 сургуульд 238 ш хромбүүк, Хатанбулаг, Айраг, Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд гал тогооны тоног төхөөрөмж, 10 сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эмчид зөөврийн компьютер олгосон. Нийт 22 сургуулийг 218 нэр төрлийн 2085 ширхэг сургалтын тоног төхөөрөмжөөр хангасан.	100
140	Иххэт, Сайншанд сумын 1-р сургуулийн барилгын их	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	65	Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны фасадын их засварыг 151.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Дэнжийн хүү” ХХК гүйцэтгэн 2025.08.15-нд ашиглалтад оруулсан.	65

	засварын ажлыг хийх							Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар ажлыг Япон улсын Засгийн газрын Өвсний үндэс төсөл болон орон нутгийн төсвийн 901.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар БЭМЭС ХХК гүйцэтгэхээр тендерт шалгарч гэрээ байгуулсан.	
141	Өргөн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	70	Өргөн суманд Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг орон нутгийн төсвийн 1,062.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Дэнжийн хүү" ХХК гүйцэтгэж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн ажил дуусаж, гадна метал фасад, дээврийн ажил хийгдэж, ажлын явц 70%-тай байна.	70
142	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна фасад засварлах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	50	100	100	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна фасадын засварыг орон нутгийн төсвийн 3,335.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Энержи парагон" ХХК гүйцэтгэж дуусгасан бөгөөд 2025 оны УҚД-БЗ-04/2025 дугаартай дүгнэлтээр ашиглалтад оруулсан.	100
143	Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын гадна дулааны шугамын ажлыг үргэлжлүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	30	100	95	Орон нутгийн төсвийн 496.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын гадна дулааны ажлыг "Жи Би Ти Эм Би Констракшн" ХХК гүйцэтгэж байна. Гадна дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан хангамж, гадна холбооны шугам татах ажлын гүйцэтгэл 95%-тай.	86.6
144	Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	94	95	95.5	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг 4 бүлэг 11 заалтын хүрээнд 95.5%-тай хэрэгжүүлэн ажилласан. Тайлант оны байдлаар орон нутгийн төсвийн 7,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр БНХАУ-ын Хөх хот, Бугат, Шааньси мужийн Анкан хот, БНСУ-ын Пусан хот, Тайланд, Киргизстан зэрэг хөрш зэргэлдээ, өндөр хөгжилтэй гадаадын улс оронд зохион байгуулагдсан 8 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөнд 34 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, улс, аймгийн хэмжээнд зохион байгуулсан эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж мэргэжил олгох, дээшлүүлэх танхимын болон цахим 26 удаагийн дотоодын сургалтад давхардсан тоогоор 2265 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Хүний нөөцийн www.hr.hdc.gov.mn цахим программд шинээр 85 албан хаагчийг бүртгэж, нийт	100

								<p>815 албан хаагч программ ашиглан багц цагийн сургалтад хамрагдсан.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийг ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх байгууллага болгох бэлтгэл ажлын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан 2 удаагийн цахим хуралд 10 эмч оролцож, явцын хэрэгжилтийн тайланг 1 удаа хүргүүлсэн. Үндсэн мэргэшил судлалын багшаар нарийн мэргэжлийн 5 эмчийг хамруулахаар нэрсийг хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөний үр дүнд эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг чадвар дээшилж, хөрш зэргэлдээ, өндөр хөгжилтэй гадаадын улс орны хамтын ажиллагаа өргөжиж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн программ ашиглалт 10.4%-иар нэмэгдсэн.</p>	
145	<p>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулан тогтвор суурьшилтай ажиллуулах эдийн засгийн хөшүүргийг оновчтой, хүртээмжтэй болгох</p>	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	95	97	97.2	<p>“Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах төлөвлөгөө”- г 4 бүлэг 18 заалтын хүрээнд 97.2%-тай хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Сум, орон нутгийн төсвийн 30,5 сая төгрөгийн санхүүжилтээр 32 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд малжуулах, сургалтын төлбөр, гэр, түлээ нүүрс авахад болон хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заасан бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Орон нутгийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хатанбулаг сумын Ханги хилийн боомт дээр эмнэлгийн ажилчдад зориулан 8 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, АЗДТГ-аас хэрэгжүүлж буй “Хөдөөгийн сэргэлт”, “Төрийн албан хаагчийг орон сууцжуулах” хөтөлбөрт 6 албан хаагчийг хамрууллаа.</p> <p>Сумдын Засаг даргатай "Хамтран ажиллах гэрээ" байгуулан анхан шатны 10 эрүүл мэндийн байгууллагын 47 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 1,4 тэрбум төгрөгийн өртөг бүхий төрийн албан хаагчийн орон сууцанд түрээсийн төлбөргүй амьдрах боломжоор хангасан.</p> <p>Төрийн дээд одон медаль, салбар, аймгийн бусад шагналаар 72 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг шагнаж урамшуулан, илүү цагийн цалинг давхардсан тоогоор 1312 албан хаагчид 1,6 тэрбум төгрөг, үр дүнгийн урамшууллыг 198 албан хаагчид 131,8 сая</p>	100

								<p>төгрөг, ур чадварын нэмэгдлийг 49 албан хаагчид 16,5 сая төгрөг, АНЭ-ээс бүтээмжийн урамшууллыг нэвтрүүлж 293 албан хаагчид 149,8 сая төгрөгийг тус тус олголоо.</p> <p>Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд төрийн эрүүл мэндийн 21 байгууллагын 1212 албан хаагчийн 687 буюу 56.6% нь хамрагдаж, 112 өвчлөл илрүүлж 100% эмчлэн эрүүлжүүлж, 101 албан хаагч хэвтэн эмчлүүлсэн. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болон лавлагаа шатлалд онош тодруулахаар илгээсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний гэр бүлийн 75 гишүүнд 2,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.</p> <p>Дээрх ажлуудын үр дүнд эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаа сайжирч, эмнэлгийн ажилчдын тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах боломжийг бүрдүүллээ.</p>	
146	Хавдрын бай, мэс засал эмчилгээг нэвтрүүлэх	Ажлын гүйцэтгэл	Тоо	2024	0	100	100	<p>Эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлгийн хавдрын тасгийг 2 их эмчтэй, 10 ортойгоор өргөжүүлж, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн хавдрын 1 эмчийг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулж, полихими, хавдрын бай эмчилгээг орон нутагт нэвтрүүлсэн.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын 1 эмчийг хавдрын мэс заслын төрөлжсөн мэргэжлээр сургаж, Хавдар судлалын үндэсний төвийн мэс заслын тасагтай хамтран орон нутагт ходоод тайрах мэс заслыг 3 удаа амжилттай хийж, эмч мэргэжилтнүүдийг ажлын байранд нь сургаж чадавхжууллаа.</p> <p>Төрийн эмнэлгийн ачааллыг бууруулж, хувийн эмнэлгүүдийн нарийн мэргэжлийн нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутагт хийгддэггүй оношилгоо шинжилгээг хөгжүүлж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжин "Хавдар, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ"-ний хувийн эмнэлэгт шинээр тусгай зөвшөөрөл олгож, иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Энэ оны жилийн эцсийн байдлаар хөнгөвчлөх эмчилгээнд 295, хими эмчилгээнд 24, бай эмчилгээнд</p>	100

								29 иргэнийг хамруулснаар Улаанбаатар хот руу явах урсгалыг 23.6%-иар бууруулсан үр дүнтэй байна.	
147	Төрөлжсөн мэргэжлийн төвүүдтэй хамтран эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийг дээшлүүлэх	100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин / 0-5 нас хүртэлх хүүхдийн эндэгдлийн түвшин	промилль	2024	111.2 / 13.1	0 / 13.0	137.2/13.7	<p>Орон нутагт төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй гэрээ байгуулан эмч, мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах мэргэжил олгох, дээшлүүлэх болон ажлын байрны сургалтуудад үе шаттайгаар сургасан.</p> <p>Өргөө амаржих газрын Эх барих эмэгтэйчүүдийн их эмч, үндэсний сургагч багшийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт 1 сарын хугацаатай ажиллуулж, эмч мэргэжилтнүүдийг дагалдуулж, чадавхжуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажилласны үр дүнд орон нутагт хийгдэхгүй байгаа 3 төрлийн 12 хагалгааг амжилттай хийсэн.</p> <p>Япон улсын Осака хотод зохион байгуулагдсан эх барих эмэгтэйчүүдийн хэт авианы нийгэмлэгийн ээлжит конгресст эх барих эмэгтэйчүүдийн 3 эмч оролцож, эх ургийн хэт авианы оношилгооны мэдлэгээ дээшлүүлсэн. Эх нярайн чиглэлээр богино хугацааны сургалтад 4 эх баригч, нярай, дүрс оношилгооны 5 их эмч, эх барих 4 эмэгтэйчүүдийн эмч хамрагдсан. Эх баригчийн ахлах зэрэг хамгаалалтад 2 эх баригч орж, ур чадвараа нэмэгдүүллээ.</p> <p>Мөн төр, хувийн хэвшлийн ЭМБ-уудын эх барих эмэгтэйчүүдийн хэлэлцүүлгийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг ЭМБ-уудад ЭМГ-ын даргын 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 124 дүгээр албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж байна.</p> <p>ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 11 ЭМБ-ын эх барих ба эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж, арга зүйгээр хангаснаар зөвлөмжийн хэрэгжилт дунжаар 90%-тай байна. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 14 хоног тутмын лхагва гарагт хийж хэвшсэн ба тайлант хугацаанд нийт 89 удаа давхардсан тоогоор 782 эхчүүдэд сургалт хийж, мэдлэгийг нэмэгдүүллээ.</p> <p>Нэгдсэн эмнэлгүүд Realtime-аар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэстэй төвтэй холбогдон, маш хүнд,</p>	0

								<p>онош тодруулах шаардлагатай 3 эмэгтэй, 20 нярайг эх, нярайн зайн оношилгоонд хамруулан, зөвлөгөө авч, эмчилгээний асуудлыг шуурхай шийдвэрлэсэн.</p> <p>Энэ оны 10 сарын байдлаар 730 эх төрсөн нь урьд оны мөн үеэс 115 тохиолдол буюу 13.6%-иар буурч, эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж 100.000 амьд төрөлтөд 137.2 промилль болсноор өмнөх оны мөн үеэс 137.2-оор нэмэгдэж, нялхсын эндэгдэл 8 бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 10.9 болж, өмнөх оны мөн үеэс 0.9-өөр, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 10 бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 13.7 промилль болсноор өмнөх оны мөн үеэс 2.8-аар буурсан үзүүлэлттэй байна.</p>	
148	Эрүүл мэндийн шинэ технологийн үзэсгэлэн гаргаж, иргэдэд сурталчлах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлж буй шинэ технологи, инновац, шилдэг туршлагаа иргэдэд танилцуулах зорилгоор “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ-2025” үзэсгэлэнг орон нутагт хоёр дахь удаагаа 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2025 оны А/199 дүгээр захирамжаар 5,75 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>“Шилдэг технологи нэвтрүүлэгч хамт олон”-оор 8 төрлийн номинацид нэр дэвшүүлж, шилдэг технологи, оношилгоо эмчилгээний төрлийг нэмэгдүүлсэн эрүүл мэндийн байгууллага, эмч нарыг шалгаруулж, урамшууллаа. Уг арга хэмжээнээс шалгарсан шинэ технологи, тэргүүн туршлагыг Улсын гуравдугаар төв эмнэлэгт болон Говийн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын чуулга уулзалтын үзэсгэлэнд танилцуулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчиллаа.</p> <p>Тус үзэсгэлэнд төр ба хувийн хэвшлийн 60 гаруй эрүүл мэндийн байгууллага оролцож, орон нутагт шинээр нэвтрүүлсэн шинэ технологи, шилдэг туршлага, оношилгоо эмчилгээний давуу тал, чадавхаа танилцуулж, төрийн болон төрийн бус 20 байгууллага, 300 гаруй иргэдэд үзлэг, оношилгоо, зөвлөгөө өгч, эмнэлгийн тусламж үйлчилгээний чадавхыг сурталчлан таниулсан үр дүнтэй арга хэмжээ болсон.</p>	100

149	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт суурин Рентген аппарат худалдан авах	Худалдан авсан суурин рентген аппарат	Тоо	2024	0	100	100	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт орон нутгийн төсвийн 750,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурин рентген аппарат худалдан авах тендерт “Сетунара” ХХК шалгарч тоног төхөөрөмжийг 100%-ийн гүйцэтгэлтэйгээр суурилуулан дотоод сургалтыг хийж, цөмийн оношилгооны төвөөс албан ёсны дүгнэлтийн хамт хүлээлгэн өгсөн.</p> <p>Тус аппаратыг шийдвэрлэснээр эмнэлгийн тусламж үйлчилгээг орон нутагтаа шуурхай авах нөхцөл бүрдэж, 2025 оны жилийн эцсийн байдлаар рентген шинжилгээнд 2735 иргэн хамрагдсан нь эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг 15%-иар нэмэгдүүлж, иргэдийн Улаанбаатар хотын лавлагаа шатлалын эмнэлэг рүү явах урсгалыг 23.6%-иар бууруулж оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмж сайжирч, үйлчлүүлэгчийн хүлээгдэл чирэгдлийг бууруулан, иргэдийн эдийн засгийн дарамтыг багасгаж, сэтгэл ханамжийг дээшлүүлсэн.</p>	100
150	Эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмжийн хангалт	Хувь	2024	84	87	87.3	<p>Улсын төсвийн 1,2 тэрбум, орон нутгийн төсвийн 1,4 тэрбум, хандив тусламжийн 1.2 тэрбум, нийт 3.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар:</p> <p>-Аймгийн Нэгдсэн эмнэлгийг орчин үеийн шинэ загварын 128 зүслэгтэй Компьютер томографын аппарат, суурин дижитал рентген аппарат, ходоодны дурангийн иж бүрдэл, мэс заслын өрөөний тоног төхөөрөмж, мэс заслын хагалгааны гэрэл, иж бүрэн зөөврийн рентген аппарат, мэс заслын C-Arm рентген аппаратаар хангасан.</p> <p>-Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг шинээр компьютер томографын оношилгоог нэвтрүүлж, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж бүхий “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг ашиглалтад оруулан, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлснээр нэгдсэн эмнэлгүүд хэвлийн диализ, полихими эмчилгээ, дурангийн хагалгаа, чих хамар хоолой, нүд, хөнгөвчлөх зэрэг 11 нэр төрлийн тусламж үйлчилгээ нэвтрүүлсэн.</p> <p>- Авто зам дагуу осол гэмтлийн тохиолдол их бүртгэгддэг анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн оношилгооны чанар хүртээмж, шуурхай бэлэн байдлыг сайжруулах, алслагдсан хөдөөгийн иргэдэд</p>	100

								цаг алдалгүй тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор Даланжаргалан сумын эрүүл мэндийн төвд зөөврийн рентген аппаратыг суурилуулан хүлээлгэн өгсөн. - Иххэт, Хөвсгөл сумын ЭМТ, Агатова өрхийн ЭМТ-үүдэд ЭХО аппарат, гематологи аппарат тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Дээрх хөрөнгө оруулалт хийгдсэнээр нэн шаардлагатай 124 ширхэг тоног төхөөрөмжөөр хангаж, тоног төхөөрөмжийн хангалтыг 87.3%-д хүргэж, өмнөх оноос 0.9%-иар нэмэгдлээ.	
151	Даланжаргалан сумын ЭМТ-ийг зөөврийн рентген аппарат тоног төхөөрөмжөөр хангах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Даланжаргалан сум нь аймгийн төвөөс 130 км, Улаанбаатар хотоос 300 км, төмөр зам, босоо тэнхлэгийн авто зам дамжин өнгөрдөг, үйлдвэр уул уурхай хөгжсөн, хөдөлгөөнт хүн ам ихтэйгээс зам тээврийн болон үйлдвэрлэлийн осол гэмтэл их бүртгэгдэг тул эрүүл мэндийн төвийн оношилгоо эмчилгээний чадамжийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 110,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Даланжаргалан сумын эрүүл мэндийн төвд зөөврийн рентген аппарат худалдан авах тендерт "Си Ай Ти" ХХК шалгарч, 100%-ийн гүйцэтгэлтэйгээр тоног төхөөрөмжийг суурилуулж, сумын Эрүүл төвийн эмч, мэргэжилтнүүдэд ажлын байрны сургалт хийж, хүлээлгэн өгч оношилгооны чадавхыг сайжрууллаа.	100
152	"Иргэний эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх" арга хэмжээг зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	81	90	90.5%	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2025 оныг "Нийгмийн эрүүл мэнд- өрх бүрд- II", "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарлаж "Эрүүл идэвхтэй амьдрал" арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд "Хавдраас сэргийлэх, мэдээлэл түгээх", "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжье" , "Алхам бүрд анхаарал сэрэмжийг нэмж эрсдэлийг бууруулах", "Эрүүл хүүхэд-эрүүл жирэмслэлт", "Сүрьеэгүй ирээдүй бидний нүдээр" , "24/3 ШҮДЭЭ ЗӨВ УГАА-2025" зэрэг нийт 549 удаагийн сургалт, аян, өдөрлөг, тэмцээн уралдаан зохион байгуулж, давхардсан тоогоор 17465 иргэнийг хамруулан, 64 төрлийн 1785 зөвлөмж тараалаа. Орон нутгийн телевизтэй хамтран эмчийн зөвлөгөө 18, охид хөвгүүдийн цаг 5, зочны цаг, мэдээ	100

								<p>мэдээлэл 29, видео шторк 11, нийт 64 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж, 36558 хүний хандалт авлаа.</p> <p>“Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 15–64 насны 6879 эрэгтэйчүүдээс идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэсэн судалгаа авсан. Судалгаанд оролцогчдын 66% нь багийн спортоор хичээллэх, идэвхтэй дасгал, хөдөлгөөний ач холбогдлын талаар мэдээлэлтэй байна.</p> <p>“Эхийн сүүгээр хооллолтын 10 алхам”-ын сургагч багшаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн нярайн эмч, нярайн сувилагч 4 хүн бэлтгэгдэж, “Эхийн сүүгээр хооллолт” өдөрлөгийг Эрүүл мэндийн газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулсан. Өдөрлөгөөр жирэмсэн, хөхүүл ээж болон гэр бүлд нь “Эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол”, “Зөв хөхүүлэх байрлал, аргачлал”-ын талаар зөвлөгөө өгч, 3 төрлийн 67 ширхэг зөвлөмж тараасан. Эрүүл мэндийн байгууллагууд хүүхдийн хөхөөр хооллолтыг дэмжин 46 удаагийн сургалт зохион байгуулж, 1251 иргэн хамрууллаа.</p> <p>Олон найрлагат бичил тэжээлийн 1,4 сая төгрөг бүхий бэлдмэлийг 6 сумын эрүүл мэндийн байгууллагат тарааж, 06-23 сартай зорилтот бүлгийн 7200 хүүхдийг хамруулсан. Аймгийн хэмжээнд 0-6 сар хүртэлх насны хүүхдийн 94.7% нь эхийн сүүгээр дагнан хооллож байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.8%-иар өссөн байна.</p> <p>Эдгээр ажлуудын үр дүнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ өргөжиж, өмнөх оны мөн үеэс 298 сургалт 6077 хүнээр нэмэгдэж, дасгал хөдөлгөөнөөр 9805 хүн тогтмол хичээллэж байна. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 90.5%-тай хэрэгжүүлснээр өмнөх оны мөн үеэс 9.5%-иар нэмэгдсэн.</p>	
153	Хүн амын урьдчилан сэргийлэх, эрт	Үзлэгийн хамрагдалт	Хувь	2024	5	50	51.80%	Монгол улсын Засгийн газрын санаачилгаар 2022 оноос эхлэн “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг”-ийг зохион байгуулсан.	100

	илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх							<p>Үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор “Эрт илрүүлэг-Эрүүл амьдралын эхлэл” уриатай 2 удаагийн сарын аян өрнүүлж, 471 удаагийн сургалтад 2942 иргэнийг хамруулсан. Үүний үр дүнд 2025 оны 9 сарын байдлаар 2149 иргэн үзлэгт хамрагдаж, хамрагдвал зохих иргэдийн 37253 буюу 51.8%-ийг эзэлж, улсын хэмжээнд нийт үзлэгийн дүнгээр 7-рт эрэмбэлэгдсэн.</p> <p>Үзлэгт давхардсан тоогоор 3515 өвчлөл илрүүлж, 1691 буюу 48.1%-ийг хяналтад авч, 858 буюу 24.4%-ийг эмчилсэн. Үүнээс хорт хавдрын 5 шинэ тохиолдол бүртгэгдэж, дээд шатлалын эмнэлэгт илгээн, хяналтад авсан. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 1а/4450 дугаар албан бичгийн дагуу үзлэгийг 10 сараас түр хугацаагаар зогсоосон.</p>	
154	Явуулын үзлэг зохион байгуулах	Үзлэгийн хамрагдалт	Тоо	2024	0	4000	4150	<p>Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/147 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны А/376 дугаар захирамжийн дагуу “Явуулын амбулаторийн үзлэг–2025” арга хэмжээг нийт 13 суманд зохион байгуулахаар төлөвлөж, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн дотор, хүүхэд, мэдрэл, эмэгтэйчүүд, арьс, чих, хамар, хоолой, ЭХО, уламжлалт анагаах ухаан, мэс засал, эрүүл мэндийн даатгал, шүд, лаборатори зэрэг 12 нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд алслагдсан сум, багийн хөдөөгийн иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийж, орон нутагт нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Үзлэгт нийт 4150 иргэнийг хамруулан, давхардсан тоогоор 10737 үзлэг, оношилгоо хийснээс 128 шинэ өвчлөл илрүүлж, 83.3%-ийг эмчилж, 16.7%-ийг онош тодруулах зорилгоор лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн.</p> <p>Хорт хавдрын сэжигтэй 4 тохиолдол илэрч, лавлагаа шатлалын эмнэлэгт илгээснээр хавдрын урьдал-2, (элэг, хөхний хавдар) хорт хавдар-2 батлагдан, эмчлэгдэж байна.</p> <p>Явуулын амбулаторийн үзлэгийн хамрагдалт өмнөх онд 3992 байсан бол энэ онд 4150-д хүрснээр 158 буюу 4%-иар өссөн үр дүнтэй байна.</p>	100

155	“Эрүүл шүд” арга хэмжээг зохион байгуулах	Үзлэгийн хамралт	Тоо	2024	5211	5800	6032	<p>“Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд 4 зорилт, 18 үйл ажиллагааг төлөвлөн 91.6%-тай хэрэгжүүлэн ажиллалаа.</p> <p>“Эрүүл шүд” арга хэмжээ, “24/3 Шүдээ зөв угаа-2025” үндэсний аяны хүрээнд хөдөөгийн хүн амд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэхэд анхаарч, хувийн хэвшлийн 2 эмнэлэг нийгмийн хариуцлагын хүрээнд 4 суманд явуулын үзлэг хийж, хөнгөлөлттэй тусламж үйлчилгээ үзүүлэн 118 хүүхэд хамруулан 49 өвчлөл илрүүлж, 100% эмчиллээ.</p> <p>ЕБС-ийн 1 дүгээр ангийн суралцагчдад шүдний нарийн мэргэжлийн эмчийн цогц үзлэгийг 13 суманд зохион байгуулж 1463 хүүхэд буюу 93.4%-ийг хамруулан, 1147 өвчлөл илрүүлж, 80%-ийг эмчилсэн. Мөн ЕБС-иудын 2-5 дугаар ангийн 2479 суралцагчийг шүдний нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 1934 өвчлөл илрүүлэн, 50.5%-ийг эмчилсэн.</p> <p>“Амны хөндийн эрүүл ахуйн зөв мэдлэг дадал төлөвшүүлэх” зорилгоор 95 удаагийн сургалтад 1257 хүүхэд, эцэг эхчүүдийг хамруулж, 36 төрлийн 255 зөвлөмж тараасан.</p> <p>ДЭМБ-ын шалгуур үзүүлэлтээр шүд цоорох өвчний тархалт 75.4%-тай, эрчим 3.1 буюу дунд үнэлэгдэж, үнэлгээг үндэслэн шүд угаах цагийг хэрэгжүүлэх чиглэлийг Ерөнхий боловсрол, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хүргүүлэн 33 цэцэрлэг, 2 сургууль буюу нийт боловсролын байгууллагын 67% нь шүд угаах цагийг тогтмол хэрэгжүүлж хэвшсэн.</p> <p>Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд шүдний нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх болон амны хөндийн үзлэгт нийт 6032 хүүхэд хамрагдаж, 3521 буюу 58.3%-д нь өвчлөл илрүүлж, түүний 93.8%-ийг эмчилж, хүүхдийн амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлж, тархалтыг 3.4%-иар бууруулсан үр дүнтэй байна.</p>	100
-----	---	------------------	-----	------	------	------	------	--	-----

156	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг зохион байгуулах	Халдварт өвчний цогц эрт илрүүлэг үзлэг	Тоо	2024	2000	2500	2871	<p>"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ"-ний хүрээнд 31 заалт бүхий төлөвлөгөө батлуулж, 96%-тай хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Глобал сангийн 59,6 сая төгрөгийн санхүүжилтээс Сүрьеэгийн "Хаалганаас хаалганд" эрт илрүүлэг үзлэгийг 23,7 сая төгрөгөөр 7 суманд зохион байгуулж, 1841 иргэн хамрагдсанаас сүрьеэгийн 4 шинэ тохиолдлыг илрүүлж, 100% эмчилсэн.</p> <p>Глобал сангийн ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран 16,8 сая төгрөгөөр аймгийн онцгой комиссын 30 гишүүнд "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэдэг халдварт өвчний цар тахлын үеийн тусламж үйлчилгээг хүний эрхийн хандлагад нийцүүлэн үзүүлэх нь" сургалт, 8,6 сая төгрөгөөр 27 эрүүл мэндийн байгууллагын 80 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд "Халдварын сэргийлэлт, хяналтын эмч, ажилчдыг чадавхжуулах" сургалтыг тус тус зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаа, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулсан.</p> <p>"Халдварт өвчний үед авах хариу арга хэмжээ" сэдвээр 14 удаагийн танхим, цахим хосолсон сургалт зохион байгуулж, 146 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа.</p> <p>Халдварт өвчний цогц эрт илрүүлэг үзлэгт 2871 иргэн хамрагдсаны 1841 нь сүрьеэгийн эрт илрүүлэгт хамрагдаж, 4 шинэ тохиолдлыг илрүүлж, 1030 нь бэлгийн замын халдварын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамрагдаж, 8 шинэ тохиолдлыг тус тус илрүүлж, 100% эмчилсэн.</p> <p>"Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх арга, эрүүл зан үйл төлөвшүүлэх" 12 удаагийн сургалт зохион байгуулж, 9 байгууллагын 388 иргэн хамруулсан.</p> <p>Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр 2025 онд халдварт өвчний 837 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 116.9 промилль болсон нь өмнөх оны мөн үеэс 1.8-аар буурч, товлолын дархлаажуулалтын бүрэн</p>	100
-----	---	---	-----	------	------	------	------	---	-----

								тунгийн хамралтыг 98.7%-д хүргэсэн нь өмнөх оны мөн үеэс 8.9%-иар өссөн үр дүнтэй байна.	
157	Ундны усны шинжилгээ хийх	Шинжилгээ авсан цэг	Тоо	2024	89	90	92	<p>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/72 дугаар захирамж, А/164 дугаар захирамжаар нийт 7,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсний дагуу аймгийн хэмжээний суурьшлын бүсийн ундны усны чанарыг үнэлэх зорилгоор төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 11 гүний худаг, төвлөрсөн шугамаар ус түгээх 15 байр, зөөврийн ус түгээх 1 байр, төвлөрсөн ус хангамжийн сүлжээний 4 хэрэглэгч, төвлөрсөн бус ус хангамжийн 17 эх үүсвэр, байгууллага, аж ахуй нэгж, иргэний 3 гүний худаг, төвлөрсөн бус ус хангамжтай 4 хэрэглэгч, нийт 92 цэгээс 92 дээж авсан. Стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораторид нян судлалын шинжилгээнд 38, химийн шинжилгээнд 30, SGS IMME Mongolia ХХК-ийн лабораторид 46 дээжийг шинжлүүлэхэд 86 дээж буюу 93.6% нь шаардлага хангасан.</p> <p>Шаардлага хангаагүй ундны усанд дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 28 заалттай, 7 албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласнаар 4 ус түгээх цэгт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулж, аймгийн ундны усны чанарыг 3.6%-иар сайжруулсан үр дүнтэй байна.</p>	100
158	Суурьшлын бүсийн хөрсөнд хяналт шинжилгээ хийх	Хөрсний дээжийн шинжилгээ	Тоо	2024	0	10	12	<p>Суурьшлын бүсийн хөрсөнд ахуйн шавж, мэрэгч устгал болон халдваргүйтгэл хийх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нарт Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 103 дугаар албан бичгийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан. Үүний үр дүнд суурьшлын бүсийн 2145 нүхэн жорлон, нийтийн эзэмшлийн 8 683 м² талбайд халдваргүйтгэл, шавж мэрэгч устгалын ажил хийгдсэн.</p> <p>Хөрсний бохирдлын түвшнийг үнэлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/630 дугаар захирамжаар 3 сая төгрөгийн санхүүжилт батлуулж, нийт 12 цэгээс хөрсний дээж авч “Хан Лаб” лабораторид шинжилгээнд хүргүүлээ.</p>	100
Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтийн дундаж үнэлгээ:									91.9
ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									

159	Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хиймэл оюун ухаанд суурилж зохион байгуулах	Тендер зохион байгуулалт	Хувь	2023	90	95	98.4	<p>Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хиймэл оюун ухаанд суурилсан цахим систем www.tender.gov.mn-ээр зохион байгуулж, тендер зарлах, материал хүлээн авах, нээх, үнэлэх, үр дүн гаргах, гэрээ байгуулах ажлууд хийгдсэн.</p> <p>Тендерт оролцогч аж ахуйн нэгжийн татвар, нийгмийн даатгалын өргүй эсэх, шүүхийн шийдвэрийн мэдээллийг Татварын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээс татаж шалгадаг.</p> <p>Мөн оролцогч байгууллагын санхүүгийн тайлан болон хүний нөөцийн боловсролын мэдээллийг цахим хэлбэрээр баталгаажуулан үнэлдэг. Энэхүү арга нь тендерийн процессыг ил тод, нээлттэй, шуурхай болгосон. 2025 онд тус газар давхардсан тоогоор 109 удаа тендер шалгаруулалтыг 98.4 хувь хиймэл оюун ухаанд суурилсан цахим системээр амжилттай зохион байгуулсан.</p>	100
160	Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт”-ыг мэдээлэх	Олон нийтэд мэдээлэл хүргэсэн байдал	хувь	2023	99	100	100	<p>Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгох “Шилэн тендер шалгаруулалт”-ыг 2025 онд амжилттай зохион байгуулан нийт 111 удаа тендерийн урилга, 106 удаа тендер шалгаруулалтын үр дүнг www.tender.gov.mn сайтад ил тод байдлаар мэдээлсэн.</p> <p>Мөн байгууллагын мэдээллийн самбар болон фейсбүүк пэйжид нийт 128 мэдээ, мэдээллийг байршуулснаар тендерийн үйл явцыг олон нийтэд ил тод, хялбар хандах боломжийг бүрдүүлсэн.</p>	100
161	Төрийн худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдад болон иргэдэд мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Шинээр АЗ-ын гэрчилгээ авсан хүн	тоо	2023	89	134	137	<p>Төрийн худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчид болон иргэдэд мэдлэг олгох сургалт, арга хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 18-19-нд зохион байгуулсан. АЗ сургалтад 14 сум, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагын нийт 157 хүн хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн 48 хүн АЗ гэрчилгээ авч тендерийн үнэлгээний хороонд ажиллах боломжтой болсон.</p> <p>Мөн 03 дугаар сарын 14-нд Дорноговь аймагт 14 аж ахуйн нэгжийн захирал, төлөөлөлд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчлэл,</p>	100

							тендерийн баримт бичиг боловсруулах талаар мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгсөн. Аймгийн боловсролын газраас зохион байгуулсан сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын багш нарын уулзалт, хэлэлцүүлэгт 3 удаа худалдан авах ажиллагааны чиглэлээр мэдээлэл, сургалтыг хүргэсэн. Дээрх арга хэмжээний үр дүнд төрийн болон орон нутгийн өмчийн худалдан авах ажиллагааны мэдлэгийг дээшлүүлж, олон нийт, байгууллагуудын оролцоо, тендерийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлсэн.		
162	Татвар төлөгчдийн хууль эрх зүйн ойлголт, хэрэглээг сайжруулах нөлөөллийн ажлыг тогтмолжуулах	Мэдээлэл хүргэсэн татвар төлөгч	Тоо	2024	5369	5637	6738	Тайлант онд танхимаар 251 удаа 6099 татвар төлөгчид, цахимаар 8 удаа 639 татвар төлөгчид, нийт 259 удаагийн сургалтыг зохион байгуулж 6738 татвар төлөгчийг хамруулан татварын эрх зүйн боловсролыг нэмэгдүүлснээр аймгийн татвар төлөгчийн тоо өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар, төсвийн орлого 19.8 хувиар тус тус өссөн. Танхим болон цахим сургалтыг эдийн засгийн салбарын ангилал, татварын хуулийн хөнгөлөлт чөлөөлөлт,буцаан олголт, татвар төлөгчийн онцлог хэрэгцээт бүлэгт зориулсан сургалт, шинэ татвар төлөгчид зориулсан сургалт, татвар төлөгчийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, албан татвар төлбөр хураамжийн тайлагнал, төлөлтөд анхаарах асуудал, цахим татвар төлөлт, хялбаршуулсан систем ашиглах, ирээдүйн татвар төлөгчид зориулсан сургалт, цахим төлбөрийн баримтын систем, цахим тайлан илгээх, татвар төлөгчөөр бүртгүүлэх зэрэг чиглэлээр олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулахаар зохион байгуулж ажилласан. “Зөвлөн туслагч Татварын алба” уриан дор татвар төлөгчдийн өдрүүдийг тэмдэглэн татварын хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулан, зохион байгуулсан ажлуудыг тухай бүр байгууллагын цахим хуудсаар олон нийтэд сурталчилж, нийт 62 мэдээллийг 51784 татвар төлөгчид түгээж ажилласан. Аймгийн хэмжээнд татвар төлөгчдийн өдрүүдээр ХХОАТ, НӨАТ, Татварын төлөгчийн бүртгэл гарын	100

								<p>авлагыг нийт 1098 татвар төлөгчид тарааж, улс орон нутгийн төсөвт 1.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Татварын лавлах 1800-1288, 7052-1288 дугаарын утсаар 19928 татвар төлөгчдөд татварын хуулийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Дорноговь аймгийн Татварын газрын цахим хуудсаар 1422 мэдээ оруулж, 2.1 сая хандалт авч, шинээр 2200 хүн дагаж, 286 татвар төлөгчийн чатад хариу өгсөн. Дорноговийн ууган хэвлэл Ялалт сонинд татварын мэдээлэл нийтэлж татвар төлөгчдөд татварын хууль тогтоомжийг сурталчлан ажилласан.</p>	
163	Орон нутагт бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх бие биеэ тэтгэсэн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэн татварын бааз суурийг нэмэгдүүлэх	Салбар татвар төлөгч	Тоо	2024	296	311	327	<p>Татварын албанд бүртгэлгүй худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 2068 иргэн, 327 хуулийн этгээдийг бүртгэн өмнөх оны холбогдох тайланг нөхөн тайлагнуулж улсын төсөвт 25.9 тэрбум төгрөг, аймгийн төсөвт 10.2 тэрбум төгрөг, сумын төсөвт 99.2 тэрбум төгрөг, нийт 135.5 тэрбум төгрөгийн албан татвар, төлбөр, хураамжийн орлогыг төвлөрүүлэн ажиллаж байна.</p> <p>Мөн 426 татвар төлөгчийн хөндлөнгийн мэдээнд үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэн 862.3 сая төгрөгийн албан татварыг ногдуулан татварын бааз суурийг нэмэгдүүлсэн.</p> <p>Хөндлөнгийн мэдээ цуглуулалт өмнөх оны мөн үеэс 69 хувиар өссөн. ААНОАТ-ын хуулийн 22.1 дэх заалтын дагуу 63 татвар төлөгчид 882.1 сая төгрөгийн ногдуулсан албан татварын 90 хувийг буцаан олгож, хуулийн 22.5.1 дэх заалтын дагуу 1 татвар төлөгчид 25.4 сая төгрөгийн Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, сумын 50 хувийн татварын хөнгөлөлт эдлүүлж, хуулийн 22.5.18 дэх заалтаар 1 татвар төлөгчид 55.9 сая төгрөгийн гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тухайн үйл ажиллагааны орлогод ногдсон албан татварын 90 хувиар хөнгөлөлт эдлүүлж, нийт 65 татвар төлөгчид 963.4 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлт эдлүүлэн тайланг баталгаажуулан, буцаан олголтыг эдлүүллээ.</p> <p>ААНОАТ-ын хуулийн 20.2.7 дэх заалтын дагуу жилийн 300.0 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон 812 татвар төлөгчид 156.1 сая төгрөгийн</p>	100

								албан татвар ногдуулан төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн. Хялбаршуулсан горим ашиглах хүсэлт гаргасан ААНОАТ-ын хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу 55 татвар төлөгчид 14.8 сая төгрөг , ХХОАТ-ын хуулийн 15.6 дугаар зүйлийн дагуу 2808 татвар төлөгчид 869.9 сая төгрөг, нийт 2863 татвар төлөгчид 1 хувийн албан ногдуулж төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн.	
164	Иргэн, хуулийн этгээдийг татварын цахим төлбөрийн системд бүрэн холбож, далд эдийн засгийн нөлөөллийг бууруулах	Цахим төлбөрийн системд холбох	Тоо	2024	21017	21648	21659	Дорноговь аймгийн хэмжээнд татвар төлөгчийн ажлын байрны хяналт шалгалт 4 , цахим хяналт шалгалт 8, нийт 12 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 15198 татвар төлөгчийн үйл ажиллагаанд НӨАТУС-ийн хэрэгжилтийн байдлыг шалгасан. Шалгалтаар 62 татвар төлөгчид цахим төлбөрийн QR наалт шинээр үүсгэж, төлбөрийн баримт олгоогүй зөрчил илэрсэн 69 татвар төлөгчийг 57.2 сая төгрөгөөр торгож зөрчлийн хуулиар арга хэмжээ авч зөрчлийг арилгасан. НӨАТ суутган төлөгчийн тоо өмнөх оны мөн үеэс 161 татвар төлөгчөөр нэмэгдэж 975 болж татвар төлөгчийн тоо өмнөх оны мөн үеэс 19.8 хувиар өсөж, төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 14.9 хувиар өссөн. Шалгалтаар цахим төлбөрийн баримт олговол зохих татвар төлөгчийн тоо 642 татвар төлөгчөөр нэмэгдэж 21659 болж суурь түвшнээс 2.9 хувиар өссөн.	100
165	Санхүүгийн салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмжийг сайжруулах	Сургалтад хамрагдсан албан хаагч	Тоо	2024	230	300	687	Дорноговь аймгийн татварын газрын ажилтан, албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ТЕГ-аас зохион байгуулдаг Чиглүүлэх болон мэргэшүүлэх цахим 12, танхим-2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 74 албан хаагч, Мэдээллийн аюулгүй байдлын цахим 1 удаагийн сургалтад 36 албан хаагч хамрагдан сертификат авсан. Мөн албан хаагчдын сургалт, зөвлөгөөнийг танхимаар зохион байгуулж холбогдох байгууллагатай хамтран 40 албан хаагчийг, “Монгол бичгийн урлан” сургалтын төвтэй хамтран цахим бичвэрийн сургалтад 20 албан хаагчийг, мөн 7 хоног бүрийн Даваа гарагт “Мэдээллийн цаг”-ийг 39 удаа	100

								<p>зохион байгуулж 23 албан хаагчийг тогтмол хамруулсан. ТЕГ-т зохион байгуулагдсан татвар хураагчийн чиглүүлэх сургалтад тус аймгийн Татварын газрын 2 улсын байцаагч хамрагдаж, амжилттай суралцаж, татварын улсын байцаагчийн эрхээ авсан.</p> <p>“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлагналд анхаарах асуудлууд, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь”, “НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал”, “Татвар төлөгчдийн татварын хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчлүүд, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт 3 удаагийн цахим сургалтыг ААНБ-ын 155 нягтлан бодогчийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Улсын салбарын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажилтны зөвлөгөөн"-д Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга, 3 санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторуд хамрагдсан.</p> <p>Мөн "Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн шинэ цахим систем"-ийг Дорноговь аймагт 2025 оны 10 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд нэвтрүүлж, аймгийн санхүү, төрийн сантай хамтран төрийн болон орон нутгийн өмчит 181 байгууллагын удирдлага, нягтлан бодогч, нярав, өмч хамгаалах зөвлөлийн дарга, сумдын санхүү албаны дарга зэрэг 336 албан хаагч хамрагдлаа.</p> <p>Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн институтээс зохион байгуулдаг "Мэргэжлийн тасралтгүй хөгжил 2025" зүүн бүсийн мэргэшсэн нягтлан бодогчийн дунд зохион байгуулагдсан сургалтад 20 мэргэшсэн нягтлан бодогч хамрагдсан байна.</p> <p>Санхүүгийн салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмжийг сайжруулахаар нийт 5 сургалт, арга хэмжээний хүрээнд 687 албан хаагчдыг хамрууллаа.</p>	
166	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтад иргэд,	Төсвийн зарцуулалтын хэмнэлт	Хувь	2024	19	19.1	34.5	<p>Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн зарим урсгал зардлыг өмнөх оноос 9-100 хүртэл хувиар бууруулан төлөвлөсөн ба 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан сум, төсвийн</p>	100

	олон нийтийн оролцоог дээшлүүлж, төсвийн ил тод нээлттэй, хариуцлагатай, хэмнэлттэй байдлыг хангах							байгууллагуудад олгох төсвийн санхүүжилтийг эрэмбэлэн төрийн албан хаагчдын цалин хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардлуудыг эхний ээлжид санхүүжүүлэн 2025 оны 9 сарын байдлаар 105.5 тэрбум төгрөгийн зарлагын санхүүжилт гаргасан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 65.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь 55.6 тэрбум төгрөг буюу 34.5 хувийн хэмнэлттэй байна. Монгол Улсын 2025 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль тайлант оны 07 дугаар сард УИХ-аар батлагдсантай холбогдуулан аймгийн 2025 оны орон нутгийн төсөвт Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого зарчмыг баримтлан нийт зарлагыг 12.5 тэрбум төгрөгөөр 9.7 хувиар бууруулж баталсан. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган иргэд олон нийтийг мэдээллээр хангасан.	
167	Санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг сайжруулан сахилга хариуцлагыг дээшлүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үр ашиггүй зардлыг бууруулах	зөвлөмжийн хэрэгжилт	Тоо	2024	82	91.5	91.5	1.Аймгийн Засаг даргаар батлуулсан Санхүүгийн хяналт шалгалтын 01 нэгдсэн удирдамжаар тайлант хугацаанд 34 байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж, шалгалтаар 655.0 сая төгрөгийн 507 зөрчил илрүүлж, улсын ахлах байцаагчийн 131 акт тогтоож, 26 албан шаардлага бичиж, 425 зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 91.5 хувьтай хэрэгжүүлсэн байна. Тайлант хугацаанд тогтоогдсон актын төлбөрөөс 69.6 хувь буюу 456.0 сая төгрөгийг барагдуулж, 199.0 сая төгрөгийн актын төлбөрийн үлдэгдэлтэй байгаагаас 64.5 хувь буюу 128.3 сая төгрөгийн актын төлбөр төлөгдөх хугацаа болоогүй хүлээгдэж байна. Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд цаашид авах арга хэмжээний санал болон шалгалтыг дүнгийн талаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад 3, аймгийн Засаг даргад 5, Орон нутгийн өмчийн газарт 4, Татварын газар, Нийгмийн даатгалын газар, Байгаль орчны газар, Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөл, Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар зэрэг	100

								байгууллагуудад нийт 22 албан бичиг хүргүүлж ажилласан. Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны 2024 он, 2025 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудал илэрсэн тул Аймгийн Цагдаагийн газарт 2025 оны 243 дугаар албан бичгээр шилжүүлсэн. 2.Аймгийн Засаг даргаар батлуулсан Дотоод аудитын 01 дүгээр нэгдсэн удирдамжаар 23 байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүү болон бусад үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл үүсэх магадлалтай асуудлыг тодорхойлж, үр дүн, сахилга хариуцлагыг дээшлүүлэх санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлээ. 3.Аймгийн Засаг даргаар батлуулсан гүйцэтгэлийн хяналт шалгалтын 02 дугаар удирдамжийн дагуу 6 байгууллага, 3 сангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал буурсан эсэхийг анхан шатны баримттай тулган шалгаж, зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай ба өмнөх жилийн хяналт шалгалтаар илэрсэн төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил давтагдаагүй, зөрчлийн давтагдах түвшин 20 хувиар бууруулсан үзүүлэлттэй байгаа нь үр ашиггүй зардлыг бууруулж, санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг сайжруулсан байна.	
168	2. Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг газрын үнэлгээний системд оруулан, дүн шинжилгээ хийх	Үнийн мэдээлэл	Тоо	2024	1930	2080	2111	Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг газрын үнэлгээний цахим системд бүртгэх ажил 2025 онд төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн. Жилийн эцсийн байдлаар газрын биржийн цахим системд нийт 181 газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн санал, зарлагдсан үнийн мэдээллийг бүртгэн, өссөн дүнгээр нийт 2111 мэдээллээр системийг баяжуулсан. Энэ нь газрын үнэлгээ, зах зээлийн судалгаа, бодлогын шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээллийн санг тогтмол шинэчилж, ил тод байдлыг хангах нөхцөл бүрдсэн.	100
169	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн	Дахин ашигласан хөрөнгө	Тоо	2024	1350	1365	1547	Тайлант хугацаанд 3 сумын 9 төсөвт байгууллагын 467.1 сая төгрөгийн 2,207 ширхэг хөрөнгийг тухайн сумын ИТХ-аар хэлэлцүүлэн	100

	хөдлөлийн менежментийг сайжруулах							<p>шийдвэрлүүлж, зарим хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж, ашиглалтын хугацааг сунгаснаас гадна орон нутгийн өмчит 6 байгууллагын хооронд 44 ширхэг хөрөнгийг хэрэгцээт байгууллагуудад ашиглалтын гэрээний үндсэн дээр шилжүүлж, үр дүнтэй ашиглуулж байна.</p> <p>Орон нутгийн өмчит 19 байгууллагаас ирүүлсэн 4,115.5 сая төгрөгийн 3327 ширхэг хөрөнгийн хөдөлгөөний саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2019 оны 70 дугаар тогтоол, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу баримт материалын бүрдлийг хянаж, аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.</p> <p>Өмч хөрөнгийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг бусад хэрэгцээт байгууллагад шилжүүлэн ашиглана гэж заасны дагуу Орон нутгийн өмчит байгууллагаас орон нутгийн өмчит байгууллага руу балансаас балансад 5 байгууллагын 586 ширхэг 557.5 сая төгрөгийн хөрөнгө, орон нутгийн өмчит байгууллагаас төрийн өмчит байгууллага руу балансаас балансад 2 байгууллагын 762 ширхэг 1,386.1 сая төгрөгийн хөрөнгө, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртгийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтсэн хөрөнгийг засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож дахин ашиглана гэж заасны дагуу 2 байгууллагын 199 ширхэг хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж, ашиглалтын хугацааг сунгах саналыг тус тус шийдвэрлүүлж, 9 байгууллага 1547 ширхэг эд хөрөнгийг дахин ашиглаж байна. Орон нутгийн өмчийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө, илүүдэл ажлын байр талбайг бусдад түрээсээр эзэмшүүлэх журмын дагуу 291 гэрээг баталгаажуулан, түрээсийн орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавьж, орон нутгийн төсөвт 6,7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.</p>	
170	Орон нутгийн өмчит байгууллагын	Хяналт шалгалтад	Тоо	2024	30	70	98	Аймгийн засаг даргаар Орон нутгийн өмчийн газраас 2025 онд 4 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний	100

	<p>хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах</p>	<p>хамрагдсан байгууллага</p>					<p>дагуу Замын-Үүд сумын “Борхойн Баянбүрд” ОНӨААТҮГ, "Нийтийн аж ахуй" ОНӨХХК-д, Эрдэнэ сумын "Дагшин-Эрдэнэ" ОНӨААТҮГ-т иж бүрэн хяналт шалгалтыг тус тус хийж гүйцэтгэж, төлөвлөгөөний биелэлт 75 хувийн хэрэгжилттэй байна.</p> <p>Шалгалтаар анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгасан, хөрөнгө бүртгэх шийдвэр гарсан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, зарим хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн зэрэг нийт 1.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх, хөрөнгө бүртгэлийн механизмыг сайжруулах хугацаатай үүрэг чиглэлийг хүргүүлж, 956.8 сая төгрөгийн зөрчлийг бүрэн арилгаж, өртөг нэмэгдүүлэх, ашиглалтын хугацаа сунгах, өмч хөрөнгийг дахин ашиглахтай зэрэгтэй холбоотой 343.2 сая төгрөгийн зөрчил нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх тул 73.6 хувийн биелэлттэй байна.</p> <p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын дагуу байгууллагуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулж, нийт 149 байгууллагын 59.7 хувь нь хангалттай дүгнэгдэж, 40.3 хувьд нь гарч буй алдаа дутагдлыг арилгах, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажиллах тухай зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/187 тоот захирамжаар батлагдсан сумдад хяналт шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу аймгийн ЗДТГ-тай хамтран 14 сумдын 98 төсөвт байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 2020-2024 оны өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд бүртгэлээр хяналтыг хэрэгжүүлж 45.3 сая төгрөгийн зөрчлийг арилгасан.</p>	
--	--	-------------------------------	--	--	--	--	--	--

171	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, холбогдох харилцааг зохицуулах журмыг боловсронгуй болгох	Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр	Тоо	2024	46	50	96	Орон нутгийн өмчит байгууллагын 2024 оны гэрээний хэрэгжилтийг тайлант онд багтаан дүгнэхэд орон нутгийн өмчит 149 байгууллагаас 86 байгууллага нь өмч хамгаалах зөвлөлтэй байв. Мөн 2024 оны гэрээ дүгнэсэн ажлын үр дүнгээр өмч хамгаалах зөвлөл байгуулж ажиллаагүй байгууллагуудад хугацаатай үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин 2025 онд 63 байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн өмчит нийт байгууллагын 98.7 хувь нь өмч хамгаалах зөвлөл байгуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмын дагуу тайлант онд 19 байгууллагын 4,1 тэрбум төгрөгийн 3227 ширхэг хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг өмчийн харилцааг зохицуулах, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор “Өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан.	50
		Журмын нэмэлт өөрчлөлт	Тоо	2024	1	1	0		
172	Эд хариуцагчдын хариуцлагыг дээшлүүлэх	Сургалтад хамрагдсан эд хариуцагч	Тоо	2024	50	80	112	"Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-ийг нэвтрүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах үүднээс 2024 оны жилийн эцэс, тайлант онд үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, тайлан мэдээ хүлээн авах, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулах тухай арга зүйн сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр орон нутгийн өмчит байгууллагын нягтлан бодогч, эд хариуцагч нарт цахим хэлбэрээр зохион байгуулж, 14 сумын 152 байгууллагын 112 албан хаагчийг хамруулсан.	100

173	Орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах	Цахим системийн баяжуулалт	Хувь	2024	10	40	100	<p>МУ-ын Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 4 дүгээр албан даалгаврын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд шинээр хийгдэж буй цахим системийн бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн өмчит 152 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 477,9 тэрбум төгрөгийн хөрөнгийн мэдээллийн дүүргэлт болон зурган мэдээллийг бүрэн оруулсан.</p> <p>Цахим системд орон нутгийн өмчит 152 байгууллагын бүтцийг оруулж, ХУР системээс мэдээллийг татан баталгаажуулсан.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А-1/1579 дугаар албан бичгийн хүрээнд "Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн шинэ цахим систем"-ийг нэвтрүүлэх үйл ажиллагааг Дорноговь аймагт 2025 оны 10 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн болон орон нутгийн өмчийн 181 байгууллагын 334 албан хаагч оролцсон. Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын удирдлага, нягтлан бодогч, нярав, өмч хамгаалах зөвлөлийн байнгын дарга, сумдын санхүү албаны дарга нарыг хамруулсан цахим системд ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Төрийн болон орон нутгийн өмчит 181 байгууллагын нягтлан бодогч нарт цахим системд ажиллах админ эрхийг олгосон бөгөөд цаашид төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын өмч хөрөнгийн нэгдсэн сан үүсэж, өмчийн менежментийг хөнгөвчлөх, мэдээллийн давхардлын зөрүү арилгаж, шийдвэр гаргалтын чанар дээшилж, иргэдэд төрийн өмчийн талаарх мэдээллийг цахимаар авах боломж бүрдэж байна.</p>	100
174	Орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллага	тоо	2024	0	4	3	<p>Хяналт шалгалтын ажлын 2025 оны төлөвлөгөөнд орон нутгийн өмчит 4 компанид ажиллахаар төлөвлөсөн бөгөөд орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай 1 компани, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 2 газарт ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 75.0 хувьтай байна.</p> <p>Хяналт шалгалтаар "Төлөөлөн удирдах зөвлөл"-ийн бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн</p>	75

								<p>батлахдаа хууль эрх зүйн заалт, холбогдох тогтоол шийдвэрийг мөрдлөг болгоогүй, илүүдэлтэй ажлын байр талбайн түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, бодлогын баримт бичгийн төлөвлөлт алдаатай зэрэг зөрчил дутагдал илэрсэн болно. Үүнд:</p> <p>- Замын-Үүд нийтийн аж ахуй үйлчилгээ орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулсан хэдий ч гишүүдийг буруу сонгосон.</p> <p>-Борхойн баян бүрд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь төлөөлөн удирдах зөвлөл байгуулж, бүтэц орон тоо, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан, төсөв хөрөнгө зарцуулсан -Дагшин-Эрдэнэ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, батлагдсан йл ажиллагаа чиглэлийг хэрэгжүүлээгүй, бодлогын баримт бичгийг буруу төлөвлөсөн.</p>	
175	Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчлан таниулж, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх	Сургалтанд хамрагдсан иргэн	Тоо	2024	980	1000	3024	<p>Аймаг дахь Монголбанк-наас “Global money week” аяныг зохион байгуулж хуримтлал, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2142 оюутан сурагч, 680 насанд хүрэгчдэд, "Гүйдэг Моги" номын зохиогч, банкир, сургагч багшаар "Өсвөр насныханд хэвшүүлэх санхүүгийн дадал" сэдвээр 202 ахлах ангийн хүүхдүүдийг сургалт, мэдээллээр хангав. Санхүүгийн эрсдэл дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлж , сэрэмжлүүлсэн масс мессежийг хүргүүлэхэд зориулж аймгийн Засаг даргын А/653 дугаар захирамжаар 2.0 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Мөн “Global money week” аяны хүрээнд явуулсан шторк мэдээ, мэдээллийг Дорноговь Монголбанк пэйж хуудсаар нийт 61,756 иргэнд, "Өөрийн орлого, зардлыг ухаалгаар төлөвлөж ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийж хэвшье", "Санхүүгийн зөв шийдэл-маргаашийн хуримтлалын эхлэл Монгол банк" уриалгатай масс мессежийг 2434 иргэнд хүргэсэн. иргэдэд санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийт 3 сургалт, арга хэмжээний хүрээнд 3024 иргэнийг хамрууллаа.</p>	100

								<p>Үнэт цаасны "Гүүдсек" Сайншанд салбараас 88 иргэний хувьцааны дансыг шинээр нээж, нийт харилцагч нартаа онлайнгаар арилжаанд оролцох заавар зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлсэн.</p>	
176	<p>"Түншлэл ба хөгжил" аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх</p>	<p>Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төсөл</p>	Тоо	2023	0	20	26	<p>Аймгийн ИТХ-ын 2023 оны 15/06 дугаар тогтоолоор батлагдсан "Түншлэл ба хөгжил" зорилтот хөтөлбөрийн хүрээнд 18 иргэн, 8 аж ахуйн нэгжид нийт 1,956 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, зээлдэгчдийн төслийн хэрэгжилтэд газар дээр нь хяналт хийж, гэрээний биелэлтийг хангах арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Хөтөлбөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бизнесийн хамтын ажиллагаа, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх "Хамтын өсөлт" арга хэмжээг зохион байгуулж, өрхийн болон жижиг дунд үйлдвэр, уран бүтээл, аялал жуулчлал, уул уурхай, мал аж ахуй зэрэг салбарын 80 гаруй төлөөллийг хамруулсан бөгөөд одоогоор 22 бизнес эрхлэгчтэй хамтран ажиллаж байна.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх хүрээнд "Их говийн тэмээ" улсын зөвлөгөөнд 350 гаруй оролцогчийг хамруулан 14 үйлдвэр эрхлэгчийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжсэн. Мөн Говийн бүсийн анхдугаар хуралдаанд Дэлгэрэх сумын "Үрлэн борц" төслийг танилцуулж, Чехийн Эдийн засгийн танхимын төлөөллүүдтэй уулзалт хийж 50 гаруй бизнес эрхлэгчийг олон улсын хамтын ажиллагааны боломжийн талаар мэдээллээр хангажээ. Хөтөлбөрийг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч санхүүжилт батлагдаагүй тул хөнгөлөлттэй зээл олголт хийгдээгүй байна.</p> <p>Тайлант онд хөтөлбөрт хамрагдсан 12 зээлдэгчийн төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, хяналт шалгалтыг зохион байгуулахад 83% нь төслийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн, 17% буюу 2 төслийн хэрэгжилт хангалтгүй байсан тул 99,0 сая төгрөгийг татан төвлөрүүлэхээр шаардах хуудсыг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.</p>	100

								Хяналтад хамрагдаагүй 14 төслийг энэ онд багтаан шалгахаар төлөвлөөд байна. Хэрэгжсэн төслүүдийн хувьд үйлдвэр үйлчилгээний газрын хүчин чадал 5-10 хувиар нэмэгдсэн үр дүн гарсан.	
177	“Дорноговьд үйлдвэрлэв” бизнес эрхлэгчдийн төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Ажлын байр	Тоо	2024	0	20	22	<p>“Дорноговьд үйлдвэрлэв” бизнес эрхлэгчдийн төвийг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Сайншанд сумын 2-р багт 849 м² газрыг аймгийн Засаг даргын 2023 оны А/589 захирамжаар шийдвэрлэж, Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн Танхимын санхүүжилтээр төвийн барилгыг барьж, орон нутгийн 190.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 140 м² гадна авто зогсоолыг гүйцэтгэн 2025 оны 10 дугаар 02-ны өдөр тус тус ашиглалтад оруулсан.</p> <p>Нээлтийн хүрээнд 3 өдрийн туршилтын үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 22 үйлдвэрлэгч оролцон бүтээгдэхүүнээ танилцуулж, банк санхүүгийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Түр хугацаанд 22 ажлын байр бий болж, цаашид төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох зорилгоор аймгийн ЗДТГ болон Худалдаа аж үйлдвэрийн танхим хоорондын бүтэц, үүргийн зохицуулалт, санхүүгийн механизмыг 2026 оноос хэрэгжүүлэхээр хэлэлцүүлгийн шатанд байна.</p>	100
178	Үйлдвэр, цехүүдийн үйл ажиллагааг дэмжих замаар хүчин чадлыг нэмэгдүүлэх	Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуй нэгж	Тоо	2023	16	20	21	<p>Аймгийн хэмжээнд 85 хүнсний үйлдвэр, цех, 16 барилгын материалын үйлдвэр, цех, 19 тавилгын цех үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>“Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Төгрөгийн уул” ХХК-д 1.5 тэрбум төгрөгийн хүүгийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээл олгон Замын-Үүд суманд “Нутгийн үйлдвэр” бялуу, талх нарийн боовны үйлдвэр шинээр байгуулан үйл ажиллагаа эхлүүлээд орон нутгийн 30 иргэнийг ажлын байраар хангаж, 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн 1.5 тонныг зах зээлд нийлүүлээд байна.</p> <p>Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Атар 4” газар тариалангийн тогтвортой</p>	100

								<p>хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй хүүгийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлд “Говийн амт трейд” ХХК нь махны үхрийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, үйл ажиллагаагаа өргөтгөх чиглэлээр 300,0 сая, “Мөрөөдлийн говь” ХХК нь тахианы аж ахуйгаа өргөжүүлэхээр 500,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус авснаар төсөл хэрэгжүүлэх шатандаа явж байна. Мөн Турк улсын “Хөдөө аж ахуйг дэмжих” төслийн нийт 3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Даланжаргалан суманд ноос, ноолуур угаах, Алтанширээ суманд арьс, нэхий боловсруулах бага оврын үйлдвэр байгуулахаар ажиллаж байна.</p> <p>Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Алтанширээ, Сайхандулаан сумд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас нийт 9 төсөлд 851.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор 8 ажлын байрыг шинээр бий болгон 9 ажлын байрыг хадгалсан.</p> <p>Тайлант онд нийт 14 ААН, хоршоонд хоршоо хөгжүүлэх сан болон “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, “Атар 4” газар тариалангийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд болон олон улсын төсөл хөтөлбөрөөс нийт 6,151.1 сая төгрөгийн зээл олгогдсоноос гадна “Түншлэл ба хөгжил” зорилтот хөтөлбөрт хамрагдсан 7 ААН-ийг дэмжиж ажилласнаар нийт 21 үйлдвэр, цехийн үйл ажиллагаа нь өргөжин, хүчин чадлаа 5-10 хувиар нэмэгдүүлж шинээр 8 иргэнийг ажлын байраар хангасан.</p>	
179	Хүнсний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг сайжруулах	Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан объект	Хувь	2023	99	100	100	<p>Аймгийн хэмжээнд хүнсний худалдаа эрхлэгч 335, үйлдвэрлэл үйлчилгээний 67, хоол үйлдвэрлэлийн 155 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Улсын ерөнхий байцаагчийн баталсан 3 удирдамжийн дагуу хийх төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 17 объектын 3 нь үйл ажиллагаагаа зогсоосон тул хүнсний худалдааны 8, хоол үйлдвэрлэлийн 6 буюу хамрагдвал зохих нийт 14 объектыг 100 хувь хамруулсан. Шалгалтаар 223 зөрчил илрүүлж, 95 буюу 42.6%-ийг газар дээр нь арилгуулсан. Зөрчил ихтэй 11 объектод 128 заалт бүхий албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснээс 10 объект шаардлагын биелэлтийг ирүүлж, гүйцэтгэлийн</p>	100

								<p>хяналтаар 113 заалт буюу 88.28%-ийн хэрэгжилттэй байна. /15 заалт нь улирлын чанартай барилга байгууламжийн шаардлага тул хугацаатай хэрэгжих нөхцөлтэй.</p> <p>Төлөвлөгөөт шалгалтаар объектуудын хууль сахин мөрдөлт 64.68% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 70.47% болж 5.79%-иар сайжирч, эрсдэлийн түвшин 37.2%-иас 29.53% болж 7.67%-иар буурсан байна.</p> <p>Хүнсний аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 9 удаагийн танхимын сургалтад 755 иргэн (325 бизнес эрхлэгч, 208 эцэг эх, 222 сурагч), цахим сургалтад 27 хүнийг хамруулж, нийт 782 иргэнд мэдээлэл хүргэн, 615 иргэнд биечлэн зөвлөгөө өгсөн. Тайлант онд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад давхардсан тоогоор нийт 218 ААН, 559 иргэн буюу нийт 773 объектыг хамруулж өмнөх оноос 300 объект буюу 64.3%-иар нэмэгдүүлж хүнсний аюулгүй байдалд хяналт тавих хяналтыг сайжруулсан.</p>	
180	Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт холбогдох стандартыг мөрдүүлэх	Худалдаа үйлчилгээний салбарт мөрдөх стандартын хангалт	Хувь	2023	93	95	100	Улсын хэмжээнд худалдааны 23, хүнсний үйлдвэрийн 16, үйлчилгээний 38 үндэсний болон олон улсын стандартыг мөрддөг. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдааны 345, хүнсний үйлдвэр, цех 46, хүнсний бус үйлдвэр 23 нийт 414 худалдаа, үйлдвэр, үйлчилгээний газрын 37,6 хувийг стандартын тохирлын үнэлгээнд хамруулахад стандарт хангалтын дундаж 100 хувьтай байна.	100
181	Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт цахим нэгдсэн санг нэвтрүүлж, хөгжлийн хоцрогдлыг арилгах бодлогыг дэмжих	Хамрагдсан бизнес эрхлэгч	Тоо	2024	25	50	56	Аймгийн хэмжээнд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний 87 төрөл, ангиллын хүрээнд 979 бизнес эрхлэгч идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байна. “Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн мөрдөх нийтлэг журам”-ын дагуу нэгдсэн бүртгэлийн системийг хөгжүүлэх ажлын гүйцэтгэл 60 гаруй хувьтай үргэлжилж, үйлчилгээ эрхлэгчдийн цахим бүртгэл нэг стандартад шилжиж байна. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд согтууруулах ундаа худалдах, үйлчилгээтэй холбоотой зөвшөөрлийг 2022 оноос хойш e-mongolia системээр бүрэн хүлээн авч шийдвэрлэх хэвшлийг	100

								<p>бүрдүүлсэн бөгөөд 2025 онд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа үйлчилгээ явуулах энгийн зөвшөөрлийг мөн цахимаар олгодог болсон. Цахим худалдааны чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд БНХАУ-ын Худалдааны яамны зохион байгуулсан хоёр сургалтад 2 төрийн албан хаагчийг хамруулж, импорт, экспортын стандарт, хяналт, хорио цээрийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэв.</p> <p>Мөн “Түншлэл ба хөгжил” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Аймгийн мэдээллийн цахим нэгдсэн сан” төслийн гүйцэтгэл 80 гаруй хувьтай, одоогоор 7 төрлийн үйлчилгээгээр 31 бизнес эрхлэгч бүртгэгдлээ.</p>	
182	<p>Малын чанар, таваарлаг байдлыг хангах чиглэлээр судалгаа, шинжилгээг хувийн хэвшлийн байгууллагуудын зах зээлийн шаардлагатай уялдуулан, бизнесийн зарчмаар хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэн малын генетикийг сайжруулах</p>	Ангилалтад хамруулсан мал	Тоо	2024	8800	9000	0	<p>Мал сүргийн ашиг шим, генетикийн чанарыг дээшлүүлэх бодлогын хүрээнд Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн сумдын нийт 9,000 толгой бог малыг 10 дугаар сард технологийн хугацаанд үзлэг, ангилалт хийж бүртгэлжүүлэх, цөм сүрэг бий болгох ажлыг төлөвлөсөн. Уг арга хэмжээ нь малын таваарлаг байдлыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн зах зээлийн хэрэгцээтэй уялдсан судалгаа, шинжилгээний тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд төсвийн тодотгол хийгдэж, шаардлагатай зардлын санхүүжилт хасагдсан тул төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байна.</p>	0
183	<p>Нутгийн Монгол адууны угшлыг судлах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулах</p>	Арга хэмжээ	Тоо	2024	0	2	1	<p>Нутгийн монгол адууны угшлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах ажлыг 14 сумын хүрээнд хийж гүйцэтгэснээр Дэлгэрэх сумын нутгийн монгол адуунд судалгааны ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Уг судалгааны ажилд шаардлагатай судалгаа, мэдээлэл, аргагүйг боловсруулж, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран судалгааг 2026 онд эхлүүлэхээр гэрээний төсөл, саналыг хүргүүлсэн.</p>	50

184	Малын генийн санг хамгаалах, нутгийн шилмэл омгийн ашиг шимийн гарц сайтай малын тархалтыг нэмэгдүүлэх	Сүрэгт эзлэх өндөр ашиг шимт мал	Хувь	2023	1.9	2	2	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 92 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын А/144 дүгээр тушаалын дагуу үүлдэр омгийн малын онцлог, нутгийн малын үүлдэр угсааг сайжруулах, өндөр ашиг шимт малыг нэмэгдүүлэх, тархалтыг өргөжүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүнд: 14 сумын ХААТ-ийн мэргэжилтэн, малчдын зөвлөгөөн, өдөрлөгөөр нийт 10 сумын 2,172 малчдыг мэдлэг, мэдээлэл, гарын авлагаар хангаж ажилласан. Дэлгэрэх сумын улаан омгийн ямааны цөм сүргээс 83 өсвөр хээлтүүлэгч бэлтгэн нутгийн малын үүлдэр угсааг сайжруулахад ашигласан. Мөн Дэлгэрэхийн улаан омгийн ямааны цөм сүргээс Эрдэнэ сумын “Эрдэнэт дунд хүр” хоршоо 110 толгой хээлтэгч худалдан авч малын чанарыг сайжруулах ажлыг эхлүүлсэн.</p> <p>“Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд Дэлгэрэх сумын 4 хоршоонд үржлийн мал өсгөх, үржүүлэх чиглэлээр 160,0 сая төгрөгийн зээл олгосон. Аймгийн хэмжээнд нийт 1,452.223 толгой мал байгаагаас өндөр ашиг шимт мал сүрэг 28662 толгой буюу 2 хувийг эзэлж байна.</p>	100
185	Мал, амьтны гоц халдварт, халдавт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргийг бүрэн хамруулах	Тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл	Хувь	2024	30	70	98.5	<p>2025 онд мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг МЭЕГ-ын даргын А/297 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны А/310 дугаар захирамжийн дагуу сумдын түвшинд зохион байгуулж, төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлсэн.</p> <p>Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 8 сумын хэмжээнд 33804 үхэр, 157 гахай, нийт 33,961 толгой мал хамрагдаж 96.7%-ийн биелэлттэй хэрэгжсэн. Бог малын мялзангийн эсрэг дархлаажуулалтад төлөвлөсөн 1.428 сая толгойноос 1.367 сая толгой мал хамрагдаж 95.7%-ийн гүйцэтгэлтэй байв.</p> <p>Зоонозын Бруцеллёз өвчний эсрэг дархлаажуулалтад 1075 өрхийн 121,129 толгой бог малыг хамруулж, төлөвлөгөөг 99.9%-тай биелүүлсэн. Мал амьтны зооноз халдварт галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 78.0 мянган толгой малыг хамруулахаар төлөвлөснөөс 77806 мянган толгой мал хамрагдсан буюу дархлаажуулалт</p>	100

								99.7 хувьтай, зооноз халдварт боом өвчний дархлаажуулалтад 18.0 мянган толгой мал хамруулахаар төлөвлөснөөс 17983 мянган толгой малыг хамруулсан буюу гүйцэтгэл 99.9 хувьтай. Хонины цэцгийн эсрэг дархлаажуулалтад төлөвлөсөн 805 мянгаас 789.1 мянган толгой мал хамрагдаж 98%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Мөн халдварт өвчний 5 төрлийн арга хэмжээнд 609.6 мянган толгой малыг хамруулахаар төлөвлөснөөс 608.6 мянга нь хамрагдаж 99.8%-ийн биелэлттэй хэрэгжсэн нь өмнөх оны мөн үеэс 71%-иар өсөж тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл 98.5 хувьтай байна.	
186	“Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг төв”, үйлчилгээний нэгж байгуулах хувийн хэвшлийг бодлогоор дэмжих	Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж	Тоо	2024	0	1	1	Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газраас жишиг төвийн зураг төслийг боловсруулж, аймгийн хэмжээнд 14 сумыг бүс болгон хуваан 3 суманд мал эмнэлгийн үйлчилгээний жишиг төв байгуулахаар төлөвлөсөн. Энэхүү арга хэмжээг аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого - Тасралтгүй хөгжил" 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусган батлуулж, Эрдэнэ, Даланжаргалан суманд жишиг төв барих газрыг шийдвэрлэсэн. Сайхандулаан суманд мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг 3 үйлчилгээний нэгжүүд хоорондоо гэрээ байгуулан иргэд малчдад 1 цэгийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	100
187	Мал эмнэлгийн тандалт, шинжилгээ, судалгааг тогтмолжуулах	Ажлыг гүйцэтгэл	Хувь	2024	76	100	100	2025 онд малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 14 суманд масс идэвхтэй болон идэвхгүй тандалт, судалгааг тогтмолжуулж зохион байгуулсан. Идэвхтэй үзлэгт 3026 өрхийн 1,367 мянган толгой бог мал, идэвхгүй үзлэгт 311 өрхийн 111.5 мянган толгой мал, нийт 3,337 өрхийн 1,478.5 мянган толгой мал хамрагдав. Бог малын мялзан, хонины цэцэг, ямааны годрон өвчний идэвхгүй тандалтад 7137 өрх хамрагдаж, халдварт өвчний эрт илрүүлгийн идэвхтэй тандалтад 151 өрхийн 94,183 мал хамрагдаж, 5.4 сая төгрөг зарцуулсан. Оролцоот эпидемиологийн аргачлалаар идэвхгүй тандалтад 206 малчин, 105,071 мал хамрагдаж, 7.9 сая төгрөг зарцуулсан. Айраг, Иххэт	100

								<p>суманд шүлхий өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх тандалтад 101,711 мал хамрагдаж, өвчний шинж тэмдэг илрээгүй.</p> <p>Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 1-4 удаагийн хяналт шинжилгээгээр 7,670 өндөг, 137,648 тн мах, 1.4 тн цагаан идээ эрүүл, аюулгүй болохыг баталгаажуулсан. Молекул биологи, хүнд металл, шимэгч судлалын шинжилгээнд 65 эмгэгт материал ирж, 17 өвчин оношлогдсон. Адууны ям, африк мялзан, халдварт цус багадах өвчний тандалтад 140 адуу хамрагдаж, 2 адуунд ям өвчин илэрч хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Шүлхий өвчний тандалтад 960 мал хамрагдаж, 1% халдвар илэрснийг давтан шинжилгээнд хамруулахад шинжилгээний хариу сөрөг дүнтэй гарсан.</p> <p>Энэ нь өмнөх онтой харьцуулахад 50%-иар буурсан. Бруцеллез өвчний тандалтад 11,200 дээжийг шинжилж бүгд сөрөг дүнтэй гарсан.</p> <p>Тандалт, судалгааны ажилд нийтдээ 57.9 сая төгрөг зарцуулж, 14 сумын 28 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 33,600 хэрэглэгдэхүүн тарааж, мал эмнэлгийн тандалт, шинжилгээ, судалгааг тогтмол зохион байгуулж байна.</p>	
188	Дутагдалтай малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтэн бэлтгэх	Хүний нөөцийн хангалт	Хувь	2024	71	85	92	<p>Тайлант онд малын эмч мэргэжилтэн дутагдалтай байсан Хөвсгөл, Сайхандулаан, Айраг суманд Мал эмнэлгийн тасагт 3 малын их эмч, 2 мэргэжилтэн, Мал, амьтны эрүүл мэндийн албанд 1 мэргэжилтэн тус тус нэмэгдсэнээр хүний нөөцийн хангалт сайжирсан.</p> <p>Мөн малын эмч мэргэжилтний тоог нэмэгдүүлэх зорилгоор Төв аймгийн Эрдэнэ суманд үйл ажиллагаа явуулдаг Политехникийн коллежид малын бага эмч мэргэжлээр 7 иргэнийг сургаж байна. Мал эмнэлгийн үйлчилгээний 30 нэгжид 32 малын их эмч, 5-малын бага эмч, Мал эмнэлгийн газарт 10 эмч, сумдын мал эмнэлгийн тасагт 14 малын эмч ажиллаж байгаа нь аймгийн хэмжээнд хүний нөөц 92.1 хувьтай байна.</p>	100
189	Сумдад махны чиглэлээр эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх	Махны чиглэлийн үхрийн	Тоо	2023	8	15	15	<p>2025 онд аймгийн сумдад махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуйг дэмжих чиглэлээр арга хэмжээ авлаа. “Атар 4” хөтөлбөрийн хүрээнд хүүгийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлээр “Говийн амт трейд”</p>	100

		эрчимжсэн аж ахуй						ХХК махны чиглэлийн герефорд үүлдрийн 65 тугалтай үнээ, 2 хээлтүүлэгч, 2 өсвөр хээлтэгч авч, төслийн гүйцэтгэл 90%-тай үргэлжилж байна. Мөн "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд Сайншанд, Улаанбадрах сумдын 2 хоршоонд мах, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд 100,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч 10 иргэн, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч 4 иргэн, 1 аж ахуй нэгж, нийт 15 иргэн, ААН үйл ажиллагаа эрхэлж, жилд дунджаар 8.1 тн махыг зах зээлд нийлүүлж байна.	
190	Сумдад "Мал нядалгааны цех" байгуулах хувийн хэвшлийг дэмжих	Мал нядалгааны цех	Тоо	2023	6	8	8	2025 онд аймгийн хэмжээнд хувийн хэвшлийг дэмжин сумдад мал нядалгааны цех байгуулах, үйл ажиллагааг өргөжүүлэн одоогоор Сайншандад, Айраг, Алтанширээ, Даланжаргалан-2, Дэлгэрэх, Мандах, Сайхандулаанд нийт 8 нядалгааны цех үйл ажиллагаа явуулж байна. "Говийн амт трейд" ХХК махны үхрийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх төслийн хүрээнд 300,0 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээл авч, төслийн хэрэгжилт 90% хүрсэн. Өргөн, Сайншанд сумдын хоршоо хөгжүүлэх сангаас 1 хоршоо, 2 аж ахуйн нэгжид мал, мах боловсруулах, нөөцлөх чиглэлээр нийт 479,1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлсэн. Мөн Дэлгэрэх сумын "Дэлгэрч дэвших дэргийн булаг", Даланжаргалан сумын "Өнгөт баянбүрд" хоршоод мал нядалгааны цэг байгуулах төсөл боловсруулж, Төрийн банкнаас 610,0 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Тайлант онд нийт 816,5 тн махыг бэлтгэн зах зээлд нийлүүлснээс 260 тн буюу 31,8%-ийг үйлдвэрийн аргаар бэлтгэж байна.	100
191	Сүүний чиглэлийн үхрийн механикжсан саалийн ферм байгуулах аж ахуйн нэгжийг дэмжих	Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй	Тоо	2023	10	13	13	Аймгийн хэмжээнд сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй 13 иргэн, аж ахуйн нэгж нийт 209 толгой үхэр, мах, сүүний чиглэлийн 11 иргэн 311 толгой үхэртэйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. "Атар 4" газар тариалангийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй хүүгийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлийг 6,4 мянган	100

								<p>иргэнд хүргэн, тайлант онд Замын-Үүд, Улаанбадрах, Сайншанд сумын 3 иргэн сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэх, өргөтгөх, тоног төхөөрөмж худалдан авах хүсэлт ирүүлснийг, мэргэжлийн арга зүйгээр ханган ХХААХҮЯ-нд уламжлан бодлогоор дэмжсэн. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр “Эвт чандмана тулга” хоршоо 70,0 сая, “Баян овоо хайрхан” 50,0 сая, “Говийн наран төхөм” хоршоо 90,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлж, сав баглаа боодлоо шинэчлэх, малын хашаагаа засварлахад зарцуулсан.</p> <p>Үүний үр дүнд хоршоод бүтээгдэхүүний нэр төрлөө 3–7 нэрээр нэмэгдүүлж, нийт 15–20 нэр төрлийн 118,8 тн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны мөн үеэс 17,3%-р нэмэгдүүлсэн.</p>	
192	Ингэний сүүний эрчимжсэн аж ахуй байгуулах хувийн хэвшлийг дэмжих	Ингэний сүүний эрчимжсэн аж ахуй	Тоо	2024	0	3	3	<p>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгоор өрнөж буй "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд Өргөн, Айраг, Сайншанд, Хатанбулаг, Улаанбадрах, Эрдэнэ, Мандах сумдын 8 хоршоо ингэний ферм, сүү, сүүн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх чиглэлээр 1.5 тэрбум төгрөгийн зээлд хамрагдан нийт 1433 толгой ингэтэй үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Эрдэнэ сумын "Говийн наран төхөм", "Өсөх ингэн тэмээн сүрэг" хоршоодын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж хоршооны гишүүн 2 малчныг Шинэ-Хоршоо" хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулж буй "Мал аж ахуй эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх" сургалтад хамруулсан.</p> <p>Ингэний сүүний эрчимжсэн аж ахуйн чиглэлээр аймгийн хэмжээнд 1 ААН, 2 хоршоо, нийт 3 эрчимжсэн аж ахуй тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаагаас “Хашаатын говийн заг” ХХК нь тус онд 12,5 мян/л буюу 12 тн ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн УБ хотод 3 цэг, орон нутгийн 8 цэг, 13 цэцэрлэгт нийлүүлж байна.</p>	100
193	Хөдөө аж ахуйн гаралтай нэмүү өртөг шингэсэн	Үйлдвэр эрхлэгчид	Тоо	2023	0	20	27	Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний үндэсний нэгдсэн холбоотой хамтран зохион байгуулсан “Монгол эв нэгдэл” төслийн хүрээнд Дорноговь	100

	эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг борлуулалтын нэгдсэн системд оруулах ажлыг эхлүүлэх							<p>аймгийн тариаланчид малчид, хоршоод цаашид бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрхэн сайжруулах, хамтран ажиллах өртгийн сүлжээнд нэгдэх талаар санал бодол солилцож, аймгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж нийт 300 гаруй иргэн, ААН-ийг оролцуулсан.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн газраас нэвтрүүлсэн Regional.gov.mn/event нэгдсэн системд Дорноговь аймгаас 27 үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийг оруулсан ба улсын хэмжээнд дата мэдээлэл цуглуулах шатандаа явж байна.</p>	
194	Малын гаралтай түүхий эдийг эцэслэн боловсруулах бага, дунд үйлдвэрийг дэмжих	Бага, дунд үйлдвэр	Тоо	2023	2	4	4	<p>Малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр Айраг, Алтанширээ, Даланжаргалан сумдад үйл ажиллагаа явуулдаг 4 бага, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжүүд нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр “Шинэ хоршоо” хөдөлгөөн, Хоршоо хөгжүүлэх сан, олон улсын төсөл хөтөлбөрөөс нийт 805.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамрагдсан. Ингэснээр шинээр 8 ажлын байр бий болж, үйлдвэрийн хүчин чадлыг 20 хувиар нэмэгдүүлсэн.</p> <p>Дээрх аж ахуйн нэгжүүд нь малын дайвар бүтээгдэхүүн болох хонь, үхрийн гүзээ, уушги, элэг, бөөр, хэл, сархинаг, гургалдай, сүүл, чөмөг, толгой, шийр зэрэг 10–12 нэр төрлийн бүтээгдэхүүнийг ангилан савлаж, нийт 12,8 тн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн.</p> <p>Мөн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр “Эвт чандмана тулга” хоршоо 70,0 сая, “Баян овоо хайрхан” 50,0 сая, “Говийн наран төхөм” 90,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлж, сав баглаа боодлоо шинэчлэн, малын хашаагаа засварласан. Зээлд хамрагдсанаар хоршоодын бүтээгдэхүүний нэр төрөл 3–7-оор нэмэгдэж, нийт 15–20 нэр төрлийн 118,8 тн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны мөн үеэс 17,3 хувиар нэмэгдүүлсэн.</p>	100
195	Малын гаралтай түүхий эд бэлтгэлд олон улсын	Арга хэмжээнд хамрагдсан иргэд, малчид	Тоо	2023	380	450	1673	<p>Аймгийн хэмжээнд малын гаралтай түүхий эд бэлтгэлд 45 иргэн, аж ахуй нэгж оролцож, сумдад 13 төлөөлөгч ажиллан үйл ажиллагааг хариуцан</p>	100

	стандартыг мөрдүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах							<p>ажиллаж байна. Тайлант хугацаанд тэмээний 6,656 ширхэг, адууны 23,724 ширхэг, үхрийн 19,108 ширхэг, хонины 237,676 ширхэг, ямааны 197,408 ширхэг арьс, нэхий бэлтгэн үндэсний томоохон үйлдвэр, орон нутгийн зах зээлд нийлүүлсэн.</p> <p>Мал, малын гаралтай түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх, мал нядалгааны үеийн гэмтлийг бууруулах, арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 1,400 гаруй малчид, иргэдэд сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлсэн. Мөн Айраг, Даланжаргалан, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ, Өргөн, Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл сумдад нэг удаагийн танхимын сургалтад 1,673 малчид, иргэд оролцон, мал аж ахуй, түүхий эд бэлтгэлийн стандарт, олон улсын туршлага зэрэг мэдээллийг хүлээн авсан.</p> <p>“Шинэ-Хоршоо” хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулсан “Мал аж ахуй эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх” сургалтад 14 сумын 40 хоршооны гишүүн, малчин өрх хамрагдан, стандартын мэдлэг, мэдээллээр хангагдсан.</p> <p>Энэ ажлын үр дүнд малын гаралтай түүхий эдийн чанар сайжирч, үйлдвэрлэлийн нөөц ашиглалт нэмэгдэж, зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний аюулгүй байдал, өрсөлдөх чадвар дээшилсэн.</p>	
196	Зарим сумдад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн агро парк байгуулах судалгааны ажлыг гүйцэтгэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2023	0	70	40	<p>Улсын төсвийн 250,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2023 онд Сайншанд сумын 7 дугаар багт “Жимс, жимсгэнэ, үр үржүүлэг, суулгацын төв” байгуулагдсан бөгөөд 4 га талбайд 14 сортын 7 нэр төрлийн 1500 ширхэг жимс, жимсний тарьц, суулгацыг тарьж нутагшуулсан. Үүнд: 2 сортын алимны мод 60 ширхэг, 2 сортын чавганы мод 60 ширхэг, 2 сортын лийр 60 ширхэг, 3 сортын чацаргана 300 ширхэг, 2 сортын үхрийн нүд 400 ширхэг, 2 сортын бөөрөлзгөнө 500 ширхэг, 1 сортын интоор 120 ширхэг багтсан байна.</p> <p>Мөн Сайншанд сумын Зээгийн хөтөлд 30 га талбайд Хилийн цэргийн 336-р ангийн харьяа иж бүрэн агропарк байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Тус агропарк 400 м² дөрвөн улирлын хүлэмж, 5,000 м² зуны хүлэмж, 124,115 м² бойжуулагын</p>	57.1

								туннел, нийт 16 га талбайд мод бутны суулгац үржүүлж байна. Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн агропарк байгуулахад шаардлагатай суурь судалгаа, мэдээллийг Ургамал, газар тариалангийн хүрээлэнтэй хамтран 40%-тай гүйцэтгээд байна.	
197	“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	Байгуулагдсан хоршоо	Тоо	2023	37	190	277	“Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд нийт 240 хоршоо шинээр байгуулагдаж, 14 сумын 517 малчин нийт 20.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйл ажиллагаа эхлүүлсэн. Үүний үр дүнд 14 сумын 142 хоршоо зээлийн хөрөнгөөр, 2 сумын 2 хоршоо хувийн хөрөнгөөр түүхий эд бэлтгэх, боловсруулах, мал сүргийн ашиг шимийг нэмэгдүүлэх, бойжуулах, худаг гаргах, хашаа саравч барих зэрэг чиглэлээр ажиллаж байна. Тайлант хугацаанд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 5 сумын 9 хоршоонд 851.1 сая төгрөгийн зээл олгож, 5 сумын 8 хоршоонд 29.09 га газар эзэмшүүлэх эрх олгосон. Мөн 5 сумын 6 хоршооны 19.5 га газар эзэмших хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа байна. Хоршоодын чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод 3 хоногийн вакум сургалт зохион байгуулж 14 сумын 40 малчин оролцсон бөгөөд 4 сумын малчдын зөвлөгөөнөөр 800 гаруй хоршооны гишүүн, малчдад мэдлэг олгов. Мөн “Говийн бүсийн анхдугаар хуралдаан”-ы үеэр болсон үзэсгэлэн худалдаанд 10 хоршоо бүтээгдэхүүнээр, 3 хоршоо үйл ажиллагаагаа сурталчлан оролцсон. Аймгийн хэмжээнд нийт 277 хоршоо үйл ажиллагаа явуулж байна.	100
198	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ертгийн сүлжээнд оролцох чиглэлээр малчид, тариаланчдыг сурган тэргүүн туршлагауудыг судлуулах	Малчид, тариаланчид	Тоо	2023	84	100	264	Малчид, тариаланчдыг чадавхжуулах, туршлага судлуулах ажлын хүрээнд 4 дүгээр сард Бүх Хятадын жимс жимсгэний тариалан, Бээжин хотын өвлийн хүлэмжийн аж ахуй, хөдөө аж ахуйн үр үрслэг, техник тоног төхөөрөмжийн худалдаатай танилцах аялалд 12 тариаланчийг, Дорноговь аймгийн Засаг дарга болон нутгийн зөвлөл хамтран Улаанбаатар хот дахь GCS олон улсын байгууллагын сургалтын төвд 5 дугаар сард 14 сумын хоршоодын 40 малчин гишүүдийг, 8 дугаар сард Улаанбаатар хотод зохион	100

								<p>байгуулсан “Дундын хоршоо ба бизнес түншлэл” улсын зөвлөгөөнд аймгийн хоршоологчдын холбооноос 9 хоршооны төлөөллийг, 10 дугаар сард Өвөрхангай аймагт зохион байгуулсан “Хоршоологчид тогтвортой хөгжилд-2025” сургалт семинарт 3 хоршооны төлөөлөл оролцож, төрөөс хоршоодын талаар баримталж буй бодлого, ТӨХХК, Хөдөө аж ахуйн биржийн дэмжлэг, дундын хоршоо, кластерын талаар мэдлэгээ нэмэгдүүллээ. Нийтдээ тайлант онд 264 малчин, тариаланчийг туршлага судлах үйл ажиллагаанд хамруулсан.</p> <p>Мөн 2025 оны 10 дугаар сард Шадар сайдын ажлын албанаас “Шинэ хоршоо-2” хөдөлгөөн өрнүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дундын хоршоо байгуулах дундын хоршоогоор дамжуулан өртгийн сүлжээнд орж борлуулалтаа нэмэгдүүлэх талаар танилцуулсан уулзалт хэлэлцүүлэгт Айраг, Сайншанд, Замын-Үүд, Хатанбулаг сумдын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 200 гаруй төлөөллийг хамрууллаа.</p>	
199	Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх	Сум дундын отрын бүс нутаг	Га	2023	108000	128000	160159	<p>Аймаг, сумын тусгай хэрэгцээний сум дундын отрын бүс нутгаар авах боломжит газрыг тодорхойлох зорилгоор 14 сумаас ирүүлсэн саналыг үндэслэн дараах судалгааг хийсэн. Үүнд: Алтанширээ, Иххэт, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах сумдаас аймгийн ИТХ-ын 2020 оны 02/11 дугаар тогтоолоор батлагдсан 108 мянган га отрын бүс нутгийг хэвээр үлдээж, хугацааг сунгах саналыг ирүүлсэн.</p> <p>Хатанбулаг сум “Номгоны хөндий” отрын бүсийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх саналыг гаргасан. Эдгээр саналуудыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлж, холбогдох газрын кадастрын мэдээллийн бүртгэлийг шалган, хил хязгаарыг баталгаажуулах, судалгааны ажлыг зохион байгуулж Алтанширээ сумын Тариачийн хэц орчмын 5510.48 га газар, Иххэт сумын Өвсөн, Агийн цагаан толгой орчмын 31042.78 га газар, Мандах сумын Ноён номгоны хөндий орчмын 13788.94 га газар, Сайхандулаан сумын Зүүн овоогийн тал орчмын 11662.08 га газар, Улаанбадрах сумын Тал хонгор орчмын 7012.0 га газар, Хатанбулаг</p>	100

								<p>сумын Номгоны хөндий орчмын 90416.06 га газар нийт 159432.34 га бэлчээрийн газрыг аймаг, сумын тусгай хэрэгцээний отрын бүс нутгаар авах боломжтойг тогтоосон.</p> <p>Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/11 дүгээр тогтоолоор 5 жилийн хугацаагаар тусгай хэрэгцээнд авсан сум дундын отрын бүс нутгийн хугацаа дуусаж, хугацааг сунгах болон шинэчлэн тогтоох асуудлыг аймгийн ИТХ-ын хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулахаар саналаа хүргүүлсэн.</p>	
200	Малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх	Тариалсан талбай	Га	2023	56	118	99.5	<p>Хатанбулаг суманд дэлхийн Зөн ОУБ-тай хамтран зохион байгуулсан малчдын өдөрлөгөөр малын тэжээлийн ургамал тариалах, малыг зөв тэжээх арга ухааны талаарх мэдээллийг 100 гаруй малчдад хүргэсэн.</p> <p>Мөн 6 сумын 360 гаруй малчид, тариаланчдад хөдөө аж ахуйн томоохон төслүүд, өвөлжилтийн бэлтгэл, тэжээл бэлтгэх арга хэмжээг газар дээр нь танилцуулсан. Иргэн, аж ахуйн нэгжийн ногоон тэжээл тариалах санаачилгыг дэмжих зорилгоор “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас Эрдэнэ сумын “Бүхэлийн баян бүрд” хоршоонд 25,0 сая төгрөг, Сайхандулаан сумын Бурхантын говийн загал хоршоонд 50,0 сая төгрөгийн зээл олгожээ.</p> <p>Аймгийн хэмжээнд Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд суманд нийт 99,5 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 219,3 тонн ургац хураан авсан.</p>	70.1
201	“Тэжээлийн цех”, “Бордоо”-ны үйлдвэр байгуулах хувийн хэвшлийг дэмжих	Төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж	Тоо	2023	1	2	2	<p>Аймагт тэжээл болон органик бордоо үйлдвэрлэх хувийн хэвшлийг дэмжих бодлогын хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн явцыг нэгтгэн үзвэл, Айраг сумын “Говийн өгөөж” ХХК 2022 оноос малын бууцаар органик бордоо үйлдвэрлэж, аймаг орон нутаг болон Улаанбаатар хотод нийлүүлж байгаа бөгөөд 2024 онд 3.2 тонн бордоо үйлдвэрлэн борлуулсан байна. ИТХ-ын 2023 оны 15/06 дугаар тогтоолоор хэрэгжиж буй “Түншлэл ба хөгжил” хөтөлбөрийн хүрээнд Сайншанд сумын “Говийн шимт увидас” ХХК 135 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр тэжээлийн цех байгуулах ажлыг эхлүүлж, одоогийн байдлаар 50 хувийн гүйцэтгэлтэй</p>	100

								үргэлжилж байна. Мөн “Атар-4” хөтөлбөрийн хүрээнд “Мөрөөдлийн говь” ХХК 500 сая төгрөгийн зээл авч, хоногт 80 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барьж байгаа бөгөөд ажил 60 хувьтай явагдаж байна. Эдгээр төслүүдийн үр дүнд аймгийн хэмжээнд хоёр шинэ тэжээлийн үйлдвэр, цех байгуулагдаж, дотоодын тэжээлийн хэрэгцээг хангах боломж бодитоор бүрдэж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг дэмжих суурь нөхцөл нэмэгдэж байна.	
202	Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Арга хэмжээ	Тоо	2023	7	10	10	Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх хүрээнд Малчны тухай хуулийн 4.2.5-т заасан, малчнаар 10-аас дээш жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээрийн чиглэлээр үнэ төлбөргүй сургах зохицуулалт 2025 оноос хэрэгжиж эхэлж байна. Энэхүү зохицуулалтын талаар Айраг, Даланжаргалан, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ, Өргөн, Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл сумдын 1673 малчинд танилцуулга хийв. Аймгийн Политехникийн коллежтой хамтран газар тариалангийн мэргэжлийн сурталчилгааны өдөрлөг зохион байгуулж, 400 гаруй иргэнд чиглэсэн мэдээлэл хүргэсэн. Тайлант онд хүлэмжийн аж ахуй, фермерийн ангид 18 суралцагч төгсөж, мөн Сайншандын 5 дугаар сургууль болон Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдын сурагчдад хөдөө аж ахуйн мэргэжлийг сурталчлах аялал, сургалт мэдээллийг зохион байгуулж 9–11 дүгээр ангийн 190 гаруй сурагчдыг хамруулсан. Салбарын хүний нөөцийн залгамж халааг бэлтгэх 10 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, нийт 2263 иргэнийг хамруулсан.	100
203	Малжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх	Хамрагдсан малчин өрх	Тоо	2023	121	151	161	Аймгийн Засаг даргын 2024 оны 02/1471 дүгээр захирамжаар батлагдсан “Малчдын амьжиргааг дэмжих төсөл арга хэмжээнд хамрагдсан малчид гэрээний дагуу эргэн төлөлт хийх Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Сайншанд сумдын 50 малчин өрхийн судалгааг сум бүрээр гарган 2025 онд эргэн төлөлтийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 29,9 сая төгрөг	100

								төвлөрүүлэхээс 23.3 сая төгрөг буюу 77,9 хувийг төвлөрүүлсэн байна. Тайлант онд нийт 11 сумын 40 өрхийг 2678 толгой малаар малжуулах ажлыг бүрэн хийсэн.	
204	“Шинэ хөдөө” төслийн хүрээнд хүн амын төмс, хүнсний ногооны улирлын хамаарлыг бууруулж, хангамжийг нэмэгдүүлэх	Хангамжийн хэмжээ	Хувь	2023	23	26	30.7	“Шинэ хөдөө” төслийн хүрээнд хүн амын төмс, хүнсний ногооны улирлын хамаарлыг бууруулж, дотоодын хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Төслийн 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр тус бүр 440 мкв багтаамжтай мах, ногооны механикжсан зоорь барих төсөл хэрэгжиж, тендерт “Хөх оноо” ХХК шалгарч Сайншанд сумын 7-р багт зоорийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Мөн төслийн хүрээнд олгосон хүлэмж, техник, тоног төхөөрөмжийн ашиглалтад газар дээр нь хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн зохион байгуулалт, ашиглалтын үр ашгийг сайжруулах арга хэмжээнүүд хэрэгжүүлэв. Аймгийн хэмжээнд 372 иргэн, 30 аж ахуйн нэгж нийт 208 га талбайд тариалалт хийж 756.9 тн ургац хураан авсан нь өмнөх оноос 168.9 тн-оор өссөн үзүүлэлт болов. Үүний дүнд хүн амын төмс, хүнсний ногооны дотоодын хангалт 30.7 хувьд хүрсэн.	100
205	Дөрвөн улирлын хүлэмж, тариалангийн талбай, агуулах, зоорины аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлэх	Тариалсан талбай	Га	2023	169	180	208	"Атар-4" газар тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд аймгийн газар тариалан эрхлэгч 1000 гаруй иргэнд хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг цахим, танхим сургалтаар хүргэж урьдчилсан мэдлэгийг олгосон. Жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Ховд аймгаас улаан бэсрэг алим, чавга, сливын 46 суулгац, Улаанбаатар хотоос 50 суулгац, гавьяат агрономчоос тарвас, гүзээлзгэнэ, улаан лоолийн 300 үрслэгийг авч тариаланчдад олгон арга технологийн гарын авлагаар хангаж тарьсан. Шинэ сортын туршилтыг Аймгийн төв Агропарктай хамтран тарвасын “Бриллиант”, “Ведун” сорт, Мора ТББ-тай хамтран Япон улсад үйлдвэрлэгдсэн бууцай, цагаан луувангийн сортуудаар хийж байна. “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас болон “Атар-4” аяны хүрээнд газар тариалангийн салбарт нийт 477,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, аймгийн хэмжээнд 372 өрх, 30 аж ахуйн нэгж 208 га талбайд	100
		Зуны хүлэмж	м2	2023	36520	37000	39240		
		Өвлийн хүлэмж	м2	2023	1000	1500	1500		

		Хураан авсан ургац	Тн	2023	588	590	756.9	<p>тариалалт хийсэн нь төмс 25 га, хүнсний ногоо 68.5 га, малын тэжээл 99.5 га, жимс, жимсгэнэ 15 га байлаа. Хуулийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлээр 8 иргэн нийт 200 сая төгрөг авч 1440 мкв хүлэмж, бууц цацагч, 3.5 га дуслын усалгааны систем нэвтрүүлсэн. Мөн зуны хүлэмжийн аж ахуйд Сайншанд сумын “Дарцаг ногоон шим” хоршоонд 150,0 сая, Сайхандулаан сумын “Баян овоо хайрхан” хоршоонд 50 сая төгрөгийн зээл олгож, 240 мкв хүлэмжид тариалалт хийжээ. Хувийн хөрөнгө оруулалтаар шинээр Сайншанд суманд 1040 мкв хүлэмж, 6000 мкв цөөрөм, 10 га дуслын усалгааны системийг нэвтрүүлснээр зуны хүлэмжийн тариалалтыг 2720 м2-аар нэмэгдүүлж, нийт 39240 мкв талбайд тариалалт хийсэн.</p> <p>1500 мкв нарлаг хүлэмжид Улаан лооль, Өргөст хэмх, Чинжүү, хаш зэрэг 4 нэр төрлийн хүнсний ногоог тариалан ургацаа 6 дугаар сарын 5-наас зах зээлд нийлүүлсэн.</p> <p>Тайлант онд нийт 372 иргэн, 30 аж ахуйн нэгж 208 га талбайд 756.9 тн ургац хураан авч, өмнөх онтой харьцуулахад 168.9 тн-оор өссөн.</p>	
206	Хөрс, цаг уурын онцлогт тохирсон дотоодын баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх	Үрийн хангамж	Хувь	2023	49,8	50	51	<p>Хөрс, цаг уурын онцлогт тохирсон дотоодын баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ХХААХҮЯ-наас олгосон 4 тн элит төмсний үрийг Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Эрдэнэ, Сайншанд сумын 58 тариаланчид хуваарилан олгож, Төв аймгийн Жаргалант сумын үр үржүүлэгчдээс 12 тн элит үрийг татан авч аймгийн үрийн хэрэгцээг хангажээ.</p> <p>"Атар-4" газар тариалангийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 8 тариаланч 40 сая төгрөгөөр хүнсний ногооны баталгаат үр, үрслэг бэлтгэн үрийн шинэчлэл хийснээр шаардлагатай үрийн 51 хувийг хангасан байна.</p>	100
207	Хүнсний ногоогоор эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэр, цехийг	Үйлдвэр, цех	Тоо	2023	2	3	12	<p>Аймгийн хэмжээнд хүнсний ногоо дахин боловсруулах 2 цех, 10 иргэн үйлдвэрлэл эрхэлж, нийт 10,000 гаруй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. Төмс, хүнсний ногоо дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сав</p>	100

	хувийн хэвшилтэй хамтран байгуулах							баглаа боодол сайжруулах, брэнд бий болгох зорилгоор 2 иргэн, 2 аж ахуйн нэгжийг Улаанбаатар дахь GCS олон улсын сургалтын төвд вакум сургалтад хамруулж чадавхжуулснаар “Оюушанд” ХХК, “Мөрөөдлийг говь” ХХК бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулж, “Нүүдэлчин-Монгол” фестиваль, “АЙТИЭМ-2025” олон улсын үзэсгэлэнд оролцон орон нутгаа сурталчилсан. Мөн "Атар-4" газар тариалангийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлээр 8 иргэн, 2 ААН нийт 1,200 сая төгрөгийн санхүүжилт авч 1,440 мкв хүлэмж, даршилгааны бага оврын тоног төхөөрөмж, бууц цацагч, 6,000 мкв цөөрөм, 13.5 га дуслын усалгааны систем нэвтрүүлсэн.	
208	Зочлох үйлчилгээний салбарын стандартыг мөрдүүлэх чиглэлээр сургалт, нөлөөлөл, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээ	Тоо	2024	5	6	7	Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил”, Дорноговь аймаг 2025 оныг “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийг чадавхжуулах сургалт, нэгдсэн зөвлөгөөнийг Монголын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж, 31 аж ахуй нэгжийг хамрууллаа. Сургалтаар аялал жуулчлалын өнөөгийн байдал стандарт, хууль, эрх зүй, цахим маркетинг зэрэг сэдвийн хүрээнд хөгжих боломж үйлчилгээний стандартыг боловсруулах арга зүй, орон нутагт тур операторын бизнес эрхлэх зэргээр мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРГАЛТЫН ТӨВ”-ийн үйл ажиллагааг нээж, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж Дорноговь аймгийн аялал жуулчлалын холбооноос 5 иргэн хамрагдсан. Тайлант хугацаанд 2 сургалтыг зохион байгуулж 31 аж ахуйн нэгж, 5 иргэнийг хамруулж өссөн дүнгээр 7 сургалт зохион байгуулж зочлох үйлчилгээний салбарын стандартын хэрэгжилтийг нэмэгдүүллээ.	100
209	Аялал, жуулчлалын	Арга хэмжээ	Тоо	2024	2	3	4	Гадаад улсаас Монгол улсад жуулчин хүлээж авах эрх бүхий түр операторын гэрчилгээг шалгуур	100

	агентлаг, аяллын операторын чиглэлээр нэн шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэх							<p>үзүүлэлтийн шаардлага хангасан орон нутгийн 5 компани 02 дугаар сарын 20-ны өдрөөс гардан авч, үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Дорноговь аймгийн "Аялал жуулчлалын холбоо" нь 2025 оны 03 дугаар сарын 24-нд мэргэжлийн аялал жуулчлалын холбооны хязгаарлагдмал эрхтэй салбар холбоо болон элссэнээр аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд элсэх, түр операторын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий компани болох тухайн мэдээллийг орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгч 90 аж ахуй нэгж байгууллага, иргэнд мэдээлэл хүргэн ажилласан.</p> <p>"Монголын хөтөч-тайлбарлагчдын холбооны мэргэжлийн үнэмлэх" олгох зорилгоор зохион байгуулсан "Хөтөч-Тайлбарлагч" бэлтгэх эхний шатны модуль сургалтад "Хилэнц Тур" оператор ХХК болон "Үүдийн шонхор" ХХК хамрагдаж батламж авсан.</p> <p>Орон нутгийн түвшинд аймгийн Аялал жуулчлалын холбоо, Соёл урлаг аялал жуулчлалын газар, Музей сургалт судалгааны төв хамтран "Хөтөч-Тайлбарлагч" бэлтгэх 3 удаагийн танхим, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж, 32 суралцагчийг хамруулан "Хөтөч-тайлбарлагч"-ийн чадамжийн гэрчилгээг гардуулсан.</p> <p>Үүнээс 16 суралцагч нь орон нутгийн хэмжээнд зохиогдож буй арга хэмжээнд хамтран ажиллах гуравласан талт гэрээ хийхээр төлөвлөж, аймгийн Аялал жуулчлалыг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулсан "Тэнгэрийн хутагт фестивалиар 1000 гаруй аялагч, жуулчдад орон нутгаа сурталчилж мэдээлэл хүргэн, хөтөч, тайлбарлагчаар ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд 4 арга хэмжээг зохион байгуулж 2 аж ахуйн нэгж, 32 иргэнийг хөтөч тайлбарлагчаар бэлтгэж аялал жуулчлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжрууллаа.</p>	
210	Үйлчилгээний байгууллагын хүчин чадал, нөөцийн судалгааг мэргэжлийн	Ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	0	100	100	<p>Аялал жуулчлалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн аялал жуулчлалын мэдээллийн санг шинэчлэн, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Дорноговь аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран</p>	100

	байгууллагатай хамтран хийх							байршуулах үйлчилгээний газруудын бүртгэл хүчин чадлын судалгаа, дотоодын болон олон улсын жуулчны тоон мэдээллийг гаргасан. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас хэрэгжүүлж байгаа аялал жуулчлалын нөөцийн мэдээллийг боловсруулж, "Аялал жуулчлалын цахим платформ" бий болгох зорилгоор нэвтрүүлж байгаа E-GUIDE цахим хөтчийн программд аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн болон үйлчилгээний нийт 48 аж ахуй нэгж, байгууллагын мэдээллийг оруулж цахим сангаар дамжуулан олон улсад сурталчилж ажилласан.	
211	Хөтөч тайлбарлагч бэлтгэх сургалт зохион байгуулах	Ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	99	100	100	"Монголын хөтөч-тайлбарлагчдын холбооны мэргэжлийн үнэмлэх" олгох зорилгоор зохион байгуулсан "Хөтөч-Тайлбарлагч" бэлтгэх эхний шатны модуль сургалтад "Хилэнц Тур" оператор ХХК болон "Үүдийн шонхор" ХХК хамрагдаж батламж авсан. Мөн орон нутгийн түвшинд аймгийн Аялал жуулчлалын холбоо, СУАЖЗГазар, Музей сургалт судалгааны төв хамтран "Хөтөч-Тайлбарлагч" бэлтгэх 3 удаагийн танхим болон практик хосолсон сургалтыг зохион байгуулж 32 суралцагчийг хамруулан "Хөтөч-тайлбарлагч"-ийн чадамжийн гэрчилгээг гардуулсан. Үүнээс 16 суралцагч нь орон нутгийн хэмжээнд зохиогдож буй арга хэмжээнд хамтран ажиллах гуравласан талт гэрээ хийхээр төлөвлөснөөс гадна аймгийн Аялал жуулчлалыг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулсан "Тэнгэрийн хутагт фестивалиар 1000 гаруй аялагч, жуулчдад орон нутгаа сурталчилж мэдээлэл хүргэн хөтчөөр ажиллуулсан.	100
212	Сити тур аялалыг зохион байгуулах	Ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	99	100	100	Сайншанд суман дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрууд, хөшөө дурсгалуудыг түшиглэн "Сити тур" хотын аяллын хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн. "Хил орчмын аялал жуулчлал"-ын маршрут, үзвэр үйлчилгээг сурталчлан, танилцуулах өдөрлөг арга хэмжээг БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консул Кэ Юшэн болон 11 албаны төлөөлөгчдийг хамруулан Замын-Үүд, Сайншанд, Хамарын хийд гэсэн маршрутаар туршилтын аяллыг зохион байгууллаа.	100

								<p>Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны аялалын компаниудтай хамтран түр дугаартай авто машинтай туршилтын аялалыг Замын-Үүд, Сайншанд, Хамарын хийд чиглэлийн дагуу 12 машинтай 57 аялагчийг хамруулан, БНХАУ-ын аялал жуулчлалын сурталчилгаа явуулах эрх бүхий инфлүүсер Ян Ши Кай Хятадын 4 цахим сувгаар цацан 3,831,074 хандалт авсан.</p> <p>Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 101 жилийн ойн тэмдэглэлт өдрийг тохиолдуулан 2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Сайншанд сумын Сити тур аяллыг аймгийн Төв цэвэрлэх байгууламж, "Чандмань илч" ОНӨ ХХК", "Дезерт Солар Пауэр Вуан" ХХК, "Байгалийн түүхийн музей" гэсэн 4 байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж Ерөнхий боловсролын 5 сургууль, Политехник коллежийн нийт 80 суралцагчийг хамруулж зохион байгуулаа.</p>	
213	Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын форум зохион байгуулах	Ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	0	100	70	<p>"Хил орчмын аялал жуулчлал"-ыг хөгжүүлэх, санал солилцох уулзалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын холбоо, БНХАУ-ын Эрээн хотоос Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газрын төлөөлөгчид болон Эрээн хотын Ардын засгийн ордны зочид, төлөөлөгчидтэй 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хийсэн.</p> <p>Уулзалтаар Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, хамтран ажиллах, маршрут гарган сурталчлах арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэж 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр "Хил орчмын аялал жуулчлал"-ын маршрут, үзвэр үйлчилгээг сурталчлан, танилцуулах өдөрлөг арга хэмжээг БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консул Кэ Юушэн болон албаны төлөөлөлтэй хамтран Замын-Үүд, Сайншанд, Хамарын хийд гэсэн маршрутаар зохион байгууллаа.</p> <p>Мөн БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны аялалын компаниудтай хамтран түр дугаартай 12 автомашинтай 57 аялагчийг хамруулан туршилтаар амжилттай зохион байгуулсан.</p> <p>БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод 2025 оны 08 дугаар сарын 25-с 27-ны өдрүүдэд "Түмэн газрын цайны зам" Монгол, Хятад,</p>	70

								<p>Орос гурван улсын соёл, аялал жуулчлал, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад харилцааг тэлэх, зах зээлийн шинэ боломжийг нээн бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын уулзалтад Дорноговь аймгийн төрийн байгууллагын болон Аялал жуулчлалын холбооны төлөөллүүд оролцож хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Цайны замын аялалын хүрээнд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа асуудлыг танилцуулж санал солилцлоо.</p> <p>Дээрх уулзалтын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 07,08-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Дархан хотод зохион байгуулагдсан Монгол, Хятад, Орос гурван улсын аялал жуулчлалын сайд нарын нэгдсэн хуралдааны хүрээнд хийгдсэн "Цайны замын нэрэмжит авто аялалын нээлт"-д оролцох БНХАУ-ын авто клубуудыг угтан авч Дорноговь аймгийн аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн төлөөлөл нэгдэн "Түмэн газрын цайны зам" дагуух Дорноговь, Говьсүмбэр, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудаар аялан 3 улсын хамтарсан нөхөрсөг авто уралдаанд оролцсон.</p>	
214	Аялал жуулчлалын гол бүс нутгуудын дэд бүтцийн хүчин чадлыг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх	Ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	0	30	65	<p>Аялал жуулчлалын гол бүс нутгуудын дэд бүтцийн хүчин чадлыг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улсын төсвийн 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хамарын хийдийн цахилгаан хангамжийг сайжруулах ажил"-ын тендерийг зарлаж "Ар хөв энерги" ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 30%-тай байна.</p> <p>Хамарын хийд орчмын аялал жуулчлалын бүс нутгаар гадаад, дотоодын аялагчид аюулгүй, тав тухтай аялах, зорчих орчин нөхцөл бүрдүүлэх зорилгоор 2024 оны улсын төсвийн 12432,6 сая төгрөг, орон нутгийн төсвийн 1181,6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтаар Хамарын хийдийн 3-н замын уулзвараас Зүүнбаян чиглэлийн хатуу хучилттай 20 км авто замын эхний үе шат буюу 13 км авто замыг "Борхойн зам" ХХК гүйцэтгэж бүрэн ашиглалтад орууллаа.</p>	100
215	"GoMongolia" арга хэмжээний	Арга хэмжээний тоо	Тоо	2024	0	2	2	<p>Дорноговь аймаг нь 2025 оныг "Аялал жуулчлалыг дэмжих жил" болгон зарласантай</p>	100

хүрээнд "Үлэмжийн чанар", "Цайны зам", "Язгуур албан өв" соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлэх	Хүлээн авсан жуулчдын тоо	Дотоод	2024	88565	90000	112000	<p>холбогдуулан Дэлхийд ховорт тооцогдох тэмээн сүргийн соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, малчид, тэмээчдээ алдаршуулах, тэмээн сүргийг өсгөн үржүүлж, хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Их говийн тэмээ-2025" тэмээчдийн баяр, Улсын зөвлөгөөнийг зохион байгуулсан.</p> <p>Тус арга хэмжээнд монголын уламжлалт ёс заншил, тэмээчдийн соёлыг олон нийтэд таниулан сурталчлах, говь нутгийн бахархал болгон хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах зорилгоор соёлын биет, биет бус өв, тайзны үзүүлбэр, уралдаан тэмцээн, соёлыг сурталчилсан 500 гаруй эд өлгийн зүйлсийг дэлгэсэн гэр үзэсгэлэнг толилуулсан. "Их говийн тэмээ-2025" арга хэмжээг нийт 3000 гаруй аялагч, жуулчид үзэж сонирхохоос гадна МҮОНРТ, NTV, орон нутгийн DTV телевиз болон цахим сувгуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.</p> <p>Засгийн газрын 2025 оны 237 дугаар тогтоолын дагуу Дэлхийн энергийн төв хэмээгддэг Хамарын хийдийн байгалийн онцлог, түүнийг үндэслэгч V Ноён Хутагтын амьдрал, бүтээл туурвилыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор "Тэнгэрийн Хутаг" аялал жуулчлалын фестивалийг 09 дүгээр сарын 19,20 өдрүүдэд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд соёлын биет бус өвийн 7 ай савын 5 өртөөний гэр үзэсгэлэн, өвлөн уламжлагч нарын тайзны үзүүлбэр, иог, хөгжимт бясалгал, энергийн засал, арт терапи болон IX Ноён Хутагт Данзанлуvsантүдэв нь сүсэгтэн олондоо айлтгал айлдах, хийдийн хурал ном хурж эргэл мөргөл хийж аялагч, сүсэгтэн олныг цэнгүүлсэн.</p> <p>"Тэнгэрийн Хутаг" фестивалийг нийт 4000 гаруй аялагч, жуулчид үзэж сонирхсоноос гадна МҮОНРТ, орон нутгийн DTV, Gobi.mn болон цахим сувгуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.</p> <p>Тайлант хугацаанд 2 арга хэмжээг зохион байгуулж, "Хамарын хийд"-ийн тусгай хамгаалалттай газар болон "Их нарт"-ын байгалийн нөөц газрын тасалбар борлуулалтын дүнгээр дотоодын 112000,</p>
		Гадаад	2024	1777	2000	2536	

								<p>гадаадын 2536 нийт 114536 жуулчин хүлээн авсан нь 2021 онтой харьцуулахад 7,9 дахин нэмэгдсэн.</p> <p>Мөн Монголын аялал жуулчлалын холбоотой Монгол Улсад аялал жуулчлалын салбарыг бүсчилэн хөгжлүүлэхэд хамтран ажиллах, Дорноговь аймагт аялал жуулчлалын чиглэлээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, Дорноговь аймагт аялал жуулчлалаар хүлээн авч буй жуулчдын тоог нэмэгдүүлэх энэ төрлийн үйл ажиллагаанд аймгийн аялал жуулчлалын оролцогчдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах, идэвхжүүлэх зорилгоор санамж бичгийг 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан.</p>	
216	Аялал жуулчлалын маршрутыг гаргаж, танилцуулгатай болох	Ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	0	100	100	<p>Дорноговь аймгийн "Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө"-нд тусгасан "Их нарт-Загийн усны хоолой-Нүдэнгийн хадны эко аялал жуулчлалын бүс", "Их бага Эрээний нурууны байгалийн аялал жуулчлалын бүс"-ээр аялах, хил орчмын аяллын 1 өдрийн маршрут, говийн бүсийн аялал жуулчлалын маршрут гэсэн 3 аяллын маршрутыг боловсруулж зураглал гарган Аялал жуулчлалын холбоо баталсан.</p> <p>Орон нутгийн төсвийн 5,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн аялал жуулчлалын хэвлэмэл ном болон газрын зурагтай танилцуулгыг аймгийн "Аялал жуулчлалын холбоо" "Их говийн хөгжлийн гарц" ОНӨААТҮГ-тай хамтран боловсруулж, 2000 ширхгийг хэвлүүлж аялагчдад тараасан.</p>	100
217	Аялал жуулчлалын контент бэлтгэж, сурталчлан таниулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	0	100	100	<p>Орон нутгийн аялал жуулчлалыг сурталчлан таниулах зорилгоор аймгийн Аялал жуулчлалын холбооноос "Контентоос брэнд болох нь" сургалтыг зохион байгуулж 6 суралцагч оролцож контент бүтээх арга барил, ур чадварт суралцсан.</p> <p>Төр хувийн хэвшил хамтран Алтанширээ сумын "Сумын 9 гайхамшигт газар" , аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч 3 аж ахуйн нэгж, 1 хувь иргэн өөрсдийн үйл ажиллагаа онцлогийн талаар контент бүтээлгэн цахим хуудсаар түгээн 1080 хандалт авснаас гадна гуравдугаар улиралд зохион байгуулагдсан "Тэнгэрийн Хутагт" фестивалийг сурталчилсан контент бүтээлгэн "Тэнгэрийн хутаг</p>	100

								<p>фестиваль", Gobi.mn сайтуудаар түгээн 11707 хандалт авсан.</p> <p>Мөн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор БНХАУ-ын ӨМӨЗО-ны аяллын компаниудтай хамтран түр дугаартай авто машинтай туршилтын аяллыг 12 машинтай 57 аялагчийг хамруулан хийж, БНХАУ-ын аялал жуулчлал сурталчилгаа эрх бүхий инфлүүсер Ян Ши Кай 4 цахим сувгаар цацан 3,831,074 хандалт авсан.</p>	
218	Орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнийг бий болгох иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжих	Дэмжлэгийн тоо	Тоо	2023	1	2	3	<p>Аймагт 71 өрхийн 979 жижиг, дунд үйлдвэр үйл ажиллагаа явуулж хүнсний 37, аялал жуулчлалын 30, ахуйн хэрэглээний 12, үндэсний хэв шинжтэй 20 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлж байна.</p> <p>Орон нутгийн онцлогт тулгуурласан брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор GCS олон улсын байгууллагатай хамтран 38 үйлдвэрлэгчийг 3 хоногийн вакум сургалтад хамруулж, 10 гаруй шинэ бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтийг эхлүүлсэн бөгөөд тайлант онд худалдаанд гаргахаар ажиллаж байна.</p> <p>“Говийн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан”-тай зэрэгцэн зохион байгуулсан “Түншлэл–Хамтын ажиллагаа” үзэсгэлэн худалдаанд Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь зэрэг аймгийн нийт 82 жижиг, дунд үйлдвэрлэгч оролцож, орон нутгийн онцлог шингэсэн 88 нэр төрлийн бүтээгдэхүүнээр 86.2 сая төгрөгийн борлуулалт хийв. Мөн “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилттэй танилцах уулзалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран зохион байгуулж, 90 гаруй үйлдвэрлэгчийг хамруулсан.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд зохион байгуулсан “Дорноговь аймгийн брэнд бүтээгдэхүүн” шалгаруулалтад 22 үйлдвэрлэгч оролцож, шалгарсан 5 бүтээгдэхүүнийг “Говийн бүсийн брэнд бүтээгдэхүүн” шалгаруулалтад амжилттай оролцуулсан.</p>	100
219	Айраг, Сайншанд, Эрдэнэ сумдын нутагт босоо	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	1	2	4	<p>Дорноговь аймгийн Айраг, Сайншанд, Эрдэнэ сумдын босоо тэнхлэгийн авто зам дагуух амралтын цэг дээр 2 шатахуун түгээх станц, 1 зоогийн газар</p>	100

	тэнхлэгийн авто зам дагуу аялал жуулчлалын амралт, үйлчилгээний цэг байгуулах аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх							үйлчилгээ эрхэлдэг бөгөөд Эрдэнэ сумын Цагаанхөтөл багийн нутаг дэвсгэрт Баярхайрхан ХХК-ний шатахуун түгээх станц, "Грит пицца" цайны газар, Сайншанд сумын 8-р багийн нутаг дэвсгэрт "Сод Монгол" ШТС үйл ажиллагаагаа явуулдаг. Мөн Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолын хүрээнд ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах ажилд Замын-Үүд суманд "Жигүүр транс" ХХК, Айраг суманд "Сайраг гэрэлт цамхаг" ХХК, Эрдэнэ суманд "Сизу" ХХК Сайншанд суманд "БУЗТ" ХХК зэрэг шалгарсан компаниудад газар олголтыг үнэгүй олгож орон нутгаас дэмжлэг үзүүлсэн.	
220	Саранхөхөө театр, Замын-Үүд сумын соёл урлагийн ордон барих ажлыг үргэлжлүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	70	100	85	Улсын төсвийн 18.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 700 хүний суудалтай Саран Хөхөө театрын барилга барих ажлыг 2021 оноос "Болор-Аграмба" ХХК гүйцэтгэж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн ажил дууссан. Сам тайзны металл хийц болон салхивчийн системийн угсралтын ажлууд хийгдэж байна. Ажлын явц 75%-тай. Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад театрын барилгын дуусгалын ажлын 15.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдсэн. Үүнээс 2026 онд 8.3 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Улсын төсвийн 8347.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд суманд 500 хүний суудалтай соёл, урлагийн ордны барилга барих ажлыг 2021 оноос "РСТ" ХХК гүйцэтгэж байна. Барилгын үндсэн хийц бүтээц, гадна, дотор засал, гадна шугам сүлжээ, тохижилтын ажил дууссан. Орон нутгийн төсвийн 2419.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар үзэгчдийн заал, үүдний хэсгийн дотор интерьер, тайз технологийн нэмэлт ажлыг гүйцэтгэж байгаа ба ажлын гүйцэтгэл 95%-тай, 12-р сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	50
221	Дэлгэрэх сум, Эрдэнэ сумын соёлын төвийн барилга барих	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	30	60	65	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд хэрэгжиж буй Дэлгэрэх суманд Соёлын төв барих ажлыг 4148.1 сая төгрөгөөр "Элит конкрет" ХХК гүйцэтгэж байна.	100

	ажлыг үргэлжлүүлэх							Барилгын үндсэн хийц бүтээцийн угсралтын ажил дууссан. Дотор ханын өрөг, шавардлага, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиоллын монтажны утас сүвлэгээний ажил хийгдсэн. Ажлын явц 70%-тай. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд хэрэгжиж буй Эрдэнэ суманд Соёлын төв барих ажлыг 3221.4 сая төгрөгөөр “Өгөөмөрөн шанд” ХХК гүйцэтгэж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн угсралтын ажил дууссан. Дотор ханын өрөг, шавардлага, гадна шугам сүлжээ, цахилгааны ажил үргэлжлэн хийгдэж байна. Ажлын явц 60%-тай.	
222	Сайншанд сумын 5 дугаар багийн Соёлын төвийн гадна фасад, цонх шинэчлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн хөгжлийн сангийн 440.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 5 дугаар багийн Соёлын төвийн гадна фасад, цонх шинэчлэх ажлыг “Идум” ХХК гүйцэтгэж 11 дүгээр сард ашиглалтад оруулсан.	100
223	Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөр хэрэгжүүлэх	Соён гэгээрүүлэх ажил	Тоо	2024	300	380	421	Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх зорилгоор сумдын Соёлын төвүүдэд орон нутгийн онцлог шингэсэн соёлын боловсролын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх чиглэл өгсний дагуу он гарснаар шинээр 25 боловсролын хөтөлбөр нэмэгдэж аймгийн хэмжээнд нийт 36 боловсролын хөтөлбөрт 5652 иргэнийг хамруулан өв соёлын боловсрол олголоо. Мөн улс орон даяар хэрэгжүүлсэн "Соёлыг орон зай бидний орчин" аяныг цахим соёл түгээх, нийтийн соёлыг түгээх, байгууллагын соёл, үйлчилгээний соёл гэсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж 266 арга хэмжээнд 10915 иргэнийг хамруулсан. Аймгийн Боловсролын газартай хамтран сар бүрийн сүүлийн өдрийг “Соёлын өдөр” болгон 2 дахь жилдээ хэрэгжүүлж хэвшсэн бөгөөд Сайншанд сумын 11 дүгээр цэцэрлэгтэй хамтран СӨБ-ийн багш нарын дунд “Үлгэрийн ертөнц” уралдааныг зохион байгуулж 15 цэцэрлэгийн 160 гаруй багш оролцож 300 гаруй хүүхэд багачуудад хүргэлээ. Кино урлагаар дамжуулан иргэдэд урлагийн боловсрол олгох зорилгоор аймгийн хэмжээнд 46 төрлийн киног 9898 иргэнд, үе тэнгийн дээрэлхэлт, буруу хэрэглээний хор уршиг, гарц, шийдлийг харуулсан “Төгсгөл биш эхлэл” ёс зүйн драмын	100

								<p>жүжгийг Саран хөхөө театрын уран бүтээлчид бүтээж нийт 3330 үзэгчдэд, мөн “Саран охин Хөхөө хүүгийн адал явдал” соён гэгээрүүлэх СӨБ-ын болон ЕБС-ийн 2000 хүүхдэд толилуулснаас гадна нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Замын-үүд сумын Соёл спортын ордноос “Зөв ирээдүйн төлөө хамтдаа” үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдийн хүчирхийллийн эсрэг драмын жүжгийг 3 сумын 430 гаруй хүүхдүүдэд хүргэлээ.</p> <p>Яруу найраг утга зохиолоор дамжуулан орон нутгийн уран бүтээлчдийг сурталчлах, хүүхэд залууст боловсрол олгох зорилгоор “ Утга зохиолын 7 хоног” арга хэмжээг хэрэгжүүлж 34 төрлийн арга хэмжээнд 3700 гаруй иргэдийг хамруулан цахимаар 5000 гаруй иргэнд хүргэснээс гадна “Үндэсний бичиг соёл, номын баяр-2025”-ыг 2 удаа зохион байгуулж 35 нэр төрлийн үйл ажиллагаанд 3900 гаруй иргэд хүүхэд залуусыг хамруулан цахимаар 12000 хүнд соёлын боловсрол олголоо.</p> <p>Тайлант онд салбарын хэмжээнд иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх 421 удаагийн арга хэмжээнд , 57285 иргэнийг цахим болон танхимаар хамруулж ажилласан.</p>	
224	Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сэргээх, өвлөн уламжлуулах замаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	Сэргээн засварлаж, хадгалан хамгаалсан арга хэмжээний тоо	Тоо	2024	2	3	3	<p>Тайлант онд соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлагчдыг алдаршуулах 19 арга хэмжээ, сумын хэмжээнд 15 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, орон нутгаас 40,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 54 өвлөн уламжлагчид хүндэтгэл үзүүлсэн.</p> <p>Мөн аймаг, улсын хамгаалалтад бүртгэлтэй 31 дурсгалт газрын 28 дурсгал буюу 90%-ийг иргэдтэй гэрээ байгуулан хамгаалуулснаас гадна тус 31 үл хөдлөх дурсгалд нөхцөл байдлын үнэлгээ судалгааг хийж 52,7% хадгалалт хамгаалалт сайн, 31% дунд, 16,3% муу буюу эрсдэлт байдал үүссэнийг тогтоосноос гадна соёлын биет өвийг Соёлын өвийн үндэсний төвд сэргээн засварлуулах 1 удаагийн арга хэмжээг хэрэгжүүллээ.</p> <p>Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн 8 төрлөөр 321 суралцагчийг хамруулж,</p>	100

								шавь сургалтыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд нийт 3 сэргээн засварлаж, хадгалан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн.	
225	Орон нутгийн түүх соёлыг илэрхийлсэн бүтээл туурвих, оюуны үнэт өв бүтээлийг судлан илрүүлж, олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хөгжүүлэх	Хамрагсан хүний тоо	Тоо	2024	15000	20000	20322	<p>Сар шинийн баярт зориулан ноён хутагтын Үлэмжийн чанар, Таван дохио, Гурван шүтээн бүжгийг МҮОНТ-тэй хамтран дүрсжүүлж видео контент бэлтгэн 29000 үзэгчдийн хүртээл болгосон. Нутгийн эрдэмтэн судлаачид, яруу найрагч, зохиолчдын 8-н бүтээлийг хэвлүүлэн 4170 иргэнд сурталчлан орон нутгаас 30,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, түүхэн баримт үүсгэсэн.</p> <p>Говийн ноён хутагт, их соён гэгээрүүлэгч Дулдуйтын Данзанравжаагийн мэндэлсний 222 жилийн ой, Дорноговь аймаг 2025 оныг "Аялал жуулчлалыг дэмжих" жил, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 237 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд "Тэнгэрийн хутагт" аялал жуулчлалын фестивалийг зохион байгуулсан. Фестивалийн үеэр орон нутгийн түүх соёлыг илэрхийлсэн шашин, соёлыг хослуулсан "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжиг, "Дорнын цадиг" тоглолт, Хутагтын зохиосон ая дангаар маани хөгжөөх, "Дорнын говийн тусгал" гэрэл зургийн үзэсгэлэн, 14 сумын онцлогийг харуулсан "Өв соёлын өргөө" гэр үзэсгэлэн, нутгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн зэрэг 25 төрлийн үйл ажиллагаагаар дамжуулан 10000 гаруй иргэнд түүх соёл, өв уламжлалаа сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлсэн.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн хүрээнд говийн бүсийн аймгуудын театр, чуулгын 350 гаруй уран бүтээлчдийн хамтарсан "Монголын их говь" хүндэтгэлийн тоглолт, арга хэмжээг 1152, цахимаар 17000 үзэгчдэд толилуулсан. Мөн "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд орон нутгийн түүх соёлын онцлогийг илэрхийлсэн соёлын биет бус өвийн тоглолтыг гадаад, дотоодын 5000 гаруй жуулчдад толилууллаа. МУУГЗ зүтгэлтэн Ш.Өлзийн аялгуу, СГЗүтгэлтэн Л.Эрдэнэбатын үг "Тэнгэрийн зарлигтай говь" дууны уран бүтээлийг үзэгч олонд толилуулсан.</p>	100

								Орон нутгаас оюуны үнэт өв бүтээлийг судлан илрүүлж, олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд 20322 хүнийг хамруулж, 152,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж Үндэсний агуулгатай 2 тоглолт, 1 дууны уран бүтээл төрөн гарлаа.	
226	Үндэсний бахархал, өв соёл, нүүдлийн соёлыг хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн түүх, орчин цагийг хослуулах замаар шинэ үеийн монгол бахархал бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний тоо	Тоо	2024	-	1	6	<p>"Монгол угсаатан хэл хуурчдын холбоо"-ны тэргүүнтэй хамтран хэл хуурын аялгууг орчин үеийн "beatbox"-ийн хэмнэлтэй хослуулан тоглож, хөгжүүлэх талаар өдөрлөг болон "Тэнгэрийн хутагт" фестивалийн үеэр хөгжмөөр эмчлэх, бясалгал хийх арга хэмжээг зохион байгуулж 1090 хүнийг хамруулсан. Мөн соёлын биет бус өвийн 7 ай саваар 5 өртөө байгуулан өвлөн уламжлагч, өв соёлыг 3000 гаруй үзэгчдэд сурталчилснаас гадна морь, тэмээ уналга зэрэг нүүдлийн ахуйг орчинг бүрдүүлж гадаад дотоодыг аялагч жуулчид, хүүхэд багачуудад үндэсний бахархал, нүүдлийн соёлыг сурталчиллаа.</p> <p>Аймгийн МССТ-өөс Монгол орны байгалийн гайхамшигт газрууд, байгалийн түүхэн өөрчлөлт хувьсал зэрэг тус бүр 26 контентыг программ хангамжийн тусламжтайгаар хэрэглэгчдэд бодитой мэт харагдах хиймэл орчин буюу VR 3 ширхэг төхөөрөмжийг нэвтрүүлэн музейн үйлчилгээг орчин цагийн шинэлэг арга барилаар 1700 гаруй хүүхэд, залуус иргэд олон нийтэд хүргэж үндэсний өв соёл, бахархлыг түгээн дэлгэрүүллэн.</p> <p>Говийн бүсийн анхдугаар зөвлөгөөнөөр говь нутгийн өв соёл, үндэсний бахархлыг сурталчилсан үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, орчин үеийн чиг хандлагатай уялдуулан 69 брэнд бүтээгчдийн бүтээгдэхүүнүүдийг танилцуулсан.</p> <p>ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний соёлын өвийн жагсаалтад бүртгэлтэй "Дэлхийн адууны өдөр"-ийг тохиолдуулан "Морьтны соёл" бэсрэг наадмыг түүхэн уламжлал, өв соёлыг орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай хослуулан, шинэ үеийн монгол хүний бахархлыг төлөвшүүлэх зорилгоор 2000 гаруй иргэдийг хамруулан зохион байгууллаа.</p> <p>Тайлант оны байдлаар орчин цагийг хослуулах замаар шинэ үеийн монгол бахархал бий болгох 6 арга хэмжээг хэрэгжүүллээ.</p>	100

227	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл III" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	Тоо	2024	-	50	50	<p>Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг орон нутагт хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор аймгийн "Соёлын бүтээлч үйлдвэрлэл"-ийн хөтөлбөрийг боловсруулж, 20 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж хэрэгжилт 50 хувьтай байна.</p> <p>Орон нутагт соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд зориулж говь нутгийн онцлогийг харуулсан "Тэнгэрийн зарлигтай говь нутаг", "Говийн дуу", "Тэнгэр заяат", "Төмөр хуурын цуурай" бүжгийг шинээр дэглэж соёлын бүтээгдэхүүн болгосон. Уг уран бүтээлд орон нутгаас 27,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Их соён гэгээрүүлэгч Ноён хутагт Данзанравжаагийн бүтээл Үлэмжийн чанар, Таван дохио, Гурван шүтээний бүжгүүдийг сэргээн, видео контент бэлтгэн олны хүртээл болголоо.</p> <p>Мөн орон нутгаас хүүхдэд зориулсан уран бүтээлийн тоог нэмэх, соёл урлагаар дамжуулан хүүхэд багачуудыг хөгжүүлэх, соёлын боловсрол олгох зорилгоор "Жаргалан зуслан" хүүхдийн дуу, "Төгсгөл биш эхлэл" ёс зүй драмын жүжгийг шинээр туурвисан. Театрын "Төгсгөл биш эхлэл" ёс зүйн драмын жүжгийг 7-12 дугаар ангийн нийт 3318 суралцагчдад толилуулж, соёлын боловсрол олголоо.</p> <p>Мөн орон нутгаас "Жаргалан зуслан" хүүхдийн дуунд 10,0 сая төгрөг, Монголын зохиолчдын "Хурмаст тэнгэр" төвөөс эмхэтгэн гаргасан "Дорнын алтан аялгуу" нутгийн яруу найрагч, уран бүтээлчдийн цоморлог ботийг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэн 3,8 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн.</p> <p>Тайлант онд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдэд орон нутгаас 52,8 сая төгрөгийг зарцуулан, нийт 6 уран бүтээл туурвиж, 3 контент бүтээн авьяас чадвараараа орлого олох, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл боломжийг бүрдүүллээ.</p>	100
228	Соёлын бүтээгдэхүүн, дижитал контент бүтээгчдийг	Дэмжлэг үзүүлсэн тоо	Тоо	2024	-	1	2	<p>Алтанширээ сум "Сумын есөн гайхамшигт газар"-ын танилцуулга бүхий контентыг орон нутгийн төсвөөс 500,000 төгрөгийн өртгөөр хийлгэж, сумын ЕБС-ийн 140 гаруй сурагчдад танилцуулсан.</p>	100

	дэмжиж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх							<p>"Их говийн тэмээ-2025" арга хэмжээний үеэр Шамбала төсөлтэй хамтран өвлийн аялал жуулчлалыг сурталчлан, орон нутгийн уламжлалт өв соёлыг танилцуулсан контент бэлтгэж хандалтын тоо 70000 хүрсэн. Мөн "Брайв ньуу Монголиа" ХХК-тай хамтран Хамарын хийд, Ханбаянзүрх хайрхны аяллын сурталчилгааны контент бэлтгэлээ.</p> <p>Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлал, соёлын салбарт эдийн засгийн болон хамтын ажиллагааны үнэ цэнийг өсгөх зорилгоор БНХАУ-ын аялал жуулчлал сурталчилгаа эрх бүхий инфлүүсер Ян Ши Кайтай хамтран аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн маршрут, аяллын тэмдэглэл бэлтгэн албаны цахим 4 сувгаар дамжуулан 3,8 сая хандалт авсан. Мөн Монголын урлаг соёлын алдартнууд болон цахим сайтуудаар дамжуулан "Тэнгэрийн хутагт" фестивалийг сурталчлан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүний үр дүнд орон нутагт зочилсон жуулчдын тоо өмнө оноос 4,4 хувиар өссөн.</p> <p>Тайлант онд соёлын бүтээгдэхүүн, дижитал контент бүтээгчдийг дэмжиж 2 хувийн хэвшилтэй хамтран ажиллаж 4 контентыг бүтээж иргэдэд хүргэлээ.</p>	
229	Соёл урлагийн үйлчилгээний менежментийг сайжруулах	Мэргэшүүлсэн албан хаагчийн тоо/ шинээр нэвтрүүлсэн цахим тоног төхөөрөмж	Тоо	2024	20/1	25/2	44/2	<p>Тайлант онд соёлын салбарын 18 байгууллагын нийт 202 албан хаагчдаас 61 удаагийн сургалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор 282 албан хаагч хамрагдаж, мэргэшүүлэх сургалтад 44 албан хаагч хамрагдаж сертификат авсан. Өмнөх онтой харьцуулахад үзвэр үйлчилгээний үйлчилгээний хүртээмж 19.5%-иар, үйлчлүүлэгчийн тоо 5.2%-иар өсөж, соёл урлагийн үйлчилгээний менежмент сайжирсан үр дүн гарлаа.</p> <p>Мөн үйлчлүүлэгчдэд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжээ нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Музей сургалт судалгааны төв байгалийн түүхэн дурсгалт газруудыг харуулсан 26 төрлийн контентыг бүтээж музейн үйлчилгээндээ нэвтрүүлсэн. Мөн төв номын сан үйлчилгээндээ "КОХА" цахим программыг нэвтрүүлж, 41000 номыг бүртгэж, цахимаар номын сангийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.</p>	100

								Аймгийн хэмжээнд 2025 оны гуравдугаар улирлын статистик мэдээгээр 26,491 үйлчилгээг 147,376 иргэнд хүргэж ажиллалаа.	
230	Орчин үеийн стандартад нийцсэн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлэх	Соёлын үйлчилгээний барилга байгууламжийн тоо	Тоо	2024	17	19	18	<p>Аймгийн хэмжээнд 14 сумын соёлын төв, мэргэжлийн урлагийн байгууллага "Саран хөхөө" театр, Музей сургалт, судалгааны төв, "Төв номын сан" болон аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нийт соёлын салбарын 18 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Орчин үеийн стандартад нийцсэн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар соёл урлагийн байгууллагын 4 байгууламжийг барих ажил 2025 оны байдлаар 75,0%-тай үргэлжилж байна. Үүнд: Сайншанд суманд баригдаж буй 700 хүний суудалтай "Саран хөхөө" театрын барилгын гүйцэтгэл 75 хувь, Замын-үүд суманд баригдаж 500 хүний суудалтай Соёлын ордон 95 хувь, Эрдэнэ суманд 200 хүний суудалтай соёлын төв 60 хувь, Дэлгэрэх суманд 320 хүний суудалтай соёлын төвийн барилгын гүйцэтгэл 70.0 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Соёлын салбарын 4-н байгууллагын барилгын ажлыг улс, орон нутгийн төсвөөр нийтдээ 25,3 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж 1 барилга энэ онд ашиглалтад орно.</p>	50
231	Байгальд ээлтэй өндөр технологийн уул уурхай болон стратегийн ач холбогдолтой төслүүдийн хөрөнгө оруулалтыг дэмжих	Үзүүлсэн дэмжлэг	Тоо	2024	0	5	7	<p>Аймагт байгальд ээлтэй, өндөр технологийн уул уурхай болон стратегийн ач холбогдолтой төслүүдийн хөрөнгө оруулалтыг дэмжих хүрээнд холбогдох зөвшөөрөл, техникийн нөхцөл, зохицуулалтын үйлчилгээг үзүүлэн ажиллав.</p> <p>Айраг суманд "Си Эм Кингс" ХХК-ийн MV-005692 ашиглалтын талбайд жонш боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ болон байгаль орчны үнэлгээний бүрдлийг хянаж, барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох процессыг зохион байгуулсан. Мөн "Говийн шандаст хүлэг" ХХК-ийн нүүрс угаах үйлдвэрийн байршлын сонголт, инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл олголт, барилга угсралтын бэлтгэл ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжсэн.</p>	100

								<p>Даланжаргалан сумын Элдэв багт MV-022826 талбайд үйл ажиллагаа явуулах “Ундармал хүдэр” ХХК-ийн төмрийн хүдэр хуурай соронзон ангиллын үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэхэд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, барилга угсралтын зөвшөөрлийн бүрдлийг хянаж, талбай ашиглах зөвшөөрөл болон дэд бүтцийн техникийн нөхцөлийг баталгаажуулан дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хөвсгөл суманд баригдаж буй “Гэрэлт говь” ҮТП-ийн төмөр замын бүтээн байгуулалтыг улсын комисс хүлээн авсан.</p> <p>Мандах суманд “Түмэн айл энерги” ХХК-ийн 100 МВт-ын цахилгаан станцын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг иргэдийн нийтийн хуралд хэлэлцүүлж, холбогдох байгууллагад уламжлав.</p>	
232	Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд иргэд, төр төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах	Үзүүлсэн дэмжлэг	Тоо	2024	2	5	5	<p>Аймагт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд иргэд, төр, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн оролцоог хангах зорилгоор хамтын ажиллагааг идэвхжүүлсэн.</p> <p>Айраг сумын Цагаан дэл орчмын уурхайнуудын нөлөөллийн асуудлаар оршин суугчид, төрийн байгууллагууд, чиглэлийн 4 ТББ, олон улсын шинжээч болон уул уурхайн 8 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллийг оролцуулсан хоёр удаагийн уулзалтыг зохион байгуулж, мэдээлэл солилцож шийдвэрлэх арга замыг хэлэлцсэн.</p> <p>Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч ААН-үүдийн төлөөлөл, Ашигт малтмал, газрын тосны газрын төвийн бүсийн төлөөлөгчийн газар оролцсон нэгдсэн уулзалтаар салбарын тулгамдсан асуудал, шаардлагатай зохицуулалтын талаар санал авч, сумдын Засаг дарга нарт хүргүүлэн шийдвэрлэлтийн үйл явцад тусгасан.</p> <p>Мөн аймгийн ИТХ-аас зохион байгуулсан “Иргэдээ сонсьё” арга хэмжээний хүрээнд байгаль орчны улсын байцаагчдыг оролцуулсан ажлын хэсэг 12 суманд ажиллаж төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцсан. Иргэдтэй уулзах, зөвлөмж өгөх, төрийн үйлчилгээ газар дээр нь хүргэх байдлаар 1,440 иргэнийг хамруулж, нийт 62 санал хүсэлтийг</p>	100

								хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэлээ.	
233	Дүйцүүлэн хамгааллын хүрээнд эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалах	Нөхөн сэргээсэн талбай	Га	2024	144	214	347	Аймгийн хэмжээнд эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, нийтдээ 40 гаруй га талбайд техникийн нөхөн сэргээлт хийлээ. Айраг суманд “Галдайгийн булаг” ХХК-ийн 58,0 сая төгрөгийн санхүүжилтээр эзэн холбогдогчгүй 6.7 га эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн. Даланжаргалан суманд “Хүдрэнт” ХХК 1.6 га, Улаанбадрах суманд “Бадрах Энержи” ХХК 7.2 га талбайн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. Алтанширээ суманд газрын тосны бүтээн байгуулалтын ажилд ашиглагдсан 20 га карьерын талбайд техникийн дүүргэлт, тэгшлэлийн ажлыг хийсэн.	100
		Хамгаалсан арга хэмжээ	Тоо	2024	2	3	3	Хатанбулаг сумын Агаруут, Эргэл багийн нутагт хэрэгжиж буй Тавантолгой–Манлай–Ханги чиглэлийн 484.4 км хүнд даацын авто замын төслийн хүрээнд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын 58 карьерын 311 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэнийг аймгаас томилогдсон ажлын хэсэг газар дээр нь шалгаж, хүлээн авсан. Эвдэрсэн газрын нэгдсэн мэдээллийн санг шинэчлэх зорилгоор аймгийн хэмжээнд 23 байршилд 626.34 га эвдрэлтэй газрыг шинээр тогтоон бүртгэлжүүлж, мэдээллийн санд бүртгэсэн. Биологийн олон янз байдлыг хамгаалах хүрээнд Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Замын-Үүд сумын хилийн бүс, төмөр зам дагуух хулангийн нүүдлийн хөдөлгөөнийг судлах зорилгоор 3 ширхэг хөдөлгөөн мэдрэгч камер, Хатанбулаг, Мандах сумдын зэрлэг амьтдын ундаалдаг булгийн орчимд 15 ширхэг ажиглалтын камер байрлуулан мониторингийн мэдээллийг цуглуулж эхэлсэн. “Их говь энержи” ХХК нь биотехникийн арга хэмжээний хүрээнд 200 боодол өвсийг 50 байршилд тарааж, зэрлэг амьтдын амьдрах болон идэш тэжээлийн нөхцөлийг сайжруулах ажиллагааг хэрэгжүүлсэн.	

								“Эрдэнэс Цагаан суварга” ХХК болон “Их түмэн хүрд” ХХК нь тээврийн авто зам дагуу зэрлэг амьтдын нүүдлийн бүсэд анхааруулах тэмдэг тус бүр 1 ширхэг байршуулсан.	
234	Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг байгаль орчинд ээлтэй “Нэг бүс-Нэг зам” бодлогыг хэрэгжүүлэх	Тусгай зориулалтын авто зам	Км	2024	0	132	248	<p>Эрдэнэс-Тавантолгойн уурхайгаас Ханги чиглэлд 473 км урттай тээврийн замын Хатанбулаг сумын нутгаар дайран өнгөрөх 226 км хэсгийг улсын тусгай комисс хүлээн авч ашиглалтад орууллаа. Даланжаргалан сумын Элдэв багаас Олон-Овоо баг чиглэлд 22 км авто замыг хайрган хучилттай сайжруулсан зам болгон засварлах ажлыг “Далан тулга майнинг” ХХК гүйцэтгэж эхлүүлсэн.</p> <p>Замын хөрсний эвдрэлийг тогтоох зорилгоор 4 хяналтын камер суурилуулж, байгаль хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрт 9.9 сая төгрөг зарцуулсан. Мандах сумын уул уурхайн компаниудад Зам тээврийн яамнаас 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн албан шаардлагын дагуу ачааны тээврийг түр зогсоосон.</p> <p>Уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэх чиглэлийг компаниудад хүргүүлж, байгаль орчинд ээлтэй тээвэрлэлтийг дэмжиж, авто замын ачааллыг бууруулах арга хэмжээг авч ажилласан. Мөн Зүүнбаян багаас Улаанбадрах сумын төв хүртэлх 110.8 км авто замын чиглэлийг баталж, хатуу хучилттай зам барих ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлсэн.</p>	100
235	"Хариуцлагатай уул уурхай" Говийн бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулах	Ажлын үр дүн хувиар	Хувь	2024	0	100	25	<p>Дорноговь аймагт 2025.10.22-ны А/652 захирамжаар “Хариуцлагатай уул уурхай” Говийн бүсийн зөвлөгөө болон “Хөрөнгө оруулалтын форум” зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн төлөвлөгөө боловсруулсан.</p> <p>Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан “Хөрөнгө оруулалтын форум”-ыг 2026 онд зохион байгуулахаар төлөвлөсөн.</p>	25
236	Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай	Хамтран ажиллах гэрээ	Тоо	2024	0	30	8	<p>Сумдад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Үүнд: Иххэт, Өргөн, Айраг сумын нутагт “Эрдэнэс критикал минералс” ХХК, Бор Өндөр уулын баяжуулах үйлдвэр, Даланжаргалан сумын Элдэв</p>	26.6

	"Хамтран ажиллах гэрээг" байгуулж, гэрээний хэрэгжилтийг нийтэд ил тод мэдээллэх							багт үйл ажиллагаа явуулж буй "Говийн шандаст хүлэг" ХХК, "Фриендшип ресурс" ХХК, "Билэгт баялаг" ХХК, "Билэгт зурвас" ХХК, "Монголиан флор стар" ХХК Улаанбадрах сумын "Арвинхад" ХХК-тай нийт 8 хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
237	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох, цуцлахтай холбоотой саналд иргэдийн оролцоог хангах	Сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Тоо	2024	0	2	2	<p>Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалттай олгох, цуцлахтай холбоотой иргэдийн оролцоог хангах хүрээнд Говийн бүсийн зөвлөгөөнийг тайлант онд зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Энэ хүрээнд аймгийн хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд "Уул уурхайн бизнес эрхлэгчдийн уулзалт-2025" арга хэмжээг зохион байгуулж, 12 сумын 38 аж ахуйн нэгжийн төлөөлөл, сумдын болон холбогдох байгууллагын төлөөлөгчдийн хамт уулзалт зохион байгууллаа.</p> <p>Уулзалтаар орон нутагт уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг харилцан нээлттэй хэлэлцэж, 18 заалт бүхий асуумжийн мэдээллийг цуглуулсан. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг нэгтгэн, сумдын Засаг дарга нарт чиглэл болгон хүргүүлсэн.</p>	100
238	Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зэрлэг амьтан хамгаалах бүсчилсэн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэлээр	Хувь	2024	0	100	100	<p>Монгол Улсад хулан, аргаль хонь, янгир ямаа зэрэг нэн ховор амьтдын нөөц ихэнхдээ Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Мандах сум болон ойр орчмын нутгуудад тархсан бөгөөд нийт хулангийн нөөц 60,000 орчим, аргаль хонь 2,500, янгир 500 орчим байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 дугаар тушаалаар нэн ховор, ховор амьтан хамгаалах төлөвлөгөө батлагдаж, бүсчилсэн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжиж байна. Төсөл, судалгааны хүрээнд Улаанбаатар төмөр зам дагуу нүүдлийн амьтдын хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах зорилгоор Эрдэнэ суманд 2, Өргөн суманд 1, Замын-үүд суманд 1 гүүрэн гарц байгуулах боломжтой гэж тогтоосон.</p> <p>Мөн Хатанбулаг 6, Хөвсгөл 8, Мандах 6 булгийг усны шинж чанар, урсгал, замаг, усны дээжийн шинжилгээнд хамруулсан. Хатанбулаг суманд 2</p>	100

								<p>нөхөрлөл байгуулан Хатны булаг, Шивнээн булгийг хашаагаар хамгаалах ажлыг 7 дугаар сард хийхээр төлөвлөсөн.</p> <p>Орон нутгийн иргэдийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхжуулахад чиглэсэн 50 өрхөд таниулах ажил болон “Эмэгтэйчүүдийн манлайллын санаачлага” арга хэмжээ хэрэгжүүлж, Хөвсгөл, Хатанбулаг сумын 19 эмэгтэйд бэлчээрийн даац хэтрэх, уул уурхайн экологи, усны хомсдлын асуудлыг шийдвэрлэх боломжит аргачлалыг сургажээ.</p>	
239	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, хамгаалалтын менежментийг сайжруулах	Тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	2023	32.7	33	33	<p>Монгол Улсад тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, менежментийг сайжруулах ажлыг хэрэгжүүлж байна.</p> <p>Дэлгэрэх сумын "Шар мод", Айраг сумын "Майхан дэл", "Хүрэн өндөр", "Үйзэн", "Баруун цагаан дэл", "Гашуун говь", "Хондлой ухаа", "Дэлгэрэх" зэрэг газруудыг нийт 67,016.33 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. 2019 оны Монгол Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолоор Айраг сумын Цагаан дэлийн агуй, Хөвсгөл сумын "Гүн гашууны хоолой"-г улсын тусгай хамгаалалтад авч, Засгийн газрын 2025 оны 106 дугаар тогтоолоор Цагаан дэлийн агуй 116.01 га, Гүн гашууны хоолой 64,911.31 га талбайтайгаар баталгаажсан. Мөн 2025 онд Эрдэнэ сумын Цант хайрхан-модонгийн худаг 6,855.37 га талбайг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтад авч, Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгүүлсэн.</p> <p>Байгаль орчны хяналтыг сайжруулах, тусгай хамгаалалттай газар нутгийг эзэнжүүлэх зорилгоор 105 газар нутгийг хариуцсан 82 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагчаар томилон ажиллуулж байна.</p> <p>Аймаг, сумын Засаг дарга хоорондын гэрээний дагуу сум тус бүрт 10-аас доошгүй иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагчаар томилох зохицуулалт хийсэн бөгөөд 2025 онд Сайншанд сумын 1 иргэнийг энэ чиглэлээр ажиллуулж байна.</p>	100
		Шинээр томилогдсон идэвхтэн байгаль хамгаалагчийн тоо	Тоо	2024	61	80	82		
240	Тусгай хамгаалалттай	Тэмдэгжүүлсэн газар	тоо	2023	1	10	23	<p>Алтанширээ сумын Засаг даргын тамгын газраас орон нутгийн тусгай хамгаалалттай "Хайлсан шанд", "Холбоогийн уул", "Баян буурал" газруудад хууль эрх</p>	100

	газар нутгийг тэмдэгжүүлэх							зүй, тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, танилцуулгатай 3 самбар байршуулж тэмдэгжүүлсэн. Мөн Даланжаргалан сумын Бичигт багт байрлах Их нартын байгалийн нөөц газрын хил хязгаарыг тэмдэгжүүлэх ажлыг Олон Ихт баян ХХК-ын нийгмийн хариуцлагын хүрээнд 20 ширхэг тэмдэглэгээ байршуулснаар тайлант хугацаанд нийт 23 газар нутгийг тэмдэгжүүлж, тусгай хамгаалалттай газрын дэглэм, хууль эрх зүйн мэдээллийг олон нийтэд сурталчлах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.	
241	Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	Тоо	2024	2	2	3	<p>Өмнөговь аймагт биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг өргөн хүрээнд зохион байгууллаа. Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг Монгол дахь төлөөлөгчийн газар “Байгалийн нөөцийн хамтын менежмент”, “Ан амьтны эд эрхтний хууль бус худалдаа, хулгайн антай тэмцэх төсөл”-ийн үр дүн, төлөвлөлтийн талаар сургалт, зөвлөгөө зохион байгуулж, Их нартын байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаа “Зэрлэг амьтны хамгаалал”, “Байгаль аппликейшнийг ашиглах” сэдэвт сургалт явуулсан.</p> <p>Мөн хамтран “Хулан адууны коридор нутгийг чөлөөлөх” сэдвээр сургалт зохион байгуулж, 870 гаруй иргэнд мэдээ мэдээлэл хүргэлсэн.</p> <p>Говийн бүсийн “Биологийн олон янз байдал” сэдэвт сургалт зөвлөгөөнд 14 сумын байгаль орчны мэргэжилтнүүд оролцсон.</p> <p>Байгаль орчны эсрэг хууль бус үйл ажиллагаа, ан амьтны эд эрхтний хууль бус худалдаа, хулгайн антай тэмцэх төслийн хүрээнд 18 удаагийн эргүүл, хяналт шалгалт явуулж, малчин 80 гаруй өрхийн 140 гаруй иргэнд “Амьтны тухай хууль”-ийн эрх зүйн танилцуулга, мэдээлэл өгсөн.</p> <p>Энэхүү арга хэмжээ нь орон нутгийн иргэд, мэргэжилтнүүдийг биологийн төрөл зүйл, байгаль хамгааллын чиглэлээр мэдлэгжүүлсэн.</p>	100
242	Усны сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилийн хувиар тооцно.	Хувь	2024	68	75	75	Сайншанд сумын төвийн 1, 2, 3-р худаг болон Замын-Үүд сумын “Замын-Үүд Дулааны Станц” ТӨҮГ-ын сумын төвийн 1, 2 дугаар ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын зурвасуудыг блок, бетон болгож	100

	төлөвлөгөөг хэрэгжүүлэх							<p>шинэчлэн засварлаж, хориглолт, хязгаарлалтын тэмдэглэгээг шинэчилсэн. Усны сан бүхий газар, эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуй бүс, тэжээгдлийн мужийн зааг зураглалын мэдээллийг судалгаагаар шинэчлэн тогтоож, Умард говийн гүвээт-Халхын дундад талын, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаанаас хамгаалалтад авсан. Судалгаагаар сумдын төвийн худгийн хамгаалалтын бүстэй 239 газар давхцалтай, 13 сумын 86 булаг ашигт малтмалын 46 тусгай зөвшөөрөлтэй талбай, 111 нуур, тойром ашигт малтмалын 44 тусгай зөвшөөрөлтэй давхцалтай байсан тул иргэн, аж ахуйн нэгжүүдэд сонсох ажиллагаа зохион байгуулж, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан арилгуулах чиглэл өгч ажилласан.</p> <p>Сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө 2019 онд батлагдаж, 2019-2020 онд 1 дүгээр үе шат, 2021-2025 онд 2 дугаар үе шат хэрэгжсэн. Төлөвлөгөө нь хүн амын ус (44 арга хэмжээ), хөдөө аж ахуйн ус (21), үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний ус (23), хүрээлэн буй орчны ус (21), усны менежментийн таатай орчин (27) гэсэн үндсэн 5 асуудлын хүрээнд нийт 136 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт нь хүн амын ус 75%, хөдөө аж ахуйн ус 60%, үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний ус 85%, хүрээлэн буй орчны ус 85%, усны менежментийн таатай орчин 70% буюу дунджаар 75% байгаа нь үр дүнтэй хэрэгжилт болсон.</p>	
243	Усны сан бүхий бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн бүсийг дэглэмийг мөрдүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тоо	2024	5	8	8	<p>Айраг сумын "Би Ти Девелопмент" ХХК-ийн 1 худаг болон Даланжаргалан сумын Цомог багийн 1 худагт эрүүл ахуйн бүс тогтоон тэмдэгжүүлж, 2025 онд шинээр гаргасан худаг, уст цэгүүдэд эрүүл ахуйн бүс тогтоох чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.</p> <p>Умард говийн гүвээт-Халхын дундад талын, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны судалгаагаар Өргөн, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн худгийн хамгаалалтын бүстэй 239 газар давхцалтай, 13 сумын</p>	100

								<p>86 булаг ашигт малтмалын 46 тусгай зөвшөөрөлтэй талбай, 111 нуур, тойром ашигт малтмалын 44 тусгай зөвшөөрөлтэй давхцалтай байсан тул иргэн, аж ахуйн нэгжүүдэд сонсох ажиллагаа зохион байгуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Мөн сумдад усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх ажлын хүрээнд 14 ус хангамжийн эх үүсвэр, 10 усны сан бүхий газарт үүссэн 40 малын сэг зэм устгаж, 3.7 га талбайд хуримтлагдсан 30.0 тн хог хаягдлыг 50 аж ахуйн нэгж, байгууллагын 1280 ажилтан, албан хаагч, 14 автомашин, техник хэрэгсэл оролцуулан сумдын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, орчны бохирдлыг бууруулсан.</p>	
244	Хөв цөөрөм байгуулах	Хөв цөөрмийн тоо өссөн дүнгээр	Тоо	2024	11	16	21	<p>2025 онд Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Сайншанд, Эрдэнэ, Өргөн сумдад нийт 61.0 сая төгрөгийн санхүүжилтээр 10 ширхэг хөв цөөрөм байгуулсан. Тодруулбал, Алтанширээ суманд 3 тн багтаамжтай 1 хөв (10.0 сая төгрөг); Даланжаргаланд 5 тн багтаамжтай 1 хөв ("Сармай дээлт" ХХК – 10.0 сая), 5 тн багтаамжтай 1 хөв ("Ачир" ХХК – 3.0 сая); Иххэт суманд 20 тн багтаамжтай 1 хөв ("Эрдэнэс кристалл менералс" ХХК – 10.0 сая); Сайншанд суманд 3 тн багтаамжтай 1 хөв ("Салхин парк" ХХК – 2.0 сая); Эрдэнэ суманд 2 тн багтаамжтай 1 хөв ("Маунтэйн хантинг" ХХК – 6.0 сая), 2 тн багтаамжтай 1 хөв (ан агнуурын орлого – 7.0 сая); Өргөн суманд 2–4 тн багтаамжтай 3 хөв (ан агнуурын орлого болон "Бишрэлт түшлэг" ХХК – 13.0 сая). Эдгээр хөвүүд нь орон нутгийн усан сан, мал, амьтны усны хэрэгцээг хангах, экологийн тэнцвэрийг хадгалахад чухал нөлөө үзүүлсэн.</p>	100
245	Булаг шандын эхийг хамгаалж, тохижуулах	Хамгаалагдсан булгийн тоо өссөн дүнгээр	Тоо	2024	18	21	26	<p>Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилт, хувийн компаниуд болон орон нутгийн хөгжлийн сангийн нийт 70.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Иххэт, Хөвсгөл, Эрдэнэ, Даланжаргалан, Дэлгэрэх, Хатанбулаг сумдад нийт 8 булгийн эхийг хамгаалж, тохижуулах ажлуудыг хийсэн. Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоож</p>	100

								мөрдүүлэх, ойр орчны хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 40 аж ахуйн нэгж, 980 иргэн, 14 техник хэрэгсэл оролцон 3.5 га талбай, 14 ус хангамжийн эх үүсвэр, 10 усны сан бүхий газарт хуримтлагдсан малын сэг зэм, ахуйн хог хаягдлыг цэвэрлэж, сумдын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн нь усны эх үүсвэрийг хамгаалах, орчны цэвэр байдлыг хангах чухал үр дүн болсон.	
246	Хүн амын усан хангамжийн эх үүсвэрт цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	Төхөөрөмжийн тоо өссөн дүнгээр	Тоо	2024	25	28	32	Тайлант онд нийт 498.1 сая төгрөгийн хөрөнгөөр 6 сумын 7 усны эх үүсвэр, худаг, уст цэгт усны төв болон ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилууллаа. Үүнд: Даланжаргалан суманд ОНХС-ын 4.0 сая төгрөгөөр “Олон овоо” багийн “Майхан овоо” нэртэй 1 худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж, Замын-Үүд суманд ОНХС-ын 39.1 сая төгрөгөөр ЕБ-ын 2, 3-р сургуулийн 2 эх үүсвэрт тоног төхөөрөмж, Сайншанд суманд ОНХС-ын 105.0 сая төгрөгөөр 2-р багийн 1 худагт усны төв, Хатанбулаг суманд ОНХС-ын 130.0 сая төгрөгөөр ундны усны эх үүсвэрийн 1 худагт цэнгэгжүүлэх төхөөрөмж, Өргөн суманд ОНХС-ын 130.0 сая төгрөгөөр 1 худагт төхөөрөмж суурилуулж, Улаанбадрах суманд орон нутгийн төсвийн 90.0 сая төгрөгөөр “Болор-1” худагт усны төв байгуулсан.	100
247	Хатанбулаг сумын Ханги боомтын суурьшлын бүсэд ундны усны гидрогеологийн судалгааны эрэл хайгуулын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Ажлын гүйцэтгэл	Тоо	2024	0	100	70	Хилийн боомтын суурьшлын бүсийн ундны усны эх үүсвэрийг тогтоох зорилгоор гидрогеологийн судалгааны эрэл хайгуулын ажлыг “Дунар Од” ХХК гүйцэтгэж ажлын явц 70 хувьтай үргэлжилж байна. Төлөвлөгөөнд эрлийн 3, хайгуулын 3–4 цооног өрөмдөж, ундны усны нөөцийг 4 л/сек ба түүнээс дээш ундаргатай тогтоохоор тусгасан. Одоогоор эрлийн 3, хайгуулын 3 цооногийг өрөмдөж, шавхалтын ажлыг хийж байна. Суурьшлын бүсийн зүүн талд 7.8 км зайд байрлах цооног 3.5 л/сек ундаргатай, сумын баруун талд 3 км зайд өрөмдсөн 1 дэх цооног 0.7 л/сек, Баруун талын 2 дахь цооног 2 л/сек ундаргатай байна.	70
248	Хөдөө аж ахуйн ус хангамжийн нөхцөлийг сайжруулж, нэмэгдүүлэх	Шинээр гаргасан худаг	Тоо	2023	21	35	44	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зарласан тендерийн дүнд “Эхний эхэн” ХХК шалгарч, нийт 97.5 сая төгрөгийн санхүүжилтээр Өргөн, Улаанбадрах, Сайншанд сумдад 3 инженерийн хийцтэй худгийн барилгын ажлыг гүйцэтгэх эрхийг	100

								<p>авсан байна. Мөн Айраг, Сайхандулаан, Хөвсгөл, Сайншанд сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн 395.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 10 инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг “Рашаан-Ундрах” ХХК, “Баясах ус эрдэнэ” ХХК, “Эхний эхэн” ХХК-иуд гүйцэтгэж байна.</p> <p>Үүнээс гадна Мандах, Хатанбулаг, Эрдэнэ сумдын ОНХС-ийн 9.0 сая төгрөгийн санхүүжилтээр малчдын оролцоотой 10 гар худгийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулж байна. Айраг сумын ОНХС-ийн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Далд эрдэнэ мөнх” ХХК таван цэгт усны геофизикийн хайгуулын ажлыг хийж гүйцэтгээд байна.</p> <p>Тайлант хугацаанд нийт 13 инженерийн хийцтэй худаг, 10 энгийн уурхай худгийг шинээр байгуулж болон сэргээн засварласнаар 29.5 мянган га бэлчээрийн газрыг усжуулж, 35.3 мянган толгой малыг услах боломж бүрдсэн.</p>	
249	“Хэрлэн тооно” төслийн бүсэд ногдох хэсгийг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгийн тоо	Тоо	2024	2	4	1	<p>Хэрлэн тоонот болон Орхон–Онгийн ус дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд судалгааны баг аймагт хоёр удаа ажиллаж, төслийн зорилго, хэрэгжилтийн төлөвлөгөөг танилцуулсан.</p> <p>Аймгийн зүгээс ТЭЗҮ-д шаардлагатай судалгаа, мэдээллийг бүрдүүлэн өгч дэмжлэг үзүүлсэн. Мөн төслийн үндсэн эхлэл болох Цагаан бургастай–Онгийн усан цогцолбор байгуулах, Улаан нуурын экосистемийг сэргээх төслийн нээлтэд аймгийн Засаг даргатай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.</p>	0
250	Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хувь	2024	0	100	100	<p>Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг аймагт хэрэгжүүлэх хүрээнд “Аймгийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/189 дүгээр захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд төлөвлөгөө боловсруулах ажил 80 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.</p> <p>Төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан GGGIS төслийн нэгжээс зохион байгуулсан сургалтад</p>	100

								<p>ажлын хэсгийн 7 гишүүн хамрагдсан. Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Монгол Улсын NDC 3.0 бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж дуустал аймгийн ажлын гүйцэтгэл хүлээлттэй байна.</p> <p>NDC зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон БНСУ-ын Байгаль орчны яамтай хамтран “Агаарын чанарыг хянах бүрэн автомат станц суурилуулах” төсөл хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд бүх аймгийн төвд агаарын чанарыг тасралтгүй хянах хүчин чадал бүхий станц суурилуулахаар төлөвлөгдсөний дагуу 2025 оны 08 дугаар сарын 28-нд Сайншанд суманд станц суурилуулах ажил бүрэн дууссан.</p> <p>Ингэснээр Сайншанд суманд хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцрын агууламжийг 24 цагийн турш тасралтгүй, автоматаар хэмжих бүрэн боломжтой болсон.</p>	
251	Агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрүүдийг бууруулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэлийн хувь	Хувь	2024	70	100	100	<p>Монгол гэрийг дулаан, аюулгүй, эрүүл орчин болгох зорилготой CHIP (Cooking, Heating and Insulation Products) төсөл аймгийн хэмжээнд сурталчлагдаж, арга хэмжээ зохион байгуулан ажилласан. Энэхүү төсөл нь: Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, Агаар сэлгэлтийн систем, Дулаан хадгалах бүрээс бүхий иж бүрэн шийдэлтэй.</p> <p>Төслийн зорилго нь гэр хорооллын айл өрхүүдийн нүүрсний хэрэглээг бууруулах, агаарын бохирдлыг багасгах, мөн хүүхэд, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн.</p> <p>Төслийн хүрээнд Сайншанд сумын 10 айл өрхөд CHIP багцыг хүлээлгэн өгсөн.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 4768 айл өрхийн хэрэгцээ ердийн зуух ашиглаж байсан бол, 2025 онд 115 айл өрх ердийн зуух ашиглахаа больсон. Үүний үр дүнд агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрүүд 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	100
252	Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй	Арга хэмжээний тоо	Тоо	2024	4	5	5	<p>Аймгийн хэмжээнд байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй амьдралын хэв маягийг түгээн дэлгэрүүлэх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх</p>	100

	амьдралын хэв маяг, хандлага, дадлыг хэвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх							<p>зорилгоор 6 байгууллага, 80 гаруй албан хаагч хамтран 21 байршилд арга хэмжээ зохион байгуулж, орчны бохирдлыг бууруулсан. Сумдын ЕБС-ийн 6-12 ангийн 23 бүлгийн 575 сурагчдад "Дахивар ба түүний ангилал, хор хөнөөл" сэдвээр сургалт, хэлэлцүүлэг явуулж, байгаль орчны мэдлэг, хандлагыг дээшлүүлсэн.</p> <p>2025 онд хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор "Хоггүй Сайхандулаан", "Аюулыг авдарлая", "Нэг чихэр-нэг зай", "Холивол хог, ангилбал баялаг" зэрэг 4 аяныг сумдад зохион байгуулсан. Мөн "Соёлтой аялъя, Соёлтой наадъя" аяны хүрээнд олон нийтийн мэдээллийн сүлжээнд хоггүй, соёлтой аялал, наадамд оролцохыг уриалсан 70 постер, уриалга нийтэлж, 49 мянга орчим иргэнд мэдээлэл хүргэсэн. Баяр наадам болон нийтийн их цэвэрлэгээнд 710 иргэн, 24 ААНБ хамтран 210 тн хог хаягдлыг цуглуулан, орчны бохирдлыг бууруулж, байгальд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлсэн.</p> <p>Эдгээр арга хэмжээ нь иргэдийн байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлж, хог хаягдлын менежментийг сайжруулахад бодитой нөлөө үзүүлсэн бөгөөд олон нийтийн оролцоо нэмэгдсэн нь орчны цэвэр байдлыг хадгалах, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.</p>	
253	Тээврийн хэрэгслийн насжилт, түүнээс гарах бохирдолд тавих стандартыг мөрдүүлж, цахилгаан машины хэрэглээг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	Тоо	2024	0	2	2	<p>2024 онд тээврийн хэрэгслийн насжилт, түүнээс гарах бохирдолд тавих стандартыг мөрдүүлэх, цахилгаан машины хэрэглээг дэмжих чиглэлээр арга хэмжээ авч, мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр 372 тээврийн хэрэгслийг (2024 онд) болон 399 тээврийн хэрэгслийг бүртгэлээс хассан. Энэ үйл ажиллагаа нь Зам, тээврийн сайдын 2023 оны А/140 дүгээр тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын 7.2.3 заалтад үндэслэн хэрэгжүүлсэн. Мөн Сайншанд, Замын-Үүд сумын техникийн хяналтын үзлэгт хамрагдаж буй жолооч нарт заавар, зөвлөмж өгч, стандартын шаардлагыг мөрдүүлэх, тээврийн хэрэгслийн насжилт болон бохирдлыг бууруулах чиглэлээр нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.</p>	100

254	Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Арга хэмжээний тоо	Тоо	2024	3	4	4	<p>Гэр хорооллын хог хаягдлын менежментийг сайжруулж, хүний эрүүл мэнд, орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар “Их говийн хөгжлийн гарц” ОНӨААТҮГ-тай хамтран 2030 он хүртэлх 6 зорилттой тогтвортой хөтөлбөр боловсруулах ажил явуулж байна. Аймгийн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ангилан ялгах, дахин боловсруулах 4 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>“Талст орд” ХХК хаягдал дугуйг дахин боловсруулж стандартын шаардлага хангасан түүхий эд болгон үйлдвэрлэж, одоогоор 300 тн хаягдал дугуй нөөцөлсөн. “Омбол-оюу ундрага” ХХК өдөрт 3000–5000 ш өндөгний цаасан үүр үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 60 тн хаягдал цаасыг дахин боловсруулсан. “Саус ресурс” ХХК хаягдал тосоос дизель түлш гаргах үйлдвэрийн угсралтын ажил хийгдэж, 250 тн хаягдал тос нөөцлөөд байна. “Эко Говь” ХХК 7 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тайлант онд жилийн 29 тн дахиврыг дахин боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Аймгийн хэмжээнд хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээ 1.6 дахин өсөж, хөдөөгийн сумдад 11.9 тн дахивар хог хаягдлыг ангилан ялган “Эко Говь” ХХК-д хүлээлгэн өгсөн.</p> <p>Энэхүү арга хэмжээ нь хог хаягдлын менежментийг сайжруулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад бодитой нөлөө үзүүлж байна.</p>	100
255	Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжих	Арга хэмжээ	Тоо	2024	2	3	4	<p>Дорноговь аймгийн Сайншанд суманд үйл ажиллагаа явуулдаг хог хаягдал дахин боловсруулах “Эко Говь” ХХК 2019 онд байгуулагдсан бөгөөд 2023 оноос үйлдвэрийн гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил удаашралтай байсан боловч 2025 оны 04 дүгээр сард ашиглалтад орсон. Тус үйлдвэр 2024–2025 онд “Түншлэл ба хөгжил” орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 150,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан. Мөн орон нутгийн төсвийн 37,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эко Ресурс” ХХК Сайншанд тохижилт</p>	100

								<p>үйлчилгээний газартай гэрээ байгуулж, “Нүүдэлчин” хог шатаах зуух худалдан авч аймгийн төвлөрсөн хогийн цэгт байршуулсан.</p> <p>Сайншанд сумын Засаг даргын 2025.08.06 ны А/179 дүгээр захирамжаар Хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоо бий болгох, төлөвлөгөөг боловсруулах зорилго бүхий ажлын хэсэг байгуулж, Их говийн хөгжлийн гарц ОНӨААТҮГ хамтарсан 2025 оны 08 дугаар сарын 28-ны №01 дугаартай "Хог хаягдлын менежментийн тогтолцоог бий болгох хөтөлбөрийн удирдамж" баталсан.</p> <p>Энэ хүрээнд 73 аж ахуйн нэгжид судалгаа, хэлэлцүүлэг явагдаж 8571 өрхөөс 492 өрхөөс асуумж авч, 48 өрх тандалтын судалгаанд оролцсон. Мөн 7 бүлэг хэлэлцүүлэгт 33 аж ахуй нэгж, сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийн төлөөлөл оролцуулан зохион байгуулсан. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой аж ахуйн нэгжүүдтэй уулзаж хог хаягдлын ангилан ялгах оновчтой хуваарилалтын төлөвлөгөөг хамтран боловсруулсан.</p> <p>Сайншанд сумын 4 дүгээр багийн 1 иргэн 3 дугаар багийн нутаг дэвсгэрт хог хаягдал боловсруулах үйлдвэрлэл эрхлэхээр хүсэлт гаргаж 0,5 га газрыг бодлогоор дэмжиж сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Улсын хэмжээнд 2025 оны эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт тухай” 120 дугаар тогтоолоор батлагдсан.</p>	
256	Сайншанд, Замын-Үүд сумдын төвлөрсөн хогийн цэгт ландфилл технологийг нэвтрүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Сайншанд сумын төвлөрсөн хогийн цэгийг цэгцэлж, 22.1 сая төгрөгийн хөрөнгөөр 50×50 м хэмжээтэй, 3.5 м гүнтэй талбай бэлтгэх ажлыг 4 техник, 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр 26 өдөрт гүйцэтгэсэн.</p> <p>Замын-Үүд суманд 2023–2026 онд “Сэвхүүлийн тойрмын төвлөрсөн хогийн цэгийг цэгцлэх” төслийг 4.0 тэрбум төгрөгийн төсөвтэйгээр “Элемент” ХХК хэрэгжүүлж, 70 га талбайд тархсан хог хаягдлыг 10 га талбайд шахаж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, химийн гаралтай хог хаягдлыг стандартын дагуу устгах, барилга болон бусад</p>	100

								<p>төрлийн хог хаягдлыг ландфиллийн аргаар устгах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн.</p> <p>Сайншанд сумын Засаг даргын 2025.08.06 ны А/179 дүгээр захирамжаар Хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоо бий болгох, төлөвлөгөөг боловсруулах зорилго бүхий ажлын хэсэг байгуулж, Их говийн хөгжлийн гарц ОНӨААТҮГ хамтарсан 2025 оны 08 дугаар сарын 28-ны №01 дугаартай "Хог хаягдлын менежментийн тогтолцоог бий болгох хөтөлбөрийн удирдамж" баталсан.</p>	
257	Сайншанд сумын Захирагчийн ажлын албыг шаардлагатай машин механизмаар хангах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	100	100	100	<p>Сайншанд сумын Захирагчийн ажлын албыг шаардлагатай машин механизмаар хангах хүрээнд аймгийн орон нутгийн төсвийн санхүүжилтээр хот тохижилтын үйл ажиллагааг дэмжих хоёр үндсэн худалдан авалтын ажил хийгдсэн. Нийт 445,3 сая төгрөгийн санхүүжилтээр зам цэвэрлэгээний автомашиныг 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Сайншанд тохижилт үйлчилгээний газарт "Егү говь" ХХК, Мөн 324,5 сая төгрөгийн санхүүжилтээр ковш машин нийлүүлэх ажлыг "Монтех дистрибьюшн" ХХК гүйцэтгэж тус тус хүлээлгэн өгсөн. Дээрх худалдан авалтын үр дүнд тохижилтын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн хангалт сайжирч, цэвэрлэгээний ажлыг тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах боломж бүрдсэн.</p>	100
258	Сайншанд сумын нутаг дахь Найрамдлын хур хогийг цэвэрлэх ажлыг эхлүүлэх	Хэрэгжилтийн хувь	Тоо	2024	0	50	10	<p>Сайншанд сумын Захирагчийн ажлын алба нь 2025 онд хэрэгжүүлэх "Найрамдлын хур хогийг цэвэрлэх" ажлын бэлтгэл хүрээнд шаардлагатай нөөц, зардлын тооцож, 30 хоногийн хугацаанд ажиллах нийт 34 машин техник хэрэгсэл болон холбогдох төсвийг тооцоолсон.</p>	20
259	Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж "Карбон кридет"-ийг нэвтүүлэхэд шаардлагатай судалгааны цэг байгуулах	Хэрэгжилтийн хувь	Тоо	2024	0	100	100	<p>Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж карбон кредитийг орон нутагт нэвтрүүлэх зорилтын хүрээнд судалгааны цэг байгуулах ажил үргэлжилж байна. Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт хэрэгжиж буй "ШАМБАЛА-2056 ИНЖЕНЕРИЙН СУУРИН" төсөл 2020–2024 онд нийт 66,857 мод тарьж, ургамжилтын нормчилсон индекс 0.3 буюу дунд зэргийн ургамалжилттай гэж үнэлэгдсэн бөгөөд ургамлын нийт масс 44,260,359 кг-д хүрсэн байна. Судалгаагаар сүүлийн дөрвөн жилийн хугацаанд нийт</p>	100

								20,802,378 кг буюу ойролцоогоор 20,800 тонн нүүрстөрөгч шингээсэн нь карбон кредитийн тооцоололд ашиглагдах суурь үзүүлэлт болж байна.	
260	Хөрс бохирдуулагч нүхэн жорлонгийн тоог бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Бууруулсан нүхэн жорлонгийн тоо	Тоо	2024	45	100	218	<p>Аймгийн хэмжээнд хөрс бохирдуулагч нүхэн жорлонгийн тооллого зохион байгуулж, нийт 9,187 нүхэн жорлон бүртгэгдсэн бөгөөд үүнд гэр хорооллын 4,570, малчин өрхийн 4,421, төрийн байгууллагын 13, уул уурхайн 57, худалдаа үйлчилгээний төвийн 28, амралт жуулчны баазын 50, нийтийн эзэмшлийн талбайн 48 жорлон багтлаа. Тооллогын дүнд үндэслэн 2025–2028 онд нүхэн жорлонгийн тоог 8,316 болгон бууруулах төлөвлөгөөг боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 10-нд холбогдох яаманд албан бичгээр хүргүүлсэн. 2025 онд хяналт шалгалтаар шатахуун түгээх станцын 6, уул уурхайн ААН-ийн 17 нүхэн жорлонг буулгаж, Сайншанд суманд 47 айл өрхийг төвлөрсөн дэд бүтцэд холбосон. Мөн Замын-Үүд суманд “Хашаандаа сайхан амьдаръя” аяны хүрээнд 92 өрхийг эко ариун цэврийн байгууламжид холбож, бусад сумдад нийт 56 нүхэн жорлонг бууруулсан.</p> <p>Айраг, Алтанширээ сумдын 450 өрхийн нүхэн жорлонд ариутгал халдваргүйтгэл хийж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог 115-аар нэмэгдүүллээ. Үүнээс гадна тайлант онд нийт 218 стандартын бус нүхэн жорлонг буулгаж, ашиглалтаас гаргасан.</p>	100
261	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, аж ахуйн нэгж, иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх	Тарьсан модны тоо	Ширхэг	2024	532061	1000000	793135	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд эрчимжүүлж, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мод тарих аяныг зохион байгууллаа. Уг ажилд 302 ААН, байгууллага болон 4,602 иргэн, ажилтан хамрагдаж, нийт 261,074 ширхэг мод, бут сөөг шинээр тарьсан нь өмнөх онтой харьцуулахад 162,368-аар өсч, төлөвлөгөөг 35 хувиар давуулсан. Ургалтын хувь 76.9 бөгөөд өнгөрсөн оноос 1.9 пунктээр нэмэгдсэн.</p> <p>Төв суурингийн ногоон байгууламжийг 43 га, тариалангийн болон авто замын хамгаалалтын</p>	81.5
		Шинээр нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ	Га	2024	16	30	92		
		Модны ургалтын хувь	Хувь	2024	75	78	76,9		
		Ойжуулсан талбайн хэмжээ	Га	2024	116893	116903	117065		

		Хамгаалалтын ойн зурвас	Га	2024	0	39	59	зурвасыг 31 га, салхинаас хамгаалах зурвасыг 18 га талбайгаар тус тус нэмэгдүүлж, нийт 92 га талбайд тарьсан мод, бут сөөг 261,074 ширхэгийг бүрдүүлсэн. Байгууллагын оролцоог нэмэгдүүлэх хүрээнд “Энержи Парагон” ХХК 10 га талбайд 30,000 мод тарьж, усалгааны системтэй иж бүрэн хашаажуулсан бөгөөд ургалтын хувь 98 хувьтай байна. Зэвсэгт хүчний 336 дугаар анги мод үржүүлгийн талбайг 5 га-аар нэмэгдүүлж 5,000 мод, “Шамбала Инженеринг Кампус” ХХК Эрдэнэ суманд 3 га талбайд 5,000 мод тарьсан. Сайншанд сумын Хамарын хийдийн чиглэлд “гүн нүхэнд тарих арга”-аар 1 га талбайд 1,500 мод тарьж хашаажуулсан. “Мөрөөдлийн Говь” ХХК 30 га талбайд 54,000 мод тарьж, авто замын хамгаалалтын зурваст 13,105 мод нэмж, нийт 71,289 модоор 36 га талбайг нэмэгдүүлсэн бөгөөд төлөвлөгөөг 92.3 хувийн гүйцэтгэлтэй биелүүлэв. Аяны үр дүнд аймгийн мод тарих талбай, байгууллагын идэвх оролцоо, ургалтын үзүүлэлт тасралтгүй өсөж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлж байна.	
262	Мэргэжлийн байгууллагатай хамтран ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 56 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх 2022–2030 он хүртэл ойн менежмент, стратегийн 28 чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулах аймгийн зорилтод хөтөлбөр баталсан.	100
263	Сайншанд, Замын-Үүд сумдад “Garden city” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Сайншанд, Замын-Үүд суманд “Garden City” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж, нийтийн эзэмшлийн газарт мод тарих ажлыг зохион байгууллаа. Сайншанд суманд нийт 6 байршилд 35 км зам дагуу 7 төрлийн 8,098 мод тарьж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн. Мөн шинээр 3 байршилд цэцэрлэгт хүрээлэн байгуулж 6,300 мод тарих төлөвлөлттэй ажилласан. Замын-Үүд сумын Сүлд багт “Найрамдалт цэцэрлэгт хүрээлэн”, “Гэр бүлийн талбай” болон авто замын хамгаалалтын 5 байршилд 10 төрлийн 10,172 мод тарьж, нийт 5 га талбайг ногооруулсан. Иргэд, аж ахуй нэгж, айл өрх,	100

								байгууллагын орчинд 8 төрлийн 12,238 мод тарьж, хашаан дахь ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Ингэснээр сумдын хэмжээнд хаврын тарилтаар нийт 21,350 модыг суулгасан байна.	
264	Ногоон байгууламжийн усалгааны систем байгуулах	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгааны системийг сайжруулах ажлын хүрээнд 7 сумын 27,48 га талбайд иж бүрэн усалгааны систем байгуулж, 4 гүний худаг гаргаж, 40 болон 20 тонны нөөцийн сав нэмэгдүүлэн, 4 иргэнийг цалинжуулан нийт 188,2 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Айраг суманд 2 га талбайд 75,9 сая төгрөгийн санхүүжилтээр хашаа, 1 худаг, усалгааны систем байгуулсан бол Алтанширээ суманд 1,5 га ойн зурваст 19,9 сая төгрөгөөр 1 худаг, 20 тонны нөөцийн сав суурилуулсан. Даланжаргалан суманд 6 га ногоон байгууламжид “Монголиан флюор спар” ХХК, “Зэт ди эл” ХХК 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай усалгааны систем хийсэн. Өргөн суманд “Эрдэнэс критикал мениралс” ТӨҮГ 2 иргэнийг цалинжуулж, “Хас прожект” ХХК 2 га талбайд 19,1 сая төгрөгөөр усалгааны систем, хашаа байгуулсан. Замын-Үүд суманд 0,6 га талбайд 16,8 км дуслын усалгааны систем байгуулж, Сайншанд суманд БНХАУ-ын Ерөнхий консулын санхүүжилтээр 800 м усалгааны систем, “Энержи парагон” ХХК 10 га талбайд 1 худаг, 40 тонны сав, иж бүрэн усалгааны систем байгуулсан. Мөн “Говийн тоорой төгөл” ХХК 5,0 сая төгрөгийн систем нийлүүлсэн.</p> <p>Эрдэнэ суманд 4.3 сая төгрөгөөр 2 га талбайд төвөөс ус татсан шугамаар 8 холболт хийж мод услах боломж бүрдүүлсэн. Ингэснээр аймгийн нийт ногоон байгууламжийн усалгааны хүчин чадал нэмэгдэж, усны хангамж сайжирч, иргэдийг цалинжуулан ногоон байгууламжийг тогтвортой арчлах нөхцөл бүрдсэн.</p>	100
265	Эко системийн тэнцвэртэй байдлыг хадгалахад үйл ажиллагаа, өөрийн хөрөнгөөр хувь нэмэр оруулсан	Иргэн, аж ахуй нэгж	тоо	2024	16	22	28	<p>Экосистемийн тэнцвэрийг хадгалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлд өөрийн хөрөнгөөр орчноо тохижуулсан 1 аж ахуйн нэгж, 13 иргэнийг урамшуулсан. “Хашаандаа 5 мод тарья” аяны хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 117.6 сая төгрөгийн санхүүжилт авч, Сайншанд, Даланжаргалан, Дэлгэрэх,</p>	100

	иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах							<p>Сайхандулаан сумын 240 өрхийн хашаанд 8 төрлийн 1,200 мод, Хилэнцтэй хөшөөний 4 га талбайд 6 төрлийн 200 мод тарьж ургуулсан. Даланжаргалан суманд 23 аж ахуйн нэгжийн дунд “Шилдэг ногоон байгууламжтай аж ахуйн нэгж” уралдаан зохион байгуулж, “Мак цемент” ХХК-ийг шалгаруулан шагнасан.</p> <p>Сайншанд суманд 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр орчны цэцгийн мандал байгуулж, мод тарьж ургуулсан 10 өрх, 3 иргэнийг батламж, мөнгөн шагналаар урамшуулсан. Эдгээр ажлын үр дүнд төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа сайжирч, ажиллах орчин болон орчны ногоон байгууламж нэмэгдсэн. Мөн 2 аж ахуйн нэгж, 26 иргэнийг урамшуулж оролцоог идэвхжүүлсэн.</p>	
266	“Нэг тонн баялаг-Нэг мод” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>“Нэг тонн баялаг-Нэг мод” хөтөлбөрийн хүрээнд 8 сумын 23 аж ахуй нэгж нийтийн эзэмшлийн 2 га талбайд 3,000 ширхэг, орчин тойрондоо 10,5 га талбайд 15,050 ширхэг, нийт 12,5 га талбайд 18,050 ширхэг мод, бут сөөг тарьсан. Алтанширээ суманд Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын талбайд 4,800 ширхэг, “Мандах дорнын Жонш” ХХК 500 ширхэг, “Эм И Ай Эл Интернэшнл” ХХК 4,000 ширхэг хайлаас тарьсан. Даланжаргалан суманд “Приеншип ресурсис” ХХК нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашааг, “Мак Цемент” ХХК төвлөрсөн хогийн цэгт ландфиллын ажил, “Кивен Инвэст” ХХК 6 га талбайд хашаа байгуулж, “Монголиан флюор спар” ХХК, “Зэт Ди Эл” ХХК 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар усалгааны систем ажиллуулж байна. Хөвсгөл суманд “Си Өү Эй Эл” ХХК нийтийн эзэмшлийн талбайд 1,500 ширхэг мод тарьж, 5,2 сая төгрөг зарцуулсан. Өргөн суманд “Ялгуун интернэшнл” ХХК 500, “Монцемент билдинг материалс” ХХК 1,000 мод тарьсан.</p> <p>Иххэт суманд 4 аж ахуй нэгж нийт 1,400 ширхэг мод тарьж, Мандах суманд 7 аж ахуй нэгж 1,200 ширхэг нийтийн эзэмшлийн, 3,150 ширхэг орчны мод, бут сөөг тарьж, сум орон нутгийн нийт талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, дүйцүүлэн хамгаалах</p>	100

								ажлыг дэмжиж, экосистемийн нөхөн сэргээлт, тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан.	
Эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн дундаж үнэлгээ:									92.5
ДӨРӨВ.ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО									
267	Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлж түүнд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	хувь	2024	90	92	92.8	<p>Хүний эрхийн төлөв байдлын тайлангаар хүний эрхийн боловсрол олгох, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, хүүхдийн эрхийг хангах гэсэн 3-н үндсэн асуудлыг цаашид анхаарч ажиллахаар тодорхойлсон бөгөөд ХЭҮК-оос ирүүлсэн чиглэл, зөвлөмж болон дээрх тулгамдсан 3-н асуудалд үндэслэн 6 зорилт, 41 арга хэмжээ бүхий жилийн төлөвлөгөөг боловсруулж, 92,8 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Хүний эрхийн нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ ХЭҮК-ын орон нутгийн ажилтан, Өмгөөлөгчдийн зөвлөл, Хууль зүйн туслалцааны төв болон сумдын хууль зүйн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон иж бүрэн мэдээлэл цуглуулж, үнэлгээний үр дүнд тулгуурласан арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үнэлгээгээр илэрсэн хүний эрхийн зөрчлийн суурь асуудлуудыг тодорхойлж, хамгааллын үйлчилгээг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан.</p> <p>1.2025 онд бүх нийтэд чиглэсэн хүний эрхийн боловсролыг тасралтгүй зохион байгуулж, давхардсан тоогоор 52,000 гаруй иргэнд сургалт, нөлөөллийн ажил, дунджаар 2,000 орчим иргэнд эрх зүйн зөвлөгөө, 350 гаруй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүллээ.</p> <p>2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, ус, агаарын бохирдлыг бууруулах, гамшгаас хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, инженерийн дэд бүтэц, хот тохижилтын салбарын хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэдийн амьдрах орчны чанарыг сайжруулсан.</p> <p>3.Хүүхдийг эрхийг хангах чиглэлээр: орон нутагт хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг</p>	100

								эрчимжүүлэх зорилгоор мэргэшсэн нэг өмгөөлөгчтэй гэрээ байгуулан ажиллуулж, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх тогтолцоог тогтвортой хэрэгжүүлэв. Төрийн байгууллагуудтай хамтран “Эерэг хандлага-Зөв дадал” нөлөөллийн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, орон нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулсны үр дүнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 23.7%, Насанд хүрээгүй хүний бэлгийн хүчирхийлэл 42% , Насанд хүрээгүй хохирсон хүний тоо 15.4%, Хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 76.1 хувиар тус тус буурсан үр дүнтэй байна.	
268	Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, чиглэлээр хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	6	7	14	<p>Хүний эрх, жендерийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, цахим орчин дахь ялгаварлал болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран орон нутгийн хэмжээнд дараах ажлуудыг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллав.</p> <p>Үүнд:</p> <p>1.Орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, хүний эрхийн хамтын ажиллагааг бэхжүүлэх асуудлаар санал солилцов. Уулзалтад ХЭҮК-ын Дорноговь аймаг дахь референт, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, ахмадын холбоо, эмэгтэйчүүдийн зөвлөл, тусгай хэрэгцээт иргэдийн байгууллага, үйлдвэрчний эвлэл, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл оролцсон бөгөөд орон нутгийн хүний эрхийн төлөв байдлын тайланг танилцуулж, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлээ тодорхойлов.</p> <p>Мөн соён гэгээрүүлэх ажлыг хамтран зохион байгуулах, хүний эрхийн нөхцөл байдлыг үнэлж хөндлөнгийн тайлан гаргах асуудлаар ойлголт өгсөн.</p> <p>2.Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ААНБ, холбоод, сайн дурын бүлэг, эмэгтэй удирдах албан тушаалтнуудын оролцоотой уулзалт зохион байгуулж, жендерийн эрх тэгш байдал, ажлын байрны ялгаварлалгүй орчныг бүрдүүлэх асуудлыг хэлэлцэв. Энэ уулзалтын хүрээнд жендерийн асуудлыг</p>	100

								<p>бодлогын түвшинд хөндөж, салбар хоорондын хамтын ажиллагааны боломжийг тодорхойлон байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх үр дүн гарсан.</p> <p>3.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг орон нутагт дэмжих хүрээнд Замын-Үүд суманд “Хүний эрхийн өдөрлөг” зохион байгуулж, иргэдэд хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн талаар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, хяналт шалгалтын ажил хийх зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэв.</p> <p>4.Орон нутгийн хэмжээнд хүний эрхийн чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын тоо цөөн, үйл ажиллагаа идэвхгүй байгаа нь тулгамдсан асуудал тул Монголын эмэгтэйчүүдийн холбооны Дорноговь салбартай хамтран “Иргэний нийгмийн байгууллага ба хамтын ажиллагаа” уулзалтыг зохион байгуулж, цахим орчинд иргэдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг хамтран зохион байгуулсан.</p> <p>2025 онд нийт: 3 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, 1 удаагийн хүний эрхийн өдөрлөг, 10 гаруй төрлийн мэдээлэл, сурталчилгааны ажил хийгдсэн бөгөөд нийтдээ 14 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлж хүний эрх, жендерийн тэгш байдлыг олон нийтэд ойлгуулах, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог сэргээж идэвхжүүлэх, төр–хувийн хэвшил–ТББ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр бодит ахиц гарч,хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоонд иргэний нийгмийн оролцоо нэмэгдүүлсэн үр дүнтэй байна.</p>	
269	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд эрх зүйн боловсрол олгох сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	0	2	4	<p>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд, аж ахуйн нэгжид эрх зүйн боловсрол олгох ажлын хүрээнд 2025 онд сумдын Хууль, эрх зүйн мэргэжилтнүүдтэй хамтран дараах арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Үүнд: “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль” болон “Өрсөлдөөний тухай хууль”-ийн гол агуулга, иргэдийн өдөр тутмын хэрэглээнд хэрхэн хэрэгжих талаар 1300 гаруй иргэнд зориулсан сургалт зохион байгуулж, хэрэглэгчийн эрх, үүрэг, хууль</p>	100

								<p>тогтоомжийн шаардлагыг тайлбарласан гарын авлага, товхимол тарааж, иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 75 иргэн, аж ахуй нэгжийн худалдаалах үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний чиглэлийн улсын байцаагч холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд гарал үүсэл нь тодорхойгүй, шинжилгээ баталгаажилтгүй хаяг шошгын зөрчилтэй хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хил гүний боомтоор нэвтрүүлэн дотоодын хүнсний сүлжээнд нийлүүлж буй зөрчил нийт зөрчлийн 60 хувийг эзэлж байна.</p> <p>Шалгалтаар чанар аюулгүй байдлын шаардлага хангахгүй, хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн, буруу шошголсон шошгын мэдээлэл шаардлага хангаагүй зэрэг 265 нэр төрлийн 2519 ширхэг бүтээгдэхүүний зөрчлийг илрүүлэн устгалд оруулсан. Мөн зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгжүүдэд цаашид дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж чиглэлийг хүргэж ажилласан.</p> <p>Легал гайд өмгөөллийн фирмтэй хамтран орон нутгийн худалдаа, үйлчилгээний байгууллагын 60 гаруй ААНБ-ын төлөөллийг оролцуулж, хэрэглэгчийн эрхийг зөрчих эрсдэл, хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарал хандуулах, гэрээ хэрхэн байгуулах асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нийт 4 арга хэмжээ зохион байгуулж, 6850 орчим иргэдэд эрх зүйн боловсрол олгосон.</p>	
270	Иргэдийг улс төрийн эрхээ эдэлснийх нь төлөө хууль бусаар мөрдөн хавчихгүй, үндэслэлгүйгээр хариуцлагад татахгүй байх талаар	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	0	2	2	<p>Аймгийн хэмжээнд 2025 онд иргэдийн улс төрийн эрхийг хамгаалах, хууль бус мөрдөн хавчих, үндэслэлгүй хариуцлагад татахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүний эрхийн Үндэсний Комисс, Прокурорын газар, Цагдаагийн газар, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 1,500 орчим иргэдийн улс төрийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүллсэн. Мөн дээрх чиглэлээр холбогдох байгууллагуудад 2 удаагийн зөвлөмж өгч, иргэдийн эрхийг хамгаалах,</p>	100

	мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах							хууль бус мөрдөн хавчих, үндэслэлгүй хариуцлагад татахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлсэн. Дээрх чиглэлээр иргэдээс гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй бөгөөд аймгийн хэмжээнд улс төрийн эрхийн зөрчил бүртгэгдээгүй байна.	
271	Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Хамтран ажилласан ИНБ-ын тоо	Тоо	2024	2	4	5	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2025 А/44, А/47, А/48 дугаар захирамжаар Ахмадын хороонд 70,4 сая төгрөг, Улаан загалмайн хороонд 20,0 сая төгрөг, Монголын эмэгтэйчүүдийн холбооны Дорноговь аймаг дахь салбарт 10,0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Аймгийн Ахмадын хороо 2025 онд аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулж, холбогдох хууль журмын хүрээнд ахмадууд, эмэгтэйчүүд, олон нийтэд чиглэсэн хүмүүнлэгийн болон нөлөөллийн 26 арга хэмжээг зохион байгуулж 2437 ахмадыг хамруулсан. Улаан загалмайн хорооноос нийгэмд тустай хүмүүнлэгийн 10 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 500 иргэнийг хамрууллаа. Иргэний нийгмийн байгууллагын 2 төлөөллийг үнэлгээний хороо, 3 төлөөллийг хяналт шалгалтын ажлын хэсэгт оруулж хамтран ажилласан. “Легал гайд” хуулийн фирмтэй хамтран “Хуульч Мазаалай” өдөрлөг зохион байгуулж, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, сурагчдад иргэний эрх зүйн мэдлэг олгох үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж 1000 гаруй иргэнийг мэдээллээр ханган ажилласан.	90
272	Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагын архинд донтох өвчнийг эдгэрүүлэх болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	0	2	3	Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан архинд донтох өвчнийг эдгэрүүлэх нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий “Мэргэжилтний баг”-ийн 4 гишүүнийг 2025 оны 6 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд Оросын Холбооны улсад туршлага судлуулах сургалтад хамруулж, орон нутгийн төсвөөс 2.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн архинд донтох өвчнийг эдгэрүүлэх чиглэлээр амжилттай үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг олон нийтэд	100

	байгаа нөхөрлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хамтран ажиллах чиг үүрэг бүхий "Мэргэжилтний баг"-ийг чадавхжуулах сургалт зохион байгуулах							сурталчлах, хамтран ажиллах чиглэлээр нөлөөллийн самбар, зурагт хуудас хэвлүүлэн байршуулахад 4,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, Сайншанд, Замын-Үүд сумдад оршин суух хаягтай архидан согтуурч, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг, архины хамаарал бүхий 58 иргэнд АА бүлгийн 2 гишүүнтэй хамтран нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа "Албадан эмчилгээ" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд архины хамааралтай 19 иргэнийг эмчийн үзлэг, оношилгоонд хамруулж, 8 иргэнийг албадан эмчилгээнд хамруулахаар холбогдох шийдвэрийг гаргуулснаас гадна архины хамааралтай эрсдэлт нөхцөлд амьдардаг 7 иргэнийг албадан эмчилгээнд хамруулсан.	
273	Архины хамааралтай иргэдийн тоог бууруулах зорилгоор АА бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	2	3	3	"Мэргэжилтний баг"-ийн 2025 оны ажлын төлөвлөгөөг 2 зорилт, 10 арга хэмжээтэйгээр төлөвлөн 82.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжилтийг ханган ажилласан. Архинд донтох өвчтэй хүмүүст болон тэдний гэр бүлийн гишүүдэд туслах, сайн дурын үндсэн дээр анх байгуулагдан амжилттай үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөлүүдийг үйл ажиллагааг сурталчлах, алба хаагчид болон иргэдийг хамруулах, архи, согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлах зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг агентлаг, байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргаас чиглэл хүргүүлж, төлөөлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээний шалгуур үзүүлэлт болгон дүгнэхээр шийдвэрлэсэн. 2025 оны эхний 10 сарын байдлаар 65 иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт архины донтох өвчний оношилгоо, сэтгэл заслын эмчилгээнд хамруулсан.	100
274	Төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, идэвх оролцоог сайжруулах нөлөөллийн арга хэмжээг хийх	Чадавхжуулсан ИНБ-ын тоо	Тоо	2024	1	2	8	Төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, идэвх оролцоог сайжруулах зорилгоор аймгийн Улаан загалмайн хороон дарга, 7 гишүүнийг Хэнтий, Дорнод аймагт зохион байгуулагдсан туршлага судлах уулзалтад хамруулсан.	90

							<p>Мөн 14 сумдын анхан шатны хороотой хамтран ажиллах гэрээ байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Дорноговь аймгийн онцгой байдлын газар, Дорноговь аймгийн Улаан загалмайн Дунд шатны хороо, АШУҮИС-н Улаан загалмайн Анхан шатны хороонууд хамтран Газар хөдлөлтийн аюулын талаарх мэдлэгийг иргэдэд түгээх зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, "Монгол хүн ба эрсдэлийн боловсрол", Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сурталчлан таниулсан.</p> <p>Хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах зорилгоор 60 иргэнийг хамруулан сургалт зохион байгуулсан.</p> <p>Аймгийн Ахмадын хорооны 19 гишүүдийг чадавхжуулах, ижил төстэй байгууллагуудтай холбож, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Эрээн хотын ахмадын хороотой туршлага судлах уулзалтад аймгийн Засаг даргын захирамжаар 6,7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Аймгийн ахмадын хорооноос 26 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 2437 ахмадыг хамруулсан. Улаан загалмайн хорооноос нийгэмд тустай хүмүүнлэгийн 10 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 500 иргэнийг хамруулсан.</p> <p>Мөн аймгийн эмэгтэйчүүдийн холбооноос 100 малчин эмэгтэйг "Уур амьсгалын өөрчлөлтөд-малчин эмэгтэйчүүд" зөвлөгөөнд хамруулсан.</p> <p>"Говь Консалтинг" болон "Их Говийн Хөгжлийн Гарц" ОНӨААТҮГ байгууллагуудын дүрмийг шинэчлэн боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулан, захирлуудыг томилж үйл ажиллагааг нь шинээр эхлүүлсэн бөгөөд эдгээр байгууллагуудын эрх зүйн орчин, дотоод зохион байгуулалтыг бэхжүүлэхэд болон төсөв санхүүгийн хувьд тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадавхжуулахад анхаарч ажилласан.</p> <p>Эдгээр байгууллагуудын удирдлага, төсөл боловсруулах, санхүүгийн тайлагнал гаргах чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсанаас гадна</p>
--	--	--	--	--	--	--	---

								туршлагатай зөвлөн туслах баг авч ажиллуулан, тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн. 2025 онд хэрэгжсэн энэхүү чадавхжуулах үйл ажиллагаа нь иргэний нийгмийн байгууллагуудын тогтвортой хөгжил, орон нутгийн хөгжилд идэвхтэй оролцох чадварыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаагаас гадна энэхүү үйл ажиллагааны хүрээнд төр болон хувийн хэвшлийн түншлэлийн боломжийг нэмэгдүүлж, хамтран төсөл хэрэгжүүлэх, санхүү, туршлага солилцох замаар байгууллагуудын хүчин чадлыг өргөжүүлэх суурь нөхцөлийг бүрдсэн. Тайлант онд 2 төрийн бус байгууллагын 26 гишүүнийг чадавхжуулж, 39 арга хэмжээг зохион байгуулж, 3097 иргэнийг хамрууллаа.	
275	Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг технологийг ашиглан олон нийтэд нээлттэй, ил тод болгон, шилэн ажиллагааг үргэлжлүүлэх	Шилэн ажиллагааны мэдээллийн гүйцэтгэл	Хувь	2024	60	80	91.2	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд хангаж ажиллах зорилтын хүрээнд нийт 135 төрийн байгууллага тайлан мэдээг төрийн мэдээллийн нэгдсэн shilen.gov.mn системд илгээсэн. Шил ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд сургалт, мэдээллийн 4 удаагийн арга хэмжээг аймгийн "ХУРДАН" төвтэй хамтран зохион байгуулан нийт 345 төрийн албан хаагчдад мэдээллийн системийн ашиглалт, ил тод байдлын талаарх мэдлэг ойлголтыг хүргэсэн. Түүнчлэн Засгийн газрын 08 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчдын 2024, 2025 оны гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг нийтийн мэдээллийн системд байршуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нийт 46 байгууллагын 343 төрийн захиргааны албан хаагчдын мэдээллийг байршуулан ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх зорилгоор https://dornogovi.gov.mn/ албан ёсны цахим сайт болон shilen.gov.mn системд улирал бүр шинэчлэн байршуулж, 2025 оны бодлогын баримт бичиг 37, захирамжийн баримт бичиг 602, албан даалгавар 6, цаг үеийн мэдээ 120, хүний нөөцийн мэдээлэл 57, тендер худалдан авах ажиллагааны мэдээлэл 4, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан</p>	100

								мэдээ 10, төсөв санхүүгийн ил тод байдлын мэдээ 5 нийт 841 төрлийн мэдээллийг хуулийн хүрээнд байршуулан shilen.gov.mn системийн жилийн эцсийн үнэлгээгээр 91.2 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.2 хувиар өссөн байна.	
276	Иргэдийн онцлог байдалд тулгуурлан мэдээлэл түгээх төрөл бүрийн арга хэлбэрийг ашиглан олон нийтийг цогц мэдээллээр хангах	Мэдээлэл хүлээн авч буй иргэд	Тоо	2024	12000	20000	72000	Иргэдэд төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг тогтмол хүргэх, мэдэх эрхийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд орон нутгийн 2 телевиз, 2 сонин, 1 сайт, иргэдийн цахим хэрэглээнд тулгуурлан Засаг даргын эрхлэх хүрээний асуудлын 26 агентлаг байгууллага, 14 сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын фейсбүүк цахим хаяг /www.dornogovi.gov.mn/, /https://www.facebook.com/DGZDTG/ зэрэг нийт 46 төрлийн мэдээллийн сувгаар дамжуулан 7 хоногт 8-10 төрлийн төрийн үйл ажиллагааны мэдээллийг иргэд олон нийтэд шуурхай хүргэж, мэдээллийн хандалтаар 2025 онд давхардсан байдлаар 72000 гаруй иргэнд хүргэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 хувиар өссөн байна.	100
277	Төрийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо, хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулах	Цахим хуудастай төрийн байгууллагын тоо	Тоо	2024	40	45	138	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 208 дугаар тогтоолын дагуу орон нутаг дахь Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын хүрээнд 2025 онд төрийн мэдээллийн нэгдсэн (www.gov.mn) систем, албан ёсны цахим хуудастай нийт 138 байгууллага үйл ажиллагааны мэдээллээ хуулийн дагуу байршуулан ажилласан. Цахим орчин болон үүрэн телефоны үйлчилгээг ашиглан иргэдийн оролцоог сайжруулах, санал хүсэлт ирүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд 4 төрлөөр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч 2025 онд аймгийн ЗДТГ-ын 7723-1111 тусгай дугаараар 21, албан ёсны www.dornogovi.gov.mn цахим хаягт 3, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 тусгай дугаарт 161, тухайн байгууллагын утсаар 13, цахим хаягаар хандсан 54 нийт 252 санал хүсэлтийг хүлээн авч, 94,3 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна.	100

								<p>Төрийн үйлчилгээнд технологийн шинэчлэлтийг нэвтрүүлэх зорилгоор 2025 онд ЦХИХХЯ-ны 140 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн 12 суманд төрийн үйлчилгээний төвлөрсөн үйлчилгээ бүхий КИОСК машиныг шинээр олгож, давхардсан тоогоор 12358 иргэнд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажилласан. Иргэдийн цахим ур чадвар, технологийн ашиглалт, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх V аян"-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, аймгийн "ХУРДАН" төвийн зөвлөгөө, мэдээлэл хүргэх явуулын үйлчилгээгээр дамжуулан 663 иргэнд төрийн мэдээллийн нэгдсэн систем ашиглан мэдээллэл хүлээн авах, үйлчилгээ авах заавар, зөвлөмжийг хүргэсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 138 төрийн болон төрийн өмчит байгууллага албан ёсны цахим хуудас ашиглаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 98 байгууллагаар нэмэгдсэн.</p>	
278	Төрийн худалдан авах ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх	Хамтран ажилласан иргэн, аж ахуй нэгжийн тоо	Тоо	2024	4	5	7	<p>"Чандмань-Илч" ОНӨХХК нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07/03 дугаар тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн сонгон шалгаруулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 иргэнийг томилсон. Шинээр байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөл 2 удаа хуралдан, эхний хуралдаанаар орон тооны нарийн бичгийн ажилтныг сонгон шалгаруулж томилсон. Хоёрдугаар хуралдаанаар Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг, компанийн өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, гишүүд үүрэг чиглэл өгсөн.</p> <p>"Замын-Үүд" НААҮ ОНӨХХК нь хараат бус гишүүний сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 07–08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх төлөвлөгөөтэй байна. Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд 4 иргэний төлөөлөл оролцож, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.</p>	100

279	Иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	Хувь	2024	81.2	90	94.3	<p>Аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бичгээр, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7723-1111 тусгай дугаар, http://dornogovi.gov.mn/ цахим хуудас, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан нийт 4 сувгаар хүлээн авч байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг бичгээр 2089, утсаар 31, цахимаар 57, 11-11 төвөөр дамжуулан 161, нийт 2338 хүлээн авч, шийдвэрлэлт 94.3 хувьтай бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад шийдвэрлэлт 12.2 хувиар өссөн.</p> <p>Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийн санал, хүсэлтийг шуурхай хүлээн авах хүрээнд “One call” үйлчилгээг нэвтрүүлж, тусгай дугаараар рекорд болон ажлын бус цагаар voice-оор дамжуулан Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар, Татварын газар, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг 25 төрийн байгууллагын үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.</p>	100
280	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, бүх төрлийн соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил хийж, авлигыг мэдээлэх, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, хариуцлага нэхэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга	сургалтад хамрагдсан иргэдийн тоо	тоо	2024	3000	3500	3880	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор шинээр томилогдсон удирдах албан тушаалтнууд, хувийн хэвшил, ТББ-ын төлөөлөл, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын ажилтан, эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан 6 удаагийн сургалт зохион байгуулж нийт 3,500 иргэн, 380 гаруй албан хаагчийг хамруулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүлээлгийн танхимд 14.2 сая төгрөгийн үнэ бүхий цахим ухаалаг дэлгэцийг байршуулж, интернэт сүлжээнд холбосноор иргэд хүссэн мэдээллээ авч, санал хүсэлт өгөх, авлигыг мэдээлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Цахим дэлгэцээр орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ, авлигаас урьдчилан сэргийлэх тухай тусгай дугаар, шторк мэдээллийг тогтмол сурталчлан ажилласан.</p>	100

	хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах								
281	Шударга байдлын үнэлгээг хийж хамгийн бага оноо авсан байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэн хяналт тавин хамтран ажиллах	Төлөвлөгөөний гүйцэтгэл	Хувь	2024	0	100	80	<p>Авлигатай тэмцэх газраас жил бүр хийдэг “Шударга байдлын үнэлгээ”-ний судалгаанд 2023 онд 73,0 оноо, 2024 онд 77,4 оноогоор 21 аймгаас эхний 2 дугаарт эрэмбэлэгдсэн нь орон нутгийн хэмжээнд шударга, хариуцлагатай байдал нэмэгдэж, төрийн байгууллага, албан тушаалтны авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангахад ахиц гарсан.</p> <p>Орон нутгийн түвшинд шударга байдлыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэх, төрийн албан хаагчдын харилцаа, ёс зүйд чиглэсэн нэгдсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж үнэлгээний хорооны ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, нийт 820 албан хаагчийг хамруулснаас гадна 14 сум, агентлаг, байгууллагын давхардсан тоогоор 3620 гаруй албан хаагчид авлигаас татгалзах, авлигын эрсдэлийг бууруулах талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд 41 байгууллага нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж байгаа бөгөөд аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-с жилд 2 удаа төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.</p>	80
282	Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөний санал, санаачилгыг дэмжин ажиллах	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	0	2	2	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжих, иргэний нийгмийн байгууллага, сайн дурын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр орон нутгийн ТББ, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн 30 гаруй төлөөллийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрт оролцогчдыг сонгон шалгаруулах үйл</p>	100

								ажиллагааны ажлын хэсэгт дээрх байгууллагуудын төлөөллийг оролцуулан, орон нутгийн ИТХ-ын хуралдаан болон бусад шийдвэр гаргах үйл ажиллагааг орон нутгийн телевизээр шууд дамжуулан ажилласан.	
283	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийн мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	0	2	2	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор шинээр томилогдсон удирдах албан тушаалтнууд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөлөл, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагч, эрх бүхий албан тушаалтнуудад 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 380 гаруй албан хаагчид, 1800 гаруй иргэдэд 14 удаагийн мэдээллийг хүргэн ажилласан.</p> <p>Түүнчлэн авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах “ТОВШ”-аппликэйшн, гомдол мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаар, авлигын хор хөнөөлийг таниулах бүх төрлийн шторк мэдээллийг байгууллагын цахим хаягаар сурталчлан ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүлээлгийн танхимд байршуулсан ухаалаг дэлгэцээр дамжуулан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ, үйл ажиллагааг видео бичлэг байдлаар хүргэж, авлигыг мэдээлэх тусгай дугаар, авлигаас урьдчилан сэргийлэх шторк мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна.</p> <p>Мөн дээрх дэлгэцийг интернэт сүлжээнд холбож иргэд хүссэн мэдээллээ авах, санал хүсэлт гаргах боломжийг бүрдүүлсэн.</p>	100
284	Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	0	2	6	<p>Насан туршийн суралцахуйн төв нь ЮНЕСКО-н "Суралцагч хот" хөтөлбөрийг орон нутгийн онцлолт тохируулан "Суралцагч аймаг-суралцагч иргэн" хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх-хүүхэд хүмүүжлийн эерэг арга 8 модуль сургалтыг насан туршийн суралцахуйн 13 нэгжтэй хамтран 7 төрлийн нөлөөллийн ажил, 5 төрлийн уралдаан тэмцээн, 64 төрлийн рилл контент бэлтгэн нийт 254 удаагийн давтамжтай явуулж 24800 иргэнд хүрч ажилласан нь өмнөх оныхоос 1,5%-иар өссөн.</p> <p>“Өгөх урлаг” ТББ-тай хамтран “Боловсролоор үлгэрлэе” төсөл арга хэмжээний хүрээнд ар гэрийн</p>	100

								<p>анхаарал сул, гэмт хэрэг зөрчилд холбогдох эрсдэлтэй 14-18 насны 30 хүүхдэд сэтгэл зүйчийн үйлчилгээ, “Амар тайван гэр бүл” арга хэмжээний хүрээнд 5197 суралцагч, 8600 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшил, зөв дадал хэвшил бий болгох нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан.</p> <p>Аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран Сайншанд сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад “Ёс зүй, ёс суртахуун-Ил тод байдал” нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, АТГ-ын гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарт хүүхдүүдээс авч буй санал, асуулга судалгааны талаар танилцуулсан.</p>	
285	<p>Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах</p>	<p>Зохион байгуулсан ажил</p>	Тоо	2024	8	10	28	<p>Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2025 онд хэрэгжүүлэх 12 дэд бүлэг 51 заалт бүхий төлөвлөгөөг батлан, улирал тутам хуралдан төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл, шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. Аймгийн хэмжээнд нийт 18 олон нийтийн цагдааг чиг үүргийн дагуу ажиллуулж тэдгээрийн урамшуулалд 225,9 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Аймгийн Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр байгууллагын “Дүн шинжилгээ, судалгааны багийг 3 удаа хуралдуулж, тус аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, өссөн гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээний талаар 12 үүрэг чиглэлийг холбогдох газруудад өгч ажилласан.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор орон төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 28 төрлийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж 61 төрлийн видео контент,</p>	100

								geel, богино хэмжээний бичлэг мэдээлэл, 300 гаруй төрлийн зурагт хуудас байршуулж 231817 иргэний зэрэг хандалт авсан. Дээрх арга хэмжээний үр дүнд 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 653 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс /715/ 62 нэгжээр буюу 8,7 хувиар буурсан.	
286	Зам тээврийн осол гэмтлээс, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	4	6	11	Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Уусан бол бүү жолоод”, “Шугаман эргүүл, цагийн менежмент”, “Гэрэл-Хууль бус тээвэр-Бүс”, “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025”, “Дүрмээ мөрдье”, “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Хичээл эхэллээ”, “Булан бус торгууль төлөлт”, “Сигнал 1,2”, “Мотоцикл ба хамгаалах малгай”, “Өвлийн дугуй” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн 11 арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, иргэдийн мэдлэг, дадлыг дээшлүүлэх зорилгоор “Моодыг дэлгэрүүлэгч” ТББ-тай хамтран “Бүсний мангас” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж Сайншанд сумын ЕБС-иудын 400 гаруй суралцагчийг оролцуулж, мэдээллийг олон нийтэд түгээсэн. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд мэдээллийн зурагт хуудас, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээн, “Гэрэлт гарц” хийх, Гэмт хэрэг, зөрчлийг баримтжуулах чиглэлээр дрон худалдан авах, тэмдэглэл тодруулах зэрэг ажлуудад зориулан орон нутгийн төсвөөс 74.7 сая төгрөг зарцуулсан бол нийт 10802 зөрчил илрүүлж, 1,085,735,000 төгрөгийн торгууль оногдуулан ажилласан. Зам тээврийн осол 2025 оны эхний 10 дугаар сарын байдлаар 32 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.9 хувиар буурсан.	100
287	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	6	8	8	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, далд үйлдэгдэж буй хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарын аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдийг дахин энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Амар	100

	<p>сэргийлж мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах</p>						<p>тайван гэр бүл”, “Хүчирхийллийг зогсооё”, “Сум, багийн-Хяналт”, “Эерэг хандлага-Зөв дадал” зэрэг нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулан үр дүнг тооцож ажиллалаа.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтыг зохион байгуулж, 22 нийгмийн ажилтныг гэр бүлийн сургагч багшаар бэлтгэсэн.</p> <p>Аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр гэр бүлийн сургагч багш нар 14 суманд 37 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 15,000 орчим эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалагчийг хамруулан хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлж, хүүхэд хүмүүжлийн эерэг хандлагыг төлөвшүүлсэн.</p> <p>Салбар дундын уялдаа холбоо, үр нөлөөг сайжруулах зорилгоор “Асран хамгаалагчийн үүрэг оролцоо”, “Хамтын шийдэл-Үр дүнд суурилсан хариу үйлчилгээ” сэдэвт чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулж нийт 27 хамтарсан багийн 165 гишүүнийг хамруулсан бөгөөд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үеийн журам, арга зүйг бодит нөхцөлд хэрэгжүүлэх аргачлал эзэмшсэн.</p> <p>Мөн насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх зорилгоор “Утаат болон электрон тамхины хор уршиг”, “Цахим орчны хэрэглээ”, “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, аюулгүй байдал” сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 22 сургуулийн ахлах, дунд ангийн 4500 сурагч, 1800 эцэг эх, асран хамгаалагч, Политехник коллежийн 550 оюутан, 56 багш ажилчид, “Өөрчлөлийг өөрөөсөө” сургалтад 975 иргэнийг тус тус хамруулан зохион байгуулсан.</p> <p>Мөн сум, багийн хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд эрийн эргэлтийг долоо хоног бүр зохион байгуулж, эрсдэлт нөхцөлд байгаа 60 хүүхдийг илрүүлэн, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хоол</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

								<p>хүнсний дэмжлэг олгох, боловсролын үйлчилгээнд хамруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор хүүхдэд үл хайхрах, хүчирхийлэл үйлдсэн 1 иргэний эх байх эрхийг шүүхийн шийдвэрээр хасаж, 4 эцэг эх, асран хамгаалагчийг Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 100,0 мянган төгрөгөөр торгож, холбогдох арга хэмжээг авсан.</p> <p>Тайлант хугацаанд 8 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 42567 эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийг хамруулсан.</p>	
288	Бүх нийтийн кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	2	4	4	<p>Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, цахим болон залилах төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийн талаарх иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Бүх нийтийн кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээний төлөвлөгөө" гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Кибер халдлагаас сэргийлэх, байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудын удирдлагуудад мэдээлэл хүргэж ажилласан. "Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх алба"-наас цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр бэлтгэсэн бичлэг болон зурган 113 постер мэдээллийг "Дорноговь аймгийн цагдаагийн газар" цахим пейж хаяг болон "Дорноговь аймгийн цагдаагийн газар", "Замын-Үүд цагдаа" facebook цахим хаягт байршуулан иргэд олон нийтэд түгээлт хийн ажилласан. Мөн Цагдаагийн ерөнхий газраас "Өнөөдөр сонго, маргааш бүтээцгээе" уриан дор зохион байгуулсан "Нээлттэй хаалганы өдөр" өдөрлөгийн хүрээнд "цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сэдэвт мэдээ мэдээллийг 400 гаруй иргэнд хүргэж ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим орчинд Дорноговь нэршилтэйгээр үйл ажиллагаа явуулж буй 95 цахим группийн судалгааг гарган, админуудтай хамтран нийт хуурамч 4189 фейсбүүк цахим хаягийг бандаж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байж болзошгүй 8414 пост</p>	100

								мэдээллийг устгаж, 11354 постыг нийтлэхээс татгалзаж, иргэдээс репорт хийсэн 49556 пост болон сэтгэгдэлд хяналт тавьсан. Аймгийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 114 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46 нэгжээр буюу 71,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
289	Шүүх шинжилгээний байгууллагад техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг	Тоо	2024	0	2	2	Шүүх шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмжийг сайжруулж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2025 онд 12,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор 50,0 сая төгрөгийн дэмжлэгийг нэмэлтээр олгож, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан.	100
290	Аюулгүй орчныг бий болгох камерын нэгдсэн системийг үе шаттайгаар шийдвэрлэх	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	2	3	3	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 86 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын А/64, А/748 дугаар захирамжийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Теле камерын хяналтын дэд төвийг байгуулж, дарга, ерөнхий инженер, сүлжээний инженер 2, системийн инженер 2 нийт 6 орон тоотойгоор үйл ажиллагааг эхлүүлсэн. Төвийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд орон нутгийн төсвөөс санхүүжилт хийж, 56 нэр төрлийн 234 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангасан. Мөн Сайншанд суманд камерын хяналт, удирдлагын нэгдсэн системийг орон нутгийн төсвийн 1,349 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Прожект девелопмент тотал сольюшн” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2024-2025 онд дуусгахаар ажиллаж байна. Тус ажлыг гүйцэтгэснээр суурьшлын бүсийн камерын тоо 3 дахин нэмэгдэж, серверийн орчинд ухаалаг удирдлагын программ хангамж суулгах, камеруудаас ирэх дүрсийг нэг цэгт төвлөрүүлэх холболт хийх зэрэг үндсэн тохиргоо хийгдэж, бүх	100

								камерын мэдээллийг төвлөрүүлэн удирдахаар ажиллаж байна.	
291	Төрийн архивын баримтын аюулгүй байдал, баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлэх	Цахимжуулсан баримтын хадгаламжийн нэгжийн тоо	Нэгжийн тоо	2024	524	550	565	Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, эх баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тасралтгүй үргэлжүүлж ажилласан. Энэ хүрээнд мастер хувь үйлдсэн 350 хадгаламжийн нэгж, 26 946 хуудас баримтыг фотошоп программын тусламжтайгаар засварла хамгаалалтын хувь үйлдэж, цахим программд тодорхойлон ашиглахад бэлэн болгосон.	100
			Хуудасны тоо	2024	5472	7520	78074	Цахимжуулалтын үр дүнг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 257 хадгаламжийн нэгж, 43 531 хуудас баримтаар өссөн нь архивын баримтыг илүү бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, цахим хэлбэрээр ашиглах боломжийг нэмэгдүүлсэн эерэг үр дүнтэй байна.	
292	Төрийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэх.	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	10	20	30	Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагын бүтцийг шинэчлэн тогтоосон. Тус тогтоолын хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны А/232 дугаар захирамжийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, төрийн хяналт шалгалт болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийг шинээр байгуулж, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн чиг үүрэг, нэршлийг шинэчлэн өөрчилж, ажлын ачааллын тэнцвэрийг хангах үүднээс хоёр албан тушаалыг шинээр бий болгож баталгаажуулсан. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар зэрэг 7 агентлаг, байгууллагын бүтцийг харьяа яам, агентлагаас шинэчлэн баталсан. АТТ-ыг батлах зөвшөөрлийг ТА3-өөс олгосны дагуу	100

								<p>томилох эрх бүхий албан тушаалтан 36 төрийн захиргааны албан тушаалыг шинэчлэн баталсан.</p> <p>Тайлант хугацаанд аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн төсвөөс санхүүждэг агентлаг, төсөвт байгууллагуудын чиг үүргийн шинжилгээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөж, тус ажлын хүрээнд Удирдлагын академийн зөвлөх үйлчилгээний багтай хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлж эхэлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүд болон сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг хамруулсан нийт 30 албан хаагчийн “Чиг үүргийн шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Цаашид аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, аймаг болон сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын чиг үүрэг, бүтэц, орон тоонд Удирдлагын академитай хамтран нарийвчилсан шинжилгээ хийх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 30 хувийн хэрэгжилттэй байна.</p>	
293	<p>Дорноговь аймгийн “Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөр” үргэлжлүүлэн хэрэгжүүлэх</p>	<p>Нийгмийн баталгаагаар хангасан төрийн албан хаагч</p>	Тоо	2024	159	220	300	<p>Тайлант хугацаанд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, урамшуулал, дэмжлэгийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд сумдын болон агентлаг, төсөвт байгууллагуудын албан хаагчдад 5 жилийн урамшууллыг 10 албан хаагчид 85.6 сая төгрөг, сургалтын төлбөрийн дэмжлэгийг 45.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Зэрэг дэвийн нэмэгдлийг 95.9 сая төгрөгөөр олгож, хоолны хөнгөлөлтийг 14 сум, 27 агентлаг байгууллага, нийт 41 байгууллага 10,000-20,000 төгрөгөөр олгож байна. Мөн 92.1 сая төгрөгийн хоол унааны хөнгөлөлт, ур чадварын нэмэгдэл, эрүүл мэндийн үзлэг, орон сууцны дэмжлэг зэрэг дэмжлэг үзүүлсэн. Үүнээс гадна Хүнс, хөдөө аж ахуйн газрын</p>	100

								<p>туслах аж ахуйгаас 16 толгой малыг хөнгөлөлттэй үнээр олгож дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хөтөлбөрийн цар хүрээнд нийт 300 гаруй төрийн албан хаагчид дэмжлэг, урамшуулал, тусламж олгосон. Хөтөлбөрийн хэрэгжилт нь төрийн албан хаагчдын тогтвор суурьшил, ажиллах таатай орчин, нийгмийн баталгааг сайжруулсан.</p>	
294	<p>“Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад анх удаа орон сууц худалдан авах, барихад нь зориулж дэмжлэг үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх</p>		Тоо	2024	47	100	157	<p>Хөтөлбөрийн хүрээнд төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллаж буй албан хаагчдыг орон сууцанд ороход дэмжлэг үзүүлэх зорилгоор түрээсийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцанд орууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор мэргэжлийн боловсон хүчнийг татан ажиллуулах болон орон сууцны дэмжлэг үзүүлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлж байна. 5 жилийн гэрээгээр 10 багш, 10 эмч ажиллуулах төлөвлөгөөнөөс боловсролын салбарт 5 багш, удирдах ажилтан, эрүүл мэндийн салбарт 8 эмч, тоног төхөөрөмжийн инженер буюу нийт 13 нарийн мэргэжлийн ажилтныг урилгаар ажиллуулж, үнэ төлбөргүй орон сууцаар хангасан.</p> <p>Түрээсийн орон сууц хөтөлбөрийн эхний ээлжийн 105 айлын орон сууцаас зорилтот бүлгийн багш, эмч, сувилагч зэрэг нийт 47 төрийн албан хаагчийг хамруулсан.</p> <p>2025 онд “Түрээсийн орон сууц” хөтөлбөрөөр ОБГ, ЦГ, Чандмань-Илч, ШШГГ, Нэгдсэн эмнэлэг болон бусад байгууллагын 16 ажилтан албан хаагч, Хатанбулаг суманд 33, Хөвсгөл суманд 20 албан хаагчийг төрийн албан хаагчийн орон сууцанд хөнгөлөлттэй үнээр, Замын-Үүд сумын “Мандах наран-6” хорооллын 288 айлын орон сууцаас 39 айлыг төрийн албан хаагчдад түрээсийн хэлбэрээр олгож, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлсэн. Мөн дотрын болон хавдрын нийт 2 эмчийг Улаанбаатар хотоос урьж, орон нутагт ажиллуулах зорилгоор аймгийн Засаг даргатай “Тусгай зориулалттай бэлэглэлийн гэрээ”-г байгуулан орон сууцаар хангасан.</p>	100

								2024–2025 онд нийт 157 төрийн албан хаагч орон сууцны дэмжлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 110 албан хаагчаар өссөн байна.	
295	Төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлж, цогц чадамжтай хүний нөөцийг бүрдүүлж, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн тогтолцоог хэрэгжүүлэх	Чадавхжуулсан төрийн албан хаагч	Тоо	2024	4887	5500	9275	Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлага, чадамжийг сайжруулах, гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэх хүрээнд аймаг, сумдын байгууллагууд төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулж, сумдын хэмжээнд нийт 683 төрийн албан хаагчийг ёс зүй, манлайлал, санхүүгийн сахилга бат, архив, сэтгэлгээний өөрчлөлтийн сургалт, зөвлөгөөнд хамруулсан. Мөн төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ, хийх арга зүйн сургалтад сумдын 30 албан хаагчийг хамруулсан. Мэргэшүүлэх сургалтын хүрээнд Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн сургалтад 2, ахлах түшмэлийн сургалтад 8, дунд хугацааны давтан сургалтад 23, анх томилогдсон албан хаагчдын сургалтад 11, нийт 44 албан хаагч хамрагдсан. Мөн “Сэтгэлгээний өөрчлөлт” сэдвийн сургагч багшийн 2, Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн, “Төрийн албаны манлайлал” говийн бүсийн зөвлөгөөнд 120, Төрийн албаны зөвлөлийн сургалтад 2, БНХАУ-д 1, БНСУ-д 2 төрийн албан хаагч хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 3 гомдлыг Ёс зүйн дэд хороо шалган, 1 албан хаагчийг зөрчил гаргасан гэж дүгнэж, хуульд заасны дагуу зөрчлийг арилгуулсан байна. Аймгийн хэмжээнд 153 төрийн байгууллага гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог үе шаттай хэрэгжүүлж, 90 гаруй хувь нь төлөвлөгөөт ажлаа бүрэн биелүүлэн “сайн” буюу түүнээс дээш үнэлгээ авсан. Тайлант онд Засгийн газар, яам, агентлаг, удирдлагын академи, төсөвт байгууллагуудын сургалт зэрэг цахим болон танхимын 800 гаруй сургалтаар дамжуулан төрийн албаны ёс зүй, харилцааны соёл, ажлын гүйцэтгэлийн чанарыг сайжруулах чиглэлээр давхардсан тоогоор нийт 9,275 төрийн албан хаагчийг хамруулсан.	100
296	Гадаад улсын ижил төстэй	Сургалтад хамрагдсан	Тоо	2024	67	90	136	Дорноговь аймаг нь гадаад хамтын ажиллагааны хүрээгээ өргөжүүлж, гадаадын 10 хот, муж болон 11	100

	байгууллагын үйл ажиллагаатай танилцах, тодорхой хугацааны сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах	албан хаагчдын тоо						олон улсын байгууллагатай хамтран нийт 19 удаагийн айлчлал, уулзалтыг зохион байгуулсны үр дүнд төрийн албан хаагчдыг олон улсын туршлага, сургалт, дадлагад тогтмол хамруулах үйл ажиллагаа эрчимжиж, 2025 онд 69 албан хаагч гадаад улс оронд мэргэжил дээшлүүлэн, олон салбарт бодит туршлага судалсан. Тухайлбал, ОХУ-ын Эрхүү мужтай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд боловсрол, соёлын чиглэлээр 16 орос хэлний багш, 15 уран бүтээлч, БНХАУ-ын Шилийн гол аймагт хийсэн айлчлалын үеэр ИТХ-ын төлөөлөгчид болон 20 малчин хөдөө аж ахуй, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр туршлага судалсан бол Ганьсу, Нинся мужид зохион байгуулагдсан цөлжилтийн хяналт, ногоон хөгжлийн семинарт байгаль орчны 10 албан хаагч, ӨМӨЗО-ны Бугат хотод эрүүл мэндийн салбарын 10 албан хаагч мэргэжил дээшлүүлэх сургалтад тус тус хамрагдсан. Мөн БНСУ-ын КОИСА-ийн дэмжлэгтэйгээр архив, хот төлөвлөлт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаатай танилцах сургалтад 3 албан хаагч, гадаад хэлний багш нарыг чадавхжуулах сургалтад 28 багш хамрагдсан. Гадаад талын байгууллагууд сургалт, арга хэмжээний зардлын ихэнхийг санхүүжүүлэн, аймгийн ОНТ-оос шаардлагатай зардлыг хэсэгчлэн дэмжсэнээр аймгийн төрийн байгууллагуудын институцийн чадавх, олон улсын хамтын ажиллагааны үр нөлөө мэдэгдэхүйц нэмэгдэж, албан хаагч олон улсын мэргэжлийн сургалт, туршлага солилцооны үйл ажиллагаанд оролцож, сурч хөгжих боломж бодитоор нэмэгдсэн.	
297	Төрийн албан хаагчдыг ажилласан жил, ажлын үр дүнг харгалзан түрээсийн орон сууцад хамруулах	Нийгмийн баталгаагаар хангагдсан төрийн албан хаагч	Тоо	2023	47	80	102	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 09/01 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг батлуулж аймгийн 35 төрийн байгууллагын хүрээнд Төрийн албан хаагчийг сургах болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах	100

								<p>хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд Түрээсийн орон сууц хөтөлбөрийн эхний ээлжийн 105 айлын орон сууцаас зорилтот бүлгийн багш, эмч, сувилагч зэрэг нийт 47 төрийн албан хаагчийг хамруулсан.</p> <p>2025 онд “Түрээсийн орон сууц” хөтөлбөрөөр ОБГ, ЦГ, Чандмань-Илч, ШШГГ, Нэгдсэн эмнэлэг болон бусад байгууллагын 16 ажилтан албан хаагч, Замын-Үүд сумын “Мандах наран–6” хорооллын 288 айлын орон сууцаас 39 айлыг төрийн албан хаагчдад түрээсийн хэлбэрээр олгож, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>2024–2025 онд нийт 102 төрийн албан хаагч Түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55 албан хаагчаар өссөн зэрэг үзүүлэлттэй байна.</p>	
298	<p>Төрийн байгууллага, албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх барилга, ажлын байрны асуудал болон шаардлагатай тоног төхөөрөмж, эд хөрөнгийг үе шаттай шийдвэрлэх</p>	ажиллах нөхцөлийг сайжруулсан албан хаагч	тоо	2024	300	500	800	<p>Тайлант хугацаанд төрийн байгууллагын албан хаагчдын ажиллах орчин, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэд хэдэн бодит ажлыг хэрэгжүүлэв.</p> <p>Аймгийн ЗДТГ болон агентлаг, төсөвт байгууллагууд, Өргөн, Улаанбадрах, Хөвсгөл, Даланжаргалан сумдын ЗДТГ-ын нийт албан өрөө, тасалгаанд 440.9 сая төгрөгийн өртөгтэй засвар шинэчлэл хийж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Албан хэрэгцээнд шаардлагатай сандал, ширээ, шкаф, сейф, агааржуулагч зэрэг тоноглолыг 66.4 сая төгрөгөөр худалдан авч, байгууллагуудад хуваарилан ашиглуулсан.</p> <p>Мөн төрийн албан хаагчдын өдөр тутмын хэрэглээнд шаардлагатай 123 нэр төрлийн компьютер, принтер болон бусад техник хэрэгслийг 241.4 сая төгрөгөөр шинэчилсэн.</p> <p>Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах үүднээс 869.3 сая төгрөгийн хөрөнгөөр автомашины парк шинэчлэлт хийж, Чандмань-Илч ОНӨХХК-ийг бохир соруулах зориулалтын автомашинаар хангасан.</p>	100

								<p>Түүнчлэн 14 сумын 65 багийн Засаг даргад төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэхээр зөөврийн компьютер болон бусад техник хэрэгслийг 325 сая төгрөгөөр худалдан авч хүлээлгэн өгсөн нь хүн ам, малын тооллогын ажилд шуурхай байдлыг хангах ач холбогдолтой байна.</p> <p>Нийт арга хэмжээнд 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр төрийн байгууллагуудын ажиллах орчин сайжирч, төрийн албан хаагчдын бүтээмж, иргэдэд хүргэх үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн. Хийгдсэн ажлын үр дүнд 800 төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл сайжирсан нь өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлт болж байна.</p>	
299	Төрийн зарим байгууллагуудад автомашины парк шинэчлэл хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	<p>Орон нутгийн 2025 оны төсөвт автомашин худалдан авах төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд тендерт шалгарсан 2 компанитай 868,3 сая төгрөгийн гэрээ байгуулж, шаардлагатай 3 автомашиныг ашиглалтад хүлээн авсан.</p> <p>Энэ ажлын хүрээнд төрийн зарим байгууллагын автопаркийг шинэчилж, албан хаагчдын ажлын үр ашиг, тээвэрлэлтийн найдвартай байдлыг сайжруулсан.</p>	100
300	Орон нутгийн хэрэгцээнд ашиглагдах нөөцийн агуулах барих ажил	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	0	<p>Орон нутгийн хэрэгцээнд ашиглагдах нөөцийн агуулах барих тендерийг 2025 оны 06 дугаар сарын 30-нд нээж, "Бэмэс" ХХК, "Эгнэгт-Өрнөх" ХХК, "Глобалгейтвэй" ХХК-уудаас үнийн санал ирүүлж, нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардлага хангасан оролцогч оролцоогүй тул тендер шалгаруулалтыг хүчингүй болгосон.</p> <p>Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн хэмнэлтэд хамарч ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон.</p>	0
301	"Цахим-Дорноговь" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	хувь	2024	76	77	81	<p>"Цахим Дорноговь" хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын "Албан бичиг солилцооны дундын систем (DOCX)", "Төрийн байгууллагын удирдлагын нэгдсэн систем (ERP)"-ийг нийт 178 байгууллагыг нэвтрүүлж, ашиглалт 72 хувьтай байна. Мөн "Аймгийн төрийн үйлчилгээний нэгдсэн цахим систем", "автобусны хяналтын нэгдсэн цахим систем"-ийг нэвтрүүлэхээр судалгааны ажлыг хийж байна.</p>	100

								<p>Сайншанд сумын хэмжээнд "Камерын хяналтын удирдлагын нэгдсэн систем"ийг нэвтрүүлэн 250 гаруй камерыг суурилуулж "DSS PRO V8" маркийн системийг "Nx Witness" систем рүү шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Иргэдийн мэдээлэл авах хүртээмж, цахим хэрэглээг хангах зорилгоор Сайншанд сумын 2, 3, 6 дугаар багт байрлах нийтийн эзэмшлийн "гэр бүлийн талбай, тэмээтэй талбай, офицерын талбай, аймгийн төв талбай" нийт 4 талбайд (free wifi) утасгүй интернэтийн нээлттэй бүсийг шинээр байгуулсан.</p> <p>Тайлант хугацаанд хөтөлбөрийн хэрэгжилт 81 хувьтай, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн.</p>	
302	<p>Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "Ухаалаг E-Mongolia" системийг хэрэгжүүлэх</p>	Төрийн цахим үйлчилгээний төрөл	тоо	2024	353	410	451	<p>Аймгийн 14 төрийн байгууллагын 78 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлсэн.</p> <p>Төрийн цахим үйлчилгээг "ХУРДАН" төв болон 13 суманд салбар нэгжээр 43 байгууллагын 451 төрлийн үйлчилгээ, 19 ширхэг КИОСК төхөөрөмжөөр дамжуулан 60 байгууллагын 600 төрлийн үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>Мөн 10 суманд "ХУРДАН" брэндбүүк стандартын дагуу тохижуулах ажлыг орон нутгийн 20 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.</p> <p>Төрийн үйлчилгээг "e-mongolia.mn" системээр дамжуулан авах боломжийг 98 үйлчилгээгээр нэмэгдүүлж нийт 451 төрлийн үйлчилгээ авах боломжтой болсон нь өмнөх оноос 27 хувиар өссөн.</p>	100
303	<p>Төрөөс иргэн, бизнест үзүүлж буй гол үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж цахимжуулах, хиймэл оюун ухаан ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авах хугацаа болон үе</p>	Төрийн үйлчилгээг цахимаар авсан иргэд	Тоо	2024	11000	18000	28025	<p>Аймгийн хэмжээнд "ХУРДАН" төв болон 13 салбар нэгжээр дамжуулан операторын горимоор 15667, өөртөө үйлчлэх 19 ширхэг КИОСК төхөөрөмжөөр 12358, нийт 28025 төрийн үйлчилгээг цахимаар үзүүлсэн.</p> <p>Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Мэдээлэл аюулгүй байдлын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран "Digital first" арга хэмжээний хүрээнд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх V аяны хүрээнд "Цахим шилжилт-2", "Цахим ур чадварын V аян", "мэдээллийн аюулгүй байдал", "Цахим орчны зохистой хэрэглээ" гэх мэт 16 сургалтыг төрийн албан хаагч 1480, ахмад настан 35, оюутан</p>	100

	шатыг 2 дахин бууруулах							сурагч 1102, бизнес эрхлэгч 120, иргэн 6800, нийт 9,537 төрийн албан хаагч, иргэнд цахим ур чадвар, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт, мэдээлэл өгч ажилласан. Мөн технологи, цахим ур чадварын чиглэлээр өсвөрийн "ХУРДАН" клубийн үйл ажиллагааг эхлүүлэн ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсрол, "явуулын технологи" сургалтын төв, "Американ корнер" төвтэй хамтран 50 гишүүнтэйгээр үйл ажиллагааг явуулж байна. Аймгийн хэмжээнд "ХУРДАН" төв болон КИОСК төхөөрөмжөөр дамжуулан 28,025 төрийн үйлчилгээг цахимаар үзүүлсэн нь өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн байна.	
304	Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН", 24/7цагаар ажиллах "СМАРТ" цэгийн тоог нэмэгдүүлж, киоск, хөдөлгөөнт цэг, төхөөрөмжүүдийг үе шаттай нэмэгдүүлэх	КИОСК төхөөрөмж	Тоо	2024	7	8	19	Өөртөө үйлчлэх КИОСК төхөөрөмжийг Айраг, Иххэт, Даланжаргалан зэрэг 12 сум тус бүрд байршуулж, 60 байгууллагын 600 төрлийн үйлчилгээг 12358 үйлчилгээг цахимаар үзүүлсэн. "ХУРДАН" төвийн брэндбүүк стандартын дагуу 10 суманд тохижилтын ажлыг орон нутгийн төсвийн 20,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Төрийн цахим үйлчилгээний өөртөө үйлчлэх КИОСК төхөөрөмжийг Алтанширээ, Өргөн суманд байршуулах, "ХУРДАН" төвийн 24/7 цагаар ажилладаг "СМАРТ" цэгийг Сайншанд суманд 3-р багийн нутаг дэвсгэрийн 1 байршилд байгуулахаар зураг төсвийн ажлыг гүйцэтгэсэн.	100
305	Төрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд инновацыг нэвтрүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлж, бүх нийтийн цахим ур	Төрийн байгууллагын дотоод системийн ашиглалт	Хувь	2024	50	60	72	Аймгийн төрийн болон төрийн өмчит 178 байгууллагыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд бүртгэж 99 хувь нэвтрүүлээ. Мөн байгууллагуудыг цахим орчинд албан бичиг солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор "Албан бичиг солилцооны дундын (Досх) систем"-д нийт 178 байгууллагыг холбож ажилласан. Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Мэдээлэл аюулгүй байдлын газар, "И-Монгол" академи УТҮГ-тай хамтран "Цахим шилжилт-2", "мэдээллийн аюулгүй байдал" гэх мэт 15 сургалтыг зохион	100

	чадварыг дээшлүүлэх							байгуулж "ERP" системийн ашиглалт, тоон гарын үсгийн ашиглалт, кибер аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчит 640 албан хаагчдыг хамруулсан. Төрийн 52 байгууллага албан хэрэгцээндээ лавлагаа мэдээлэл гаргах, албан бичиг цахимаар боловсруулах, Төрийн сангийн нэгдсэн системд тайлан мэдээ хүргэхэд нийт 474 албан хаагч тоон гарын үсгийг ашиглаж байна. Тайлан хугацаанд "Албан бичиг солилцооны дундын (Docx) систем"-д 33 байгууллага бүртгэж, тоон гарын үсгээр албан бичиг баталгаажуулах, цаг бүртгэл, өргөдөл, гомдол, чат болон тоон гарын үсэг ашиглах зорилгоор "төрийн байгууллагын удирдлагын нэгдсэн (ERP) систем"-д 38 байгууллага шинээр бүртгэсэн нь системийн ашиглалт 72 хувьтай байна.	
306	Тоон гарын үсгийн ашиглалтыг нэмэгдүүлж, кибер аюулгүй байдлыг хангах	Тоон гарын үсэгтэй иргэн	Тоо	2024	3988	4500	5950	Төрийн 52 байгууллага албан хэрэгцээндээ лавлагаа мэдээлэл гаргах, албан бичиг цахимаар боловсруулах, Төрийн сангийн нэгдсэн системд тайлан мэдээ хүргэхэд нийт 474 албан хаагч тоон гарын үсгийг ашиглаж байгаа бол Улсын бүртгэлийн хэлтэс иргэдэд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхэд суулгах ажлыг зохион байгуулж, тайлант онд 5950 иргэнд тоон гарын үсэг олгож, "И-Монгол академи"-ийн УТҮГ, Улсын бүртгэлийн газартай хамтран зохион байгуулсан чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлын хүрээнд төрийн 520 албан хаагч, 23 аж ахуйн нэгж, байгууллага болон нийт 5200 иргэний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ыг аймгийн ЗДТГ-ын даргын А/140-р тушаалаар батлан мөрдөж, бусад төрийн болон төрийн өмчит байгууллагад танилцуулж, мөрдүүлэх арга хэмжээ авч ажилласны үр дүнд 96 байгууллага уг журмыг баримтлан, өөрийн дотоод үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн "Кибер аюулгүй байдал, цахим ур чадварыг дээшлүүлэх" чиглэлээр зохион байгуулсан 3 удаагийн сургалтаар 42 байгууллагын 84 албан хаагчдыг	100

								чадавхжуулж, кибер аюулгүй байдлын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн.	
307	Орон нутгийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хувь	2024	86,7	87	90	<p>Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг гарган 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүний хуралдааныг 1 зохион байгуулж, зарим тусгай чиг үүргийн байгууллагууд орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй асуудал, үүсэж болзошгүй эрсдэл, нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулж, аймгийн Засаг дарга асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэх үүрэг, чиглэлийг өгсөн. Сумдын Засаг дарга нарт “Үндэсний аюулгүй байдлыг орон нутагт хангах бодлого”, “Хил хамгаалалтад туслах хүчний оролцоо” сэдвүүдээр сургалт мэдээлэл хүргэж, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал” номыг албан хэрэгцээнд хэрэглэн, уншиж судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах арга зүйн зөвлөгөөг өгсөн.</p> <p>Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай хамтран зарим сумдад ажиллан судалгаа мэдээллийг гаргуулан, үүсэж болзошгүй эрсдэл, нөхцөл байдлын талаар танилцуулж, зөвлөмж өгч ажилласан.</p>	100
308	Хилийн торон саадыг үе шаттайгаар засварлах, дохиолол, хяналтын нэгдсэн систем суурилуулах ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг	Тоо	2024	1	3	2	Хил хамгаалалтын ажлыг нягтруулан бэхжүүлэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 142.1 км өргөст утсан хашааг шинээр байгуулж, Хилийн цэргийн 0168 дугаар ангийн хяналтын төвийн тохижилтын ажилд орон нутгийн төсвөөс 80,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлснээр хилийн 8 салбарт “Хяналтын төв” байгуулж, улсын хил хамгаалалтын удирдлагын холбоо, мэдээлэл, нэгдсэн системд холбогдож, хяналтын үйл ажиллагааг төвлөрүүлж, хил орчмын аюулгүй байдал, эрсдэлийг шуурхай илрүүлэх, мэдээлэх чадвар нэмэгдсэн.	50
309	Соёл урлагийн газар болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	0	2	3	Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын 16 хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид 2025 оны 1 дүгээр улиралд ХЦ-ийн 3 анги болон хил хамгаалалтад туслах хүчний гишүүдэд сэтгэл зүйн бэлтгэл олгох	90

	хамтран хилчид, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдэд соён гэгээрүүлэх, эрх зүйн боловсрол дээшлүүлэх, сэтгэл зүйн бэлтгэл олгох сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах							соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/376 дугаар захирамжийн дагуу “Явуулын амбулаторийн үзлэг” хилийн бүсийн сумдад зохион байгуулагдахад алба хаагчид, тэдний гэр бүлийн гишүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Хатанбулаг, Хөвсгөл сумдын хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлийн хурлыг 2025 оны 1 дүгээр улиралд Хилийн цэргийн 0168 дугаар ангийн байрлалд зохион байгуулж холбогдох мэдээлэл өгч, сургалтыг зохион байгуулж, хамтран ажилласан.	
310	Хилийн цэргийн анги, салбарын үйл ажиллагаа, хилчдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг	Тоо	2024	3	6	6	Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын 16 хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид 2025 оны 1 дүгээр улиралд ХЦ-ийн 3 анги болон хил хамгаалалтад туслах хүчний гишүүдэд сэтгэл зүйн бэлтгэл олгох соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/376 дугаар захирамжийн дагуу “Явуулын амбулаторийн үзлэг” хилийн бүсийн сумдад зохион байгуулагдахад алба хаагчид, тэдний гэр бүлийн гишүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн алба хаагчдын 24-н айлын орон сууцны засварын ажилд 80,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг нэмэгдүүлсэн. Мөн Хилийн цэргийн 0168 дугаар ангийн хяналтын төвийн тохижилтын ажилд 80,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс үзүүлснээр хилийн 8 салбарт “Хяналтын төв” байгуулж, улсын хил хамгаалалтын удирдлагын холбоо, мэдээлэл, нэгдсэн системд холбогдож, хяналтын үйл ажиллагааг төвлөрүүлж, хил орчмын аюулгүй байдал, эрсдэлийг шуурхай илрүүлэх, мэдээлэх чадвар нэмэгдсэн. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хил хамгаалалтад иргэн, байгууллагын	100

								оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Дорноговь аймгийн хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн зөвлөгөөнийг Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн байрлалд 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хилийн сум буюу Замын-Үүд, Улаанбадрах, Хатанбулаг, Эрдэнэ сумдын удирдлага, зөвлөлийн гишүүд зэрэг 50 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан.	
311	Хилийн боомтын сэргэлтийн бодлоготой уялдуулан боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ухаалаг цахим гарц, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, тоног төхөөрөмжөөр хангах ажилд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг	Тоо	2024	3	4	4	<p>Замын-Үүд Засаг даргын Тамгын газар Нi рау, Тоффика компаниудтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн Замын-Үүд суманд бичил үйл ажиллагаа эрхэлж буй иргэдээс авах татварыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Уг үйлчилгээг нэвтрүүлснээр 2024 оны мөн үетэй харьцуулахад 127,4% буюу 837 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.</p> <p>Замын-Үүд боомтын зорчигч тээврийн терминалын импортын хэсэгт суурилуулсан 24, экспортын хэсэгт суурилуулсан 30 буюу нийт 54 байршилд, ачааны терминалын экспортын хэсгийн 11, импортын хэсгийн 28 гарц буюу нийт 39 байршилд ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж байна.</p> <p>Мөн зорчигчдын орох, гарах хэсэгт тус бүр 4 ширхэг цахим гарцын төхөөрөмж суурилуулснаар иргэд цахим паспортаар саадгүй зорчиж байна. Энэ оны байдлаар орох чиглэлд 21508 иргэн, гарах чиглэлд 32568 иргэн, нийт 54076 зорчигч цахим гарцаар Улсын хилээр нэвтэрсэн.</p>	100
312	Төрийн цэргийн болон хууль сахиулах чиг үүргийн байгууллагын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах	Зохион байгуулах зөвлөгөөн	Тоо	2024	0	1	0.5	<p>Төрийн цэргийн болон хууль сахиулах чиг үүргийн байгууллагын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулах талаар 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр аймгийн ЗДТГ-ын Хурлын танхимд чиг үүргийн байгууллагуудын удирдлага, төлөөллүүдийг оролцуулсан уулзалтыг зохион байгуулж, саналыг авсан.</p> <p>Уулзалтаар жагсаал парад, урлаг спортын тэмцээн уралдаан, сургалт, мэдээлэл хосолсон байдлаар өргөн хүрээтэй зохион байгуулах санал гарсны дагуу 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулна.</p>	50

313	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг	Тоо	2024	5	11	24	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Олон нийтийн цагдаагийн урамшуулал, хувцас хэрэгсэлд 309,4 сая тус аймгийн Айраг сумын сум дундын цагдаагийн тасагт PRIUS-20 маркийн тээврийн хэрэгслийг 19,8 сая Улаанбадрах сумын хэсгийн төлөөлөгчид албанд ашиглах торгуулийн төхөөрөмж багаж 800,0 мянга Цагдаагийн газарт мэдүүлэг авах зориулалт бүхий 8 өрөөний засвар үйлчилгээнд 11,0 сая, Эрүүлжүүлэх, саатуулах байрны тохижилтод 1.0 сая төгрөг, Иххэт сумын кобан засвар 19,7 сая, Дэлгэрэх сумын Цагдаагийн байрны их засварын ажилд 124,6 сая төгрөг, Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэст драйвер 4,9 сая төгрөг, бэлэн бус торгуулийн төхөөрөмж 3 ширхэг 1,8 сая төгрөг, Ланд 300 авто машин 1 ширхэг 199,9 сая төгрөг. Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн албан хаагчдын 24-н айлын орон сууцны засварын ажилд 80,0 сая төгрөг, 0168 дугаар ангийн хяналтын төвийн тохижилтын ажилд 80,0 сая төгрөг, терроризмтэй тэмцэх үйл ажиллагаанд зориулж аймгийн Тагнуулын хэлтэст 39,9 сая төгрөг, Шүүхийн шинжилгээний хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмжийн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 50,0 сая төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 6,2 сая төгрөг, нийт 10 байгууллагад орон нутгийн төсвөөс 949,2 сая төгрөгийн 18 дэмжлэгийг үзүүлж хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын материаллаг баазыг нэмэгдүүллээ.	100
314	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, орон сууцанд хамруулах, урамшууллыг үе шаттайгаар шийдвэрлэх	Дэмжлэг	Тоо	2024	2	7	15	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудаас түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлтэй 23 алба хаагчийн судалгааг гаргаж, үе шаттайгаар байр, орон сууцаар хангах ажлыг зохион байгуулж, аймгийн Цагдаагийн газрын 3 албан хаагчийг төрийн албан хаагчийн орон сууцанд, Замын-Үүд сумын Прокурорын газрын 2, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2, Хилийн цэргийн 0168 дугаар ангийн 2 албан хаагчийг тус тус Замын-Үүд сумын түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулж, нийт 9 албан хаагчийн нийгмийн баталгааг ханган ажиллаж,	100

								амьдрах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн. Аймаг, орон нутгийн ажилд идэвх санаачилгатай ажилласан. Цагдаагийн газрын 3, Улсын бүртгэлийн хэлтсийн 1 албан хаагчийг Бүгд Найрамдах Хятад ард улсын Бээжин хотод туршлага судлах арга хэмжээнд оролцуулж урамшуулахаар шийдвэрлэсэн.	
315	Дэлгэрэх сумын Цагдаагийн байранд их засвар хийх	Ажлын гүйцэтгэл	Хувь	2024	0	100	100	Орон нутгийн төсвийн 121,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрэх сумын Цагдаагийн байранд "Мандах Таун" ХХК их засварын ажлыг гүйцэтгэж, албан хаагчдын амьдрах, ажиллах орчны нөхцөлийг сайжруулж, аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.	100
316	"Нэг цонх-Нэгдмэл гадаад бодлого"-ыг үргэлжлүүлж, ОХУ, БНХАУ-тай тогтоосон түншлэлийг эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд өргөжүүлэх	хамтран ажилласан арга хэмжээ	Тоо	2024	12	13	16	ОХУ-тай хамтын ажиллагааны хүрээнд аймгийн төлөөлөгчид 2025 онд ОХУ-д ажиллаж, боловсрол, соёл, эдийн засаг, логистикийн хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцсэн бөгөөд орос хэлний багш нарыг богино хугацаагаар сургуулиудад ажиллуулах зохион байгуулалт хийж, соёлын солилцооны хүрээнд 15 уран бүтээлч оролцсон арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. БНХАУ-тай хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд байгаль орчин, боловсрол, аялал жуулчлал, эрүүл мэнд, хөдөө аж ахуй чиглэлээр нийт 4 төрлийн сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг амжилттай зохион байгуулсан. Тодруулбал, аймгийн малчдын төлөөлөл ижил түвшний хоршоо, байгууллагуудад зочлон туршлага солилцож, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх санал солилцсон. Хил орчмын байгууллагуудтай хамтран цөлжилтөөс хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг дэмжиж, үндэсний хөдөлгөөнд оролцох хүрээнд мод тарих ажил эхлүүлсэн. Боловсролын салбарт дижитал анги байгуулах, сургалтын тоног төхөөрөмж нэмж суурилуулах, сурагчдад санхүүгийн дэмжлэг олгох зэрэг бодит оролцоотой ажлууд хийгдсэн бөгөөд сурагчдын гадаад айлчлал, сургалтын орчинтой танилцах боломж тасралтгүй өргөжсөн. Бүс нутгийн түвшний уулзалтаар авто замын шинэчлэл, логистикийн сүлжээ, хил дамнасан аялал жуулчлал, соёлын хамтын ажиллагаа болон эдийн засгийн уялдааг нэгдсэн байдлаар авч үзэж, дэд бүтцийн судалгаа,	100

								төлөвлөлтийн талаар тохиролцолд хүрсэн. Байгаль орчны салбарт хамтарсан сургалт, семинаруудад 10 мэргэжилтэн оролцож, шинэ аргачлал судалсан бол эрүүл мэндийн чиглэлээр 10 эмч, сувилагч гадаадын байгууллагад дадлага хийж, орчин үеийн технологи, мэс заслын арга зүйтэй танилцах боломж бүрдүүлсэн.	
317	Япон, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс орнуудтай “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	Хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	Тоо	2024	3	4	7	<p>“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Япон, БНСУ, БНЧУ(Чех Улс) зэрэг улс оронтой худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр нийт 4 төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, эдийн засаг, хөдөө аж ахуй, шинэ технологийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд бизнес эрхлэгчид, байгууллагуудын оролцоотой 5 удаагийн уулзалт, форум зохион байгуулсан.</p> <p>Үүнд: Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг Японд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, хоёр талын солилцооны хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж байна.</p> <p>Техникийн шинэчлэл, автоматжуулалт, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх чиглэлээр БНСУ-тай хамтын ажиллагааны боломжийг судалж, салбарын төлөөллийг хүлээн авч, тоног төхөөрөмжийн дэмжлэг, сургалтын шинэ арга барилыг нутагшуулах чиглэлээр шаардлагатай техник эдийн засгийн үзүүлэлтийн судалгааны ажлыг хэрэгжүүлж байна.</p> <p>Гадаадын бизнесийн байгууллагуудтай хамтарсан уулзалтаар хувийн хэвшлийн түншлэл бий болгож, БНСУ, Чех улсад хөдөлмөрийн ажиллах хүчин нийлүүлэх, боловсролын салбарт Япон улстай хамтран хэрэгжүүлэх дэд бүтцийн төслийн санхүүжилтийг баталгаажуулж, сурагчдын сургалтын орчныг сайжруулах чиглэлд бодит ахиц гарсан.</p> <p>Аялал жуулчлалын салбарт БНСУ-ын байгууллагатай хамтран шинэ маршрутын төлөвлөлт хийж, олон улсын агентлагуудтай ажиллах суурь нөхцөлийг бүрдүүлсэн нь ирэх онуудад гадаадын жуулчдыг татах боломжийг нэмэгдүүлсэн.</p>	100
318	Хөрөнгө оруулалт, аялал жуулчлал,	Гадаадын төсөл хөтөлбөр,	Тоо	2024	3	4	4	Хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, бизнес, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт гадаад	100

	<p>бизнес, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт гадаад түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх</p>	<p>хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p>					<p>түншлэлийн бодлогыг идэвхтэй хэрэгжүүлж, олон улсын арга хэмжээнд оролцож, гадаадын төлөөлөгчдийг урьж бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчилсан бөгөөд хамтын ажиллагааны 4 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүнд БНСУ, БНХАУ, ОХУ, БНЭУ-ын төр, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулсан “Тэнгэрийн хутагт” аялал жуулчлалын фестивалийг зохион байгуулж, шинэ маршрут, өв соёл, орон нутгийн үйлчилгээний онцлогийг танилцуулан гадаадын жуулчдыг татахад чиглэгдсэн. гадаад жуулчин татахад чиглэсэн. Мөн ӨМӨЗО-ны хот, хошуудтай хамтран логистикийн төв байгуулах, авто зам, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээр 2 удаагийн уулзалт зохион байгуулж, Монгол-Хятадын 5 дахь экспод хөрөнгө оруулалт татах чиглэлээр оролцон боломжит төслүүдээ танилцуулж, аймгийн гадаад хамтын ажиллагааг бэхжүүлсэн.</p> <p>БНСУ-ын Кимжэ хоттой техникийн шинэчлэл, автоматжуулалт, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж (2024 онд буцалтгүй тусламжаар 2 автобус хүлээн авсан), 2025–2026 онд хүлээн авах автобус, галын машин, түргэний тэрэгний асуудлаар тохиролцсон. Япон Улсын Засгийн газрын 2025 оны “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих “Дорноговь аймгийн Иххэт сумын ЕБС-ийн барилгыг засварлах төсөл”-ийн гэрээг үзэглэж, 154,971 ам.долларын санхүүжилтийг баталгаажуулсан бөгөөд төслийн хүрээнд сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвүүдэд засвар, тоног төхөөрөмжийн хангалт хийгдэж, сурагчдын сургалтын орчин сайжирч, иргэдийн амьдралын чанарт хувь нэмэр оруулсан.</p> <p>Дорноговь аймаг Япон улсын Шизуока мужтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны 15 жилийн ойн хүрээнд боловсрол, соёл, аялал жуулчлал, бизнес, эрүүл мэнд, дэд бүтэц, нийгмийн хамгаалал, спортын салбарт хамтран ажиллах 15 арга хэмжээг төлөвлөж, аймаг, мужийн Засаг даргын айлчлал, ИТХ-ын хамтын ажиллагаа, сурагч</p>	
--	---	---	--	--	--	--	--	--

								солилцоо, сургалт, төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна.	
319	Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулах нэгдсэн стратеги бүхий цогц эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх.	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулах дадлага сургууль зохион байгуулсан тоо	тоо	2024	-	4	12	<p>Монгол Улсын Шадар сайдын баталсан “Аймаг, нийслэлд гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулах хуваарь, төлөвлөгөө”, Онцгой байдлын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6.16 дахь заалтын хэрэгжилтийг хангаж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/248 дугаар тушаалаар Дорноговь аймагт Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 2025 оны 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургуульд аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, хуулийн этгээд, сумдын Засаг дарга, нийт-117 удирдах ажилтан танхимаар, 14 сум, 13 орон нутгийн гамшгаас хамгаалах албаны шуурхай штабын бүрэлдэхүүн 333 хүн цахимаар, бэлэн байдлын үзлэгт 392, нийт 823 хүн, 58 машин техник, хэрэгсэлтэйгээр оролцсон.</p> <p>Аймгийн Засаг даргын “Тогтвортой бодлого - Тасралтгүй хөгжил” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын 2025 оны "Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах тухай" А/247 дугаар захирамж, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль-1 (Хөвсгөл сум), Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль-2 (Өргөн, Мандах сум), Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг-2 (Хатанбулаг, Сайхандулаан сум), Ерөнхий болон болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын бүлэг, хэсгийг чадавхжуулах сургалт-1 (Сайншанд сум), Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүний сургалт-1, нийт 8 удаагийн сургалтыг буюу өссөн дүнгээр 12 сургалтыг 604 томилгоот бүрэлдэхүүн, 450 иргэн, нийт 1054 ажилтан, алба хаагч, иргэдийг хамруулж гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүллээ.</p>	100

320	Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон болон цасан шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлэх	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулах техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн тоо	Тоо	2024	-	60	70	<p>Онцгой байдлын газрын гамшигтай тэмцэх чадавх, байгууллагын тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах ажлын хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 3.2 сая төгрөгөөр (DAYUN маркийн мотоцикл), 2.9 сая төгрөгөөр сансрын хиймэл дагуулын өндөр хурдны интернэт төхөөрөмж, (Старлинк), нийт 31.1 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж, Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газраас Онцгой байдлын хэлтэст 47 сая төгрөгөөр (старлинк, мотоцикл, дулаан мэдрэгчтэй дрон) техник тоног төхөөрөмж, Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн хүрээнд 18 нэр төрлийн 36 ширхэг багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвөөс тус тус шийдвэрлүүлсэн.</p> <p>Мөн Онцгой байдлын ерөнхий газраас 25.0 сая төгрөгийн үнэ бүхий өндөр хүчин чадал бүхий (ус соруулах помп), 11.9 сая төгрөгийн үнэ бүхий 25 нэр төрлийн 31 ширхэг тусгай зориулалтын багаж, (ой хээрийн түймэр унтраах зориулалттай үлээгч аппарат, үүргэвчин гал унтраагуур, гал унтраах зориулалтын өндөр даралтын хоолой, аврах олс), 192 сая төгрөгийн үнэ бүхий Туулах чадвар сайтай (Ланд криузер-78), 45 сая төгрөгийн үнэ бүхий ачаа тээврийн зориулалттай (Бонго-3) маркийн автомашиныг тус тус хүлээн авсан.</p> <p>Онцгой байдлын газрын техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт 70% -д хүрч гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэх чадавх сайжирсан.</p>	100
321	Стандартаар гамшигын удирдлагыг хэрэгжүүлэх	Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Тоо	2024	425	450	482	<p>Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль-1, Гамшгаас хамгаалах команд штабын сургууль-2, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт-21, Удирдах албан тушаалтны сургалт-19, Сайн дурын бүлэг, хэсгийн сургалт-3, Их, дээд сургууль, коллежийн оюутны сургалт-1, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын сургалт-10, дунд ангийн сурагчдын сургалт-8, бага ангийн сурагчдын сургалт-9, Сургуульд элсэхээс өмнөх насны хүүхдийн сургалт-23, Төрийн болон</p>	100

								<p>нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны сургалт-266, Цэргийн дүйцүүлэх албаны сургалт-1, Иргэний сургалт-124, нийт 476 удаагийн гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 558 цагийн хугацаатай зохион байгуулж, 4769 эрэгтэй, 4542 эмэгтэй нийт 9311 ажилтан, алба хаагч, иргэдэд ангиллын сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Онцгой байдлын газраас албаны үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, иргэд, олон нийтэд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголт олгох зорилгоор 6 удаа өдөрлөг арга хэмжээ зохион байгуулахад нийт 1782 иргэн, ажилтан, алба хаагчид хамрагдаж, 891 гарын авлага, брошур тарааж, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл олгосон.</p> <p>Тайлант онд 482 арга хэмжээг хэрэгжүүлж 11,093 иргэн, албан хаагчдыг хамруулж гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүллээ.</p>	
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хэрэгжилтийн дундаж үнэлгээ:									95.4
Нийт арга хэмжээний дундаж үнэлгээ:									92.5

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

У.ШИНЭЧИМЭГ

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.БАДРАЛ